

БЯРААГИЙН ЧИМИДИЙН УНШЛАГА:

СОНГУУЛЬД
СУРАЛЦАХУЙ





Монгол Улсын Их Сургууль
ҮНДСЭН ХУУЛИЙН
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

БЯРААГИЙН ЧИМИДИЙН УНШЛАГА СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

2025 он

БЯРААГИЙН ЧИМИДИЙН УНШЛАГА:
СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

Эмхэтгэсэн:

Р.Анар

Г.Даваадалай

Р.Мухийт

Хянан тохиолдуулсан:

Г.Баясгалан

О.Мөнхсайхан

ГАРЧИГ

Бяраагийн Чимидийн товч намтар	5
--------------------------------------	---

I илтгэл: Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудалд

Илтгэгч: Д.Солонго	11
--------------------------	----

Санал, дүгнэлт

О.Машбат	26
Д.Оргил	30
О.Дарханболд	35

II илтгэл: Сонгуулийн байгууллага

Илтгэгч: Ж.Сүхбаатар	43
----------------------------	----

Санал, дүгнэлт

Н.Лувсанжав	67
Б.Төрболд	73
Б.Сарантуяа	83

III илтгэл: Нам сонгуульд оролцох тухай

Илтгэгч: Э.Гэрэлт-Од	95
----------------------------	----

Санал, дүгнэлт

Д.Бумдарь	109
Ж.Жаргал	113
Д.Баяндүүрэн	117

IV илтгэл: Сонгуулийн сурталчилгаа, санхүүжилт

Илтгэгч: Д.Энхцэцэг	127
---------------------------	-----

Санал, дүгнэлт

Б.Эрдэнэдалай	143
С.Бат-Орших	150
М.Түвшинжаргал	154

V илтгэл: Сонгогчийн боловсрол чухал болох нь

Илтгэгч: С.Оюунтуяа	161
---------------------------	-----

Санал, дүгнэлт

Д.Сүнжид	177
Б.Хишигсайхан	186

VI илтгэл: Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх хэргийн харьяалал

Илтгэгч: Д.Бат-Эрдэнэ		195
-----------------------	-------	-----

Санал, дүгнэлт

Т.Сүхболд		226
П.Баттулга		235
Э.Лхагвасүрэн		246

ТОВЧ НАМТАР

Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг баригч Бяраагийн Чимид

Төрсөн газар: Ач хариадынхны Бяраагийн Чимид нь 1934 оны 8 дугаар сарын 1-ний өдөр тухайн үеийн Архангай аймгийн Чандмань сумын 5 дугаар баг, одоогийн Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Баяннуур багийн нутаг Зөөлөн гэдэг газар төржээ.

Боловсрол: Шинэ-Идэр сумын бага сургууль (1943-1947), Мөрөнгийн оройн 10 жилийн сургууль (1958-1962), Хилийн ба дотоодын цэргийн тусгай хорооны дэргэдэх Цэргийн бага даргын сургууль (1953-1954), МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын хуулийн анги (1962-1966), ШУА-ийн аспирантур (1972-1975), ЗХУ-ын Улс ардын аж ахуйн академи (1985).

Цэргийн алба: Хилийн ба дотоодын цэргийн тусгай хороонд сонсогч, бага дарга (1953-1956).

Эрдмийн цол: Хууль зүйн ухааны дэд эрдэмтэн (1975), Удирдлагын академийн профессор (1999), МУИС-ийн ХЗС-ийн Хүндэт профессор (2000), Улаанбаатар Эрдэм Их сургуулийн Хүндэт профессор (2007), МУИС-ийн Хүндэт профессор (2012).

Монгол Улсын төрийн цол: Гавьяат хуульч (1992 оны 2 дугаар сарын 10), Ардын багш (2008 оны 7 дугаар сарын 9), Хөдөлмөрийн баатар (2010 оны 1-р сарын 13)

Одон, медаль: Хөдөлмөрийн хүндэт медаль (1972), Алтан гадас одон (1981, 1984), Ардын хувьсгалын 60, 70, 80 жилийн ойн медаль (1981, 1991, 2001), Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон (2004), Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль (2006), Монгол Улсын ШУА-ийн судалгааны шилдэг

бүтээлд олгодог “Хубилай хаан” алтан медаль (2010), Хөдөлмөрийн баатрын Алтан соёмбо тэмдэг (2010), Сүхбаатарын одон (2010)

Ажил, хөдөлмөр эрхлэлт:

- Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд малчин, баг, арван өрхийн бичиг үсгийн багш, ухуулагч (1947-1953),
- Хилийн ба дотоодын цэргийн тусгай хороонд сонсогч, бага дарга (1953-1956),
- Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын 15 дугаар багийн гүйцэтгэх захиргааны дарга (1956-1957),
- Хөвсгөл аймгийн Намын хорооны зааварлагч (1957-1962),
- Монгол Улсын Их Сургуулийн багш, тэнхимийн эрхлэгч (1966-1978),
- БНМАУ-ын Шүүх яамны сайд (1978-1982),
- Улсын Дээд шүүхийн дарга, Улсын ерөнхий арбитрч (1982-1986),
- БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн Төрийн байгуулалтын хэлтсийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгч гишүүн, Монголын парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны гишүүн (1986-1990),
- Монгол Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга, Бага Хурлын Тамгын газрын дарга, Монголын парламентын бүлгэмийн гишүүн (1990-1992),
- Монгол Улсын Их Хурлын гишүүн (1992-1996),
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (1996-1997),
- Монгол Улсын Их Хурлын зөвлөх (1997-2003),
- Монгол Улсын Ерөнхий сайд (Р.Амаржаргал)-ын зөвлөх (1999-2000),
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн профессор (1990-2013),

- “Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр” төслийн Үндэсний зөвлөх (2001-2005),
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч, зөвлөх, профессор (2002-2007, 2002-2013),
- Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл сурталчилгааны үндэсний төв (Хууль зүйн үндэсний хүрээлэн)-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга (2003-2010), зөвлөх (2010-2012),
- ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн захирал (2009-2013),
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх (2010-2013).

Сонгуульт ажил:

- Монголын хуульчдын холбооны дарга,
- Монголын нутгийн удирдлагын шинэтгэлийг дэмжих холбооны ерөнхийлөгч,
- Монголын Үндсэн хуулийг дэмжих холбооны ерөнхийлөгч,
- Монголын харьцуулсан эрх зүйн нийгэмлэгийн ерөнхийлөгч,
- Монголын “Хархорин” нийгэмлэгийн тэргүүн.

I

Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудалд

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АСУУДАЛД

Д.Солонго

Хууль зүйн доктор, профессор

Хэн нэг эрдэмтний бүтээлээр уншлага зохион байгуулах нь 1.Мэдлэг олж авах, өмнө авсныгаа бататгах, дэвшүүлсэн санаа онолыг ойлгох, 2.Уг эрдэмтний сэтгэлгээ, дэвшүүлсэн санааны шинжлэх ухааны хэв маягийг судлах, 3.Тэрээр өөрийн дүгнэлтэд хэрхэн хүрсэн талаар мэдэж урам зориг авах, 4.Эрдэмтдийн бүтээл нь цаг үеийнхээ соёл, шинжлэх ухааны төвшин, асуудлуудын илэрхийлэл байдаг тул эрин үедээ дүн шинжилгээ хийх зорилготой байдгийг бид бүхэн мэдэх билээ.

Юуны өмнө илтгэлээ ийнхүү нэрлэсэн учрыг товч айлтгая. Энэ удаагийн уншлагаар орж байгаа Б.Чимид багшийн туурвисан Сонгуульд суралцахуй номын эхний 3 бүлэг буюу “Монгол оронд сонгуулийн тогтолцоо үүсэж¹ хөгжсөн үе шат”, “Сонгуулийн тогтолцоо ба эрх зүйн тухайд юу мэдвэл зохих вэ?”, “Сонгуулийн тойрог, хэсэг хоёр” гэсэн сэдвүүд нь яах аргагүй сонгуулийн эрх зүйн тулгуур асуудалд тооцогддог. Миний хувьд Үндсэн хуулийн эрх зүй, Сонгуулийн эрх зүй хичээлийг бэлтгэн заахдаа ч эдгээрийг хөтөлбөрийн агуулгадаа тусган ярьж ирсэн. Чухам иймээс дээрх гурван бүлгийн агуулгыг бүхэлд нь Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудалд хэмээн нэрлэсэн бөлгөө.

Уг илтгэлээрээ өөрт оногдсон гурван бүлгийн хүрээнд Б.Чимид багшийн өөрийнх нь хэлснээр “... хуулийн заалтыг онолын үндэстэй зөв тайлбарласныг (Б.Чимид, 2008, х. 13) мөхөс

¹ Эх зохиол дээр “үүсч” гэж бичигдсэн хэдий ч хэл бичгийн сүүлийн үеийн дүрмээр “үүсэж” гэж бичдэг болжээ.

би хэрхэн ойлгосноо та бүхэнтэй хуваалцах зорилго дэвшүүлэн ажилласан.

Энэхүү бүтээлдээ зохиогч эх орныхоо түүхэн туршлага, өнөөгийн байдлыг харгалзан үзэхдээ өөрийн үзэж өнгөрүүлснийг баримт жишээ болгон бичсэн нь үзсэн уншсан хэн бүхэнд ойлгомжтой, шингэцтэй байдаг. Эрхэм багш маань иргэд сонгогч, нэр дэвшигч, сонгуулийн болон улс төрийн байгууллагын ажилтан, судлаач, суралцагсдад туйлын хэрэгцээтэй мэдлэгийг сонирхолтой, шинэлэг хэлбэрээр бичиж оюуны өв болгон үлдээжээ.

Сонгох эрх нь хүний оюунлаг чанар болон хувь хүний оюун ухаан, ёс суртахууны хэвийн хөгжлийг төгөлдөршүүлэх чухал хүчин зүйлийн нэг. Энэ талаар английн онолч Ж.С.Милль (1806-1873) "...сонголт хийх явцад хүний ойлгох, эргэцүүлэх, сайн мууг ялгах чадвар, оюуны үйл ажиллагаа болон юмс үзэгдэлд ёс суртахууны үнэлгээ өгөх зэрэг нь хөгжиж байдаг" (М.В.Баглай, 2001, х. 219-220) хэмээн маш оновчтой тодорхойлон бичсэн байдаг. Эндээс төрийн байгууллагыг байгуулах сонгууль нь улс төрийн идэвхтэй иргэдийн хэвийн хэрэгцээ, өөрийн байр суурийг илэрхийлэх боломж болох нь ойлгогдож байна.

Чухам иймээс дэлхийн улсууд иргэдийн сонгуулийн эрх, уг эрхээ хэрэгжүүлэх зарчим, тэдний саналыг хүндэтгэх, мандат хуваарилахад аль болох өргөн харгалзах асуудалд ихээхэн анхаарч гол хууль буюу Үндсэн хуульдаа тусган хуульчилдаг. Өнөөдөр зохион байгуулагдаж буй уншлагад товлогдсон бүтээлийн агуулга ч дээрх үндэслэлийг батлан харуулна.

Номын нэгдүгээр бүлэг 3 зүйл, 11 дэд зүйлтэй. Үүнд: Сонгууль үүссэний товч тоймын хүрээнд сонгууль хэмээгчийг орхиж болдоггүйн шалтгаан, сонгуулийн нийтлэг тогтолцоо гэж байдаг эсэх, Монгол Улс дахь сонгох ёсны үүсэл хөгжлийг анхдугаар, хоёрдугаар, гуравдугаар гэж үечилж, анхны ардчилсан сонгууль (1990 он) хийх үндсэн шалтгаан, үйл явц, анхны үр дүн,

сонгуулийн шинэ тогтолцоо, шинэ хууль, шинэчлэгдсэн сонгуулийн үр дүн, намын төлөө санал хураалт, түүний хэрэгцээ, шинэ Үндсэн хуулиар сонгуулийн тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан талаар авч үзжээ.

Сонгууль өнө эрт үүсэж, өдгөө хүртэл хувьсаж ирсэн ч сайн хүн шилж олж, засаг төрийнхөө жолоог бариулах гэсэн “төрөлх утгаа” алдаагүй талаар тэмдэглээд, “Сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах амин хэрэгцээ мөн бөгөөд хамгийг эзэрхэгч хаант ёсыг халах, ганцаар дарангуйлагчийг хавчин зайлуулах тэмцлийн үр дүн мөн” (Б.Чимид, 2008, х. 21) гэж тодорхойлжээ.

Үүнийгээ дэлгэрүүлж, “Хүний өөрийн жишгээс үзвэл засаг төрийн сонгууль нь улс төрийн байгууллагаас салдаггүй, ёстой л орхиж болдоггүй байнгын дагуул мэт” (Б.Чимид, 2008, х. 22) гээд сонгууль байхын хийгээд орхиж болдоггүйн үндсэн шалтгааныг нэгдүгээрт, “...ард түмэн засгаа гартаа авч, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээнээс шууд урган гарсан...”; хоёрдугаарт, “... сонгууль нь ганцаар дарангуйлах ёсноос ангид байх гэсэн ард түмний язгуур ашиг сонирхлыг бас илэрхийлдэг” (Б.Чимид, 2008, х. 22) хэмээн онцолсон байна.

Б.Чимид багш “сонгууль гэдэг хууль зүйн ойлголт”, түүнийг эзэн хаанаа тодруулан угсаа залгамжлуулах ёс болон хэд гурван хүн ахлагчаа тодруулах сонголттой хутган бүрхэгдүүлж хэрхэвч болохгүйг сануулан бичжээ.

Тэрээр улсын болон орон нутгийн хурлын сонгуулийн тогтолцооны үүсэл хөгжлийг тогтолцооны зарчим, ардчиллын хөгжлөөр нь гурван үед хуваан хураангуйлсан. Ингэхдээ үе тус бүрийн онцлогийг маш оновчтой нэрлэн бичсэн нь хэн хүнд ойлгогдохоор байна. Ингэснээр манай сонгуулийн тогтолцооны өнгөрсөн болон өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхэд бодит тус үзүүлэх нь дамжиггүй.

Багшийн энэхүү номдоо бичсэн нэг чухал санааг эшлэн авч үзэх нь чухал гэж үзлээ. Учир нь манай зарим хүмүүс монголд хоёр танхимт парламент байгуулж байсан бэлэн туршлага бий, парламентын хяналтыг бэхжүүлэхэд хоёр танхимт парламент илүү ач холбогдолтой тул Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулж үүнийг хуульчлах шаардлагатай гэж ярьж, бичдэг. Харин Б.Чимид багш энэ талаар юу гэж дүгнэснийг дор сийрүүлбээс:

“Монголын Богд хаант засгийн үед сонгуулийн оронд олон язгууртны угсаа залгамжлах ёс дээр дооргүй ноёрхож байв. 1914 оноос Улсын Дээд, Доод хурал байгуулсан ч Дээд хурал нь сайд, ноёд, дээд зиндааны лам нарыг албан тушаал, зэрэг дэвээр нь оролцуулан бүрдүүлдэг. Доод хуралд яам, газрын бичиг, цэргийн түшмэлүүдийг томилон суулгадаг (Ж.Галбадрах, Ү.Дэлгэрмаа, Э.Жавзандулам, 2003) , суухгүй бол торгодог байжээ. Дээд Хурал хаанд зөвлөх эрхтэй, Доод хурал санал шийдвэрээ Дээд хуралд хянуулдаг байв. Энэхүү хоёр хурал нь сонгуулийн бус, хууль тогтоох эрх мэдэлгүй тул парламент биш байсныг одооныхтой хольж хутгуузай” (Б.Чимид, 2008, х. 26) гэжээ.

Монголын сонгуулийн тогтолцооны хөгжлийн эхний хоёр үеийг нэгтгэн “өмнөх сонгуулийн тогтолцоо нийгэм, улс төрийн ач холбогдол, үр дүн нь түүнийг тунхагласан хууль тогтоомжоос төдийгүй, оршин буй улс төрийн тогтолцоо, юуны өмнө улс төрийн дэглэмээс шууд хамаардгийг нотолсон сургамж үлдээжээ” (Б.Чимид, 2008, х. 28) гэж дүгнэснийг хуучнаа санагалзан, өрөөсгөлөөр дөвийлгөн магтан сайшаагчид анхаармаар л бодогдлоо. Тухайн үед сонгууль ард түмэн шууд хүсэл зоригоо илэрхийлэх хууль ёсны хэлбэр болох чанараа олж чадаагүй байсан.

Улмаар ардчилсан анхны сонгууль (1990 он) явуулах болсон үндсэн шалтгаан, үйл явцын талаар гаднаас ажиглагчийн бус үйл явдлын дунд нь байж, оюун санааны манлайлагчдын нэг байсны хувьд одоо болон ирээдүйнхэнд маш ойлгомжтой дүрслэн

үлдээжээ. “Ирсэн замаа эргэж хараагүй хүн, буцахдаа гэрээ олохгүй” гэсэн ардын мэргэн үгийг бидэнд сануулаад өмнөхөө мэдэхгүй бол өнөөдрийн өнгө төрхийг үндсээс нь олж харахгүйг онцолсон байна.

Тухайн үеийн үйл явцыг түүхэн баримтад тулгуурлан 1980-аад онд социализм мухардалд орсон үеэс эхлэн Ардын Их Хурал засаг төрийн дээд байгууллагын хуучин тогтолцоог зарчмын хувьд халж, шинийг тогтооход чиглүүлэн “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”-ийг батлан гаргаж, зарчмын ямар ямар өөрчлөлт оруулах болсныг тоочин харуулсан нь үнэ цэнтэй.

Сонгуулийн хуулийн шинэчлэлийн тухайд өмнө тус тусдаа байсан хэдэн хуулийг халж, тэр үеийн гурван шатны (улс, аймаг, сум, хот район) Хурлыг “Ардын депутатуудын хурал” гэсэн нэрэнд “багцалж” 1990 онд “БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хууль” гэсэн төрөлжсөн нэг хууль гаргаж мөн оныхоо 6 дугаар сард уг хуулийн дагуу сонгууль явуулсан.

Энэхүү хуулиар бэхжүүлсэн сонгуулийн тогтолцооны зарчим, журам өмнөхөөс үзэл баримтлалын ялгаатай болохыг багш дараах хэдэн зүйлээр онцолсон байдаг. Үүнд:

- “Сонгогчид нийтийн, шууд, тэгш эрхийн зарчмаар саналаа нууцаар гаргаж оролцох журам нэрийн хувьд давтагдсан боловч зарчмын шинэ агуулгатай болов.
- Иргэдийн сонгох, сонгогдох эрхийг нэгэн адил 18 наснаас эдлүүлэхээр тогтоосон.
- Тэгш эрхийн хувьд тэр үеийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж бүрээс, хотуудад адил тооны хүн ам бүхий тойрог бүрээс нэг депутат сонгох болов.
- Сонгуулийн нэг намын захиргаадлаас ангижруулж олон нам, эвсэл хөдөлмөрийн болон нутаг дэвсгэрийн хамт олон, гишүүнчлэл бүхий олон нийтийн байгууллага зэрэг сонгогчдын бусад нэгдлээс нэр дэвшүүлэн өрсөлдүүлэх зарчимд шилжсэн нь агуулгын хамгийн гол өөрчлөлт нь юм.

Өөрөөр хэлбэл нэг тойрогт нэг мандатын төлөө улс төрийн олон нам, сонгогчдын бүлгийг төлөөлөсөн хэм хэдэн хүнийг өрсөлдүүлэн сонгох болов.

- Сонгуулийг сонгогчдын дийлэнх олонх (гуравны хоёроос доошгүй) нь оролцсон бол хүчинтэйд тооцож, тэдний ердийн олонхийн санал авагчдыг сонгогдсонд тооцохоор шийдсэн зэрэг онцлогтой” (Б.Чимид, 2008, х. 33).

Дээрх онцлогуудаас сонгогчдын тэгш эрхийн зарчмын талаар хувийн зүгээс бяцхан тодотгол нэмэрлэе. Сонгогчдын тэгш эрхийн зарчим бол ардчилсан сонгуулийн гол зарчмуудын нэг бөгөөд нийт сонгогчид сонгуульд тэгш эрхтэй оролцоно гэсэн утгатай. Сонгуулийн эрх зүйд тухайн зарчмын агуулгыг дараах дөрвөн утгаар задлан авч үздэг. Үүнд: 1.Сонгогч бүр нэг саналын эрхтэй ба санал бүр ижил жинтэй, хэн нэгний нэг санал бусдаас илүү ач холбогдолтой байх учиргүй; 2.Сонгуульд тэгш нөхцөлтэй оролцох – сонгуулийн идэвхтэй эрх бүхий бүх иргэд саналаа өгөх тэгш боломжоор хангагдана. Нас, хүйс, үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, нийгмийн байдал гэх мэт аливаа шинжээр ялгаварлал гаргахыг хориглодог; 3.Сонгуулийн тойрог байгуулахад тэгш эрхийг хангах – тойрог нь ойролцоо тооны хүн амтай байвал өөр өөр тойргийн сонгогчид сонгуулийн дүнд тэгш нөлөөтэй байх; 4.Сонгуулийн идэвхгүй эрхтэй буюу нэр дэвшигчид хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд сонгогдох тэгш эрхтэй байна. Эндээс үзвэл 1990 онд сонгуулийн хууль гаргаж байх үед манайд тэгш эрхийн зарчмыг тойрог байгуулах үед илүү харгалзан үзэж байсан бололтой.

Ардчилсан анхны сонгуулийн талаар “АИХ-ыг анх удаа олон нам, бүлгийн оролцсон олонхын (мажоритар) зарчмаар, Улсын Бага Хурлыг АИХ-ын депутатууд төлөөлөн сонгогчид маягаар хувь тэнцүүлэх (пропорциональ) зарчмаар сонгох анхны туршилт болсон нь энэ сонгуулийн гол онцлог юм” (Б.Чимид, 2008, х. 32) хэмээн тодотгоод, “эцсийн дүнд энэ сонгуулийн зорилго нь

Монголын түүхэнд анх удаа олон улс төрийн нам, бүлэглэл, хамт олныг нэг тойрогт нэг мандатын төлөө өрсөлдүүлэн иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэг дээрээ хангахад оршиж байв” (Б.Чимид, 2008, х. 33) гэж тодорхойлжээ.

Түүнчлэн Ардын Их Хурал ба Улсын Бага Хурлыг ардчилсан үндэслэлээр олон намын оролцоотойгоор бүрдүүлсэн нь анхны ардчилсан сонгуулийн гол үр дүн, сонгуулийн өнөөгийн тогтолцооны суурь болсон ач холбогдолтой гэж дүгнэсэн.

Ер нь Б.Чимид багш аливаа юмс үзэгдлийн хөгжлийг үечлэн харуулахдаа голлон түүний агуулга, мөн чанарыг шалгуур болгодгийг мөхөс би ажигласан. Өмнөх номын уншлага дээр ч Үндсэн хуульт ёсны хөгжлийг мөн л ийнхүү ангилсан талаар бид сонсож байсан. Манай ихэнх судлаачид голлон хронологи буюу он цагийн хэлхээсийг шалгуурлан үечилж ирсэн, одоо ч тааралддаг. Энэ нь асуудлын утга учир, шалтгаан гээд нарийн ширийнийг нээн харуулахад учир дутагдалтай буюу тоочин нурших нь өнгөц танин мэдэхүйн л ач холбогдолтой юм. Иймээс Б.Чимид багшийг хууль зүйн шинжлэх ухааны судалгаанд шинэлэг хандлага, судалгааны аргыг анхлан нэвтрүүлсэн эрдэмтэн гэж хүлээн зөвшөөрөхөөс аргагүй билээ.

Хоёрдугаар бүлэг 8 зүйл, 16 дэд зүйлтэй. Үүнд: Сонгуулийн талаар илэн далангүй хүүрнэж, сонгуулийн тухай ойлголт, сонгуулийн эрх зүй, түүний эх сурвалж, иргэдийн сонгох, сонгогдох эрх, сонгуулийн эрх зүйн зарчим, зарчмын тогтолцоо, Улсын Их Хурлын сонгууль, Улсын Их Хурлын сонгуулийн төрөл, зүйл, саналаа өгөхийн учир холбогдол, сонгуулийн процесс, түүний зохицуулалтын талаар дэлгэрэнгүй авч үзсэн байна.

Үүнээс үзвэл төрийн байгууллагуудыг байгуулах үйл явцын төвд нь мэдээж иргэдийн сонгуулийн эрх байж, өөрөөр хэлбэл тухайн эрх нь төрийн засаглал, эрх мэдлийг үүсгэгч шинжтэй болохыг илэрхийлж байна. Төрийн байгууллагыг сонгох бүх нийтийн сонгууль нь түүний үйл ажиллагаанд ард түмний хяналт

тавьж үнэлгээ өгөх маш өргөн боломж олгодог хэрэгсэл байдаг.

Б.Чимид багш 1992, 1996, 2000, 2004 оны сонгуульд сонгогчдын оролцсон тоо баримтыг (Б.Чимид, 2008, х.38) хүснэгтээр харуулаад зөвхөн дээрх дөрвөн сонгуулийн тухайд нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын 4.4-17,8 хувь нь сонгуульд (санал хураалтад) оролцохгүй байгаа, үүнд олон шалтгаан бий хэдий ч оролцооны хувийн жин сонгууль бүрээр буурах хандлагатай байгаад санаа зовнин бичиж байжээ.

“Сонгуульд оролцохгүй болох энэ “өвчнийг” “абсентеизм” гэж оношилдог. Тэр нь улс төрийн хямралын нэг шинж тэмдэг юм” (Б.Чимид, 2008, х. 38) гэжээ. Үнэхээр ч Үндсэн хуулийн эрх зүй болон улс төр судлалын шинжлэх ухаанд “абсентеизм” бол сонгуулийн санал хураалтад сонгогчид оролцохоос зайлсхийсэн улс төрийн үзэгдэл хэмээн тодорхойлдог. Түүнээс зайлсхийх, тархалтыг бууруулах зорилгоор улс орнууд эерэг (санал хураалтад оролцсон сонгогчдод улсын төсвөөс мөнгө төлөх, ээлжийн амралт дээр сонгуульд оролцсон өдрийг нэмж амраах г.м.), сөрөг (торгох, төрийн албанд ажиллах эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах г.м.) шинжтэй эрх зүйн зохицуулалтын арга хэрэглэдэг билээ (Д.Солонго, 2003, х. 5-6).

Б.Чимид багш сонгуулийг хялбархнаар ойлгож огт болохгүй дээ гээд:

“Сонгууль гэдэг улс төр,

Сонгууль гэдэг ардчилал,

Ардчилал гэдэг ард түмний засаг,

Ард түмний засаг гэдэг улсаа эзэгнэн захирах ёс. Үүний төлөө л сонгууль байдаг” (Б.Чимид, 2008, х. 39) хэмээн Сонгууль гэж юу вэ? гэсэн асуултын хариуг товчхон бөгөөд тодорхой өгсөн байдгийг эргэн санахад таатай байна. Үүнтэй холбоотой багшийн хэлсэн бас нэг тодорхойлолт уг номд оржээ. Тухайлбал,

“Сонгууль нь:

1. Ард түмэн бүрэн эрхт байдлаа үндэслэн улс төрийн хүсэл зориггоо шийдвэрлэх чанартайгаар илэрхийлэх хэлбэр;
2. Засаг төрийн төлөөлөх байгууллагыг тодорхой хугацаагаар шинэтгэн байгуулах үндсэн арга;
3. Засаг төрийн хэргийг төлөөлөгчдөөрөө дамжуулан жолоодох буюу түүнд оролцох арга зам мөн” (Б.Чимид, 2008, х. 40) гэсэн байна.

Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн нэг дэх хэсгийн заалтад зарчмын шинжтэй гүн утга, санаа шингэснийг тэмдэглээд түүнээс “сонгож байгуулсан” засгийн тухай онцолсныг сийрүүлбээс:

“Засаг гэдэг үг олон салаа утгатай ч эрх зүйн утга нь нэг. **Хүмүүс тэдний тодорхой хэсэг бүлэг, улмаар улс гүрэн бүхэлдээ эцсийн дүнд тухайн нийгэмдээ зонхилж буй хүсэл зоригт захирагдахыг засаг гэнэ.** Товчхондоо нэг нь нөгөөг хүслээрээ захирах эрх мэдэл юм. Засгийг “эрх мэдэл” гэх нь бий. Хууль зүйн тусгай нэр томьёо болж байгаа нь тэр” (Б.Чимид, 2008, х. 39) гэжээ.

Б.Чимид багш мэргэжлийн тусгай нэр томьёог оновчтой сонгон хэрэглэх, юмс үзэгдлийг мөн зөв оноон нэрлэх тал дээр үнэхээр гарамгай байсныг бид бэлхнээ гэрчилнэ. Тухайлбал, энэхүү номын 39 дэх талд “... амьдрал дээр засгийг эрх мэдэл гэдгээр буулгах нь илүү оновчтой. Жишээ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь дөрөв дэх засаг гэснээс “эрх мэдэл” гэх нь ерөөсөө бусдыг захирдаггүй, харин хянаж шүүмжилдэг хэрэглүүр болоход нь нийлэмжтэй юм” гэсэн байгаа.

Дурдалгүй орхиж боломгүй бас нэг чухал санаа олж харснаа хуваалцъя. Тухайлбал, “Засгийг” засгийн газар гэдэгтэй хутган ярих нь бүр ч хазгай. ... Монгол нь парламентын засагтай учир “хоёр засаг” болгож орхисноороо буруу юм. ... засгийн газар нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Парламентыг төр гэж ойлгодог ч буруутай. Тэр нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж,

хуулиар улсаа жолоодно. Иймээс парламентын засагтай гэдэг. Эдгээр нэрийг нийлүүлэн **“төр засаг”** гэх биш, **“засаг төр”** гэдэг нь **“өргөн”** утгаарх **“Government”** гэдэгтэй дүйдэг уламжлалт хэллэг” (Б.Чимид, 2008, х. 40) гэснийг өнөө цагт болон цаашид ч харгалзан нэг мөр хэвшүүлмээр л санагддаг.

“Сонгуулийн харилцааг зохицуулж байгаа хууль, түүнчлэн эрх зүйн бусад хэм хэмжээний нийлбэрийг сонгуулийн эрх зүй гэнэ. Тэдгээр хэм хэмжээ ба түүнийг ойлгож, хэрэглэж байгаа нийгмийн ухамсар, практикийг бүхэлд нь сонгуулийн тогтолцоо гэж ойлгоно” гэснээс “сонгуулийн тогтолцооны” талаарх тодорхойлолт уншигч олны анхаарлыг татсан гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ багш энэ тухай жичид нь авч үзсэн байна билээ. Энэ тухай бид ч хөндөх болно.

Уг бүтээлд сонгуулийн эрх зүйн эх сурвалжийг өргөн ба явцуу утгаар нь эрх зүйн хэм хэмжээг үндэсний болон олон улсын төвшинд ойлгомжтой тайлбарлан таниулсан байна.

Улмаар “сонгуулийн эрх зүйн амин сүнс нь иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрх юм гээд эдгээрийг сонгуулийн идэвхтэй, идэвхгүй эрх гэж ангилах ёсон бий” (Б.Чимид, 2008, х. 45) гээд “... нэр дэвшигч хийгээд сонгуультан амин хувьдаа ашиг олдог, тушаал ахидаг утгаар нь ташаа ухаарвал идэвхгүй эрхийг “идэвхтэй” (өөрт нь хэрэгтэй) юм шиг сольж ойлговол инээдэмтэй хэрэг болно” гэсэн нь төөрөгдөж, төөрөгдүүлж буй хүмүүст сургамжтай л санаа аж.

“Зарчим”-ын талаарх эргэцүүлээ бодит амьдрал дээрх ойлголтоос эхлээд “сонгуулийн тогтолцоонд, түүнийг зохицуулдаг эрх зүйд сонгогчийн эрхийг эдлүүлэн хангахад тус бүрд нь тохирсон бодлого баримталдаг. Түүнийг л зарчим гээд байгаа юм” (Б.Чимид, 2008, х. 47) гэж ой тойнд шингэтэл тодорхойлжээ. Эдгээр “... зарчмыг хуульчилж тууштай баримтлах нь үнэлж баршгүй ач холбогдолтой. Уул зарчим нь нийгмийн бодит харилцааг тусгах бөгөөд иргэд, тэдний сонгуулийн нэгдлүүдийн болон сонгуулийг

бэлтгэх, зохион байгуулах, нийт байгууллагын үйл ажиллагааны **хууль ёсны** хийгээд **шударга ёсны үндсэн шалгуур** болдог байна. Зарчмаас хазайвал замаа алдана. “Туушгүй хүн тугалган жадтай адил” гэдэгтэй энэ үг холбоотой” (Б.Чимид, 2008, х. 47) гэж онцолсныг эргэн санахад илүүдэхгүй буй заа.

Түүнчлэн сонгуулийн эрх зүйн зарчмын иж бүрэн шинжийг нэрлэн бичсэн нь онол, практикийн ач холбогдолтой бөгөөд хаа сайгүй тааралдаад байдаггүйг 40 гаруй жил Үндсэн хуулийн эрх зүй, Сонгуулийн эрх зүйн хичээлд бэлтгэн зааж, судалгаа хийж ирсэн хүний хувьд нотлон хэлж чадна. Тухайлбал, Сонгуулийн эрх зүй нийтийн эрх зүйд хамаардаг учир зарчим нь:

- 1.Бүх талын, нийтээр хүлээн зөвшөөрсөн заавал биелэгдэх тулган заасан (императив) шинжтэй
- 2.Сонгуулийн эрх зүйн янз бүрийн үүсэл, зарчмын үүрэг, ач холбогдлыг тусгасан өвөрмөц үүрэгтэй;
- 3.Сонгуулийн цогц чанарыг тусгаж харилцан уялдаатай хэрэглэдэг;
- 4.Сонгуулийн харилцааны зохицуулалтын эрх зүйн механизмыг бүрэлдүүлдэг үндсэн хэмжээс болдог;
- 5.Сонгуулийн эрх зүйг Үндсэн хуулийн эрх зүйн дэд салбар болтол хөгжүүлэх чиглэлийг тодорхойлдог” (Б.Чимид, 2008, х. 47) гэжээ.

Б.Чимид багш “... Бид багадаа “Менделеевийн үелэх систем”, томорсон хойноо “дэлхийн хоёр систем” гэж хүртэл хэлж сурсан. Систем гэдэг “тогтолцоо” гэсэн монгол үгтэй яг тохирдог. Тэгээд ч “сонгуулийн тогтолцоо” гэж байгаа юм” (Б.Чимид, 2008, х. 49) гэжээ. Сонгуулийн тогтолцоо бол яах аргагүй аль ч улсын улс төрийн амьдралын чухал бүрдэл хэсгийн нэг мөн. Чухам түүний тусламжтайгаар иргэд төрийн хэрэгт оролцох эрхээ эдэлдэг. Сонгуулийн эрх зүйд сонгуулийн тогтолцоо гэх нэр томьёо нь өргөн, явцуу хоёр утгаар хэрэглэгддэг. Багш ч хоёр утгаар нь дэлгэрэнгүй авч үзсэн байна. Өмнө нь Б.Чимид багшийн өгсөн

сонгуулийн тогтолцооны тодорхойлолтод анхаарлаа хандуулахыг хүсэж байсан. Дахин давтал: "... Тэдгээр хэм хэмжээ ба түүнийг ойлгож, хэрэглэж байгаа нийгмийн ухамсар, практикийг бүхэлд нь сонгуулийн тогтолцоо гэж ойлгоно" хэмээн өргөн утгаар нь, мөн "олонхийн тогтолцоо бол ... олонхийн саналаар нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог арга юм" (Б.Чимид, 2008, х. 51) гэж явцуу утгаар нь тодорхойлсон нь сонгуулийн эрх зүйд түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр хоёр утгыг Б.Чимид багш ч дэмждэгийг харуулж байна.

Түүнчлэн "Сонгууль бол угтаа шууд ардчиллын гол хэлбэр юм. Иймд сонгуулийн аль ч тогтолцоог² (суудал хуваарилах аргыг) хэрэглэсэн сонгогчдын шууд оролцоог хангах үндсэн зорилгоос гажиж болохгүй" (Б.Чимид, 2008, х. 55) гэж анхааруулж байжээ. Харамсалтай бид хувь тэнцүүлэх (пропорциональ) аргаар суудал хуваарилах нь шууд сонгох зарчимтай харшилна гэж ойлгож дүгнэсээр ирснийг Үндсэн хуулийн цэц 2022 оны 01 дүгээр тогтоолоороо залруулж шийдвэрлэсэн нь үнэхээр сайшаалтай юм.

Тогтолцоо гэдэг нь өргөн утгаараа суурь ойлголт тул түүнийг өөрчилнө гэхээр л хүмүүс нэгэнт бүрэлдсэн сонгуулийн тогтолцоог орвонгоор нь эргүүлэх мэтээр сэтгэн сөргөөр хүлээн аваад байх шиг. Харин явцуу утгаараа суудал хуваарилах л арга. Энэ тохиолдолд тогтолцоо хэмээн нэрлэх нь зохимжтой эсэхэд эргэлздэгээ нуух юун. Гадаад үгийг бүгдийг нь заавал монгол хэлнээ буулгамаар бол өөр өөрөөр нэрлэж хэвшвэл утгаа алдахгүй, олон түмнийг ч төөрөгдүүлэхгүй байхад тустай гэсэн санааг энэ дашрамд хувийн зүгээс нэмэрлэе.

Улмаар "хуулийг материаллаг (агуулгын) болон процессын (хэлбэрийн) хэмээн ангилдаг, энэ нь "угтаа хуулийг хуулиар биелүүлдэг гэсэн үг" (Б.Чимид, 2008, х. 69) гээд үүнийгээ дор

² Сонгуулийн систем /тогтолцоо/ гэдэг нь явцуу утгаараа суудал хуваарилах арга. Д.Солонго, 2003, х. 110 дэлгэрүүлж үзнэ үү

“агуулгын хуулийг хэлбэрийн (үйл явцын) хуулиар дамжуулан хэрэгжүүлнэ гэдэг юм” (Б.Чимид, 2008, х. 69) , “сонгох, сонгогдох эрх нь агуулга; сонгууль явуулах нь үйл явц; түүнийг хуулиар зохицуулах нь үйл явцын эрх зүйн журам гэж болно” хэмээн тодорхой жишээн дээр дэлгэрүүлж тайлбарласан нь эрх зүйн онолын ач холбогдолтой билээ.

Энэ номын гуравдугаар бүлэг 5 зүйл, 2 дэд зүйлтэй. Үүнд: Тойрог гэж юу ба түүний үүрэг, тойрог хэдэн янз байдаг, түүнийг байгуулахад юуг харгалздаг, сонгуулийн хэсэг ба таны орон гэр, сонгуулийн хэсэг гэж юу болох, түүнийг хэрхэн байгуулах талаар авч үзжээ.

“Сонгуулийг нутаг дэвсгэрээр зохион байгуулдаг. Улсын Их Хурлын сонгуулийн хувьд улсын нутаг дэвсгэрийг тойрогт, тойргийг хэсэгт хуваана” гээд “тойрог бол “тулалдааны гол талбар” юм. Энд л та сонгох, сонгогдох эрхээ эдэлж хэрэгжүүлдэг”, “... **тойрог бол сонгуулийн ажлын зохион байгуулалтын гол хэлбэр мөн**” (Б.Чимид, 2008, х. 81) гэж тодорхойлоод тойрог ямар үүрэгтэй талаар:

- “сонгогчдыг оршин суугаа нутаг дэвсгэрээр нь хуваарилж зохион байгуулах;
- сонгуулийн өмнөх цогц үйл ажиллагааг чиглэсэн зорилготой төвлөрүүлж явуулах;
- сонгогчдоос өөрсдийн төлөөлөгчөөр сонгох хүнээ нийтлэг ашиг сонирхлын дагуу тодруулан саналаа илэрхийлэх;
- сонгогчдын саналыг нэгтгэн дүгнэж, сонгогдогчдыг тодруулах;
- улмаар сонгогдсон гишүүнтэй холбоотой байж УИХ, ИТХ-тай харилцах гол суваг, зохион байгуулалтын үндсэн хэлбэр болдог” (Б.Чимид, 2008, х. 83) гэж маш цэгцтэйгээр эрэмбэлж өгчээ.

Түүнчлэн тойргийн төрөл зүйлийг нэгдмэл, нэг мандаттай, олон мандаттай гэж ангилж тус бүрээр тайлбарласан нь Үндсэн

хуулийн эрх зүй, сонгуулийн эрх зүйг эхлэн суралцагсдад болон иргэдэд ихээхэн ач тустай билээ.

Б.Чимид багш “Тойрог байгуулахдаа сонгуулийн зарчмын тухай онолын үндэслэлтэй шалгуурыг харгалзах ба хуульд заасан шаардлагыг баримтална” гээд онолын хувьд бол:

- сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хангах;
- үүний тулд хүн амын тоо тойргуудад адил буюу ойролцоо байх;
- нэг сонгогч нэг тойрогт саналаа нэг удаа өгөх шаардлагыг хангах учиртай юм” (Б.Чимид, 2008, х. 84) гэж бичсэн нь юуны түрүүнд хууль тогтоогчдод хэрэгтэй санаа аж.

“Тойрог бол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчид, тэднийг дэмжигчдийн өрсөлдөөний талбар, сонгуульд ялж гишүүний (мандат) бүрэн эрхийг олж авах өлгий нутаг нь болно”. Тэгвэл сонгуулийн хэсэг нь уул тойргийн нутаг дэвсгэрийн нэгээхэн хэсэг юм” (Б.Чимид, 2008, х. 88) гээд “... сонгуулийн хэсэг байгуулж ажиллуулахын гол зорилго нь **“сонгогчдын санал авах, тоолох”** ажлыг төвлөрүүлж зохион байгуулах явдал юм” (Б.Чимид, 2008, х. 89) гэж сонгуулийн тойрог, хэсгийн ялгааг тод томруунаар тоймлон харуулаад, “эцсийн дүнд хэсэг бол сонгогчдыг саналаа өгөх газраар нь нэгтгэсэн, сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийн нэгж мөн” (Б.Чимид, 2008, х. 89) хэмээн тодорхойлсон байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Б.Чимид багшийн бичиж үлдээсэн энэ их оюуны далайн дусал бүрийг үлдээлгүй дурдмаар байвч бүтээлийн уншлагын ерөнхий зорилго, илтгэлийн зөвшөөрөгдсөн хэмжээ, ярих цагаас хамаарч өөрт оногдсон гурван бүлгийн сэдвийн хүрээнд хамгаас чухал гэснийгээ л чадан ядан буулгалаа.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
2. М.В.Баглай (2001). Конституционное право Российской Федерации, Москва.
3. Эмхэтгэсэн Ж.Галбадрах, Ү.Дэлгэрмаа, Э.Жавзандулам. (2003), "Монгол Улсын Дээд, Доод хурал". Баримт бичгийн эмхтгэл (1914-1916).
4. Д.Солонго (2003). Төрийн эрх зүйн тайлбар толь, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

О.Машбат

*Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
шинжээч, хууль зүйн доктор*

“Сонгуулийн тогтолцоо ба эрх зүйн тухай юу мэдвэл зохих вэ?” бүлгийн тухай

“Чимидийн уншлага” энэ удаагийн арга хэмжээнд түүний бичсэн “Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй)” нэртэй 2008 онд хэвлэгдсэн номын “Сонгуулийн тогтолцоо ба эрх зүйн тухайд юу мэдвэл зохих вэ” бүлгийн талаар шүүмж бичихийг зохион байгуулагчийн зүгээс хүссэн билээ.

Багш энэ номыг анх “сонгогчдод хийгээд сонирхогчдод зөвлөсөн бяцхан “гарын авлага” бичье юү гэж эхэлснээ нэгэнт барьж авсан юм чинь хуулийг нь бүрэн хамарсан эрт, эдүгээгийн сонгох ёсыг харьцуулсан хэрдээ “бүрэндүү ажил” болгоё юү гэж зүтгэв” гэж номын зорилгыг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, жижигхэн “гарын авлага” болгох ёстой байсан боловч том, бүрэн “гарын авлага” болгожээ. Тиймээ багш “хууль өөрчлөгдвөл ном өөрчлөгдөхөд хүрэх талтай болов (ххi)” гэж онцолжээ.

“Сонгуулийн тогтолцоо ба эрх зүйн тухайд юу мэдвэл зохих вэ” бүлэг бол сонгуулийн тогтолцоо, сонгуулийн эрх зүйн тухай уншигчид танилцуулж байгаа гол бүлэг юм. Энд сонгууль гэж юу болох тухай тодорхойлоод сонгуулийн эрх зүйн үндсэн ойлголт, эх сурвалж, иргэдийн сонгох, сонгогдох эрх, сонгуулийн эрх зүйн зарчим, зарчмын тогтолцоо, сонгуулийн тогтолцооны олон хэлбэр, тэдгээрээс УИХ-ын сонгуулийн тогтолцооны хэлбэр, сонгуулийн

төрөл, зүйл, хэнийг шилж, юу хийлгэхийн тухайд гишүүний захирагдмал болон чөлөөт мандатын тухай, эцэст нь сонгуулийн үйл явцын тухай өгүүлжээ.

Номын онцлогийг товч тайлбарлая.

Гарын авлага болохын хувьд тогтсон ойлголтыг тайлбарласан

Тогтсон ойлголтын талаарх хууль зүйн тодорхойлолтыг тухайлан энэ бүлэгт дурдсан тул тэдгээрийг шүүмжлэх боломжгүй юм. Тухайлбал, эрх зүйн эх сурвалж гэдэгт сонгуулийн эрх зүйн хэм хэмжээ, түүний дотор Үндсэн хууль, сонгуулийн хууль, тэдгээрийг ойлгож, тайлбарлаж буй эрх зүйн ухамсар, мөн тэдгээрийг хэрэглэж ирсэн эрх зүйн практик хэмээн тодорхойлсон байна (Б.Чимид, 2008, х. 23-26) .

Түүнчлэн, УИХ-ын сонгуулийг ээлжит сонгууль, ээлжит бус сонгууль, нөхөн сонгууль, дахин сонгууль зэрэг ангилсан байна (Б.Чимид, 2008, х. 39). Эдгээр тодорхойлолт, ангилалтай маргах зүйлгүй юм. Үүгээрээ зарим талаар сурах бичгийн чанартай гэж үзэж болно.

Ойлголтыг хялбарчлах гэж оролдсон нь афоризмд хүргэсэн

Жирийн иргэнд ойлгомжтой болгохын тулд хялбарчлах гэж оролдсон, ийнхүү хялбарчлах гэж оролдсон нь багшийн хувийн үзэл бодлыг уудлан илтгэсэн байна. Үүний үр дүнд афоризм болохоор олон өгүүлбэр бий болжээ. Хамгийн тод жишээ нь:

Сонгууль гэдэг ардчилал

Ардчилал гэдэг ард түмний засаг

Ард түмний засаг гэдэг улсаа эзэгнэн захирах ёс.

“Агуулга нь ерөнхийдөө үнэн товч хүүрнэлийг афоризм гэнэ” гэдэг тодорхойлолтын хүрээнд дээрх өгүүлбэр багтахаар байна. Түүнчлэн,

Ард түмний бүрэн эрхт байдал юун түрүүнд сонгуулиар хамгийн тод илэрнэ (Б.Чимид, 2008, х. 21)

Сонгууль бол зайлшгүй, тогтмол, цаг үеэ олсон чөлөөтэй, өрсөлдөөн бөгөөд ард түмэн засгийн эрхэнд шууд оролцож, төлөөлүүлэн хэрэгжүүлэх хууль ёсны гол арга мөн. Тэр нь төр ёсны орчин үеийн загварын бүрэлдэхүүн хэсэгболсон ардчилсан төлөөлөх байгууллагыг төлөвшүүлэх зүй зохистой, хүчтэй хэрэглүүр болно (Б.Чимид, 2008, х. 21).

Улс төр хийгээд эрх зүйн холбоосыг тайлбарласнаараа онцлог

Үндсэн хуулийн зохицуулах зүйл бол улс төр юм. Манай хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн хэм хэмжээ, зарчим, ёс суртахууны үнэлэмж, тухайлан шударга ёс, хүний эрх талаас нь асуудалд ханддаг. Гэхдээ нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлын зөрчил, сонгуулийн хэлбэр, тэдгээрийн улс төрийн мөн чанарыг орхигдуулах хандлага байдаг.

Багшийн энэ ном, тухайлан энэ бүлэг улс төр судлалын талыг орхигдуулаагүй сайн талтай байна.

Зарим талаар хувийн үзэл бодолтой нь зөрчилдөх зүйл бас байна.

Сонгуульд оролцохгүй байгаа явдлыг “өвчин” бөгөөд “улс төрийн хямралын нэг шинж тэмдэг” гэж тодорхойлжээ (Б.Чимид, 2008, х. 19). Олон эрдэмтэн үүнтэй санал нийлдэг боловч үүний учир шалтгааны талаар эргэцүүлэхэд заавал “өвчин”, “хямралын шинж тэмдэг” байх албагүй юм. Европын олон оронд сонгуулийн ирц буурсаар ирсэн боловч төр засаг хямраагүй ирсэн бөгөөд нийгэм хангалуун болох тусам сонгуульд саналаа өгөхийг иргэний “үүрэг” гэж үзэхээ больсон тухай Ф.Костелька, А.Блэйз нар Сонгогчийн ирц дэлхий даяар буурч байгаа үеийн болон институцийн сурвалж (The Generational and Institutional Sources of the Global Decline in Voter Turnout) өгүүлэлдээ тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр эдийн засаг дахь төрийн оролцоо сүүлийн арван жил

огцом нэмэгдэж байгаа боловч иргэний хувийн амьдралд оролцох нь багасч, иргэний нийгэм тодорхой хэмжээнд хөгжиж байгаагийн үзүүлэлт гэж дээрх сонгуулийн оролцоо багассаныг үзэж болох юм. Дэлхий даяар гарч байгаа геополитикийн өөрчлөлт, холимог дайн, өнгөт хувьсгалын үр дагавараас болж иргэний нийгмийн цар хүрээг хумих явдал эргэн тойронд элбэг гарч, манайд ч зарим талаар үзэгдэж байгаа боловч манай иргэний нийгэм хүчтэй хэвээр гэдгийг энэ хаврын үйл явдал бэлхнээ харуулсан билээ.

Эцэст нь, дүгнэхэд багшийн энэ ном, тухайлан энэ бүлгийг бичсэн, найруулсан хэлбэр анхаарлыг маань татасныг дахин тэмдэглэмээр байна. Нийгэм, улс төрийн үзэгдлийг хууль зүйн шинжлэх ухааны нарийн ойлголтын хүрээнд гэхдээ энгийн үгээр тайлбарлаж, үр дүнд нь өвөрмөц афоризмаар дүүрэн болсон нь уншихад хөнгөн, ойлгоход дөхөм болжээ.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008), Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Д.Оргил

Улс төр судлаач

Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Б.Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын “Монгол оронд сонгуулийн тогтолцоо үүсэж хөгжсөн үе шат”, “Сонгуулийн тогтолцоо ба эрх зүйн тухайд юу мэдвэл зохих вэ?” “Сонгуулийн тойрог хэсэг хоёр” гэсэн эхний гурван бүлэг, хууль зүйн доктор, профессор Д.Солонгын “Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудалд” хэмээх тус гурван бүлгийг тоймлосон илтгэлд өөрт ногдсон үүргийн дагуу энэхүү санал дүгнэлтийг бичлээ. Ингэхдээ, “Сонгуульд суралцахуй” хэмээх бүтээл хэвлэгдсэнээс хойш сонгуулийн тогтолцоог 5 удаа өөрчилж, 3 өөр төрлийн сонгуулийн тогтолцоогоор байгуулагдсан 5 удаагийн УИХ-ын сонгуулийн цикл өнгөрснийг санан, тухайн үед зохиогчийн анхаарч, захиж байсан асуудал өнөөдөр хэрхэн өөрчлөгдсөн гэдэг талаас нь голчлон анхаарав.

Нэгдүгээр бүлэгт сонгууль үүссэн тоймын хүрээнд олон асуудал хөндөх боловч Монголд сонгох ёсны үүсэл хөгжлийг анхдугаар, хоёрдугаар, гуравдугаар гэж үечилсэн нь эрхгүй анхаарал татна. Монголд сонгуулийн тогтолцоог үүсэж хөгжсөний анхдугаар үе буюу 1923-1951, хоёрдугаар үе буюу 1951-1985, гуравдугаар буюу 1990 оноос хойш хэмээн үечилжээ. Сонгох сонгогдох суурь эрх олгогдсон эсэх, олон намын тэгш өрсөлдөөн бүхий сонгуулийн тогтолцоо байсан эсэхээс үл хамааран Монголд орчин цагийн сонгуулийн тухай үзэл санаа нэвтэрч байсанд нь

үндэслэн үечлэхдээ Хааныг ураг төрлийнхнөөс нь тодруулан угсаа залгамжлуулах ёсыг сонгууль гэж ойлгохоос, мөн Богд хаант засгийн үеийн сонгуулийн бус, хууль тогтоох эрх мэдэлгүй Дээд, Доод хурлаас заагласан нь (Б.Чимид, 2008, х. 24) ихээхэн оновчтой үечлэл болжээ.

Хууль зүйн доктор, профессор Д.Солонго “Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудалд” хэмээх илтгэлдээ “Хэн нэг эрдэмтний бүтээлээр уншлага зохион байгуулах нь мэдлэг олж авах, өмнө авсныгаа бататгах. ... эрдэмтдийн бүтээл нь цаг үеийнхээ соёл, шинжлэх ухааны төвшин, асуудлуудын илэрхийлэл байдаг тул эрин үедээ дүн шинжилгээ хийх зорилготой байдаг” (Д.Солонго, 2025) талаар дурджээ. Өнөөгийн байнгын ажиллагаатай парламент байгуулагдсанаас хойш, ялангуяа 1992 оноос хойш сонгуулийн талаар гарын авлага, дүн шинжилгээ, сурталчилгааны материал, тогтолцооны өөрчлөлтийн талаар судалгааны эх сурвалж арвин боловч 1990-1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулийн дагуу явагдсан сонгууль хүртэлх богино боловч ач холбогдолтой тэр зурвас үеийн талаарх эх сурвалж зарим нэг бүтээл, тухайн үеийн төрийн зүтгэлтнүүдийн дурсамж яриа зэргийг эс тооцвол тун хязгаарлагдмал байдаг. Сонгуульд суралцахуй бүтээлийн нэгдүгээр бүлэгт тус зурвас үеийн үйл явц, үндсэн шалтгаан, эрх зүйн үндэс, шинэ тогтолцооны талаар бодит баримттай, хувь тэнцүүлсэн тогтолцоогоор явагдсан санал асуулгын үр дүнг хүртэл хэрхэн хуваарилсан талаар дэлгэрэнгүй өгүүлсэн нь чухал эх сурвалж болжээ.

Сонгуульд суралцахуй номын хоёрдугаар бүлэгт сонгууль, сонгуулийн тогтолцоо, сонгох, сонгогдох эрх, сонгуулийн үйл явц, сонгуулийн дүн гаргах, зарлах гэх мэт аль ч гарын авлагад байдаг материалыг монгол хүн уншаад ойлгох, ухаарах, мэдлэг авахад зориулж энгийн монгол хэлээр өгүүлэхдээ, монгол ухаан сэтгэлгээг харгалзан үзэж, сонгуулийн үеийн монголчуудын дунд яригддаг энгийн хүүрнэлээр баяжуулан тайлбарлажээ.

Тухайлбал, “монголчууд бид “тогтолцоо” гэж өөд уруугүй ярина. Юм л бол “тогтолцоо буруу байна”, хариуцлагын тогтолцоо алга гэнэ. Буруугаа чихдэг нэг хонгил болж уу гэмээр” (Б.Чимид, 2008, х. 42) гэжээ. Өнгөрсөн жилүүдэд бид Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тусгаж, парламентын гишүүдийн тоог нэмэгдүүлэхдээ мөн л гажуудсан тогтолцоо, тогтолцооны шинэчлэл гэж ихэд яригдсаныг, ялангуяа улс төрчид хонгил угсрах, хонгилоор чирэх, хонгилыг нураана гэх мэт ярьдаг болсныг дахин санууштай.

“Сонгууль бол угтаа шууд ардчиллын гол хэлбэр юм. Иймд сонгуулийн аль ч тогтолцоог хэрэглэсэн сонгогчдын шууд оролцоог хангах үндсэн зорилгоос гажиж болохгүй” (Б.Чимид, 2008, х. 46) гэж анхааруулж байжээ. Харамсалтай нь бид хувь тэнцүүлэх (пропорциональ) аргаар суудал хуваарилах нь шууд сонгох зарчимтай харшилна гэж ойлгож дүгнэсээр ирснийг Үндсэн хуулийн цэц 2022 оны 01 дүгээр тогтоолоороо залруулж шийдвэрлэсэн нь үнэхээр сайшаалтай (Д.Солонго, 2025) талаар Солонго профессор тэмдэглэснийг мөхөс би зориуд дахин тэмдэглэж байна.

Сонгуульд суралцахуй номд “...Сонгуулийн “... явц нь шударга бус, үр дүн нь санаанд хүрэхгүй болохоор эгдүүцэн, оролцохоосоо ч ой нь гутаж хойш суудаг хэсэг бий болжээ. Сонгуульд иргэдийн оролцооны хувь хэмжээ буурсаар ирлээ. Бүр хувьдаа хүрэхгүй бол яана аа. Нийслэлийн ИТХ-ын 2004 оны сонгуульд сонгогчдын олонх оролцсон эсэх талаар эргэлзсэн мэдээ сэлт гарч л байсан” (Б.Чимид, 2008, х. 33) гэжээ. Үнэхээр ч ялангуяа аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн ирц багассаар багассаар, 2019 онд хуульд өөрчлөлт оруулан ирцийн босгыг авч хаясан төдийгүй, 2024 оны орон нутгийн сонгуулийн ирц улсын хэмжээнд 53,1 хувь, Улаанбаатар хотод 42,3 (Г.Мөрөн, 2024) хувьтай байсан нь ерөөс орон нутгийн хурлын легитим шинжид эргэлзээ төрүүлж, цаашлаад тус сонгуулийг тогтолцоо, зохион байгуулалтын хувьд дахин харах шаардлага үүссэнийг харуулж байна.

Тус номын гуравдугаар бүлэгт сонгуулийн тойрог, хэсэг гэж юуг хэлэх, хэрхэн байгуулах талаар авч үзжээ. Тойрог байгуулахдаа сонгуулийн зарчмын тухай онолын үндэслэлтэй шалгуурыг харгалзах ба хуульд заасан шаардлагыг баримтална гээд сонгуулийн тэгш эрхийн зарчим, үүний тулд хүн амын тоог тойргуудад адил буюу ойролцоо байх, нэг сонгогч нэг тойрогт саналаа нэг удаа өгөх шаардлагыг хангах учиртай (Б.Чимид, 2008, х. 71) талаар дурдсан. Мөн, сонгуулийн тойрог байгуулах нь зөвхөн хугацаа, зохион байгуулалтын чанартай асуудал биш, харин их бодож журамлаж шийддэг орон нутаг, иргэдийн болон улсын ашиг сонирхлыг хосолсон төвөгтэй асуудал билээ (Б.Чимид, 2008, х. 71) гэж тэмдэглээд сонгуулийн тойрог байгуулахад хүн амын тооллого, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжтэй уялдуулахын ач холбогдлыг онцолжээ. Зохиогч тус бүтээлд сонгуулийн тухай хуулийг тайлбарласан хэдий ч хот хөдөөгийн хүн амын үлэмж ялгаа 2008 оноос хойш улам даамжирсаар дээр дурдсан сонгуулийн тэгш эрхийн зарчим, тойрог байгуулахад хүн амын тоог харгалзах гэх мэт чухал зарчим өнөөдөр алдагдсаар буйг энд тэмдэглэе. Тухайлбал, 2024 оны УИХ-ын сонгуулийн 13 тойргийн арван нэгийнх нь сонгогчдын тоо сонгогчдын дундаж тооноос хамгийн багадаа 15 хувиар, Улаанбаатар хотын дөрвөн тойргийн сонгогчдын тоо 50 хувиар хэтэрчээ (УИХ-ын сонгууль ажиглах хорооны эцсийн тайлан, 2024, х. 8). Цаашид бид сонгуулийн тэгш эрхийн зарчим, нэг санал нэг үнэ цэн зарчмыг харгалзан сонгуулийн тойргийг улам боловсронгуй болгох ажил ялангуяа шинэ сонгуулийн тогтолцоог хэрэглэж буй үед улам бүр чухлаар тавигдаж байна.

Сонгуульд суралцахуй номыг бичих үед Монгол Улс олонхын буюу мажоритар сонгуулийн тогтолцоог ашиглаж байв. Сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульдаа суулгаж өгсөн өнөө цаг үед тойргийн болон жагсаалтын гишүүн гэх ойлголт улс төрчдийн дунд үүсээд буйг үгүйсгэх аргагүй. Б.Чимид багш

өнөө цагт энэхүү үзэгдлийг анзаарч байсан бол шүүмжилж, ард түмний төлөөлөгч болсон УИХ-ын гишүүдийн талаар чухалчлан авч үзэх нь гарцаагүй байсан буй за. Хоёр танхимтай парламентад танхимын эрх хэмжээ, хэлэлцэх асуудал, төлөөлөх төлөөлөл зэргээс хамаараад дээд, доод танхимын гишүүн гэх ойлголт байхаас бус нэг танхимтай парламентад тойргоос сонгогдсон, намын жагсаалтаас сонгогдсон УИХ-ын гишүүн гэж ялгаатай эрх ямба бүхий гишүүд байхгүй. Үндсэн хуульд, УИХ-ын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж заасныг зориуд тэмдэглэж үлдээхийг хүсэж энэхүү санал, дүгнэлтээ өндөрлүүлж байна.

---ooOoo---

Ном зүй.

1. Г.Мөрөн (2024, 10 11). Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн ирц улсын хэмжээнд 53.1 хувьтай өндөрлөлөө. Retrieved from <https://ikon.mn/n/39a8>
2. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгууль Ажиглах Хороо. (2024). 2024 оны УИХ-ын сонгууль ажиглах хорооны эцсийн тайлан.
3. Д.Солонго (2025). Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудал. Сонгуульд суралцахуй номын уншлагад тавигдсан илтгэл.
4. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

О.Дарханболд

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш

“СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ” (ТОГТОЛЦОО, ҮЙЛ ЯВЦ, ЭРХ ЗҮЙ) НЭГ, ХОЁР, ГУРАВДУГААР БҮЛГИЙН САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Бяраагийн Чимид багшийн (цаашид “зохиогч” гэх) номын уншлагыг уламжлал болгон хоёр дахь удаагаа зохион байгуулж буй нь түүний үйл хэрэг, оюуны өвийг түгээн дэлгэрүүлэх, гол үзэл санааг уламжлуулах ач холбогдолтой билээ.

Энэ удаагийн уншлагад сонгосон түүний “Сонгуульд суралцахуй” ном нь Ардчилсан Үндсэн хуульт ёс буюу ард түмний засаг гэдгийн утга учир, хэрэгжилтийн баталгаа болох сонгуулийн тогтолцоо, түүний үйл явц болон эрх зүйн үндсийг задлан шинжилж, олон өнцгөөс тайлбарласан бөгөөд бүтээлдээ өөрийнхөө онцлог, өвөрмөц арга барилыг шингээжээ. Энэхүү санал, дүгнэлт нь тус номын нэг, хоёр, гуравдугаар бүлгийн хүрээнд байх бөгөөд ач холбогдлыг өргөн хүрээнд илэрхийлэх боломжтой гэж үзсэн ойлголтыг сонгон авч бичсэн болно.

Зохиогч тус номын Нэгдүгээр бүлэгт сонгуулийн тогтолцооны

үүсэл хөгжлийг гурван үед хуваан авч үзсэн. Ийнхүү хуваан авч үзэх болсон шалтгааныг “тогтоцлооны зарчим, ардчиллын хөгжлөөр нь” (Б.Чимид, 2025, х. 5) гэсэн нь зохиогч аливаа асуудалд агуулгын шалгуур тавьж хандахын үнэ цэнийг эрхэмлэсэн болохыг харуулж байна. Мөн түүнчлэн “... эзэн хаанаа ард түмэн өрсөлдүүлэн сонгодог ... ёс ... байсангүйг түүх нотолжээ” (Б.Чимид, 2008, х. 5) гээд “Ер нь багцаалдан бүдүүвчлэх нь танин мэдэхүйн алдаанд хүргэх нигууртай” (Б.Чимид, 2025, х. 5) гэсэн. Түүний ийнхүү бичсэн хэв маягаас үзвэл нэгдүгээрт сонгуулийн хууль зүйн агуулгыг тодруулсан. Өөрөөр хэлбэл сонгуулийн тухай хэлэлцэхэд арчдиллын хөгжил, тогтолцооны зарчим гэсэн элементүүдийг авч үзэх нь зүйтэй болохыг илэрхийлсэн байна. Хоёрдугаарт, агуулгад тулгуурлан өгөөжтэй, үр дүнд хүрж болохуйц судалгааны арга зүйн үнэ цэнийг өөрийн бүтээлээр нотлон харуулжээ.

Тус номын Хоёрдугаар бүлэг дэх “Сонгуулийн эрх зүй, түүний эх сурвалж” гэх хэсэгт Зохиогч “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ыг онцолсон. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлд “сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй” (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 1966, 25 дугаар зүйл, b) гэсэн байна. Үүнээс үзвэл сонгууль нь 1) бүх нийтийн, 2) тэгш эрхийн үндсэн дээр, 3) нууцаар, 4) сонгогчид хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой, 5) жинхэнэ ёсоор, 6) тогтмол байх шинжийг хангах ёстой. Эдгээр элементүүдийг хангасан эсэхийг зохиогчийн зүгээс хуваан хураангуйлсан үечлэл түс бүрд нь авч үзэж болохоор байна.

Зохиогчийнхоор анхдугаар үе нь 1923-1951 оныг хамарна. Тухайн үеийн сонгуулийн тогтолцооны гол онцлог нь шууд бус олон шаттай, бүх нийтийн биш, саналаа ил гаргадаг, нэг нам жолоодон чиглүүлдэг байжээ. Энэхүү онцлогийг харгалзан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлд

заасан элементүүдийг шалгуур болгон авч үзвэл алийг нь ч хангахгүй болох нь илэрхий байна. Гэхдээ зохиогч “Монголд орчин цагийн сонгуулийн тухай үзэл санаа нэвтэрч байсны илрэл болно” (Б.Чимид, 2025, х. 6) гэснээс үзвэл сонгуулийн тогтолцооны үүсэл “анхдугаар үе”-эс эхтэй гэж үзсэн болохыг харуулж байна.

Хоёрдугаар үеийг зохиогч номондоо товч байдлаар “Энэ бүхнээс социалист төрийн сонгуулийн үйл ажиллагаа их нүсэр харагдавч шийдвэрлэгч бодит эрх мэдэл нь намд төвлөрсөн учир түүнийг хэлбэрдэлд орсон гэж байгаа хэрэг” (Б.Чимид, 2025, х. 9) гэж тодорхойлсон. Ийнхүү дүгнэснээс үзвэл шалгуур болгон авч үзсэн элементүүдээс тухайн үеийн сонгуулийн тогтолцоо нь нууцаар, сонгогчид хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой, жинхэнэ ёсоор байх шинжийг хангадаггүй байсан гэж үзэж болохоор байна.

Зохиогч гуравдугаар үеийн сонгуулийн тогтолцоог “1990 оноос эхлэн өдгөө үргэлжилсээр буй бөлгөө” (Б.Чимид, 2025, х. 9) гэсэн. Хэлэлцэгчийн зүгээс үүнтэй санал нийлж байгаа бөгөөд шалтгаан нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлд заасан элементүүдтэй холбогдоно. Учир нь тухайн үеийн сонгуулийн тогтолцооны зарчим нь “сонгогчид нийтийн, шууд, тэгш эрхийн зарчмаар, саналаа нууцаар гаргаж оролцох” (Б.Чимид, 2025, х. 13)-д чиглэсэн. Мөн түүнчлэн сонгуулийг нэг намын захиргаадлаас ангижруулахад анхаарал хандуулсан байна.

Монгол Улсад сонгох ёсон үүсэж хөгжсөнийг зохиогч ийнхүү үечилсэн нь сонгуулийн тогтолцооны агуулга, зарчимд тулгуурласан. Үүнийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакттай уялдуулан авч үзвэл Монгол Улсын хууль зүйн салбар төгөлдөржих чиглэлд хөгжих хүрээг тогтоох, түүхэн баримтуудаас сургамж авч үлдэхэд ач тустай гэж хэлэлцэгчийн хувьд үзэж байна. Энэ тухай илтгэгч хууль зүйн доктор, профессор Д.Солонго “Манай судлаачид голлон хронологи буюу он цагийн хэлхээсийг шалгуурлан үечилж ирсэн, одоо ч тааралддаг. Энэ

нь асуудлын утга учир, шалтгаан гээд нарийн ширийнийг нээн харуулахад учир дутагдалтай буюу тоочин нурших нь өнгөц танин мэдэхүйн л ач холбогдолтой юм. Иймээс Б.Чимид багшийг хууль зүйн шинжлэх ухааны судалгаанд шинэлэг хандлага, судалгааны аргыг анхлан нэвтрүүлсэн эрдэмтэн гэж хүлээн зөвшөөрөхөөс аргагүй билээ.” гэсэнтэй санал нэг байна.

Тус номын хоёрдугаар бүлгийн 2.1.2-т “Сонгууль гэж юу вэ?” гэсэн хэсэгт сонгуулийг ард түмний засагтай уялдуулан тайлбарласан. Тодруулбал, зохиогчийнхоор сонгууль гэдэг нь “жинхэнэ утгаараа: 1) ард түмэн бүрэн эрхт байдлаа үндэслэн улс төрийн хүсэл зоригоо шийдвэрлэх чанартайгаар илэрхийлэх хэлбэр, 2) засаг төрийн төлөөлөх байгууллагыг тодорхой хугацаагаар шинэтгэн байгуулах үндсэн арга, 3) засаг төрийн хэргийг төлөөлөгчөөрөө дамжуулан жолоодох буюу түүнд оролцох арга зам” (Б.Чимид, 2025, х. 21) юм.

Үүнийг хураангуйлбал, сонгууль гэдэг нь ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл бөгөөд төрийн байгууллыг шинэтгэн байгуулах, төрийн хэргийг жолоодох арга зам юм. Үүнээс “арга зам” гэсэн нь хэлэлцэгчийн анхаарлыг татсан юм. Учир нь Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд авч үзвэл Үндсэн хуульт ёс гэдэг нь: 1) Үндсэн хуулийн агуулга, 2) эрх мэдлийн уг сурвалж, 3) хэм хэмжээний эрэмбэ, 4) хэрэгжүүлэх баталгаа гэсэн дөрвөн шинжээр тодорхойлогдоно (Цэцийн тогтоол, 2024, №02, Үндэслэл хэсгийн догол 2). Үүнээс эрх мэдлийн уг сурвалж болон хэрэгжүүлэх баталгаа гэсэн хоёр шинж нь сонгууль гэдэг хууль зүйн ойлголттой шууд холбогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” (Монгол Улсын Үндсэн хууль, 1992, §3) гэж заасан. Үүнээс үзвэл сонгууль гэдэг нь ард түмний хүсэл зориг болохын хувьд эрх мэдлийн уг сурвалжаас улбаатайг Үндсэн

хуулиар тогтоожээ. Харин сонгуулийн тогтолцоо нь Үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх баталгааны илэрхийлэл гэж үзэж болохоор байна.

Эцэст нь дүгнэхэд Үндсэн хуульт ёсны нэг баталгаа бол сонгуулийн тогтолцоо ба түүний хэрэгжилт юм. Үндсэн хуулиар баталгаажуулсан сонгох, сонгогдох эрхийн бодит байдал тодорхой шаардлагыг хангах учиртай. Үүнийг материаллаг болон процессын хуулиар хэрэгжүүлнэ. Үүнд иргэд ч гэсэн хариуцлагатай хандах нь зүй ёсны хэрэг. Эрх зүйн хөгжил, ухамсрын түвшинтэй холбоотойгоор Монгол Улсад өнөөдөр ч гэсэн тулгамдаж буй асуудлууд бий. Үүнээс сонгууль дахь иргэдийн оролцоо, эдийн засгийн шалтгаантай шударга бус өрсөлдөөн, намуудын төлөвшлийн нөлөөлөл зэргийг дурдаж болно. Гэхдээ аль зүгт явж байгаагаа мэдэхийн зэрэгцээ өмнөх алдаагаа давтахгүй бол эрх зүйн хөгжил сайжран, төгөлдөржих чиглэл рүү хөтлөгдөх боломж нээлттэй байна. Сайн тохиолоор өнгөрснөөс үлдэх сургамж, хамгаалах ёстой үнэт зүйлийн учир шалтгааныг эрдэмтэн, мэргэд баримттайгаар шинжлэн судалж өнөө үед зориулан тэмдэглэн үлдээжээ.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2025). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол, “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай,” 2024.11.08, №02
3. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.01.13
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 1966, 25 дугаар зүйл, b

II

Сонгуулийн байгууллага

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Ж.Сүхбаатар

Сонгуулийн ерөнхий хорооны

Нарийн бичгийн дарга асан

Оршил

Бяраагийн Чимидийн уншлага: “Сонгуульд суралцахуй” сэдвийн хүрээнд судалгаа, хэлэлцүүлгийн маш сонирхолтой эрдэм шинжилгээний ээлжит хуралдаанд оролцож байгаадаа миний бие туйлын их баяртай байна.

Урьсан, оролцуулсан Та бүхэнд баярлалаа.

Бид шинэ Монголын ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид соён гэгээрүүлэгч (цаашид “зохиогч” гэх) Улс Монголынхоо төлөө төр, эрх зүйн салбарт хийж бүтээсэн гайхамшигт их үйлсийн оюуны өв сангаас нь уудлан шинжилж, шимтэн суралцах, түгээн дэлгэрүүлэх, тайлбарлан таниулах зорилгоор “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын уншлагын удаах нь “Сонгуульд суралцахуй” ном байхаар зохион байгуулагчид сонгосонд ихэд олзуурхан уг номоос надад оногдсон “Сонгуулийн байгууллага” сэдэвт илтгэлээ “Оршил”, “Сонгуулийн үйл явцыг эрхлэх, түүнд оролцох хоёрын ялгаа”, “Сонгуульд оролцогч байгууллагын төрөл, оролцоо”, “Сонгуулийн байгууллагын тогтолцоо”, “Дүгнэлт” гэж бүлэглэн авч үзнэ.

Зохиогч “Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй), УБ, 2008 он” бүтээлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн нэг

дэд салбар болох Сонгуулийн эрх зүйн асуудлыг анх удаа эрх зүй, практик хэрэглээ талаас нь нэгтгэн ойлгомжтой тайлбарлажээ. Энэхүү ном хэвлэгдэн гарснаас хойш 17 жил өнгөрч, ялангуяа манай сонгуулийн хууль тогтоомжид эрс өөрчлөлтүүд хийгдсэн.

“Энэ удаад сонгуулийн тогтолцоо, бэлтгэл, үйл явцыг зөвхөн эрх зүйн талаас нь хандаж гол төлөв одоо мөрдөж буй хуулийг тайлбарлах аргаар бичсэн тул хууль өөрчлөгдвөл ном “өөрчлөгдөхөд хүрэх” талтай болов.” (Б.Чимид, 2025, х. 16) гэж мэргэн зохиогч номын эхэнд хэдийнээ сануулж бичсэн хэдий ч өдгөө бидний хэлэлцэх илтгэлийн маань сэдвийн үндсэн агуулга, ач холбогдлыг бууруулахгүй юм. Учир нь, уг бүтээлдээ тогтолцоо, үйл явцын эрх зүйн үндсийг онолын өндөр түвшинд тодорхойлж үлдээсэн байна. Энэ талаар Дүгнэлтийн хэсэгт өгүүлэх болно.

I. “Сонгуулийн үйл явцыг эрхлэх, түүнд оролцох хоёрын ялгаа”

Зохиогч засаг төрийн төлөөлөх байгууллагын сонгуулийг улсын хэмжээний нийгмийн өргөн цар хүрээтэй нарийн дэгтэй нийлмэл үйл явц бөгөөд бараг бүх байгууллагыг хамардаг болохыг дурджээ.

Сонгуулийн байгууллагыг тодруулан харуулахын тулд сонгуулийн хууль тогтоомжид заасан эрх хэмжээгээр нь “сонгуульд оролцогч байгууллага”, “сонгууль эрхэлсэн байгууллага”(товчоор “сонгуулийн”) гэж бүлэглэн ангилсан байна (Б.Чимид, 2025, х. 91).

“Сонгуулийн байгууллага” нь сонгуулийг эхнээс бэлтгэн, хуулийн биелэлтийг эрхлэн зохион байгуулж, хянан зохицуулах, шалган дүгнэх эрх хэмжээтэй хууль ёсны байгууллага мөн бол “сонгуульд оролцогч байгууллага” нь сонгуулийн үйл явцын зөвхөн тодорхой үе шат, цувралд хамаатай ямар нэг тусгай үүрэг гүйцэтгэдэг аж. Тухайлбал, төрийн төв, орон нутгийн болон өөрөө удирдах байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, аж ахуйн нэгжийг хамааруулан үзжээ.

Ийнхүү зохиогч “нэг байгууллага нь эрхэлдэг, нөгөө нь

оролцдог” гэж ялгамжтай авч үзэж, үүрэг, хариуцлагын ялгааг онцолсон байна. Ингэснээр сонгуулийн үйл явцын тодорхой шатанд хэн юу хийх ёстойг зааглан танин мэдэж, сонгуулийг зөв хөтлөн явуулахад тустайг тайлбарласан.

Сонгуулийн байгууллага нь ардчилсан институцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд засаг төрийн хууль ёсны эрх мэдлийн эх сурвалж ард түмний хүсэл зоригийг баталгаажуулах механизм. Цаашид энэ талаар дараачийн хэсгүүдэд дэлгэрүүлэн шинжилнэ.

II. “Сонгуульд оролцогч байгууллагын төрөл, оролцоо”

Зохиогч сонгуульд оролцогч олон төрөл байгууллагуудаас жишээлэн Улсын Их Хурал, Засгийн газар, түүний орон нутгийн нэгж (Засаг дарга), Улс төрийн нам, эвсэл болон бусад байгууллагыг тухайн үеийн Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтаас эш татан авч үзжээ.

Монгол Улсын Их Хурал сонгуулийг товлон зарлахаас, нэгдсэн дүнг хэлэлцэж, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх хүртэл уг үйл явцыг эрх зүйн талаар зохицуулах нийтлэг зарчмын бүх асуудлыг хуульчлан шийдвэрлэдэг (Б.Чимид, 2025, х. 92).

Улсын Их Хурлын сонгуулийн тухайд, сонгууль зарлах, сонгуулийн зардлын хэмжээг тодорхойлох, нөхөн сонгууль зарлах, тойрог байгуулах, өөрчлөх, гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлыг УИХ хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хувьд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сонгуулийн байгууллагуудаас түүний гүйцэтгэлийг хангахад дэмжлэг үзүүлэх, зөрчлөөс сэргийлэх арга хэмжээ авдаг. Энэ нь тэдгээрийн Үндсэн хуулийн чиг үүргээс урган гардаг болохыг зохиогч тайлбарлажээ.

Түүнчлэн УИХ, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нутгийн

өөрөө удирдах байгууллага нь улс төрийн намын төлөөлөлтэй, үндсэн бүрэлдэхүүн нь сонгуульд аль нэг нам, эвслээс нэр дэвших буюу ухуулан оролцдог учир сонгуулийн үйл явцыг удирдахгүй буюу сонгуулийг бэлтгэж явуулах үйл явцад “хөндлөнгөөс хутгалдан оролцох ёсгүй” гэсэн зарчмын шаардлага бийг тэмдэглэсэн байна.

Зохиогч тухайн үеийн Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлээс “14.7.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллага нь сонгууль зохион байгуулахад энэ хууль холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд оролцоно.” (Б.Чимид, 2025, х. 93) гэснийг эш татан дурдсан байдаг. Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2019 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “14.16.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллага нь сонгууль зохион байгуулахад энэ хууль холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож, сонгуулийн зохих шатны байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, тэдгээрийн ажилд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.” гэж хуульчлан заажээ.

Дээр дурдсан байгууллагууд нь зөвхөн иргэдийн сонгуулийн эрхийг хамгаалах үүднээс хууль зүйн хүрээнд дэмжлэг үзүүлдэг. Иргэдийн төлөөлөгчдийн хурал гэхэд сонгуулийн хэсэг байгуулах, сурталчилгааны зүйл байрлуулах байршлыг тогтоож өгөх гэх мэт, тухайн шатны Засаг дарга сонгуулийн хорооны ажиллах байр, тээвэр, холбооны бусад шаардлагатай хэрэгслээр хангах, нэр дэвшигчдийн сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаанд тэгш дэмжлэг үзүүлэх, сум, дүүргийн Засаг дарга санал авах байр, бусад зүйлсийг бэлэн болгох зэрэг олон үүргийг хуулиар хүлээдэг.

Улс төрийн нам, эвслийн тухайд зохиогч сонгуулийн үйл явцад удирдлагын бус оролцооны үүрэгтэй байгууллага болохыг тэмдэглэсэн. Тэдгээр нь зөвхөн тус тусын сонгуулийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийг дэмжин сурталчилж сонгуульд ялахын төлөө олон нийтийг өөртөө татан оролцуулахад шууд чиглэсэн

хуулиар хориглоогүй арга хэмжээг зохион байгуулна, олон нийтийн хяналтыг тавьдаг гэжээ. Үүнээс “хуулиар хориглоогүй арга хэмжээг зохион байгуулна” гэсэн нь илтгэгчийн анхаарал татна. Өнөөгийн сонгуулийн хууль тогтоомж сонгуулийн сурталчилгаанд тавих хяналт, хязгаарлалт, хориглох үйл ажиллагааг өмнөхөөс үлэмж нэмэгдүүлсэн буюу өргөтгөсөн, цаашид ч улам нарийвчлан зохицуулах хандлагатай байгаа юм. Сонгуульд оролцогч нам, эвсэл нь сонгуулийн үндсэн оролцогч буюу иргэдийн болон намын гишүүдийнхээ үзэл бодол, ашиг сонирхлыг илэрхийлэн төлөөлж сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцдог.

Засаг төрийг бүрдүүлэх сонгуульд улс төрийн намууд үүрэг оролцоогүй байна гээд төсөөлөх боломж хомс. Тэдгээрийн үүрэг оролцоо нь ардчилсан төрийн тогтолцооны тулгуур баганын нэг болдог гэхээр дээр дурдсанчлан оролцооны байгууллага гэснээрээ онцгой ач холбогдлыг нь сулруулахгүй ба зохиогч нам, эвслийн сонгуулийн үйл явцад оролцох зарим гол ажилбаруудыг энд тухайлан дурджээ.

Сонгуульд оролцогч бусад байгууллагын хүрээнд сонгогчдын нэрийн жагсаалт гаргахад иргэний бүртгэлийн алба, санал тоолоход байлцах ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч, сонгуулийн сурталчилгаанд Олон нийтийн болон бусад радио, телевиз, нэр дэвшигчийн уулзалт, хурал, цуглаанд зориулж байр, танхим үнэ төлбөргүйгээр ашиглуулахад төрийн болон орон нутгийн өмчийн мөн түүний оролцоотой хуулийн этгээд, албан газар зэрэг байгууллагуудын зарим үүрэг оролцоог товч дурдаж, тэдгээрийн үүрэг тусгай шинжтэй, үүгээрээ сонгуулийн байгууллагаас ялгаатай гэж тодотгосон байна.

III. “Сонгуулийн байгууллагын тогтолцоо”

“Сонгуулийн байгууллага нь хуульд заасан хугацаагаар байгуулагдаж, сонгуулийг бэлтгэж явуулах ажлыг эрхлэн зохион байгуулдаг.” (Б.Чимид, 2025, х. 96) гэжээ.

Зохиогч сонгуулийн байгууллагын тогтолцоог тухайн үеийн хуульд зааснаар

- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо;
- Тойргийн хороо;
- Сонгуулийн тойргийн салбар хороо;
- Сонгуулийн хэсгийн хорооноос бүрдэнэ.” гээд УИХ-ын

2004 оны сонгуулиар Тойргийн хороо 76, салбар хороо 338, хэсгийн хороо 1645 байсныг дурджээ.

Өнгөрсөн хугацаанд хууль тогтоомж шинэчлэгдсэнтэй холбогдуулан сонгуулийн байгууллагын өнөөгийн тогтолцоог авч үзвэл:

- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо;
- Аймаг, нийслэлийн хороо;
- Сум, дүүргийн хороо;
- Сонгуулийн хэсгийн хороо;
- Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион

байгуулах төв болон салбар комиссоос бүрдэж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим хуудаснаас үзвэл УИХ-ын 2024 оны сонгуулиар аймаг, нийслэлийн хороо 22, сум, дүүргийн 339 хороо, хэсгийн хороо 2198, Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв 1, салбар 47 комисс ажиллажээ.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “14.1.Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороо, гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.”

Сонгуулийн байгууллагуудын салаа мөчрийг ерөнхийд нь сонгуулийн төв, орон нутгийн (байнгын биш, түр зуурын шинжтэй) байгууллага гэж ангилаад сонгуулийн тойргийн төрөл, бүтцээс хамааран сонгуулийн байгууллагын байршил, эрх зүйн байдал

өөрчлөгдөн хувьсаж байдаг хэмээн оновчтой дүгнэжээ.

Илтгэгчийн зүгээс зохиогчийн **Сонгуулийн ерөнхий хорооны тухайд** тусгайлан авч үзсэнийг хөндөхийн өмнө сонгуулийг удирдах байгууллагын талаарх олон улсын жишиг, хандлагыг товч хөндөх нь сэдвийн маань агуулгыг ойлгуулахад ач холбогдолтой гэж үзэв.

Сонгуулийг удирдах (менежментийн) байгууллагыг “улс орон бүрд сонгуулийн төв байгууллага, комисс, хороо, зөвлөл гэх мэт янз бүрээр нэрлэдэг боловч харьцуулсан судалгаанд эдгээрийг ерөнхийд нь сонгуулийн удирдлагын байгууллага гэж хэвшиж байна.” (Д.Бат-Эрдэнэ, 2024, х. 11)

Олон улсад сонгуулийг удирдах байгууллагыг гурван загварт ангилж бүлэглэх нь түгээмэл. Үүнд:

- 1.Бие даасан сонгуулийн байгууллагын загвар (Independent model) – жишээ: Өмнөд Солонгос, Энэтхэгийн сонгуулийн комисс гэх мэт Засгийн газрын бус бие даасан сонгуулийн байгууллага.
- 2.Засгийн газрын хандлагатай загвар (Governmental model) – сонгуулийг Яам буюу төрийн захиргааны бусад байгууллага зохион байгуулдаг. Франц, Итали зэрэг орнуудад хэрэглэгддэг.
- 3.Холимог загвар (Mixed model) – дээрх загваруудын хослуулсан зохион байгуулалт, бүтцийн загвар.

Бас тусгайлан “Шүүхийн хандлагатай сонгуулийн байгууллагын загвар” гэж ангилах нь ч үзэгддэг. Сонгуулийг удирдах, маргаан шийдвэрлэх ажиллагаанд шүүх, шүүгч давамгайл байдалтай оролцоно. Жишээ нь, Коста Рика, Латин Америкийн зарим орнуудад.

Манай улсын сонгуулийн байгууллага аль загварт хамаарах талаар илтгэгчийн байр суурийг Дүгнэлтдээ хуваалцах болно.

Зохиогч Сонгуулийн ерөнхий хорооны болон бусад түр хороодын эрх зүйн байдлын талаар Сонгуулийн төв байгууллагын

тухай хуульд заасныг үндэслэн тухайн үеийн хууль зүйн зохицуулалтаар тодруулан тоочсон байгааг Улс төрийн намын (шинэчилсэн найруулга) шинэ хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, хуулийн бусад олон нэмэлт, өөрчлөлтүүд сүүлийн жилүүдэд орсонтой холбогдуулан энд шинээр дурдах нь ач холбогдолтой гэж үзлээ.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар

“3.1. Сонгуулийн төв байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо мөн.

3.2. Сонгуулийн ерөнхий хороо /цаашид «Хороо» гэх/ нь Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага мөн.

3.3. Хороо нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.”

Уг хуульд зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь 9 гишүүнтэй. Тэдгээрийн 2 нь орон тооны, 7 нь орон тооны бус байна. Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно. Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно.

Хорооны эрх зүйн байдлыг түүний чиг үүрэг, бүрэн эрх илэрхийлдэг болохыг зохиогч онцолсон байна.

Сонгуулийн ерөнхий хороо дараах үндсэн чиг үүрэгтэй:

1. Сонгуулийн хуулийн биелэлтийг зохион байгуулах үндсэн дээр:

- Ард нийтийн санал асуулга;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль;
- УИХ-ын сонгуулийг эрхлэн явуулж, дүгнэх.

2. Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэглэх арга ажиллагааны журмыг тогтоох, мөрдүүлэх буюу нормчлон тохируулах;

3. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн орон нутгийн хороодыг удирдах;

4. ИТХ-ын сонгуулийг зохион явуулахад аргачилсан туслалцаа үзүүлэх;

5. Сонгуулийн үйл явц, түүнд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүжилтэд эрх зүйн хяналт тавьж зохицуулан маргааныг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх;

6. Сонгуулийн асуудлаар хүн амыг мэдээллээр хангаж лавламж, мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулж үйлчлэх, “сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах үйл ажиллагааг удирдах”(Илтгэгч нэмж оруулав). Эдгээрийг хэрэгжүүлэх тодорхой эрх, үүрэгтэй (бүрэн эрх) юм. Хураангуйлж томьёолбол сонгуулийн хуулийн биелэлтийг зохион байгуулах, сурталчлан мэдээлэх, сонгуулийн үйл явцыг аргачлан удирдах, нормчлон тохируулах, хянан шалгаж, маргаан шийдвэрлэх чиг үүрэг бүхий тусгай эрх хэмжээтэй гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болно. Тиймээс улс төрийн байгууллагуудаас хараат бус зарчмаар бие даасан байдалд ажиллана.

Энэ хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны үндсэн бүрэн эрхийг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд 15 хэсгээр тодорхойлжээ. Хураангуйлбал:

1. ард нийтийн санал асуулга болон сонгууль (хойшид зөвхөн “сонгууль” гэв) бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах;
2. сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
3. сонгуулийн бүх шатны хороодын үйл ажиллагааг нэгтгэн

- зохион байгуулах;
4. сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар төрийн зохих байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
 5. сонгуулийн зардлын төсвийг батлагдсан хэмжээний дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;
 6. сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах;
 7. сонгуулийн хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, баримт бичгийн загвар маягт батлах;
 8. сонгуулийн төв архивыг зохион байгуулах, үүнтэй холбогдуулан архивын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран сонгуулийн баримт бичгийг архивд шилжүүлэх, хадгалах журам баталж мөрдүүлэх;
 9. сонгуулийн хууль тогтоомжийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхэд оруулах;
 10. сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хуралд санал тавих;
 11. сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал, Засгийн газарт санал оруулах;
 12. Хорооны дүрмийг хэлэлцэн батлах (Хорооны “хөдөлмөрийн дотоод журам” гэж ойлгох нь зөв болов уу. Зохиогч);
 13. Хорооны төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;
 14. өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар сонгуулийн хороод, сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад туслах үүрэг бүхий төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн хууль тогтоомжид заасан асуудлаар холбогдох бусад байгууллагаас

шаардлагатай баримт, мэдээ сэлтийг гаргуулж авах, зохих албан тушаалтны мэдээллийг сонсож, хууль биелүүлэх асуудлаар үүрэг даалгавар өгөх;

15. хуульд заасан бусад бүрэн эрх. “Бусад” гэдэг нь сонгуулийн болон бусад хуульд заасан эрх, үүргийг хэлсэн гэжээ.

УИХ-ын сонгуулийг бэлтгэж зохион явуулах талаар Сонгуулийн ерөнхий хороо дараах эрх, үүрэгтэй:

1. тойрог байгуулах, өөрчлөх саналыг Улсын Их Хуралд оруулах;
2. тойргийн хороог байгуулах, түүний бүрэлдэхүүнийг батлах;
3. тойргийн хорооны үйл ажиллагааг дуусгавар болгох;
4. сонгуулийн аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол болон сонгуулийн асуудлаар гаргасан бусад өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх, хэрэв хууль тогтоомжид нийцээгүй бол тухайн тойргийн хорооны шийдвэрийг хүчингүй болгох;
5. Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам,эвслийг бүртгэх;
6. сонгуульд оролцогч нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагатай сонгуулийн асуудлаар харилцах;
7. Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн бүртгэлийг хуульд заасан үндэслэл байвал хүчингүй болгох;
8. саналын хуудасны загварыг батлах, түүнийг хэвлүүлэх, хуваарилах;
9. сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, сонгогдсон Улсын Их Хурлын нийт гишүүний нэрийн жагсаалтыг үйлдэж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган мэдүүлэх, тэдгээрийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, нийтэд мэдээлэх;
10. нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан хандивын хэмжээ, зарцуулалтад хяналт тавих;
11. сонгуулийн зардлын тайланг хянан хэлэлцэх, дүнг нийтэд

мэдээлэх.

Хуульд заасан “бусад бүрэн эрхтэй” гэсэн заалт бас бий. Энэ нь ямар ч байсан бүх эрх, үүрэг нь хуульд тодорхойлогдсон байх зарчимтайг илэрхийлнэ гэсэн нь чухал санамж мөн.

2023 онд батлагдсан Улс төрийн намын шинэ хууль, түүнийг дагалдан Сонгуулийн ерөнхий хорооны чиг үүрэг, бүрэн эрхэд цоо шинэ нэмэлт орсон болно.

Илтгэгч үүний ач холбогдлыг харгалзан тоочих нь зүйтэй гэж үзэж байна. Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхтэй:

1. Улс төрийн намын тухай хуульд заасан мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлэх;
2. төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах маягтыг батлах;
3. намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах;
4. хуульд заасан үндэслэл, журмын дагуу намыг тараах тухай санал гаргах;
5. төрөөс намд олгох санхүүжилтийн хэмжээг тогтоож, төсөвт суулган олгох;
6. төрөөс намд үзүүлэх шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;
7. Улс төрийн намын тухай хуульд заасан хяналт хэрэгжүүлэх;
8. Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу шийдвэр гаргах;
9. улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт тавих.

Зохиогч “сонгуулийн байгууллага” сэдвийн төгсгөлд сонгуулийн орон нутгийн (түр) хороодын эрх зүйн байдал болон бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалтыг тодруулан тайлбарласан байна. Энэ тухайд сонгуулийн шинэ хууль тогтоомж, сонгуулийн тогтолцооны шинэчлэл, автоматжуулсан систем нэвтэрсэнтэй холбоотой нэлээд өөрчлөлтүүд орсон тул зохиогчийн өгүүлснийг баримтлан тодотгон үзье.

Үндсэн хуульд оруулсан 2023 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор УИХ 126 гишүүнтэй болж, 78 гишүүнийг сонгуулийн тойргоос мажоритар буюу олныг төлөөлөх аргаар, 48 гишүүнийг намын жагсаалтаар хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох болсон. Үүний дагуу сонгуулийн тойргууд өөрчлөгдөн сонгуулийн хороодын нэршил, байршил зэрэгт өөрчлөлт оржээ.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг УИХ-ын тогтоолоор аймгуудыг 7, нийслэлийг 6 тойрог болгож, нийт 13 тойрог байгуулсан байна. УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар

“14.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороо, төв комисс, салбар комисс нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага /цаашид «сонгуулийн хороод» гэх/ бөгөөд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.

14.17.Сонгуулийн нэг тойрогт хоёр ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь сонгуулийн зохион байгуулалтын ажлыг хариуцна.”

Аймаг, нийслэлийн хороо бол өөрийн харьяалах сум, дүүргийн сонгуулийн хороодыг нэгдсэн удирдлагаар ханган сонгуулийг эрхлэн явуулах үндсэн чиг үүрэгтэй юм.

Сонгуулийн бүх шатны хороод сонгууль эрхэлсэн байгууллагын хувьд хуулиар тогтоосон нийтлэг зарчмыг баримтална. Үүнд:

1.Сонгуулийн ерөнхий хорооноос бусад сонгуулийн хороо, комисс түр зуурын шинжтэй. Тэдгээр нь үндсэндээ сонгуулийн хугацаанд ажиллана. Сонгуулийн хороодын үйл ажиллагаа тэдгээрийг байгуулсан этгээд нь татан буулгах тухай шийдвэр гаргаснаар дуусгавар болно.

2.Эдгээр хороодод нээлттэй сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан

хаагчийг томилон ажиллуулах зарчимтай болсон. Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталдаг. Ингэснээр улс төрийн нөлөөлөл, төлөөлөл сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд байхыг хориглон хязгаарласан нь зохиогчийг бүтээлээ туурвиж байх үеийн “нам, эвслийн адил тооны төлөөлөл байна” зохицуулалт үйлчилж байснаас эрс өөрчлөгдсөн болохыг илтгэнэ. Гэхдээ зохиогч энэ талаар “сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хэн боловч үүргээ нам, улс төрийн байгууллагаас хараат биш байх үндсэн дээр хэрэгжүүлнэ. Энэ нь тэдгээрийн хууль зүйн болон ёс зүйн үүрэг мөн.” хэмээн тодорхойлсон нь шинэ хуулийн зохицуулалтаар бүрэн баталгаажсан байна. Энэ тухайд УИХ-аас баталсан “Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их Хурлаас баталсан сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм”-ийг баримтална. Түүний үндсийг сонгуулийн хуулиар тогтоон баталгаажуулжээ.

УИХ-ын сонгуулийн хуулийн 14 дүгээр зүйлд “14.12. Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар байр сууриа илэрхийлэх, сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ эдлэхэд болон санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд саад учруулах, бусдыг төлөөлж санал өгөх, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус аливаа үйлдэл хийх, зохион байгуулах, бусад хэлбэрээр дэмжихийг хориглоно.” гэжээ.

3. Хорооны бүрэлдэхүүн дархан эрх эдэлнэ. Энэ талаар УИХ-ын сонгуулийн хуульд “19.19. Сонгуулийн хороодын ажилтныг энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.” гэж заажээ.

Энэ бол сонгуулийг зөв шударгаар явуулахын тулд тогтоосон

баталгааны нэг бөгөөд гагцхүү дээрх дархан эрх, зарчмыг сайтар ухамсарлаж зөвхөн Сонгуулийг бэлтгэн явуулахын тулд хууль ёсоор эдэлбэл зохино. Түүнийг зөрчвөл хууль зүйн хариуцлага хүлээхийг сануулсан байна.

Зохиогч ухаант багшийн онцолсноор “сонгууль бол угтаа иргэдээс улс төрийн үндсэн эрхээ бие даан хэрэгжүүлэх өөрийн удирдлага бүхий үйл ажиллагаа. Сонгогчид гэгдэх ард түмэн энэхүү эрх мэдлээ өөрсдийн шууд оролцооноос гадна сонгуулийн хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ. Тэгэхлээр орон нутгийн хороод бол уг чанар, нийгмийн үндэс, бүрэлдэхүүн, үүрэг зорилгоороо тэндхийн иргэдийн (сонгогчдын) байгууллага шууд ардчиллын хэлбэр мөн. Энэ бол онолын баримтлал” хэмээжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын даргаар тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгчийг томилох ба аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төлөөлөл, цагдаагийн болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын дарга нарыг оруулна. Харин сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг сонгуулийн хороодод томилохыг хориглодог.

Сонгуулийн хороодод ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүний тоо гэвэл маш олон мянган хүмүүсийн хүч хөдөлмөр, зүтгэл орсон нүсэр арми болно. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион явуулахад сонгуулийн байгууллагуудад 21943 хүн ажилласан ба ай ти, цагдаа, эрүүл мэнд, онцгойгийнхон гээд нэмээд тоолбол 25000 хүнтэй хамт олны хичээл зүтгэл шингэсэн байна.

Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах эрх, үүрэгтэй:

1. сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;
2. сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
3. сум, дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;
4. сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;
5. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;
6. саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
7. харьяалах сонгуулийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэх, хариуг бичгээр өгөх, доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох;
8. санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу нэгтгэж, хүргүүлэх;
9. дахин болон нэмэлт санал хураалтыг хуульд заасны дагуу зохион байгуулах;
10. сонгууль зохион байгуулахтай холбогдуулан дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн үүргийг биелүүлэх;

11. хуульд заасан бусад эрх.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон 3, эсхүл 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

Сум, дүүргийн сонгуулийн хороо харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1. сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;
2. сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
3. сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;
4. харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;
5. аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах хэсгийн хорооны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлыг гаргах, зарцуулалтад хяналт тавих;
6. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгөх;
7. харьяалах хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргэх;
8. дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

9. сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;
10. саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
11. дахин болон нэмэлт санал хураалтыг хуульд заасны дагуу зохион байгуулах болон хуульд заасан бусад эрх.

Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон 6, эсхүл, гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

Хэсгийн хороо дараах чиг үүрэгтэй:

1. хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;
2. санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах төхөөрөмж зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;
3. санал хураалтын дүн танилцуулах, нэн даруй дамжуулах;
4. сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;
5. дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх.

Хэсгийн хорооны дарга хэсгийн хорооны чиг үүрэгт хамаарах ажлыг удирдан зохион байгуулж, хууль зүйн хариуцлагыг хүлээнэ. Тус хороо санал тоолох, дүн гаргах үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх эрхгүй аж.

Дээд шатны сонгуулийн хороо нь доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.

Дээд шатны сонгуулийн хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн үүргийг биелүүлээгүй нь тухайн доод шатны сонгуулийн хороо, түүний бүрэлдэхүүнийг өөрчлөх үндэслэл болдог.

Сонгуулийн хорооноос сонгууль зохион байгуулах, сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, нэр дэвшигч, сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, менежер, ухуулагч болон бусад этгээд хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно. Үүнийг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд энэ нь түүнийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалтын тухайд:

Сонгуулийн хороод нь хамтын удирдлагатай. Эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж хуралдаанд оролцсон бүрэлдэхүүний олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Сонгуулийн хорооны бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй нь хуралдаанд оролцсон бол тухайн сонгуулийн хорооны хуралдааныг хүчинтэйд тооцогдоно.

Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Хорооны үйл ажиллагаанд оролцохгүй байх, хуралдаанд ирэхгүй байх, таслах, хуралдаан орхих, хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзахыг хуулиар хориглосон. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр орхисон тохиолдолд түүнийг хуралдаанд оролцож тухайн асуудлаар татгалзсан санал гаргасанд тооцно. Хорооны тогтоолд тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Аль нэг нь гарын үсэг зураагүй нь уг тогтоолыг хүчингүй, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан хуралдааны дэг,

тэмдэглэл хөтлөх журмыг баримтлах ба хорооны дарга гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтооно. Хороод нь үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулна. Хорооны дарга, нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуваарийг 7 хоногоор гаргаж, тухайн сонгуулийн хорооны мэдээллийн самбарт ил тавина. Хорооны хуралдаанд сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, ажиглагчийг байлцуулж болох бөгөөд хуралдааныг ажиглах, дуу болон дүрс бичлэг хийх боломжоор хангах асуудлыг хуралдааны дэгээр зохицуулна. Хуралдааны шийдвэрийг нэн даруй нийтэд ил тод мэдээлэх ёстой.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой болон хууль зөрчсөн тухай асуудлыг шалгуулах, эсхүл зөрчлийг таслан зогсоох асуудлаар Сонгуулийн хороо сонгуулийн хууль тогтоомжоор үүрэг хүлээсэн аливаа байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьсан бол түүнийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ажлын 3 өдрийн дотор хариуг бичгээр мэдэгдэнэ. Сонгуулийн хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэр дэх бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана. Сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бүртгэнэ.

Сонгуулийн хороодын ажилтныг энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно. Төрийн албан хаагчийг сонгуулийн хороонд ажиллах хугацаанд харьяалах байгууллага нь цалинтай чөлөө олгоно гэж эдийн засаг, хууль зүйн баталгааг хуулиар тогтоожээ.

Хуульд өөрөөр заагаагүй бол доод шатны сонгуулийн хорооны шийдвэр, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны

талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш гурван хоногийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид хариуг бичгээр мэдэгдэнэ.

Сонгуулийн хороод нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх эрхтэй.

Дүгнэлт

1. Сонгууль бол ард түмний засаглах бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр, засаг төрийг бүрдүүлэх гол арга. Сонгуулийн байгууллага байхгүй бол сонгуулийн үйл явц эмх цэгцгүй, шударга бус явагдана. Иймд сонгуулийн байгууллага нь ардчилсан төрийн хууль ёсны эх сурвалж болох ард түмний хүсэл зоригийг хангах суурь баталгаа. “Эрх баригчийн дур зоргоос ангид, хууль ёсны дагуу цэвэр, шударга, чөлөөт явуулах” зарчим нь сонгогчдын өөрсдийнх нь байгууллага-сонгуулийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

2. Зохиогчийн онож тэмдэглэснээр сонгуулийн бүх үе шатыг тойрсон улс төрийн их давлагаа үүсэж, эдийн засаг, улс төр, зохион байгуулалтын олон талт арга хэмжээнд төр, нам, иргэний нийгмийн бусад байгууллага өөр өөрийн хууль ёсны эрх хэмжээний дотор татагдан ордог.

3. Манай улсын сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал цаашид хэрхэн өөрчлөгдөн хөгжих нь анхаарал ихэд татав. Монгол Улсын Үндсэн хуульд нэршлээрээ орсон байгууллага. Сонгуулийн байгууллагын загварын хувьд манай сонгуулийн байгууллагын өнөөгийн загвар холимог бүтэцтэй гэж үзэж болно. Хөгжил хувьслын зам хандлага нь бие даасан, хүчтэй сонгуулийн байгууллага болон төлөвших чиглэлд байгаа гэж хувийн дүгнэлтээ илтгэгчийн зүгээс илэрхийлж байна. Сэдвийн хүрээнд СЕХ-ны Тамгын газрын даргаар ажиллаж буй судлаач Д.Бат-Эрдэнийн “Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг

(Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал)” УБ, 2024 сонирхолтой бүтээлийг уншиж танилцсан. Сонгуулийг удирдах байгууллага нь Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан байгууллагын нэг мөн гэснийг бүрэн хүлээн зөвшөөрөх бөгөөд цаашид энэ чиглэлээр тус байгууллагын эрх зүйн байдал, бүрэлдэхүүнийг томилох журмыг боловсронгуй болгох байр суурийг дэмжин хуваалцаж байна.

4.Өдгөө сонгуулийн байгууллагын эрхлэх ажлууд иж бүрэн автоматжиж, иргэний бүртгэлд суурилсан сонгогчдын бүртгэлийн систем нэвтэрсэн, төрийн албан хаагчдаар сонгуулийн хороод бүрдэх болсон зэргээр ихээхэн “хөнгөрч” байгаа ч хүлээх үүрэг хариуцлага буураагүй, харин ч нэмэгдсэн. Улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналт, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нам тараах тухай санал гаргах, хилийн чанадад байгаа сонгогчдын санал хураалтыг зохион байгуулах зэрэг хуулиар хүлээсэн нэмэлт үүргүүдээ гүйцэтгэхэд хүн хүч, хөрөнгөний зохих нөөц шаардагдах болно.

5.Манай улсын сонгуулийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаанд өнгөрсөн хугацаанд УИХ, СЕХ, сонгуулийн орон нутгийн байгууллагад ажилласан үе үеийнхний хамтын зүтгэлээр маш их ахиц дэвшил гарсан, олон улсын жишиг болохуйц хэмжээнд хүрсэн. Миний бие СЕХ-ны нарийн бичгийн даргаар ажиллаж байх үедээ өөрийн биеэр амссан туршлага, бага сага судалсан мэдлэгтээ дулдуйдан 2005 онд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төслийг бүхэлд нь боловсруулан бичиж, УИХ-аар батлуулж байсан, хууль тогтоогчийн хувиар УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөл, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн төсөл зэргийн санаачлагч, батлагч байсан, Улс төрийн намын шинэ хуулийн төслийн боловсруулалтад оролцож батлалцсан, сонгуульд нэр дэвшигч байсан гээд хууль зүйн талын хийгээд практик хэрэглээг мэдэрч, судалж яваа хүний хувьд ийн дүгнэж байгаа юм.

6.Эрхэм мэргэн багшийн “Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй” бүтээлийг эргэн уншихуй дор Зохион байгуулагч, санаачлагчид яагаад “Чимидийн уншлага II – Сонгуульд суралцахуй ” ном болов оо гэдгийг ухааран тайлснаа мөхөс би төгсгөлд нь өөрийн бодлоо өчиж байна.

Зохиогч энэхүү бүтээлээ хэрхэн туурвиснаа номынхоо хэд хэдэн хуудаст буулгасныг онцлон нийлүүлэхэд “Бодон бодсоор энэхүү номыг бичих аядлаа ... түмэн олон сонгогч, сонгуулийн болон сонгуулийн цогц ажилд оролцогч засаг захиргаа, нам, эвслийн байгууллагын ажилтан нарт зориулсан нэгэн зүйл гарын авлага болно ... үйл явцын зарчим, журмыг хууль тогтоомж, арга зүйн үүднээс өгүүлсэн ... Сонгогч түмэн, сонгуулийн болон түүнд оролцогч байгууллагын ажилтан нарт гарын авлага маягтай юм бичиж байгаа болохоор ... таамгаар хандсангүй, харин эрх зүйн онол, юуны өмнө Үндсэн хуулийн эрх зүйн тулгуур ойлголт, зарчим, амьд ажлын туршлага, жишээн түшиглэсэн ... Энэ удаад сонгуулийн тогтолцоо, бэлтгэл, үйл явцыг зөвхөн эрх зүйн талаас нь хандаж гол төлөв одоо мөрдөж буй хуулийг тайлбарлах аргаар бичсэн тул хууль өөрчлөгдвөл ном “өөрчлөгдөхөд хүрэх” талтай болов ... энэхүү бүтээлд зөвхөн тогтолцоо, үйл явцын эрх зүйн үндсийг хамран өгүүлэв ... УИХ-ын сонгуулийн асуудлаар сонгогчдод хийгээд сонирхогчдод зөвлөсөн бяцхан “гарын авлага” бичье юу гэж эхэлснээ нэгэнт барьж авсан юм чинь хуулийг нь бүрэн хамарсан эрт, эдүгээгийн сонгох ёсыг харьцуулсан хирдээ “бүтэндүү ажил” болго юу гэж зүтгэв. Эцэст нь Монгол Улсын Үндсэн хуулийн үндэслэл хийгээд УИХ-ын сонгуулийн хуулийг бүхэлд нь хамарсан 13 бүлэгтэй номын сүүлийг мушгив... Хамгийн гол нь хэн ч гэсэн уншихад хэрэг болохуйц дундаж түвшнийг баримталсан ... сонгуулийн тогтолцоог төгөлдөржүүлж хуулийг эрс сайжруулах цаг болжээ гэж уг хуультай туушид нь танилцсаны эцэст өөрийн эрхгүй бодогдном.” хэмээн бичгийн их багш маань бидэнд 17 жилийн өмнө даруухнаар хандан өгүүлжээ.

Илтгэгч миний бие уг номыг ахин уншихад сонирхогчдод, сонгогч олонд зориулсан сургалтын практик хэрэглээний нэгэн “гарынавллага” төдий бус “Монгол Улсын Сонгуулийн эрх зүйн анхны сурах бичиг” -тэй танилцсан мэт мэдрэмж төрснөө нуух юун. Нэг талаас уншвал гарын авлага, нөгөө талаас нь ухвал мэргэжлийн сурах бичиг мэт бичигджээ. Хэдий Зохиогчийн өөрийнх нь урьдчилан анхааруулснаар тухайн үеийн хууль тайлбарлах аргаар бичсэн учраас ном “өөрчлөгдөх” талтайг сануулсан ч номын агуулга, үнэ цэн өөрчлөгдсөнгүй хэвээр, харин ч тухайн үеийн хуулийн зохицуулалтуудыг одоогийнхтой харьцуулж болохоор байна. Угаас уг бүтээл Монгол улсын сонгуулийн тогтолцоо, үйл явцын эрх зүйн үндсийг углуургаар нь авч үзсэн тул шинжлэх ухааны өндөр үнэ цэнтэй, цаашид Монгол Улсын Сонгуулийн эрх зүйн шинэ сурах бичиг туурвих, Сонгуулийн эрх зүйн хөгжлийг шинэ шатанд гаргах бат бөх суурь болж чаджээ.

Ном дор мөргөмү,
Багш дор мөргөмү
Номын буян арвижих болтугай.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
2. Д.Бат-Эрдэнэ (2024). Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Н.Лувсанжав

Сонгуулийн ерөнхий хорооны дарга асан

Бяраагийн Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын уншлагад оролцож байгаа тохиолдлыг ашиглан зохиогчийн талаар бяцхан дурсамж өгүүлье. Миний бие Б.Чимид гуайн хичээлийн танхимд сууж ном заалгаж байгаагүй хэдий ч энэ хүнийг амьдралын багшаа гэж бодож хүндэлж явдаг билээ. 1980 онд “Ардын хяналт шалгалтын тухай” хуулийн төсөл боловсруулах ажилд оролцож Б.Чимид гуайтай анх ойртон танилцаж, түүнээс хойш байнгын холбоотой ажиллаж амьдарч ирсэн юм. Тэр үед хуулийн төсөл боловсруулах ажлын утга учрыг Б.Чимид, Г.Совд, О.Амархүү нарын ахмадуудын гарын үзүүрт зарагдаж, тэдний хоорондын яриа хөөрөө, мэтгэлцээнээс ойлгож авсан нь надад амьдралын их сургамж болсон юм. 1990 оны анхны ардчилсан сонгуульд нэр дэвшихэд нь түүний итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцож Хөвсгөл аймгийн Ардын хянан шалгах хорооны даргаар ажиллаж байсан Доржготовын хамт Шинэ-идэр суманд ажиллаж, чанга яригч “цагаан хоолой”-той хот айлуудын дунд очиж уулзалтаа зарлахад хүмүүс даруй цуглан бид нэр дэвшигчээ сурталчлан таниулж явсан билээ. Дашрамд хэлэхэд анхны ардчилсан сонгуулийн компанит ажил өнөөгийнхтэй харьцуулахад их л аядуу даруухан, тайван амгалан болж байв. Бид нэр дэвшигчээ танилцуулан айл өрхөөр орж явахдаа нөгөө талын ухуулагчидтай нэг айлд тааралдан хоймрынх нь хоёр талд суугаад

өөр өөрийн нэр дэвшигчээ танилцуулаад цай идээг нь амсаад гарч байлаа. Тэр үед бие биеийг харлуулах, хоорондоо дайсагнах өнөөгийнх шиг сөрөг үзэгдэл бараг гараагүй, сонгогч олон түмэн ч асуудалд ул суурьтай хандаж сонголтоо хийсэн билээ.

Б.Чимид гуай 1951 оны УИХ-ын шинэ сонгуулийн анхдугаарыг бэлтгэн явуулахад багийн ахлах ухуулагчаар оролцсоноос хойш хэд хэдэн сонгуульд хэсэг, тойргийн комиссын гишүүн, ухуулагчаар ажиллаж, Ардын Их Хурлын хоёр ч ээлжит сонгууль, 1990 оны анхны ардчилсан сонгууль, мөн шинэ Үндсэн хуулийн дараах УИХ-ын 1992, 1996 оны сонгуульд нэр дэвшигчээр оролцож ялж, ялагдаж үзсэнээ номондоо дурсжээ. Тэрээр сонгуулийн хуулийг боловсруулах, батлахад оролцохын зэрэгцээ сонгуулийн системийн ардчиллын асуудлыг судалж ирсэн зэргээс үндэслэн “Сонгуульд суралцахуй” хэмээх энэ номоо бичсэн тухайгаа дурдаж, “Өмнөх үеийн нэг намт сонгуульд хэний нэрийг дэвшүүлнэ, түүний төлөө саналаа өгч дадсан өвөг дээдсийн удамшилтай шинэ Монголчууд өдгөө цагийн өрсөлдөөнт сонгуульд өөрийн бодолтой оролцож, бие даан шийддэг чадавхыг эзэмших нь төрийн хэрэгт нийтээр суралцахуйн гайхамшигт сургууль мөн болой.” (Б.Чимид, 2008, х. 12) хэмээн онцлон тэмдэглэсэн нь сонгуулийн үндсэн утга агуулгыг тодорхойлж, сонгогч түмэн болон сонгуульд оролцогчид, зохион байгуулагчдад нэгийг ухааруулсан хэрэг байв. Б.Чимид номондоо “сонгуулийн тогтолцоо, бэлтгэл, үйл явцыг зөвхөн эрх зүйн талаас нь хандаж гол төлөв одоо мөрдөж буй хуулийг тайлбарлах аргаар бичсэн тул хууль өөрчлөгдвөл ном “өөрчлөгдөхөд хүрэх” талтай болов.” хэмээн сонгуулийн нарийн түвэгтэй, олон талт харилцааг онол, арга зүйн болоод эрх зүйн талаас нь дэлгэрэнгүй бичих боломжгүй байгаагаа учирласан байна. Мэдээж Үндсэн хуулийн эхийг баригч, хуульч эрдэмтэн, багшийн хувьд хөндөж бичих зүйл, цаашид боловсронгуй болгох талаар өөрийн байр суурийг илэрхийлэх хүсэл их байсан нь ойлгомжтой. Б.Чимид гуай энэ номынхоо “Сонгуулийн байгууллага” гэсэн бүлэгтээ сонгуулийн

үйл явцад хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудыг “сонгуульд оролцогч байгууллага”, “сонгууль эрхэлсэн байгууллага” гэсэн хоёр хэсэгт хуваан ангилж, тэдгээрийн чиг үүрэг, оролцоог тухайн үед мөрдөж байсан хуулийн дагуу тайлбарлаж, нэлээд товчхон бичжээ. Энэ сэдвээр зохиогч онолын болоод эрх зүйн хувьд бичих, дэлгэрүүлэх зүйл их байсан нь дамжиггүй.

Энэхүү номын Дөрөвдүгээр бүлгийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга асан, “Сонгуулийн төв байгууллагын тухай” хуулийг боловсруулж, батлуулж байсан хуульч, судлаач Ж.Сүхбаатар дэлгэрэнгүй илтгэж дүгнэсэн тул түүнтэй давхардуулахгүйгээр цаашид бид юуг анхаарах талаар зарим нэг асуудлыг хөндөж саналаа хэлье.

1. “Сонгуульд суралцахуй” ном бичигдсэнээс хойш 17 жил өнгөрсөн хэдий ч уг номонд тусгагдсан онол, арга зүйн олон асуудлууд өнөөдөр ч гэсэн сонгуульд хандах хандлагын суурийг тодорхойлсон өндөр ач холбогдолтой хэвээр байна. Өнгөрсөн хугацаанд сонгогчид болоод сонгуульд оролцогчид, сонгууль эрхэлсэн байгууллага, сонгуулийн технологид ихээхэн өөрчлөлт орж, зохицуулж буй хууль тогтоомж олон удаа шинэчлэгдэн мөрдөгдөж иржээ. Сонгуулийн төв байгууллагад хэд хэдэн шинэ чиг үүрэг нэмэгджээ. Үүнтэй холбогдон “Сонгуульд суралцахуй” номын дараагийн хувилбарыг шинээр бичиж гаргах цаг нэгэнт болжээ. Үүнийг манай залуучууд, эрдэмтэн судлаачид даруй бичиж гаргана гэдэгт итгэлтэй байна. Сүүлийн үед сонгуулийн үйл явцыг онол, арга зүй, эрх зүйн талаас судалсан бүтээл гарах болсон байна. Сонгуулийн Ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ “Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг” (Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал) УБ 2024 он номыг туурвисан нь олзуурхуштай бөгөөд цаашид анхаарвал

зохих олон асуудлыг хөнджээ.

2. Б.Чимид номондоо сонгуульд оролцогч байгууллагуудыг тодорхойлохдоо тэдгээр нь сонгуулийн үйл явцад хуулиар хүлээсэн үүргийн дагуу оролцдог бөгөөд ийнхүү хүлээх үүрэг нь тусгай шинжтэй болохыг онцолж, сонгуулийг бэлтгэж явуулах үйл явцад **хөндлөнгөөс хутгалдан оролцох ёсгүй** гэсэн зарчмыг баримталж, бусдын ажил хэрэгт оролцохыг бус үүрэгт ажилдаа бүрэн эзэн болохоо хариуцах ёстойг онцлон сануулсан юм. Өнгөрсөн хугацаанд сонгуулийн хуульд нэлээд өөрчлөлт орж, сонгуульд оролцогч байгууллагуудын чиг үүргийг зааглан ялгасан байдаг. Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, түүний үнэн зөв байдлыг хариуцах, хяналт тавих, нэрийн жагсаалттай холбогдох гомдлыг хянан шийдвэрлэж, гаргасан шийдвэрээ шүүхийн өмнө хариуцах чиг үүргийг зөвхөн иргэний бүртгэлийн байгууллага гүйцэтгэж байна. Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг шалган тогтоох чиг үүргийг хариуцах байгууллагыг ч хуульд тодорхой болгож, сонгууль эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг мөн хуулиар ялгавартай тогтоосон юм.

Сонгууль эрхэлсэн байгууллага нь сонгуулийн бэлтгэлийг хангах, сонгуулийн үйл явцыг удирдан зохион байгуулах, бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих, сонгуулийн дүнг гаргах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх болжээ. Өөрөөр хэлбэл найрал хөгжмийн удирдаачийн нэгэн адил сонгуульд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, сонгуулийн үйл явцад бүхэлд нь хяналт тавьж, хуульд заасан зорилгыг хангахад нэгтгэн зангидах өндөр хариуцлагатай үүргийг хүлээж байна. Тиймээс ч сонгууль эрхэлсэн байгууллага

нь улс төрийн байгууллагуудаас хараат бус зарчмаар бие даасан байдалд ажиллах ёстойг зохиогч тэмдэглэсэн байдаг.

3. Б.Чимид гуай номондоо “Сонгууль бол угтаа иргэдээс улс төрийн үндсэн эрхээ бие даан хэрэгжүүлэх өөрийн удирдлага бүхий үйл ажиллагаа мөн ... сонгуульд бэлтгэж явуулах ажлыг сонгогчид өөрсдөө мэдэж зохион байгуулах боломжийг аль болохоор хангах нь ардчилсан ёсны шаардлага юм. “Засгийн эрх ард түмний мэдэлд” гэдэг зарчмын уг чанар энд бас оршино.” (Б.Чимид, 2008, х. 103) хэмээн тэмдэглэж, орон нутгийн хороодыг дээрээс, төвөөс томилж байгуулах зарчим тогтоосон нь эргэлзээтэй” хэмээн сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүнийг тодорхойлоход цаашид анхаарвал зохих нэг асуудлыг хөндсөн байна. Чингэхдээ Улсын Их Хурал болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мөн чанарыг Үндсэн хуульд ялгаатай тодорхойлсныг анхаарч тэдгээрийн сонгуулийн тогтолцоо, зохион байгуулалт нь ялгаатай байх ёстойг эш үндэс болгосон болов уу.
4. Хууль шинэчлэгдэхийн хэрээр Сонгуулийн төв байгууллагын чиг үүрэг, бүрэн эрх шинэчлэгдэж байна. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 13 жил өнгөрчээ. Сонгуулийн автоматжуулалт Монгол Улсад үндсэндээ нутагшсан байна. Бид мэдээллийн эрин зуунд амьдарч байна. Төрийн ажил, үйлчилгээг цахимжуулах үйл явц эрчимтэй өрнөж байна. Хөгжлийн энэ үйл явцаас сонгуулийн байгууллага хоцрох ёсгүй. Хэдийгээр цахим сонгуульд шилжих тухай ярихад эрт боловч энэ чиглэлд зарим нэг алхам хийх талаар судалж боловсруулах шаардлагатай байна. Энэ ажлыг урьдаас төлөвлөсөн үе шат бүхий

үндсэн чиглэлийг боловсруулж баталсаны үндсэн дээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

5. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой тодорхой чиг үүрэг СЕХ-нд нэмэгдэж холбогдох бүтэц, зохион байгуулалтад ороод ажиллаж байна. Бүхэлд нь аваад үзвэл сонгуулийн холбогдолтой мэдээ мэдээлэл СЕХ-нд нэлээд төвлөрч байна. Сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгон хөгжүүлэх талаар эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, төрийн бус байгууллагууд, судлаачдын судалгаа, лавлагааны бүтээлүүд цөөнгүй гарч байна. Эдгээрийг нэгтгэн судлах судалгааны нэгжийг Сонгуулийн ерөнхий хороонд бий болгож, сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал зөвлөмжийг судалгаа, шинжилгээнд тулгуурлан боловсруулдаг болох шаардлагатай байна.

Энэхүү “Сонгуульд суралцахуй” номын уншлагыг зохион байгуулсан Сонгуулийн Ерөнхий хороо, Үндсэн хуулийн цэц, Б.Чимид сан, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнд болон оролцогчдод гүнээ талархал илэрхийлье.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Б.Төрболд

“Оюуны-Инноваци” ТББ-ын гүйцэтгэх захирал

1992 оны Үндсэн хуулийн эхийг баригч, хууль зүйн ухааны доктор, профессор Б.Чимид (цаашид “зохиогч” гэх)-ийн “Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй)” бүтээлийн “Сонгуулийн байгууллага” гэсэн дөрөвдүгээр бүлэг болон түүнд хийсэн Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга асан Ж.Сүхбаатарын дүн шинжилгээтэй танилцаж, бүтээлд нарийвчлан тусгаагүй асуудлын талаар товчхон дүгнэлт, саналыг бичихийг зорилоо. Ингэхдээ дараах гурван үндсэн санаанд төвлөрөхийг хичээлээ:

Нэг.Сонгуулийн ерөнхий хороо бие даасан байгууллага болох нь

Төрийн тогтолцоонд бие даасан байгууллагууд нь зохицуулах, хянах чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлж ардчилсан засаглалыг бэхжүүлэх, шударга, зарчимч байдлыг хангах, үндсэн хуульт ардчиллыг бататгах зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн хувьд төвийг сахисан, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрөөс хараат бус, шударга ёсыг сахиулж, ардчилсан засаглалын чанар, тогтвортой байдлыг хангах зорилго бүхий нийтийн эрх зүйн этгээд (Eliot Bulmer, 2019, 6) гэж ойлгодог. Улс төрийн болоод институцийн хувьд хараат бус байх нь ардчилсан тогтолцоонд хүлээх үүргээ гүйцэтгэх гол нөхцөл болдог.

Олон улсын туршлагаас авч үзвэл эдгээр байгууллагууд нь

ихэвчлэн парламентаас байгуулагдаж, түүний өмнө ажлаа зохих журмын дагуу хариуцан тайлагнадаг бөгөөд парламент, засгийн газраас хараат бус байж, өөрөө бие даан шийдвэрлэх асуудлыг хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийг улс орон даяар эрхлэн явуулах процесст шаардлагатай зүйлсийг сонгуулийн төв байгууллага өөрөө мэдэж шийдвэрлэдэг.

Монгол Улсын төрийн тогтолцоонд бие даасан байгууллагуудыг зохион байгуулахдаа дараах нийтлэг зарчим, зохицуулалтыг мөрдлөг болгосон байдаг:

- Парламентаас буюу Улсын Их Хурлын оролцоотойгоор байгуулагдан, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд аливаа байгууллагын хөндлөнгийн оролцоогүй бие даан явуулж, Улсын Их Хуралд тайлангаа танилцуулдаг;
- Төсвөөс санхүүждэг боловч бусад төсвийн байгууллагаас ялгаатай нь хараат бус байдлыг нь хамгаалах тодорхой зохицуулалт үйлчилдэг;
- Удирдлага нь ихэвчлэн 5-6 жилийн хугацаатай /Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанаас үл хамаарах байдлаар/-аар томилогддог.

Энэхүү чиг үүргийн онцлогтой нь холбоотой, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрөөс хараат бус байх мөн чанарыг нь үндэслэн эрх мэдлийн “4 дэх салаа мөчир” гэж зарим судлаачид үздэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал дараах асуудлыг өөрийн **онцгой** бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэсний дотор: 4/-т “... хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын **бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх**” 6/-д ... хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг **томилох, өөрчлөх, огцруулах**” гэж заасан.

Тэгвэл энэхүү “Онцгой бүрэн эрх” гэдэгтэй холбоотой тайлбарыг зохиогч БНМАУ-ын Ардын Их Хурлын 1991.12.04-ний өдрийн хуралдааны протоколд үлдээсэн байна (Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. Боть VIII, 2022, х. 194).

<“Онцгой бүрэн эрх” гэдэг бол ач холбогдолтой үг. Энэ бол бусад байгууллага шийддэггүй асуудлыг хэнтэй ч хуваалцдаггүйг “онцгой” гэж байгаа юм. Хуваалцдагийг нь бол хуваалцах барих, харилцах нь бол мөн адил бусад бүрэн эрх гэж байгаа юм. Тийм учраас онцгой гэдэг бол хууль зүйн ач холбогдолтой үг. Өөрөөр хэлбэл цааш нь шилжүүлж болохгүй, манайхны ширүүхэн ярьдгаар үүний төлөө Их хурлаас өөр хэн ч хариуцахгүй гэсэн үг.>” гэж тайлбарласан нь бие даасан байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, томилох, өөрчлөх, огцруулах асуудлыг Улсын Их Хурал бие даан шийдвэрлэх онцгой бүрэн эрхэд Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн нь харагдаж байна.

Ийнхүү Монгол Улсад үйлчилж буй хууль тогтоомжийг ерөнхийд нь шинжлэн үзвэл бие даасан байгууллагыг гүйцэтгэх эрх мэдлийн шинжтэй тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газраас хараат бус, бие даасан, мэргэжлийн байгууллагууд гэж ойлгон зохих эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь харагдана (Б.Хатантуул, 2005, х. 21). Тухайлбал, Захиргааны ерөнхий хууль (Төрийн мэдээлэл, 2015.07.24, №28)-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д захиргааны байгууллага нь (1).нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх, (2).бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг, (3).нийтийн эрх зүйн этгээд байна.¹ гэж тодорхойлсон байна. Улмаар Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-т “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага” гэсэнд бие даасан байгууллагууд багтаж байна.

¹ Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал нь эх газрын эрх зүйн системийн ойлголт, хандлагад тулгуурлан боловсруулагдсан бөгөөд Германы захиргааны эрх зүйн ойлголтыг чиг баримжаа болгож боловсруулагдсан болно. (Ц.Цогт, 2019, х. 135)

Иймээс Сонгуулийн төв байгууллага буюу Сонгуулийн ерөнхий хороо бие даасан байгууллагын шинжийг Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу бүрэн утгаар нь хангаж байгаа болно.

Хоёр. Сонгуулийн төв байгууллагыг бүрдүүлэх буюу томилгооны тухай

Эрх зүйн орчин бүрэлдсэнтэй холбоотой бие даасан байгууллага нь Засгийн газраас хараат бус шинжтэй, Улсын Их Хурлаас байгуулагддаг субъект боловч мөн чанараараа гүйцэтгэх эрх мэдэлд хамаарна (Р.Мухийт, 2013, х.100) гэж дотоодын судлаачид үзэж ирсэн. Гэхдээ бие даасан байгууллагууд гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа буюу бүрэлдэхүүн, төсөв, зохион байгуулалтын хувьд хараат бусаар ажиллахын зэрэгцээ бүрэлдэхүүний томилгоонд Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх зэрэг тал талын оролцоо (санал болгох, зөвшилцөх, томилох)-г хангах замаар бие даасан, тэнцвэртэй, төвийг сахисан байдлыг баталгаажуулсан нь чухал юм.

Ингэхдээ, Бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, зарчмыг баримталж зохицуулах нь зүйн хэрэг юм. Үүнд төрийн эрх мэдлийг аливаа этгээдэд төвлөрүүлэх бус, хуваарилах замаар хяналт, тэнцлийг хангах нь хэзээд баримтлах учиртай гол зарчим билээ.

Бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд Улсын Их Хурал дахь олонх болон түүний байгуулсан Засгийн газар давамгай оролцоотой бол бие даасан байдал нь алдагдаж тал засаж ажиллах, улмаар парламентын сонгуульд ялсан нам, эвсэлд хяналтгүйгээр эрх мэдэл төвлөрч, төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцэл алдагдах, цаашлаад ардчилсан үндсэн хуульт байгуулал үгүй болох эрсдэл үүснэ. Венецийн комиссоос бие даасан байгууллагуудыг бүрдүүлэхэд **“улс төржилтийг сааруулах”** зарчим дагах нь зүйтэйг анхааруулсан байдаг. Иймээс, сонгон шалгаруулах, санал болгох,

томилох процедур нь аль болох зөвшилцөлд тулгуурлавал зохино. Парламентын олонхын давамгайллыг бууруулах эсхүл эрх баригч нам, эвсэлд харьяалагддаг хүнийг албан тушаалд томилох явдлыг хязгаарлах механизмыг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзсэн байдаг (Venice Commission, CDL-AD (2019)015).

Бие даасан байгууллагыг бүрдүүлэх янз бүрийн арга хэлбэр байна. Тухайлбал:

1. Парламент дийлэнх олонхын саналаар томилох;
2. Олон цөөнхийн хувь тэнцүүлж томилох эсхүл тус тусад нь квот өгч томилох;
3. Мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага зэрэг бие даасан этгээдээс санал болгох гэсэн гурван аргаар бүрдүүлэх боломжтой гэж Венецийн комисс үздэг.

Харин Ардчилал болон сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн бие даасан байгууллагыг бүрдүүлэх дараах аргууд байгааг тоочсон байна:

1. Олонх болон цөөнх хамтран томилох;
2. Нэрдэвшүүлэх эсхүл томилох бүрэн эрхийг парламентад суудалтай болон бусад намд хувь тэнцүүлэн олгох;
3. Парламент дийлэнх олонхын саналаар томилох;
4. Нэг институт санал болгож өөр нэгэн институт томилох;
5. Томилгоо хийх үүргийг олон талын төлөөлөлтэй тусгай комисст хариуцуулах;
6. Бие даасан нэг байгууллага нь нөгөө бие даасан байгууллагаа томилох;
7. Шүүх эрх мэдлийн байгууллагаас томилох (Eliot Bulmer, 2019, 24-29) гэж тодорхойлсон байдаг.

Дээрх аргуудыг дангаар нь эсвэл хослуулж хэрэглэж болох бөгөөд арга тус бүр нь давуу сул талтай тул Монгол Улсын нөхцөлд аль нь илүү тохирохыг судалж үзэх нь чухал юм.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хараат бус, бие даасан байгууллагуудыг Улсын Их Хурлаас байгуулдаг. Түүнчлэн

хараат бус хяналтын байгууллагуудыг чиг үүргийнх нь хүрээнд парламентын хяналтад татан оролцуулах эрх зүйн механизмыг бүрдүүлэх (Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал.) нь чухал гэх хандлага сүүлийн үед давамгайлах болсон.

Дүгнэн үзвэл, бие даасан, хараат бус байгууллагыг бүрдүүлэхэд олон талын төлөөллийг оролцуулах, улс төрөөс хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэхээр зохицуулах шаардлагатай нь харагдаж байна.

Гурав. Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний томилгоо, анхаарах асуудал

Б.Чимид багш “Сонгуульд суралцахуй” номдоо сонгуулийн төв байгууллагын томилгоотой холбоотой асуудлыг дэлгэрүүлэн авч үзээгүй ч сонгуульд оролцогч байгууллагын төрөл, оролцоо, сонгуулийн байгууллагын тогтолцооны хэсэгт дурдсан байдаг.

Үндсэн хуулиар баталгаажсан иргэний “сонгох, сонгогдох” эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг сонгуулийн төв байгууллага нь бие даасан, хараат бус байгууллага болохын хувьд бүрэлдэхүүний асуудлыг хэрхэн зохицуулж ирснийг холбогдох эрх зүйн орчинд туссан өөрчлөлтийг харгалзан үзэхэд доорх хоёр үед хувааж үзэж болохоор байна. Үүнд:

- 1992-2006 - Сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хуульгүй, холбогдох харилцааг Улсын Их Хурлын сонгуулийн хуулиар зохицуулж байсан үе;
- 2006 - одоо - Сонгуулийн төв байгууллагын тухай хууль батлагдаж хараат бус байгууллагын эрх зүйн үндэс бүрэлдэж эхэлснээс өнөөг хүртэлх үе.

1992-2006 онд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр ажиллах хүнд ашиг сонирхлын зөрчил гарахаас сэргийлсэн зарим шаардлага тавихын зэрэгцээ, хараат бус байдлыг хангах үүднээс 5 жилийн бүрэн эрхийн хугацаатай байхаар хуульд тусгасан

байв. Гэвч Сонгуулийн ерөнхий хорооны нь хэдэн гишүүнтэй байх, томилгооны шийдвэрийг хэрхэн гаргах, үүнд олон талын тэнцвэртэй оролцоог яаж хангах талаар огт зохицуулаагүй байснаас гадна гишүүд нь улс төрийн намын харьяалалтай байхыг ч хориглоогүй байсан.

Харин энэ хугацаанд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдсон анхны иргэний нийгмийн төлөөлөл 2000-2006 онд ажиллажээ. Түүнээс хойш өнөөг хүртэл иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдоогүй байна.

2006 оноос хойш Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн хувьд төрийн жинхэнэ албан хаагч байна гэсэн шалгуурыг гол үндэс болгож ирсэн байна. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Монгол Улсын Ерөнхийлөгч нарын хувьд ямар шалгуураар нэр дэвшигчдийг шилж сонгож, нэр дэвшүүлэх ажиллагаа хийгддэг нь өдийг болтол тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Харин Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2021 оны А/01 дугаар тушаалын хавсралтаар “Монгол Улсын шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх зарим асуудлын бэлтгэл хангах журам”-ыг баталсан байх бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаараа нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулж, дэмжигдсэн нэр дэвшигчийг санал болгох зохицуулалтыг журамласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний бүрэн хугацаа 6 жил байна гэж заасан. Харин хэдэн удаа улируулан томилж болох, нөхөн томилогдсон гишүүний хугацаа өмнөх гишүүний бүрэн эрхийн хугацаатай адилхан байх зэрэг асуудал тодорхойгүй, эрх зүйн зохицуулалтгүй байна.² Цаашид улируулан томилох,

² Тухайлбал, Улсын дээд шүүхээс санал болгож Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байсан Д.Эрдэнэчулууны хувьд 3 удаа буюу нийт 19 жил, Ч.Содномцэрэнг 2 удаа буюу 11 жил 7 сар, Ш.Солонго 2 удаа буюу 10 жил, Б.Ганбат 2 удаа буюу одоогоор 11 жил Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдон ажилласан байна.

бүрэн эрхийн хугацаа дууссан үед нөхөн томилгоо хийх эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгайлан тусгаж зохицуулах шаардлагатай байна.

2006 оноос хойш Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нэлээд маргаантай хэрхэн яаж нэр дэвшүүлэх асуудал нь тодорхойгүй явж ирсэн байна. Гэвч 2020 оноос Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дээр “албан ажлын шаардлагаар томилох” гэсэн нэршилтэй болсон. Энэ нь үйл ажиллагаагаа бие дааж, хараат бус байдлаар явуулах Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасан шаардлагатай зөрчилдөж байна. Хуульд тусгагдаагүй асуудал цаашид жишиг болон хэрэгжих эсэх нь тодорхойгүй юм. Энэ асуудлыг цаашид нэр мөр болгож зохицуулах шаардлагатай.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр 2006 оноос хойш томилогдсон төрийн жинхэнэ албан хаагчдын талаарх мэдээллийг авч үзвэл нийт 18 байгууллагын 36 албан тушаалтан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний бүрэлдэхүүнд ажилласан байна. Үүнээс, Улсын Их Хурлын Тамгын газраас 6, Цагдаагийн ерөнхий газрын дарга 5, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 4, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга 3, Үндэсний статистикийн хорооноос 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2, Сангийн яамнаас 2, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын ажлын албаны дарга 2, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга 1, Төрийн албан тушаал хашиж байгаагүй 1, бусад яамдаас 4 (тус бүр 1 удаа), Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга 1, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга 1, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга 1 удаа тус бүр томилогдсон байна.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг гурван эрх мэдлийн төлөөллөөс санал болгож, олон талын оролцоог хангаж байгаа хэдий ч нэр дэвшигчдийг санал болгох шалгуур нь тодорхойгүй

байна. Тухайлбал, Улсын дээд шүүхээс санал болгосон нэр дэвшигчдийн дунд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга гэсэн албан тушаалтнуудыг санал болгож байсан. Цагдаагийн ерөнхий газрын даргын хувьд гүйцэтгэх эрх мэдлийн буюу Засгийн газрын тохируулагч агентлагийн төлөөлөл байх бөгөөд эрх мэдэл, хяналт тэнцлийн зарчимд нийцэхгүй томилгоо болсон гэж үзэж болохоор байна.

Тухайн үедээ төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллаж байсан нэр дэвшигч томилогдож байгаа хэдий ч албан тушаалаасаа чөлөөлөгдөж, төрийн алба хашихгүй болсон тохиолдолд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр цаашид ажиллах боломжтой эсэх асуудлыг хуульд нарийвчлан зохицуулаагүй байна. Тухайлбал, 2020 онд Ерөнхийлөгчөөс санал болгосон Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал болгосон УИХ-ын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нар албан тушаалаасаа одоогоор чөлөөлөгдсөн. Цаашид энэ асуудлыг нэр мөр зохицуулах шаардлага үүссэн байна.

Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Гучин гуравдугаар зүйлийн 4-т “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно” гэж заасан. Гэтэл өдийг хүртэл Сонгуулийн ерөнхий хорооны есөн гишүүний хоёрыг Ерөнхийлөгчөөс санал болгодог эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх асуудлыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар засах шаардлагатай байгааг анхаарах нь зүйтэй байна.

---ooOoo---

Ном зүй

1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. Боть VIII, БНМАУ-ын АИХ-ын 1991.12.04-ний өдрийн хуралдааны протокол.
2. Б.Хатантуул (2005). Монгол Улсын Их хурлаас байгуулагддаг хараат бус, бие даасан байгууллагууд (агентлаг)-ын эрх зүйн зохицуулалт, Улаанбаатар.
3. Захиргааны ерөнхий хууль. 2015.07.24.
4. Ц.Цогт (2019). Захиргааны хэргийн шүүх, Улаанбаатар.
5. Р.Мухийт (2013). Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №2.
6. Eliot Bulmer. Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions, International IDEA Constitution-Building Primer 19 (2019)
7. Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition in A Democracy: A checklist,” Adopted by the Venice Commission at its 119th plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion № 845/2016, CDL-AD (2019)015
8. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал. <https://forum.parliament.mn/projects/11162> сүүлд 2025.10.08-ны өдөр хандсан.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Б.Сарантуяа

УИХ-ын Тамгын газрын дэргэдэх

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн

Судалгааны хэлтсийн судлаач

Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн (цаашид “Зохиогч” гэх.) “Сонгуульд суралцахуй” бүтээлийн “Сонгуулийн байгууллага” хэмээх дөрөвдүгээр бүлэг болон Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга асан Ж.Сүхбаатар (цаашид “Илтгэгч” гэх.)-ын илтгэлтэй танилцаад сонгуулийн байгууллагын талаарх өөрийн санал, дүгнэлтийг хүргэж байна. Юун түрүүнд, Зохиогчийн бүтээлийн “Сонгуулийн байгууллага” хэмээх бүлэг нь 1) Сонгуулийн үйл явцыг эрхлэх, түүнд оролцох хоёрын ялгаа, 2) Сонгуульд оролцогч байгууллагын төрөл, оролцоо, 3) Сонгуулийн байгууллагын тогтолцоо хэмээх дэд хэсгүүдээс бүтжээ. Үүнээс, эхний дэд хэсэгтээ сонгуульд оролцогч байгууллага болон сонгуулийг эрхлэн зохион байгуулагч байгууллага хоёрын ялгааг тодорхойлсон бол “Сонгуульд оролцогч байгууллагын төрөл, оролцоо” хэмээх хэсэгтээ 1) Улсын Их Хурал, 2) Засгийн газар, 3) Улс төрийн нам, эвсэл, 4) Бусад байгууллагын оролцоог тусгайлан авч үзэж тайлбарласан байна. Эцэст нь “Сонгуулийн байгууллагын тогтолцоо” гэх хэсэгтээ 1) Сонгуулийн ерөнхий хороо, 2) Сонгуулийн орон байгууллага (хороод), 3) Хорооны бүрэлдэхүүн, 4) Хорооны орон тоо, эрх үүрэг, 5) Хорооны ажлын зохион байгуулалтыг тус тус тайлбарласан байна. Харин Илтгэгчийн

хувьд өөрийн илтгэлийг “Оршил”, “Сонгуулийн үйл явцыг эрхлэх, түүнд оролцох хоёрын ялгаа”, “Сонгуульд оролцогч байгууллагын төрөл, оролцоо”, “Сонгуулийн байгууллагын тогтолцоо”, “Дүгнэлт” гэж бүлэглэн авч үзжээ. Хэлэлцүүлэгч миний хувьд Зохиогчийн бүтээл болон Илтгэгчийн илтгэлтэй танилцаж санал, дүгнэлтээ дараах агуулгад төвлөрүүлэн бичлээ.

Сонгуулийн төв байгууллагын бүтэц чиг-үүргийн бие даасан байдлын тухайд

Сонгууль бол ардчилсан улс төрийн үйл явцын тулгын чулуу бөгөөд улс төрийн нам, нэр дэвшигчид сонгогчдын өмнө тэгш нөхцөлд төрийн албан тушаалд өрсөлдөх механизмын суурь болдог. Үүнийг Зохиогчийн хувьд “Засаг төрийн төлөөх байгууллагын сонгууль бол улс төрийн өргөн цар хүрээтэй нарийн дэгтэй, нийлмэл үйл явц” (Б.Чимид, 2008, х.70) хэмээн үзсэн бол Илтгэгч “Сонгуулийн байгууллага нь ардчилсан институцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд засаг төрийн хууль ёсны эрх мэдлийн эх сурвалж ард түмний хүсэл зоригийг баталгаажуулах механизм” (Энэ номын 45 дахь тал) хэмээн дурджээ. Сонгууль найдвартай байхын тулд өрсөлдөөн шударга байхёстойбөгөөдүйл явцыгшударгаарудирданявуулахбиедаасан, хараат бус институц зайлшгүй шаардлагатай. Улс орнуудын хууль тогтоомжоос харахад сонгуулийн төв байгууллага, сонгуулийн хороо, сонгуулийн зөвлөл, мужийн сонгуулийн хороо, сонгуулийн удирдлагын байгууллага гэх мэтээр тодорхойлон заасан (ACE, Electoral Knowledge Network) байх ба ерөнхийдөө нэг чиг-үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг өөр өөрөөр нэрлэн хэвшсэн байна. Энэ нь Манай улсын хувьд Сонгуулийн төв байгууллага (General Election Commission) буюу сонгуулийн үйл явцыг удирдах эрх бүхий байгууллага болох Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд тодорхойлон заасан “Сонгуулийн төв байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо мөн” юм.

Сонгуулийн байгууллагын тухай өгүүлсэн “Сонгуульд

суралцахуй” бүтээлийн дөрөвдүгээр бүлэгт “Сонгуулийн үйл явцад хуулиар ногдуулсан үүрэг бүхий байгууллагуудыг “сонгуульд оролцогч байгууллага”, “сонгууль эрхэлсэн байгууллага” (товчоор “сонгуулийн”) гэж хоёр их хэсэгт хувааж болно” улмаар, “Сонгуулийг эхнээс бэлтгэн, хуулийн биелэлтийг эрхлэн зохион байгуулж, хянан зохицуулж, шалган дүгнэх бүрэн эрх бүхий байгууллагыг сонгуулийн байгууллага гэнэ. Харин сонгуулийн үйл явцын тодорхой үе шатанд хуулиар ногдуулсан ямар нэг тусгай үүрэг гүйцэтгэдэг бол сонгуульд оролцогч байгууллага гэж болно” гэж Б.Чимид (2008, х.77) тайлбарласан байна. Харин Илтгэгч өөрийн бүтээлдээ сонгуулийн байгууллагын тогтолцоо”-ны хүрээнд Зохиогчийн өгүүлсэн сонгуулийн байгууллагын тогтолцоог тухайн үеийн (СТХ) хуульд зааснаар мөн шинэчлэгдсэн хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн өөрчлөгдсөн болохыг харьцуулсан авч үзжээ. Тухайлбал:

Хүснэгт 1. Монгол Улсын Сонгуулийн байгууллагын тогтолцоо (өөрчлөлтийн харьцуулалт)

Зохиогч	Илтгэгч
• Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (ЕХ); • Тойргийн хороо (ТХ); • Сонгуулийн тойргийн салбар хороо (ТСХ); • Сонгуулийн хэсгийн хороо (ХХ) - ноос бүрдэнэ.	• Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо; • Аймаг, нийслэлийн хороо; • Сум, дүүргийн хороо; • Сонгуулийн хэсгийн хороо; • Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссоос бүрдэнэ.

Дээрхээс харахад, Зохиогчийн бүтээлд төрийн байгуулалтад хамаарах сонгуулийн тогтолцоог дотоодын дөрвөн түвшинд ангилж байжээ. Харин Илтгэгч энэхүү зохион байгуулалтыг хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд сонгуулийн байгууллагын

тогтолцоотой харьцуулжээ. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд хийгдсэн хуулийн шинэчлэлийн хүрээнд “тойргийн хороо”-г “аймаг, нийслэл-сум, дүүрэг”-ийн шатлалаар орлуулсан нь хууль, засаг захиргааны нэгдсэн тогтолцоотой нийцүүлсэн эрх зүйн шинэчлэл байна. Энэ нь сонгуулийн хороодыг нутгийн удирдлагын тогтолцооны дэргэд байгуулж, зохион байгуулалтын уялдаа, хариуцлага, эргэх холбоог баталгаажуулсан явдал хэмээн үзэх боломжтой байна. Мөн гадаад дахь салбар комиссыг бий болсон нь иргэний оролцоог нэмэгдүүлэх, сонгогчдын эрхийг нутаг дэвсгэрийн хүрээнээс ангид хэрэгжүүлэх шинэ туршлага болж, олон улсын жишгийг дагасан (transnational electoral management) өөрчлөлт болжээ. Үүнээс судлаач миний санал шүүмж сонгуулийн байгууллага хэмээх том малгай институцийн бүтэц-чиг үүргийн бие даасан байдалд төвлөрч Зохиогч болон Илтгэгчийн санаа, үзэл баримтлалыг уялдуулан авч үзэх болно.

Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн бие даасан байдалд юуг хамруулан авч үзэх тухай өгүүлье.

Нэгдүгээрт, сонгуулийн төв байгууллагыг судлах, бүтэц-чиг үүргийн бие даасан байдлын хувьд хэрхэн хөгжиж буйг тодорхойлох, сонгуулийн байгууллагын хараат бус байдлыг үнэлэх нь орчин үеийн ардчиллыг бэхжүүлэхэд туслах сонгуулийн шинэчлэлийн үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Сонгуулийн байгууллагын бүтэц, чиг үүргийг шинжлэхдээ нийгмийн бүтцийн функционализмын онол (Э.Дюркгейм, Т.Парсонс)-ын хүрээ ашиглах нь зүйтэй. Тус онолын дагуу нийгэм нь тогтвортой байдал, дэг журмыг хангахын тулд хамтран ажилладаг, харилцан уялдаатай хэсгүүдийн цогц систем юм (Durkheim, 1951). Энэ үүднээс сонгуулийн байгууллага бол улс төрийн тогтолцооны нэгэн институц бөгөөд түүний чиг үүрэг нь зөвхөн техник ажиллагаа бус, харин нийт ардчилсан тогтолцооны тогтвортой байдлыг хангах үүрэгтэй. Үүнийг Зохиогч “Сонгуульд суралцахуй” бүтээлдээ “сонгуулийн байгууллага нь зөвхөн техникийн зохион байгуулалтын

нэгж бус, харин хуулийн биелэлтийг хангах, сонгуулийн шударга ёсыг баталгаажуулах бүрэн эрх бүхий институц” байна хэмээн тайлбарласан байдаг. Үүнээс институцийн хараат бус, бие даасан байдлыг хангах нь сонгуулийн тэгш, шударга өрсөлдөөнийг дэмжиж, хуулийн биелэлтийг хангах, сонгуулийн шударга ёсыг баталгаажуулах, тайван замаар эрх мэдлийг шилжүүлэхэд ихээхэн чухал болно. Тиймд, сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүрэг хэмээх томъёоллыг онолын үүднээс задлан тайлбарлавал, Тоби Жеймсийн “Сонгуулийн удирдлагын байгууллага: үйл ажиллагаа, харилцаа, хэмжүүр” харьцуулсан судалгаанд дурдсанчлан бүтцийн хараат бус байдал гэдэг нь сонгуулийн төв байгууллагууд нь засгийн газрын салбар, ялангуяа гүйцэтгэх засаглалаас хараат бус, бие даасан байхыг ойлгоно. Энэ нь сонгуулийн байгууллага нь өөрийн гэсэн хууль эрх зүйн орчинтой, өөрийн төсөвт хяналт тавих, шийдвэр гаргах эрх мэдэлтэй, улс төрийн оролцогчдын зүй бус нөлөө, хөндлөнгийн оролцоогүй байх ёстой гэсэн үг. Харин чиг үүргийн хараат бус байдал гэдэг нь сонгуулийн төв байгууллага чиг үүргээ гадны нөлөөлөл, дарамт шахалтгүйгээр гүйцэтгэх чадварыг хэлнэ. Үүнд, сонгогчдын болон нэр дэвшигчийн бүртгэлийг хийх, санал авах байрыг бэлтгэх, зохион байгуулах, санал тоолох, санал хураалтад хяналт тавих, сонгуулийн маргааныг шийдвэрлэх зэрэг асуудал багтана. Дээрхэд хамаарах агуулгыг Зохиогч “сонгуулийн байгууллагын тогтолцоо” хэсэгт Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн орон нутгийн байгууллага (хороод)-ын бүрэн эрх, чиг үүргийн хүрээг нэрлэн тайлбарлаад “энэ бол сонгуулийг зөв шударгаар явуулахын тулд тогтоосон баталгааны нэг бөгөөд гагцхүү дээрх дархан эрх, зарчмыг сайтар ухамсарлаж зөвхөн Сонгуулийг бэлтгэн явуулахын тулд хууль ёсоор эдэлбэл зохино...” (Б.Чимид, 2008, х.86) мөн “...сонгуулийг бэлтгэж явуулах үйл явцад “хөндлөнгөөс хутгалдан оролцох ёсгүй” гэсэн зарчмын ойлголт, шаардлага бий.” хэмээн (Б.Чимид, 2008, х.78) өөрийн үзэл баримтлалыг өгүүлсэн байдаг.

Хоёрдугаарт, олон улсын зөвлөмж, баримт бичиг, гарын авлага, судалгааны тайлангуудад сонгуулийн төв байгууллагыг ангилах гурван үндсэн шалгуур ашиглагддаг (López-Pintor, 2000). Үүнд, **нэгт**, чиг үүргийн бие даасан байдал (бие даасан, засгийн газрын болон холимог сонгуулийн төв байгууллага хэмээн 3 хэсэгт ангилна); **хоёрт**, газарзүйн харьяалал (төвлөрсөн ба төвлөрсөн бус сонгуулийн төв байгууллага хэмээн ангилна); **гуравт**, байнгын болон түр зуурын зохион байгуулалтад ордог гэх шинжээр сонгуулийн төв байгууллагын ангилдаг. Үүнээс АСДҮОУХ-ийн боловсруулсан “Сонгуулийн удирдлагын дизайн” судалгаанд нь сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдлыг бие даасан, засгийн газрын болон холимог гэсэн гурван загварт ангилсан (Catt, 2014) бөгөөд бие даасан загвар бүхий улсууд сонгуулийн төв байгууллагыг Үндсэн хууль эсвэл хууль тогтоомжийн хүрээнд байгуулж баталгаажуулдаг (Catt, 2014). Засгийн газрын харьяа бүтэцтэй сонгуулийн төв байгууллага нь засгийн газрын шууд удирдлага дор эсвэл хууль зүйн яамны дор зохион байгуулагддаг. Холимог загварт хамаардаг улсууд сонгуулийн удирдлагыг удирддаг хоёр ба түүнээс дээш байгууллагуудын холимог загвар болох бөгөөд хяналтын үүргийг бие даасан байгууллагад, бодлого боловсруулах, санал гаргах үүргийг засгийн газрын харьяа хэсэгтээ өгч үүргийн хувьд хуваагддаг (Musbeh, 2011). Сонгуулийн төв байгууллагыг институцийн хувьд бие даасан эсэх нь бүтцийн, чиг үүргийн, эрх хэмжээний, нөөцийн хувьд бие даасан эсэхээс хамаардаг (International IDEA, 2014). Дээрх агуулгыг Илтгэгч өөрийн бүтээлдээ эш татан “Олон улсад сонгуулийг удирдах байгууллагыг гурван загварт ангилж бүлэглэх нь түгээмэл. Үүнд: 1) Бие даасан сонгуулийн байгууллагын загвар (Independent model); 2) Засгийн газрын хандлагатай загвар (Governmental model); 3) Холимог загвар (Mixed model) - дээрх загваруудын хослуулсан зохион байгуулалт, бүтцийн загвар; мөн тусгайлан “Шүүхийн хандлагатай сонгуулийн байгууллагын загвар” гэж

ангилах нь ч үзэгддэг” (Энэ номын 49 дэх тал) хэмээсэн байна. Дээрхээс байнгын болон түр зуурын зохион байгуулалтад ордог гэх шинжээр сонгуулийн төв байгууллагын ангиллыг “...сонгуулийн төв, орон нутгийн байгууллага гэх ба орон нутгийнх нь 3 шаттай, байнгын биш (түр зуурын) шинжтэй” мөн “сонгуулийн тойргийн төрөл, бүтцээс хамааран сонгуулийн байгууллагын байршил, эрх зүйн байдал өөрчлөгдөн хувьсаж байдаг” мөн “.. орон нутгийн хороод түр зуурын шинжтэй” хэмээн Зохиогч (Б.Чимид, 2008, х. 81) бүтээлдээ дурджээ. Харин Илтгэгч өөрийн илтгэлийн дүгнэлт хэсэгт “Сонгуулийн байгууллагын загварын хувьд манай сонгуулийн байгууллагын өнөөгийн загвар холимог бүтэцтэй гэж үзэж болно. Хөгжил хувьслын зам хандлага нь бие даасан, хүчтэй сонгуулийн байгууллага болон төлөвших чиглэлд байгаа гэж хувийн дүгнэлтээ илтгэгчийн зүгээс илэрхийлж байна” (Энэ номын 63 дахь тал) хэмээжээ. Харин хэлэлцүүлэгч миний хувьд сонгуулийн төв байгууллагыг “бие даасан загвар” хамаардаг хэмээн үздэг. Учир нь Монгол Улсын сонгуулийн төв байгууллагыг олон улсын судалгаануудад болон хууль тогтоомжид суурилсан нээлттэй өгөгдөлд буюу АСДҮОУХ-ийн сонгуулийн удирдлагын дизайн мэдээллийн санд “Бие даасан загвар”-тай улс хэмээн бүртгэсэн (International IDEA, 2020) байдаг. Мөн тус хүрээлэнгийн боловсруулсан “Сонгуулийн удирдлагын дизайн” тайланд мөн “бие даасан загвартай” хэмээн тодорхойлогдсон (International IDEA, 2014). Түүнчлэн дотоодын судлаачдын бүтээлд “Сонгуулийг бие даан зохион байгуулах эрхийг хуулиар олгосон зэрэг бие даасан загварын үндсэн шинжийг агуулж байна” (Д.Бат-Эрдэнэ, 2024, х.36) гэж үзсэн байдаг. Түүнчлэн манай улс дан ганц чиг-үүргийн бие даасан байдлын ангилалд хамаарах биш бүс нутгийн онцлогоос хамааран байнгын болон түр зуурын зохион байгуулалтын хэлбэрийг ашиглаж байжээ.

Гуравдугаарт, сонгуулийн төв байгууллагын хараат бус байдлыг нэмэгдүүлэх чиглэлд Зохиогчийн үзэл баримтлалыг

дэлгэрүүлэн авч үзвэл, Зохиогч "...нам, эвслийн адил тооны төлөөлөлтэй байх, хорооны бүрэлдэхүүнд улс төрийн албан тушаалтныг оруулахгүй байх, дарга болон нарийн бичгийн дарга нэг нам, эвслийн байхыг хориглох.." гэх зарчмыг (Б.Чимид 2008, х.85) бүтээлдээ тусгасан нь сонгуулийн байгууллагын институцийн хараат бус байдлыг дотоод зохион байгуулалтын түвшинд хангах агуулга бүхий байна. Энэхүү санаа нь АСДҮОУХ-ийн судалгаанд тодорхойлсон сонгуулийн байгууллагын хараат бус байдлын хоёр хэмжээст ойлголттой буюу (1) бүтцийн буюу институцийн хараат бус байдал, (2) шийдвэр гаргах үйл явц дахь улс төрийн нөлөөллөөс ангид байх байдалтай шууд уялдаж байна. Өөрөөр хэлбэл, Зохиогч бүтээлдээ эдгээр хоёр түвшний хараат бус байдлыг заавал хангах ёстойг тайлбарласан. Түүнчлэн хараат бус байдлын энэ хоёр хэмжээс нь Венецийн комиссын "Сонгуулийн сайн туршлагын кодекс" (Code of Good Practice in Electoral Matters)-т тусгагдсан олон улсын зарчимтай мөн нийцдэг. Тус кодекс сонгуулийн байгууллагыг улс төрийн манипуляцаас ангид байлгахын тулд бүтэц, бүрэлдэхүүн, шийдвэр гаргах үйл явц, ил тод байдлын бүх шатанд хараат бус байхыг шаарддаг. Энэ хүрээнд "гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа, бүрэлдэхүүн, төсөв, зохион байгуулалтын хувьд хараат бус байх" зарчим нь олон улсын эрх зүйд сонгуулийн институцийн ардчилсан баталгааны үндсэн илэрхийлэл гэж тооцогддог. Үүнээс Зохиогчийн үзэл баримтлал нь зөвхөн хорооны бүрэлдэхүүний дотоод харьцааг зохицуулах зарчим бус, харин сонгуулийн бүх шатны хороодыг гүйцэтгэх эрх мэдлээс институцийн хувьд ангид байлгах зарчмыг тайлбарласнаараа онцлог байна.

Дүгнэлт

Зохиогчийн "Сонгуулийн байгууллага" хэмээх дөрөвдүгээр бүлэг нь ардчилсан тогтолцооны үндэс болсон сонгуулийн үйл явцын институцийн зохион байгуулалт, эрх зүйн баталгаа, хараат

бус байдлын зарчмыг шинжлэх ухааны түвшинд тайлбарласан онцгой ач холбогдол бүхий судалгаа байна. Судалгааны ач холбогдлыг тодруулан авч үзвэл, Монгол Улсад сонгуулийн үйл явцыг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх зүй, чиг үүрэг, хариуцлага, бүтэц, хуваарилалтыг системтэй судалсан анхны онолын тайлбаруудын нэг бөгөөд: “сонгуулийг эрхэлсэн байгууллага” болон “сонгуульд оролцогч байгууллага”-ын ялгааг тодорхойлж, сонгуулийн үйл явцын удирдлага ба оролцооны хоёр өөр шинжийг ялгаж; Сонгуулийн байгууллагын төв-орон нутгийн шатлалт тогтолцоог цогцоор нь авч үзэж, түүний эрх мэдэл, чиг үүрэг, хариуцлага, уялдааг тайлбарласан; мөн хараат бус байдал, тэгш төлөөлөл, улс төрийн нөлөөллөөс ангид байх зарчмыг дотоод зохион байгуулалтын түвшинд тодорхойлсон нь онолын хувьд чухал хувь нэмэр бүхий бүтээл байна. Зохиогч сонгуулийн байгууллагыг зөвхөн техник туслалцаа үзүүлэгч бус, хуулийн биелэлтийг хангах, шударга ёсыг баталгаажуулах институц гэж үзсэн нь онолын гүнзгий ач холбогдолтой. Мөн Сонгуулийн байгууллагын бүтэц, чиг үүргийн бие даасан байдлыг төрийн эрх мэдлийн хуваарилалт ба ардчиллын хяналт-тэнцвэрийн зарчимтай холбож тухайлбал, хорооны бүрэлдэхүүний тухайд, “Нам, эвслийн адил тооны төлөөлөлтэй байх”, “дарга, нарийн бичгийн дарга нэг намын харьяалалтай байхыг хориглох” зэрэг дотоод зохион байгуулалтын зарчмыг тодруулан авч үзсэн нь сонгуулийн байгууллагын хараат бус байдлыг баталгаажуулах; улмаар төрийн эрх мэдэл хуваарилалтын бусад институцүүд “... сонгуулийг бэлтгэх, явуулах үйл явцад “хөндлөнгөөс хутгалдан оролцох ёсгүй”” гэсэн үзэл санааг дэвшүүлснээр институцийн хэм хэмжээг онолын түвшинд тодорхойлсон байна. Илтгэгчийн зүгээс Зохиогчийн бүтээлийг “Монгол Улсын Сонгуулийн эрх зүйн анхны сурах бичиг”..., “Нэг талаас уншвал гарын авлага, нөгөө талаас нь ухвал мэргэжлийн сурах бичиг мэт бичигджээ” (Энэ номын 66 дахь тал) хэмээн дүгнэсэнтэй санал нэгдэж байна.

Учир нь Зохиогчийн “Сонгуульд суралцахуй” бүтээл нь Монгол Улсын ардчилсан сонгуулийн эрх зүйн тогтолцоог онолын болон практикийн түвшинд системтэйгээр тайлбарласан, сонгуулийн байгууллагын хараат бус, бие даасан, хууль ёсны институцийн төлөвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан судалгааны бүтээл байна.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.
2. Д.Бат-Эрдэнэ (2024). Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг. Улаанбаатар.
3. Ж.Сүхбаатар (2025). “Сонгуулийн байгууллага” илтгэл.

III

Нам сонгуульд
оролцох тухай

СОНГУУЛЬД НАМ, ЭВСЭЛ ОРОЛЦОХ ТУХАЙ

Э.Гэрэлт-Од

*МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
дэд профессор, улс төрийн судлалын доктор*

Оршил

Миний бие Б.Чимид багш (цаашид “зохиогч” гэх)-ийн “Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй (2008 он) бүтээлтэй анх 2009 онд танилцаж, олзуурхан уншиж байлаа. Харин өнөөдөр уг бүтээлийн зургаадугаар бүлэг “Улс төрийн нам сонгуульд оролцох тухай”, долоодугаар бүлэг “Сонгуульд нэр дэвшүүлэх, түүнд тавигдах шаардлага, таны оролцоо” гэсэн хоёр бүлэгт улс төр судлалын арга зүйгээр тайлбарлах, дүгнэн шинжлэх нь нэн сонирхолтой агаад гүн хүндэтгэл гэж үзэж байна. Мөн улс төрийн намын дотоод ардчилал сэдвийг судалдгийн хувьд уг номын дээрх бүлгүүд нь нэн сонирхолтой, бас хариуцлагатай байсныг мөн тэмдэглэж хэлье.

“Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй” бүтээл нь сонгууль бол ардчиллын илэрхийлэл, сонгуульд суралцах нь ардчилалд суралцаж буй тасралтгүй үйл явц гэсэн үзэл санааг илэрхийлж дүгнэж байгаа бөгөөд, түүн дотроо энэхүү хоёр бүлэг нь сонгуульд оролцож буй намын үүрэг, нам, эвсэл, нэр дэвшигч сонгуульд оролцохын ач холбогдол, тавигдах шаардлага, цаашлаад намын дотоод ардчилал тэр дундаа урд нь огт хөндөгдөж байгаагүй намаас нэр дэвшүүлэх үйл явц, түүний ач холбогдлыг тайлбарлаж, цаашид анхаарах асуудлуудыг гаргаж

тавьснаараа улс төр судлал онолын болон улс төрийн практик асуудал, мөн иргэний улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд нэн ач холбогдолтой юм. Тодруулбал, уншигчдад i) шинэхэн ардчилсан Монгол Улсад хүний эрх, олон ургалч үзэлд тулгуурласан олон намт нөхцөл, сонгуулийн өрсөлдөөнийг хэрхэн зөв, үндэслэлтэй ойлгох, учир шалтгаан, хэрхэн шударга өрсөлдөхийг тайлбарласан, ii) сонгуулийн үйл явц, учгийг энгийнээр ойлгох, ухааруулах, мэдлэг чадвараа нэмэгдүүлэх, улс төрийн боловсрол олгох, iii) судлагдахууны хувьд дахин дахин судлах, хууль эрх зүйн орчныг сайжруулахад туслах философи, улс төр, эрх зүйн бүтээл гэж үзэж байна.

Агуулгын дүгнэлт

Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй” бүтээл Монгол Улсын Их Хурлын 1990-2008 хүртэл ардчилсан сонгуулийн үйл явц, эрх зүйн орчинд анализ хийж, сонгогч болон улс төр сонирхогч хэн бүхэн ашиглахуйц “амьдралтай”, “онолтой”, “ойлгомжтой”, **“бүтэндүү ажил”** (Б.Чимид, 2008, х. 291) ажээ. Учир нь энэ бүтээлд гаргаж ирсэн асуудал, санаа бүр нь одоо ч улс төр, эрх зүйн хөгжилд анхаарах үнэтэй санал, зөвлөмжүүдийг агуулсан байна.

Номын “Улс төрийн нам сонгуульд оролцох тухай” бүлэгт Нам, эвсэл сонгуульд оролцохын учир хэсэгт нам бол улс төрийн байгууллага гэдгийг онцолж, улс төрийн харилцааны сүнс нь засгийн эрх мэдлийг авах, оролцох, хэрэгжүүлэхийн төлөөх хууль ёсны оролцоо буюу тэмцэл, намууд тэгш эрхийн үндсэн дээр оролцох, олон нам сонгуульд оролцохын ач холбогдол нь иргэдэд сонголт өгч байгаа тухай, сонгогч сонгуульд оролцож саналаа өгөхдөө хариуцлагатай байх, сонгогчдоос авсан саналаараа намууд олонх болох, бүлэг байгуулах боломж олгогддог тухай бичжээ. Нам, эвсэл сонгуульд оролцохын тулд юу хийх ёстой хэсэгт нам өнгөрсөн хугацаанд юунд алдаж оносон, ирээдүйд ялахын тулд юу хийх, юунд анхаарах ёстой, хэд хэдэн нам эвсэл байгуулж сонгуульд оролцож болно, энэ тохиолдолд гэрээнд

нарийн зохицуулалтууд шаардлагатай. Нам, эвсэл сонгуульд оролцуулахаар бүртгэх үндэслэл, журам хэсэгт бүрдүүлэх материал, ямар нөхцөлд бүртгэхээс татгалзах үндэслэл зэргийг тодорхой хэлжээ. Мөн эвсэл тарах хэсэгт эвсэл гэж юу вэ?, эвсэлд нэгдсэн намуудын эрх, үүргийг тодорхой байх, эвсэлд нэгдсэн намууд тарснаар үүссэн нөхцөл, маргаантай асуудлуудыг цаашид хэрхэн зохицуулах талаар анхаарахыг зөвлөсөн. Эцэст нь бүртгүүлсний дараа нам, эвсэл сонгуульд хэсэгт нам, эвсэлд сонгуульд оролцох, сонгогдох аль аль нь хариуцлагатай шийдвэр болох, нэг ч сонгогчдын итгэлийг алдаж болохгүйг тайлбарлажээ.

“Сонгуульд нэр дэвшүүлэх, түүнд тавигдах шаардлага, таны оролцоо” бүлэгт Нэр дэвшүүлэх танд ямар хамаатай вэ? хэсэгт нам, эвслээс нэр дэвшүүлэх үйл явц нь сонгогчдод хамаатай маш чухал зүйл, үүнд сонгуулийн ямар тогтолцоо хэрэглэж байгаа нь нөлөөлдөг, мөн сонгогдох эрх бүхий иргэн бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэйг бичжээ. УИХ-ын гишүүнд нэр дэвшүүлэх нийтлэг үндэслэл, журам хэсэгт сонгуулийн ямар тогтолцоо хэрэглэж байгаа нь нөлөөлдөг, нэр дэвшигчдэд тавигдаж буй хуулийн шаардлагаа гадна улс төр, ёс суртахууны шаардлага байдаг тухай бичжээ. Нам, эвслээс нэр дэвшүүлэх хэсэгт нам, эвслүүд нэр дэвшигчээ амьдралын гүнээс олж нэр дэвшүүлэх, мөнгийг шалгуур болгохгүй байх талаар бичжээ. Эцэст нь бие даан нэр дэвших хэсэгт иргэн өөрөө бусад иргэний дэмжлэгтэйгээр нэрээ дэвшүүлэх боломж л байна, энэ нь бусад орнуудтай харьцуулахад хатуу зохицуулалт байгааг тус тус бичжээ.

Агуулгын шинжилгээ

Нэг. Нам хэмээх ойлголтын тухай. Улс төр судлалд намыг төрийн эрхийг барих зорилготой бүлэг хүмүүс гэсэн сонгодог тодорхойлолт байдаг бөгөөд орчин үед зорилго, үйл ажиллагаа, бүтэц, үүрэг зэрэг олон талаас тодорхойлох болсон. Зохиогч “нам” хэмээх ойлголт, түүний мөн чанарыг тайлбарлахдаа төрийн сонгуульд ямар хамаатай, яагаад түүнд идэвхтэй оролцдог

болохыг зорилгод тулгуурласан философийн өнцгөөс харж “аливаа нам засаг төрийн эрх мэдлийн төлөө, парламентад чадвал олонх, ядвал цөөнх, гацвал ганц суудалтай болохын төлөө чармайн ажилладаг” (Б.Чимид, 2008, х. 117) гэж тодорхойлжээ. Энэ нь нам байгуулсан болон нэгдэн орсон зорилгыг ойлгоход нэн чухал тайлбар юм. Мөн “намыг засгийн эрхийг хэрэгжүүлэхэд оролцох юм уу, эсвэл түүнд хяналт тавьж нөлөөлөх зорилготой учраас **улс төрийн байгууллага** мөн” (Б.Чимид, 2008, х. 117) гэж намын философи үндсийг гаргаж ирсэн байна. Тиймээс зохиогч “улс төрийн харилцааны амин сүнс нь засгийн эрх мэдлийг авах, оролцох, хэрэгжүүлэхийн төлөөх хууль ёсны оролцоо буюу тэмцэл мөн” (Б.Чимид, 2008, х. 117) гэж тодорхойлсон. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 16.10 зүйлээр иргэдэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх (Монгол Улсын Үндсэн хууль, 1992, §16) олгосныг эшилсэн байна.

Хоёр. Сонгууль ба намын тухай. Зохиогч “төрийн засгийн үйл хэрэгт зөвхөн сонгуулийн замаар голлон оролцдог”, “нам болж нэгдэх нь засгийн эрх, сонгуулийн **ардчиллаас үүдэлтэй**” гэж тайлбарласан. Энэ нь иргэд сонгуульд идэвхтэй оролцохын тулд нам болж зохион байгуулагдах энэ эрхээ эдэлж буй хууль ёсны өрсөлдөөн ажээ. Харин “нам засаг төрийг бүхэлд нь булаан эзэлж, ажил үүргийг нь орлон хийж, бүрэн эрхийг төлөөлөн хэрэгжүүлдэггүй юм” (Б.Чимид, 2008, х.119) ардчилсан улсад төрийн эрх мэдлийг хугацаатай, хяналттай, хуулийн хүрээнд хэрэгждэг тогтолцоо болохыг дурджээ. Тиймээс төр засаг тогтвортой байх ёстой, нам бол ардчилсан сонгуулиар төрийн эрхийг хугацаатай, хязгаартай удирдаж, намын бодлого хөтөлбөрийг л хэрэгжүүлдэг, намын эрх хязгаартай болохыг сануулжээ. Мөн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улс төрийн намын тухай хууль (2005)-д зааснаар 801 ба түүнээс олон тооны иргэд **нам байгуулах гэрээ** байгуулж, хөтөлбөр, дүрмээ батлан, нам байгуулснаа УДШ-д

хянуулан бүртгүүлнэ, тийнхүү бүртгүүлж гэрчилгээ авснаар намд тооцож үйл ажиллагаа явуулах эрхтэйг дурджээ. Энд нэг сонирхолтой үг нь зохиогч намыг “гэрээ байгуулж” эвлэлдэн нэгдсэн иргэд гэж тодорхойлсон. Энэ нь улс төр судлалд дахин судлах, **нутагшуулах** учиртай нэр томьёо гэж үзэж байна. Хуульчид иргэдийн дунд үүсэж байгаа аливаа харилцаа нь гэрээний үндсэн дээр зохицуулагддаг гэж үздэг. Тиймээс улс төр судлалд нам байгуулахыг эвлэлдэн нэгдсэн иргэдийн “улс төрийн гэрээ” гэж тодорхойлж болох юм. Учир нь намын гишүүний эрх, үүргийн харилцаа хэрэгжвэл гэрээгээр үргэлжилнэ, эс хэрэгжвэл гэрээ цуцлагдаж, харилцаа дуусгавар болох юм. Судлаач Д.Болд-Эрдэнэ намын эрх зүйг ерөнхий, корпоратив, ёс зүйн гэж хувааж судалсан (Д.Болд-Эрдэнэ. 2008) байдаг.

Зохиогч олон намын тогтолцоотой улсад буюу “олон ургалч ёсны нөхцөл дэх нам бол улс төрийн харилцаанд буюу засгийн эрхийн төлөө өрсөлдөөнд хүн амын зохих бүлэг хэсэг нэгдэн оролцохын тулд сайн дураараа нэгдсэн иргэдийн байгууллага юм” гэжээ. Энэ нь нам сонгуульд оролцох нь албан тушаалын хуйвалдаан биш, харин “улс төрийн хүсэл зориг, хууль ёсны ашиг сонирхол нэгтэй хэсэг иргэд нэгдэн оролцдог зохион байгуулалтын томоохон хэлбэр” (Б.Чимид, 2008, х.119) гэж тайлбарласан нь улс төр, эрх зүйн хөгжсөн өрнөдийн орны ойлголт, ухагдахууныг анх хэрэглэжээ.

Гурав. Сонгуульд оролцооны тухай. Зохиогч 1990 онд сонгосон олон намын тогтолцоог “олон намт нөхцөл” (Б.Чимид, 2008, х. 119) гэж хэлсэн нь энгийн атлаа ойлгомжтой, уншигчдад хүрэхүйц үгийг хэрэглэжээ. Сонгуульд олон нам оролцохын ач холбогдлыг “рестораны цэсэд нэг хоол бичсэн бол сонгоггүй, хэдэн хоол байгаа бол үйлчлүүлэгч дуртай хоолоо шилж сонгож захиална. Хэрэв дуртай нь байхгүй бол орхиод гарч болно” гэж нэгэн судлаачийг үгийг эш болгож сонгож нэг бол “төлөө”, нэг бол “эсрэг” өгнө, эсвэл хэнийг ч дэмжихгүй орхиж болно, мөн аль ч

намыг дэмжихгүй бол бие даан нэр дэвшигчийг дэмжин оролцох, эсвэл саналын хуудсанд бичигдсэн хэнд ч саналаа өгөхгүй орхих нь мөн чөлөөтэй” (Б.Чимид, 2008, х.119) гэж тайлбарлажээ. Зохиогч “сонгуульд оролцоно гэдэг нь таамгаар тэмтэрч, бусдыг дагалдан дарвих, наалдаж хэдэн бор төгрөг, аар саар өглөг, аятайхан амлалтад хууртаж ээлж өнгөрөөхийн нэр биш” (Б.Чимид, 2008, х.119) гэдгийг тодотгон хэрэглэж буй нь уншигчдад нэгийг сануулж, хоёрыг тунгаахад хүргэж байна. Мөн таны сонгосон намаас багадаа 8 нэр дэвшигч ялбал УИХ-д бүлэг байгуулж, таны дэмжсэн хөтөлбөрийг засаг төрийн бодлогод тусгах боломж бүрддэг, энэ нь өглөгөөр бус засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгээр дамжиж танд хүрдэг болохыг бичжээ.

Сонгуульд оролцох субъектүүд (нам, эвсэл, бие даагч) хариуцлагатай хандахыг зөвлөжээ. Мөн иргэнд хандан “Та аль нэг нам, эвслийг дэмжих бол бусдынх нь эсрэг байр суурьтай оролцож таарна. Ийм учир нам, эвсэл сонгуульд оролцохын учир утга эрх зүйн үндэс, журмыг судалж мэдэх нь зүйтэй. Ялангуяа тэдгээрийн хөтөлбөр, үйл ажиллагааны өнгөрсөн, одоо, ирээдүйн эерэг сөрөг тал, ашиг тус, үр нөлөөг цэгнэж үзэж сонголтоо хийвэл илүү оновчтой л доо” (Б.Чимид, 2008, х.119) гэсэн. Энэ нь иргэдэд сонгуульд оролцож нам, эвсэлд саналаа өгөхдөө илүү нарийн судалгаатай, гярхай, өөрийн болон улс орныхоо ирээдүйг харж сонголт хийх хэрэгтэй зөвлөсөн байна. Энэ иргэний болон улс төрийн боловсрол иргэн бүрд чухал болохыг дүгнэсэн юм.

Хэдийгээр сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчид улс төрийн үзэл бодол, асуудлыг шийдэх арга барилаараа уралдаж байгаа ч **зайлшгүй шаардлага** (заавал хэрэгжүүлэх) байгааг гаргаж ирсэн. (Б.Чимид, 2008, х.120) Энэ нь “юуны өмнө бүгд өнгөрсөн сонгуулийн оноо, алдаагаа дүгнэх нь нэн чухал байдаг, удаад нь ирээдүйд ялахын төлөө оролцоно, үүний тулд сонгуулийн мөрийн хөтөлбөр, арга тактикаа боловсруулна, хүн хүчээ базаана, намууд эвсэх эсэхээ шийднэ, зорилго бодлогоо олон түмэнд

таниулна, төсөв санхүүгээ бүрдүүлнэ, өөрийгөө болон нэр дэвшигчээ бүртгүүлэхэд үзүүлдэг бичиг баримтаа зэхнэ”. Тэгээд сонгуульд оролцох хууль ёсны эрхээ олж авах хэрэгтэй. Хэрэв намууд сонгуульд нэгэн эвсэл болж оролцох бол хуульд заасан шаардлагыг хангах хэрэгтэй. Үүнд эвсэлд нэгдсэн намууд гэрээ байгуулж, гэрээндээ эвслээ бүртгүүлэх, төлөөлөх байгууллагаа байгуулах, эвслийг тараах үндэслэл, журам, эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон байхыг хуулиар шаардаж байгааг бичжээ. Мөн эвслийн гэрээнд илүү хариуцлагатай хандах, гэрээ байгуулсан бол УИХ, эсвэл ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байх тул намуудын хамтын ажиллагааны чухал баримт бичиг болохыг сануулсан.

Дөрөв. Нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай. Зохиогч “аливаа сонгуульд хууль ёсны субъект, хуулийн шаардлагыг хангасан тохиолдолд оролцох эрхтэй” гэж бичжээ. Энэ нь хэн дуртай нам байгуулж, хэзээ ч хамаагүй сонгуульд оролцохоо илэрхийлж болохгүй, нам, эвслийг сонгуульд хариуцлагатай хандах, сонгуульд шударга өрсөлдөх, өрсөлдөгчдөд гарааны тэгш боломж олгох тухай асуудал юм. Нөгөө талаас эрх бүхий байгууллага, албан тушаалтан субъектив буюу хуульд зааснаас өөр шаардлага тавихаас сэргийлж байгаа зохицуулалт юм. Монгол Улсад энэ эрхийг Сонгуулийн төв байгууллага олгох бөгөөд сонгуулийн хуулиар нам, эвслийн бүрдүүлэх материал, бүртгэхээс татгалзах үндэслэлийг тодорхойлсон байдаг. (Б.Чимид, 2008, х. 124)

- Бүртгэхэд бүрдүүлэх материал: Сонгуульд оролцох тухай шийдвэр, Эвссэн намуудын дүрмийн (нотариатын гэрчилгээтэй) хуулбар, Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, Өмнөх сонгуулиас хойш намуудад иргэд, хуулийн этгээдийн өгсөн хандивын тайлан (аудитын баталгаатай), Намын буюу эвслийн эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүн, хаяг, утас зэрэг мэдээлэл,

Эвсэл бол эвслийн гэрээний хуулбар (нотариатын гэрчилгээтэй), нам тус бүрийн эвсэлд нэгдсэн тухай зохих байгууллагын шийдвэр, тэмдэглэл тус тус байна.

- Татгалзах үндэслэл (шалтгаан): Нам бүртгэгдээгүй, бүрдүүлэх материалд буй баримт бичгүүд дутуу эсвэл хүчинтэй биш, Хүсэлт болон эдгээр баримт бичгийг (сонгуулийн өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө) ирүүлэх хугацаа хожимдуулсан, Хуульд заасан эсвэл байгуулах журам, шаардлага зөрчсөн, Эвсэлд орсон аль нэг нам уг эвслийг бүртгэхээс өмнө түүнээс гарахаа илэрхийлсэн, Өмнөх сонгуулийн зардлын тайланг уул сонгууль дууссанаас хойш 1 сарын дотор ирүүлээгүй зэргээс өөр үндэслэлээр нам, эвслийг сонгуульд оролцуулахгүй байж болохгүй.

Тав. Эвсэл тарах тухай. Зохиогч эвсэл байгуулах бол хариуцлагатай шийдвэр, энэ шийдвэрийг гаргасан бол тогтвортой байлгахад намууд хариуцлага хүлээх үүрэгтэй. Тиймээс нэгт эвсэлд нэгдэж буй намуудын зохих байгууллага албан ёсоор шийдвэр гаргаж, эвслийг төлөөлөх байгууллагад албан ёсоор мэдэгдсэнээр эвслээс гарсанд тооцно. Өөр хэн дуртай хүний үг, захидал, мэдэгдэл огт хамаагүй, эвсэл бол намуудын сонгуулийн нэгдэл гэдгийг тодруулж өгсөн. Хэрэв “гэрээг цуцалж байгаа нь ердийн нэг шийдвэр биш, эвслийн төлөө саналаа өгсөн сонгогчдын итгэлийг эвдэж байгаа” (Б.Чимид, 2008, х.125) тухай онцгойлон сануулжээ. Үүнтэй холбоотой кейс УИХ-ын 1996, 2004 оны ээлжит сонгуулиудад болсон бөгөөд эвслийн гэрээ байгуулсан улс төрийн намууд сонгогчдыг хүндэтгэхгүй байгаа, судалгаагүй хөөрлөөр шийдвэр гаргадаг болох нь ажиглагдсан тул зохиогч энэ дээр онцгой ач холбогдол өгч тайлбарласан байна. Хэрэв эвсэл тарвал төлөөллийн байгууллагад эвслээс сонгогдсон төлөөлөгч/ гишүүний эрх үүрэг дуусгавар болох, бүлэг тарах зэрэг эрх зүйн үр дагавар гарахыг сануулжээ. Хэрэв “УИХ-д олонх болсон эвсэл

задарвал тэр байр сууриа алдаж, засгийн газрын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт орох ноцтой үр дагавар гарч болно” гэжээ. Иймээс намууд улс төрийн итгэлд үндэслэсэн эвсэл байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, үнэнч байж, хууль биелүүлэх ёс зүйн болон журамт үүрэгтэй гэж сануулжээ. (Б.Чимид, 2008, х. 125)

Зургаа. Нам, эвсэл сонгуульд оролцох тухай. Зохиогч “сонгуульд нам, эвсэл оролцох нь онцгой давуу эрх биш, харин ард түмний өмнө хүлээх бүх талын ачаа үүрэг нэмэгдсэний нотолгоо” (Б.Чимид, 2008, х.126) гэж ойлгомжтой бичжээ. Мөн нам, эвсэл сонгуульд оролцох нь “өргөн утгаараа улс орны өмнө тулгарсан бэрхшээлийг даван туулж, хөгжлийн замыг шулуутгах, иргэнийхээ сайн сайхан аж байдлыг тэтгэгч засаг, үр ашигтай удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнийг төлөвшүүлэн, төрийн үйлчилгээний хүртээмж өгөөжийг дээшлүүлэх үйлсийг хошуучлах өндөр хариуцлага ойртож буйн дохио юм” гэжээ. (Б.Чимид, 2008, х. 126)

“Нам, эвсэл сонгуульд оролцохын шууд зорилт нь сонгуулийг хууль ёсоор шударгаар явуулж, улс орныг удирдан хөтлөх ихээхэн чадвартай, үнэнч, шударга, ажил хэрэгч, шалгарсан улс төрчдийг олж сонгох талаар сонгогчдод дөхөм үзүүлж, хүний нөөцийг дайчилж, үлгэр жишээгээр ажиллахад оршино” гэжээ. Ер нь “сонгууль зохион байгуулалттай, зөв шударга, ардчилсан ёс журмаараа болж өнгөрөх эсэх нь нам, эвслийн төрх төлөв, ёс зүй, үйл ажиллагаанаас шууд хамааралтай” (Б.Чимид, 2008, х.126) байдаг гэжээ. Зохиогчийн энэ үг үнэхээр чухал бөгөөд ардчилсан сонгууль ба нам, эвслийн өрсөлдөөний тухай асуудал юм.

Мөн сонгуулийн тогтолцоо бүр эерэг болон сөрөг үр дагавартай байдгийг анхааруулж, элдэв гаж, сөрөг үзэгдлээс соргоогоор сэргийлж, дээд зэргийн соёлч, ёс зүйтэй байхад үлгэрчлэх нь ард түмний хүндэтгэл хүлээх гол нөхцөл мөн гэжээ.

Нам, эвсэлд сонгуульд оролцохдоо мөрийн хөтөлбөрөө Үндсэн хуулийн хүрээнд боловсруулж олон нийтэд таниулах, нэр

дэвшигчээ зөв шилж сонгох, тойрогт байршуулах, сонгуулийн байгууллагын үйл ажиллагаанд хөдлөнгөөс оролцохгүйгээр хууль ёсны шаардлагыг биелүүлэх, нэр дэвшигчээ бүртгүүлэх, туслах ухуулагч томилох, сурталчлах, кампанит ажлыг нь дэмжих, хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж зөрчил гажуудалтай тэмцэх, нэр дэвшигчдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, санал хураах, тоолох, дүн гаргахад хяналт тавих ёстой гэжээ.

Ер нь “нам, эвсэл сонгуульд оролцохдоо ил тод байдал, хууль ёс, шударга ёс, эрх тэгш байдлыг чанд сахих нь ардчилсан сонгуулийн үндсэн шаардлага мөн” гэжээ. (Б.Чимид, 2008, х. 127)

Долоо. Нэр дэвшигчийг тодруулах тухай. Зохиогч “санал өгөхийн өмнөх сонгуулийн үйл явцын хамгийн хариуцлагатай үе нь сонгох тушаал (Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгч)-д бүрнээ тэнцэх хүнийг тодруулж нэр дэвшүүлэх ажил” юм гээд “элсэх нь төгсөхийн хагас” гэдэг шиг “нэр дэвшүүлэх нь эцэслэн сонгохын эхний хагас” гэж зүйрлэж хэлсэн. Нэрээ улс төрийн намын дотоод ардчилалд намаас нэр дэвшүүлэх үйл явцыг илүү нээлттэй, ардчилсан аргаар тодруулахыг шаарддаг. (Б.Чимид, 2008, х. 128) Өнөөдөр ч Монголд намаас нэр дэвших эрхээ авах нь сонгуульд өрсөлдөхөөс хүнд даваа болчихоод байгаа талаар судлаачид (Э.Гэрэлт-Од, Д.Энхцэцэг) дурдсан байдаг.

Мөн нам, эвслээс нэр дэвших үйл явц зөвхөн нам, эвслийн асуудал биш, бас сонгогчдод маш их хамаатай тул зохиогч сонгогчдод хандаж “нам, эвслээс нэр дэвшүүлэх үйл явцыг сайтар анхаарч ажиглаж бай. Хэдийгээр нам, эвсэл нэр дэвшигчийг тодруулж байгаа энгийн үйл явц мэт боловч “хар нүднээс хөмсөг далдуур” гэж хандаж болохгүй, харин “нүдийг нь олох учиртай” амин чухал үйл явц” (Б.Чимид, 2008, х. 128) гэж хэлсэн нь иргэдэд зүйрлэл хэрэглэн ойлгуулах арга ажээ.

Нам, эвслээс нэр дэвшигчийг тодруулах энэ үйл явц нь үнэндээ нэг төрлийн сонгууль бөгөөд зарим оронд намын гишүүдийн дунд, эсвэл нээлттэй хэлбэрээр санал хураалтаар

тодруулдаг. Зохиогч “УИХ-ын гишүүнд нэр дэвшүүлэх гэдэг чухамдаа **урьдчилан сонгох хэлбэр** бөгөөд сайн парламенттай болохын тулд уг тушаалд бүх талаараа тохирох зүтгэлтнүүдийг амьдралын гүнээс илрүүлэн олж, өрсөлдөөнд оруулан шалгаруулна гэсэн үг” тиймээс нам, эвсэл ч, иргэд ч сайн судалгаатай хандаарай гэжээ.

Мөн зохиогч сонгуулийн мажоритар тогтолцоог “олонхоор сонгох тогтолцоо” гэж нэрлэсэн бөгөөд энэ тогтолцоог хэрэглэж байгаа тохиолдолд нэр дэвшигчийг нам эвслээс, эсвэл сонгогдох эрх бүхий иргэн бие даан нэрээ дэвшүүлэх гэсэн хоёр хувилбар байдаг. Иргэн та нэр дэвшигчдийг тоохгүй “хувиа бодон довоо шарлуулбал” та хамгийн зожиг идэвхгүй, улсын эзэн байх эрхээ эдэлдэггүй нэгэн болж үлдэнэ. Нэр дэвшүүлэх нь огт муу зүйл биш, харин ч сайн, эрхээ эдэлж байгаа зүйл гэж хэлжээ.

Нэр дэвшүүлэх нь сонгуулийн ямар тогтолцоотой байхаас хамааран өөр өөр байж болно. Манай улс сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэглэж байсан тул зохиогч нэр дэвшигчийг тодруулахад дараах зарчмыг баримтлахыг зөвлөсөн. Үүнд **хууль зүйн тусгай шаардлагад** нэг хүн зөвхөн нэг тойрогт нэрээ дэвшүүлнэ, УИХ-д нэр дэвшигч нь 25 нас хүрсэн Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн байна, нэр дэвшигч нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, батлан заалтын хийгээд бусад гэрээний болон албан татварын өр төлбөргүй байх, ялгүй буюу гэмт хэргийн учир ял шийтгүүлээд эдэлж дууссаны дараа Эрүүгийн хуульд зааснаар ял шийтгэлтэйд тооцогдох хугацаа дууссан байх зэрэг болно. Мөн **ажил хэрэг, улс төр, зан суртахууны өндөр шаардлага** байх ёстой гэжээ. Зохиогч Монгол төрийн албанд “түмний итгэлийг олсон”, “шударгуу”, “эрдэм илүү, сахилга ариун, ажил хэрэгт хичээнгүй, нас залуу буюу тэнхлүүн” хүнийг олж тавихыг хичээнгүйлж байсан. Түүнчлэн ховдог, шунахай, харгис, чадалгүй, үхээнц, эрдэм дорой, хичээнгүй бус зэргийг төрийн түшмэлд тохирохгүй гэж үзэж байсныг дурджээ.

(Б.Чимид, 2008, х. 133)

Тиймээс зохиогч нам, эвслээс нэр дэвшүүлэх үйл явцыг зураглаж үзүүлсэн нь хэрэглэгчдэд энгийн ойлгомжтой болжээ. Зарим нам нэр дэвшигчээ тодруулахдаа анхан шатны байгууллагын гишүүдийн хурлаар хэлэлцэж тодруулаад, аймаг, улсын хэмжээнд урьдчилан шалгаруулах, олон нийтийн дунд тандан судалгаа явуулах зэрэг арга хэрэглэж буй үлгэр жишээ туршлага байгааг дурджээ. Харин нөлөө бүхий МАХН, АН-ууд УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг тодруулахдаа хүн бүрээс “хандив”, “дэнчин” гэх нэрээр 20 сая төгрөг авсан нь нам албан тушаалын арилжаа явагдаж, авлигын үүдийг нээж байна. Улмаар сонгогчид хууль зөрчсөн хандивлагчдыг сонгох болж байна уу? (Б.Чимид, 2008, х. 117) гэж асуужээ.

Мөнгөний сонгуулийн талаар эртний сэтгэгч Аристотель Грек, Ромын улс төрийг судлаад “сонгуулийн их тушаалыг их хөрөнгөтэй хүн худалдан авдаг”, “их биш хөрөнгө хуримтлуулсан хүн ч бас босгыг давах хөрөнгийг цуглуулан албан тушаалыг аваад дараа нь гарзаа нөхдөг” (Б.Чимид, 2008, х. 136) гэснийг эш татсан байна.

Орчин үед АНУ-д нэр дэвшигчийг тодруулахдаа нам дотроо урьдчилсан сонгууль явуулдаг нь сайн туршлага, Монгол Улс 1990 онд УИХ-ын нэг мандатад нам, эвсэл, хөдөлмөрийн болно нутаг дэвсгэрийн хамт олноос хэд хэдэн хүн нэр дэвшүүл нийт 430 тойргоос 3-аас дээш нэр дэвшигчтэй тойрогт урьдчилсан санал хураалт явуулж байсныг дурдсан нь цаашид сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэглэсээр байвал энэ мэт туршлагаас судлахыг зөвлөжээ.

Найм. Бие даан нэр дэвшүүлэх тухай. Монгол Улс “олонхоор сонгох тогтолцоо”-г хэрэглэж байгаа тул сонгуулийн насны эрх бүхий иргэн сонгогдох эрхтэй. Зохиогч “Гадаадын олон оронд тодорхой тооны (жишээ нь 25 иргэний гарын үсэг) иргэд нэгдэж дотроосоо нэр дэвшүүлэх, эсвэл иргэн барьцааны мөнгө төлж

өөрийгөө нэр дэвшүүлэх арга байдаг. Харин Монгол Улсын иргэн өөрөө бусад иргэний дэмжлэгтэйгээр нэр дэвшүүлэх аргыг хэрэглэж байна” (Б.Чимид, 2008, х.138). Гэхдээ хуулиар улс төрийн нам байгуулахтай ижил шалгуурыг 1992 оноос хойших сонгуулийн хуулиудад хэрэгслээр иржээ. Бие даан нэр дэвших нь Үндсэн хуулиар олгогдсон иргэний сонгогдох эрх, гэтэл бид эхлээд 801-ээс доошгүй сонгогч-иргэний гарын үсэг, тэр гарын үсгийг нэр дэвших тойрогт хамрагдах бүх хорооны төлөөлөл байх, маш бага хугацаанд цуглуулах ёстой гэсэн нь гэсэн хэт хатуу шаардлага болсныг шүүмжилжээ. Энэ нь нам бусуудын нэр дэвшүүлэх эрхийг хуулиар хязгаарласан үйлдэл болсон гэжээ. Ардчилал бол төлөөлөл байгууллагаа өөрсдөө сонгож байгуулах ард түмний бүрэн эрхт байдал. Гэтэл энэ мэт согогийг арилгах, илүү ардчилсан арга замыг тогтоох нь улс төрчид, иргэний нийгэм, улс төрийн хөдөлгөөний нийтлэг зорилго байх ёстой гэсэн.

Дүгнэлт

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй” бүтээл нь 1990-2008 хугацааны ардчилсан сонгуулийн үйл явц, эрх зүйн орчинд анализ хийсэн ч, өнөөдөр 17 жилийн дараа ч үнэ цэнэ, ач холбогдолтой, сонгогч болон улс төр сонирхогч хэн бүхэн хэрэгтэй “ширээний ном” байна.

Номын “Улс төрийн нам сонгуульд оролцох тухай” болон “Сонгуульд нэр дэвшүүлэх, түүнд тавигдах шаардлага, таны оролцоо” бүлгүүд бүхэлдээ улс төр судлалын судлагдахуун бөгөөд философийн тайлбар, эрх зүйн зохицуулалтын шинжилгээ, дэвшүүлж буй саналууд нь онол практикийн ач холбогдолтой тул цаашид олны хүртээл болгох хэрэгцээ байна. Учир нь өнөөдөр олон нийтийн дунд нам ямар хэрэгтэй юм, намд итгэхгүй байна, намаас татгалзъя гэсэн туйлширсан ойлголт, хандлага байгаа

нь сүүлдээ ардчилал, сонгуульд сөргөөр нөлөөлөх эрсдэл байна. Тиймээс намын төлөвшил, намын дотоод ардчилал, иргэдийн улс төрийн боловсролыг нэмэгдүүлэхэд тус дөхөм болох юм.

Улс төрийн харилцааг эрх зүйгээр бүрэн зохицуулж чадахгүй нь ойлгомжтой, мөн өөрчлөгдөж буй нийгэм, улс төрийн харилцаанд энэ бүтээлийн агуулга, үнэ цэнэ, утга учиртай өргөхийн тулд үргэлжлүүлэн судалж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах хэрэгтэй юм байна.

Зохиогч өөрөө 2008 онд уг номыг танилцуулах уулзалт дээрээ энэ бүтээлийг бичсэн нэг шалтгаан нь “нам, эвсэл, улс төрчид сонгуулийн хуулиа мэддэггүй, мэдсэн ч мөрддөггүй байдал хуульчдын санааг зовоож буй асуудлын нэг болсон байна. Тиймээс намуудын хувьд хариуцлагатайгаар нэр дэвшүүлэх, нэр дэвшигчид хуулийн дагуу хариуцлагатай байх, мөн иргэд сонгогчид сонголтдоо хариуцлагатай байж ач холбогдол өгч сонголтдоо хийхийг уриалсан байна. Өнөөгийн нийгмийн байдалд дүн шинжилгээ хийвэл ард иргэдээ сонгуульд суралцуулах нэн шаардлагатай” хэмээн хэлжээ. Тэгэхээр ардчилсан сонгуульд суралцах, ялангуяа намуудыг хариуцлагатай байх, хуулиа дагаж мөрдөж, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа /урьдчилсан сонгох хэлбэр/-г нийтэд ил тод болгох, иргэд сонголтдоо хариуцлагатайгаар хийж сурах хэрэгцээ, шаардлага одоо ч байсаар юм.

---ooOoo---

Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.01.13.
2. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
3. Э.Гэрэлт-Од. Нэр дэвшигчийг тодруулах үйл явц хаалттай байсаар байх уу? <https://ikon.mn/opinion/1zpw>
4. Д.Энхцэцэг. Намын дотоод ардчилал, нэр дэвшүүлэх процесс - Бодлогын асуудал №41. <https://forum.mn/product/357100?page=25>

САНАЛ, ДҮГНЭЛТ

Д.Бумдарь

УИХ-ын Тамгын газрын

*Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал,
улс төр судлалын доктор, дэд профессор*

Миний бие Э.Гэрэлт-Од судлаачийн Бяраагийн Чимид хэмээх олноо хүндлэгдсэн эрхмийн “Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй (2008)” хэмээх бүтээлийн 6, 7 дугаар бүлэгт зориулан бичсэн дүгнэх илтгэлд санал, шүүмж өгөх үүрэг хүлээн авсан. Э.Гэрэлт-Од судлаач тус бүтээлийг улс төр-эрх зүйн бүтээл хэмээн нэгтгэн дүгнэсэнтэй санал нэг байхын сацуу, дүгнэх илтгэлийг уншихад өгөөжтэй байлаа.

Бяраагийн Чимид багшийн “Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй” эх бүтээлийг дахин уншаад тус бүтээл хэвлэгдээд 17 жилийн цаг хугацааг үдсэн хэдий ч бид сонгуульд бүрэн суралцаагүй гэдгээ дахин баталгаажуулав. Судлаач Э.Гэрэлт-Од илтгэлдээ “сонгууль бол ардчиллын илэрхийлэл, сонгуульд суралцах нь ардчилалд суралцаж буй тасралтгүй үйл явц...” (Энэ номын 95 дахь тал) хэмээн дүгнэжээ. Явцуу утгаараа сонгуулийн замаар төрийг эмхлэн байгуулж буй нь судлаачийн өгүүлсэн ардчилалд сурч байгааг илтгэх талтай. Үнэхээр, сонгуулийг тогтмол зохион байгуулж буй нь ардчиллын нэг илрэл боловч, манай улсын ардчиллын индексүүд буурах, сонгуулийн идэвх саарах, сонгуулийн санхүүжилт тэлэх, сонгогчийн боловсрол ахихгүй байх зэрэг үзэгдлүүд нь “сонгуулийн ардчилал” хангалтгүй байгааг илтгэж байна. Иймээс бид ардчилалд суралцаж байгаа ч сонгуулийн мөн чанар, агуулгыг зөв ойлгож эзэмшээгүй байж болох юм.

Э.Гэрэлт-Од судлаач эх бүтээлийн 2 бүлгийг дүгнэн бичихдээ бүтцийн хувьд 8 хэсэгт ангилжээ. Үүнээс миний бие нэгдүгээр

хэсэг болох “Нам хэмээх ойлголтын тухай”, тавдугаар хэсэг болох “Эвсэл тарах тухай”, долдугаар хэсэг болох “Нэр дэвшигчийг тодруулах” тухай хэсгүүдэд багахан нэмэлт санал дүгнэлтийг өгч байна.

1. Нам хэмээх ойлголтын тухай: Нам бол улс төрийн байгууллага, “...засгийн эрх мэдлийг олж авах, оролцох, хэрэгжүүлэхийн төлөө хууль ёсны оролцоо буюу тэмцэл... сонгуульд оролцох...” гэж Э.Гэрэлт-Од (Энэ номын 97 дахь тал) судлаач тодорхойлжээ. Б.Чимидийн бүтээлд ч мөн “... нам болж нэгдэх нь засгийн эрх, сонгуулийн ардчиллаас” үүдэлтэй хэмээсэн (Б.Чимид, Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй, 2008, 2025). Энэ хоёр тайлбар нь улс төрийн нам сонгуулиар төрийг эмхлэн байгуулах туйлын зорилготой улс төрийн байгууллага болохыг илтгэдэг. Гэхдээ эх бүтээлд сонгуулийн ардчилалтай нам хамааралтай хэмээсэн нь сонгууль, улс төрийн намын шууд харилцаа, уялдаанд анхаарал хандуулах ёстойг илэрхийлсэн болов уу. Учир нь сонгуулийн тогтолцооноос хамаарч улс төрийн намын систем, өрсөлдөөний хэлбэр, нам, эвслийн тогтвортой байдал хэлбэрждэг. Нөгөө талаас, сонгуулийн үйл явцыг системтэй, хариуцлагатай болгох нь улс төрийн намын анхдагч үүрэг байдаг. Иймд, сонгууль ба улс төрийн нам нь ардчилсан тогтолцооны хоёр тулгуур институт юм. Сонгууль нь ард түмний засаглах эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, нам нь тэрхүү эрхийг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх зуучлагч билээ гэдгийг онцлон нэмэх саналтай байна.

2. Эвсэл тарах тухай: Судлаач Э.Гэрэлт-Од энэ хэсэгт эх бүтээлийн үзэл санааг дэмжин сонгуулийн өмнө эвсэл байгуулах нь хариуцлага, тогтвортой байдал, сонгогчдын илтгэл юм хэмээн онцолсон. Улмаар эвсэл тарах нь төлөөллийн байгууллагад эвслээс сонгогдсон төлөөлөгч/ гишүүний эрх үүрэг дуусгавар болох, бүлэг тарах эрх зүйн үр дагавар гарах талаар онцгойлон авч үзсэн байна. Хэлэлцэгч миний хувьд улс төрийн намууд эвсэх талаар холбогдох

хуулийн заалтыг мэддэг ч, эвсэл тарах асуудлаарх улс төрийн мөн чанарыг суралцаагүй байна гэж дүгнэж хэлмээр байна. Учир нь эх бүтээлд Б.Чимид багш "... хөтөлбөрийг дэмжиж, нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн бүх сонгогчийн илтгэлийг эвдэж, парламентын үйл ажиллагааг сүрхий доголдуулдаг" (2008, 2025) хэмээсэн нь өнөөдрийн улс төрийн нөхцөлийг урьдчилж бичсэн мэт. Тодруулбал эвсэл байгуулахад гэрээ хийдэг, эвсэл тарах бол эрх зүйн бөгөөд улс төрийн соёлын сөрөг үр дагавар авчирч хууль тогтоох байгууллагын легитим байдлыг бууруулдаг хэмээжээ. Гэвч, сонгуулийн үр дүнгийн дараа сонгогчдын итгэлийг эвдэн хууль ёсны бус "зохицол" хийн хамтарсан засгийн газар байгуулсан нь улс төрийн ямар ч соёлд суралцаагүйг илтгэнэ. Энэ үйлдэл нь сонгуулийн мөн чанар, сонгуулийн ардчилалд үзүүлэх үр нөлөөг үнэгүйдүүлж буй хэлбэр юм. Энэ хэсэгт эвсэл тарах нь сонгогчдын илтгэлийг эвддэг бол гэрээгүй хамтрал нь сонгуулийн тогтолцоонд үл итгэх байдлыг бий болгодог гэдгийг тэмдэглэхийг санал болгож байна.

3. Нэр дэвшигчийг тодруулах: Улс төрийн намын энэхүү чухал үүргийг миний хувьд судлах дуртай сэдэв юм. Манай улс төрийн шинжлэх ухаанд намаас сонгуульд нэр дэвшүүлэх үйл явцыг "нууц цэцэрлэг (secret garden)" (Michael Gallagher and Michael Marsh, 1988) гэж нэрийддэг. Учир нь цэцэрлэгийн дотор юу ургаж байгааг цөөн хүмүүс мэддэгтэй зүйрлэсэн санаа юм. Судлаач Э.Гэрэлт-Одын илтгэлд нэр дэвшигчийг тодруулах үйл явц ач холбогдол, улс төрийн соёлын үүргийн талаар дэлгэрэнгүй бичжээ. Мөн эх бүтээлийн зохиогч "элсэх нь төгсөхийн хагас гэдэг шиг нэр дэвшүүлэх нь эцэслэн сонгохын эхний хагас" хэмээх зүйрлэсэн нь нэр дэвшигчийн улс төрийн үнэ цэнийг тодорхойлсон гүнзгий санаа юм. Б.Чимид зөв, шударга, эрдэмлэг, ажилсаг хүнийг нэр дэвшүүлэн сонгох талаар энгийн ойлгомжтой бичсэн байхад өнөөдрийг хүртэл манай улс төрийн намууд нэр дэвшүүлэх нээлттэй журамгүй, намын дотоод ардчилал сул хэвээр байна. Тус бүтээлийг 1990-2008 оны хоорондох

сонгуулийн кейсүүд дээр суурилан бичсэн. Эндээс дүгнэхэд бид нэр дэвшүүлэх үйл явцад “суралцаагүй” хэвээр байна. Олон улсын жишгээр нэр дэвшигчийг тодруулахдаа ердийн, тусгай гэсэн шалгууруудыг ашигладаг бол манай улс төрийн тогтолцоонд энэ үзэл санаа бүрэн орхигдсон. Тиймээс энэ илтгэлд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журмыг нээлттэй, хариуцлагатайгаар албажуулах талаар онцолмоор байна.

Дээрхээс дүгнэн хэлэхэд Бяраагийн Чимид багшийн үлдээсэн улс төр-эрх зүйн өвөөс бид суралцах зүйлээ хангалттай олж аваагүй байна. Э.Гэрэлт-Од судлаачийн илтгэл нь тус бүтээлийг улс төрийн судлалын үүднээс “сонгууль-нам-иргэн” гэсэн гурвалсан харилцааг эрх зүйн болон философийн өнцгөөс нэгтгэн тайлбарласан анхны оролдлогын нэг юм. Манай улс төр судлалд сонгууль, улс төрийн нам бол цөм судлагдахуун байдаг. Тиймээс сонгуульд суралцахуй гэдэг нь зөвхөн хуулийн мэдлэг бус улс төрийн соёл, иргэний боловсрол, улс төрийн хариуцлага хэмээх цогц ойлголт болох ёстой.

Эцэст нь сонгуульд суралцах нь ардчилалд суралцах, ардчиллыг хөгжүүлэх үйл явц, улс төрийн тогтолцоог төлөвшүүлэх гол хэрэгсэл гэдгийг энэхүү бүтээл гүн гүнзгий харуулсан байгааг бид дахин суралцах хэрэгтэй байна.

---ooOoo---

Ном зүй

- 1.Б.Чимид (2008, 2025). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
- 2.Michael Gallagher and Michael Marsh. (1988). Candidate Selection in Comparative Perspective: The Secret Garden of Politics. London: Sage.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Ж.Жаргал

*Удирдлагын академийн Судалгаа, эрдэм шинжилгээний
албаны дарга, улс төр судлалын доктор, дэд профессор*

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Бяраагийн Чимид гуайн “Сонгуульд суралцахуй” бүтээлийн уншлагад зориулж, доктор, дэд профессор Э.Гэрэлт-Одын бичсэн “Сонгуульд нам, эвсэл оролцох тухай” илтгэлийг уншиж төрсөн сэтгэгдэл, хувийн үзэл бодлоо сийрүүлэн бичихийг зорилоо.

Монгол Улс авторитар дэглэмээс ардчилалд шилжиж, парламентын засаглалыг сонгон, чөлөөт сонгуулийн замаар төрийн эрх барих дээд байгууллагаа сонгодог болоод 30 гаруй жилийг үджээ. Энэ хугацаанд манай улс ардчиллын үнэт зүйлсээ хадгалж, Ази тивдээ төдийгүй дэлхийд загвар болохуйц ардчиллын түүхийг бүтээж чадсан. Ази-номхон далайн бүс нутгийн 4.3 тэрбум хүний дөнгөж 5 хувь нь буюу 200 сая гаруй хүн эрх чөлөөт, ардчилсан улсад амьдарч байна (Freedom house, 2024, р. 24). Ардчилсан засаглал тогтвортой, дарангуй дэглэм рүү шилжих, аливаа эрсдэл, аюулаас ангид байхад нөлөөлөх чухал хүчин зүйл нь чөлөөт ардчилсан сонгууль, олон намын тогтолцоо, сонгуулийн бүх процесс өөрөө шударга, зөв байх явдал юм.

Б.Чимид гуайн уг бүтээл мэргэжлийн нэр томьёо ойлголт, сонгуулийн нарийн үйл явцыг хэн бүхэнд энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлаж илэрхийлсэн, үнэ цэнэ, ач холбогдлоо түүхийн явцад алдахгүй, дунд сургуулийн сурагчаас, их хурлын

танхимд сууж байгаа гишүүд, улс төрч хэн бүхний хувьд уншвал зохих ширээний ном юм. Уг бүтээлийн нэг онцлог шинж нь нэг талаас хүн бүр өөр өөрийн онцлогтой дүгнэлт, санал шүүмжийг хялбархан гаргаж болохуйц байдлаар бичигдсэн бол нөгөө талаас онол, практик, бодлого, эрх зүйн өндөр түвшний санал шүүмжийг ч гаргах боломжтой юм. Судлаачийн хувьд тус бүтээлийг уншаад бидний цөөхөн монголчууд ийнхүү ардчиллаа сахин хамгаалж, үлдэхэд Монгол Улсын Үндсэн Хууль, сонгосон засаглалын хэлбэр, сонгуулийн тогтолцоо чухал нөлөө үзүүлэх юм байна гэсэн итгэл үнэмшил улам хүчтэй болсныг онцлон тэмдэглэх нь зөв болов уу.

Энэхүү бүтээлийн үнэ цэнэ, ач холбогдлыг Э.Гэрэлт-Од доктор сонгуульд нам, нэр дэвшигчийн гүйцэтгэх үүргийн тухай бүлэгт дүн шинжилгээ хийхдээ улс төрийн шинжлэх ухааны өнцгөөс гаргаж ирсэн нь сонирхолтой болжээ. Ялангуяа бидний төдийлөн ач холбогдол өгөлгүй өнгөрөөдөг, нэр дэвших тухай процесст ач холбогдол өгчээ.

Өнөө цагт сонгуульд нэр дэвших нь зөвхөн мөнгөтэй хүний хийдэг ажил шиг харагддаг болсон энэ цаг үед Б.Чимид гуайн бүтээлд нэр дэвшигчийн тухайд “Амьдралын гүнээс орон нутаг, салбар хүрээндээ тодорч хүлээн зөвшөөрөгдсөн шинэ сэргэг хүнийг товойлгон гаргаж олны сонголтод оруулах” (Б.Чимид, 2008, х. 109) гэдэг санааг хөндсөн нь өнөөгийн монголын улс төрд, иргэд сонгогчдын эргэцүүлэн бодох нэг чухал асуудал юм. Зөвхөн нэг баримтыг авч үзье. Үндэсний Аудитын газраас УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлсэн бөгөөд нэр дэвшигч нь тойргоосоо хамаарч 890.0 саяас 1.5 тэрбум хүртэл төгрөгийн зардал гаргахаар тогтсон (Төрийн аудит, 2024). Жилээс жилд сонгуулийн зардал өсөх тусам Б.Чимид гуайн бидэнд үлдээсэн үзэл санаа, энэхүү бүтээлийг эргэн харах, дахин унших сэдэл улам сэргэсэн болно. Бид цаашдаа улс төрийн санхүүжилт тэр дундаа улс төрийн нам, сонгуулийн санхүүжилтийн

ил тод байдал, бодлого эрх зүйн орчныг сайжруулж, улс төрийн намыг төрөөс санхүүжүүлдэг хэв загвар луу явах хэрэгтэй байна.

Бүтээл хэвлэгдэх тухайн цаг үед манай улс 76 гишүүнтэй парламенттай байсан бол өнөөдөр Үндсэн Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 126 гишүүнтэй болж өргөжсөн. Илүү өргөн бүрэлдэхүүнтэй болсон парламентад улс төрийн жижиг намууд орж ирж олон намын систем бүрэлдэх суурь нөхцөл тавигдлаа. Улс төрийн нам нь төр, иргэн хоёрын дунд ашиг сонирхлын урсгалын гүүр болж өгдөг. Үүний тод жишээ болж, янз бүрийн сонирхолын бүлгийн төлөөлөл болсон их хурлын гишүүд сонгогдлоо. Эндээс Монгол Улсын ардчилсан Үндсэн Хуулийн эхийг баригч Б.Чимид гуайн үзэл санаа, үйл хэрэг цаашид улам бэхжих нэг чухал суурь нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Улс төрийн намууд цаашдаа бодлогын нам болж төлөвшин, дотоод ардчилал бэхжихийн хэрээр нэр дэвших үйл явц илүү шударга, нээлттэй, жендерийн тэгш байх боломж бүрдэнэ. Түүнчлэн сонгуулийн хувь тэнцүүлэх тогтолцоог сонгож явах нь Б.Чимид гуайн хэлсэнчлэн “урьдчилан сонгох” боломжийг бидэнд өгдөг, санал гээгдэхгүй байх зэрэг олон давуу талтай бөгөөд нэр дэвшигчээс гарах сонгуулийн зардал буурч, улс төр дэх мөнгөний нөлөө багасна.

Э.Гэрэлт-Од докторын хувьд өөрт оногдсон бүлгээс уншигчдад эргэцүүлэл, шинэ хэлэлцүүлгийн сэдэв төрүүлэхүйц хэсгүүдийг оновчтой олж харж, ишлэн судлаачийн тайлбар, час хийсэн дүгнэлтүүдийг хийж өгсөн нь сайн болжээ. Тухайлбал, “сонгуульд оролцоно гэдэг нь таамгаар тэмтэрч, бусдыг дагалдан дарвих, наалдаж хэдэн бор төгрөг, аар саар өглөг, аятайхан амлалтад хууртаж ээлж өнгөрөөхийн нэр биш” (Б.Чимид, 2008, х.119) зэрэг хэн хүнд эргэцүүлэл, шүүмжийг төрүүлэхүйц хэсгүүдийг олж харж, илтгэлдээ ишилсэн байна. Илтгэгчийн хувьд иргэний улс төрийн боловсрол чухал байгааг үүгээрээ хөндсөн байна. Үүнтэй санал нийлэхийн сацуу, өнөөдөр манай улсад ардчиллаа бэхжүүлэх, ирээдүй хойч үедээ ардчилсан соёл, үнэт

зүйлсээ өвлүүлэн үлдээх, залгамжлан хадгалахад хамгийн чухал зүйл нь улс төрийн боловсрол юм. Бид зөв ойлголт, хандлага, мэдээллээр иргэдээ хангах, улс төрийн зөв соёл төлөвшүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

Б.Чимид гуайн үзэл санаа, үйл хэрэг өнөөдөр ч төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгалаа олсоор байна. Тухайлбал “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Үндэсний нэгдмэл үнэт зүйлс”, “Хүний хөгжил”, “Засаглал” зорилтуудын агуулга, хүрэх үр дүнг харвал Б.Чимид гуайн үзэл санаа тодорхой хэмжээнд туссан, нөлөөлсөн байгааг хэлэх нь зүйтэй (Монгол Улсын Их Хурал, 2020).

Уг бүтээлийг улс төрийг сонирхдог, судалдаг, улс төрч болохоор зорьж буй хэн бүгдийн уншвал зохих улс төрийн цагаан толгой гэхэд буруудахгүй. Б.Чимид гуайн бидэнд үлдээсэн энэхүү өв бүтээл нь сонгуулийн тухай гарах дараа, дараагийн ном, бүтээлүүдэд загвар жишиг, суурь болохуйц юм. Нийгэм, улс төрийн амьдрал тасралтгүй хувьсан өөрчлөгдөж, үүнийг дагаад сонгуулийн тогтолцоо, намын систем хувьсан шинэчлэгдсэн ч эрхэм хүний үзэл санаа монголын ардчиллын хөгжилд эерэг үр нөлөө үзүүлсээр байх болно.

---ooOoo---

Ном зүй

1. Freedom house. (2024). Freedom in the World. Freedom House.
2. Б.Чимид. (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
3. Монгол Улсын Их Хурал. (2020). Алсын хараа - 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Улаанбаатар.
4. Төрийн аудит. (2024, 02 29). Audit.mn. Retrieved from <https://audit.mn/content/detail/5595>

САНАЛ, ДҮГНЭЛТ

Д.Баяндүүрэн

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн

Сонгууль, сонгуулийн үйл явц, сонгуулийн эрх зүйн чиглэлээр бичигдсэн цөөн бүтээлийн нэг болох Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй” бүтээлээр номын уншлагыг зохион байгуулж байгаа нь сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйг хөгжүүлэхэд, мөн цаашид энэ чиглэлийн судалгаа шинжилгээ хийх судлаачдын хувьд томоохон, чухал үйл явдал болж байна.

Б.Чимид багш 2008 оны хавар УИХ-ын сонгуулийн ажил эхэлчихсэн, шахалт шаардлага, жагсаал цуглаантай давчуухан тэр цаг үед “Сонгуульд суралцахуй” номынхоо эхийг өгч явуулсныг Хорооны дарга Б.Баттулгатай хамт уншилт хийж өгсөндөө таатай явдаг юм.

МУБИС-ийн дэд профессор, улс төрийн судлалын доктор Э.Гэрэлт-Одын “Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй” номын “Улс төрийн нам сонгуульд оролцох тухай” зургаадугаар бүлэг болон “Сонгуульд нэр дэвшүүлэх, түүнд тавигдах шаардлага, таны оролцоо” долоодугаар бүлгүүдэд дүн шинжилгээ хийсэнтэй танилцаж тус илтгэлд санал, дүгнэлт гаргах үүрэг хүлээж хэлэлцүүлэгт оролцож байна.

Доктор Э.Гэрэлт-Од уг бүтээлд тэр тусмаа зургаа, долоодугаар бүлгийн агуулгад дүн шинжилгээ хийхдээ нухацтай хандаж Б.Чимид багшийн өгүүлсэн чухал санаа бүрийг орхигдуулалгүй авч үзсэн байна. Өөрөөр хэлбэл, бүлгийн сэдэвтэй холбогдох гол санаанууд болох намын тухай үндсэн ойлголт, сонгууль ба нам, сонгуульд оролцохын тухай, нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай, эвсэл тарах тухай, сонгуульд нэр дэвшигчийг тодруулах тухай болон бие даан нэр дэвшүүлэх тухай гэсэн гол гол санаанууд Э.Гэрэлт-Од докторын илтгэлд багтсан байна. Миний бие сонгуулийн төв байгууллагад олон жил ажиллаж ирсний хувьд практик талаас нь цөөн санаа нэмэрлэе.

1. Нам, эвслийн сонгуулийн оролцооны асуудал. Нам, эвсэл сонгуульд оролцох нь “өргөн утгаараа улс орны өмнө тулгарсан бэрхшээлийг даван туулж, хөгжлийн замыг шулуутгах, иргэнийхээ сайн сайхан аж байдлыг тэтгэгч засаг, үр ашигтай удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнийг төлөвшүүлэн, төрийн үйлчилгээний хүртээмж өгөөжийг дээшлүүлэх үйлсийг хошуучлах өндөр хариуцлага ойртож буйн дохио юм. (Б.Чимид, 2008, х. 126) гэсэн зохиогчийн санааг Э.Гэрэлт-Од доктор илтгэлдээ дэмжиж тусгасан байна. Миний хувьд ч мөн адил энэ санааг дэмжиж хэдэн үг өгүүлье. Нам, эвслийн сонгуулийн оролцооны асуудал нь зөвхөн сэтгэл, хөдлөл зоригийн асуудал биш илүү хариуцлага, сахилга батын асуудал юм. Сонгуульд оролцох бэлтгэл ажил улс орны өнөөгийн асуудлыг шийдэж, ирээдүйд илүү сайн нийгмийг зөв арга замаар бүтээх мөрийн хөтөлбөр боловсруулах, түүнийгээ хянуулах, сонгуулийн сурталчилгааны зардал, төсөв бэлтгэх, буцааж тайлагнах, аудит гэх мэт нөр их ажлын ард, асар их хариуцлага дагадаг. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулиудаар намын үүрэг хариуцлага нэмэгдэж зөвхөн сонгуулийн жилд төдийгүй, сонгуулийн бус жилүүдэд ч тогтмол үйл ажиллагаатай байж тайлан, мэдээллээ

нээлттэй мэдээлэлдэг, сургалт зохион байгуулах, судалгааны ажил хийх хэрэгцээ, шаардлагатай болж байгаа нь зохиогчийн сонгуульд суралцахуй бүтээлдээ тусгасан нам хэмээх ойлголт болон нам нь улс төрийн байгууллага гэсэн санааны бодит илрэл болж байна.

Зохиогч эвсэл байгуулах бол хариуцлагатай шийдвэр, энэ шийдвэрийг гаргасан бол тогтвортой байлгахад намууд хариуцлага хүлээх үүрэгтэй. Тиймээс нэгт эвсэлд нэгдэж буй намуудын зохих байгууллага албан ёсоор шийдвэр гаргаж, эвслийг төлөөлөх байгууллагад албан ёсоор мэдэгдсэнээр эвслээс гарсанд тооцно. Өөр хэн дуртай хүний үг, захидал, мэдэгдэл огт хамаагүй, эвсэл бол намуудын сонгуулийн нэгдэл гэдгийг тодруулж өгсөн. Хэрэв “гэрээг цуцалж байгаа нь ердийн нэг шийдвэр биш, эвслийн төлөө саналаа өгсөн сонгогчдын итгэлийг эвдэж байгаа” (Б.Чимид, 2008, х.125) тухай онцгойлон сануулжээ. Үүнтэй холбоотой кейс УИХ-ын 1996, 2004 оны ээлжит сонгуулийн үеэр тохиолдсон бөгөөд эвслийн гэрээ байгуулсан улс төрийн намууд сонгогчдыг хүндэтгэхгүй, судалгаагүй, сэтгэлийн хөөрлөөр шийдвэр гаргадаг болох нь ажиглагдсан тул зохиогч энэ дээр онцгой ач холбогдол өгч тайлбарласан байна. Хэрэв эвсэл тарвал төлөөллийн байгууллагад эвслээс сонгогдсон төлөөлөгч/гишүүний эрх үүрэг дуусгавар болох, бүлэг тарах зэрэг эрх зүйн үр дагавар гарахыг сануулжээ. Хэрэв “УИХ-д олонх болсон эвсэл задарвал тэр байр сууриа алдаж, засгийн газрын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт орох ноцтой үр дагавар гарч болно” гэжээ.

Иймээс намууд улс төрийн итгэлд үндэслэсэн эвсэл байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, үнэнч байж, хууль биелүүлэх ёс зүйн болон журамт үүрэгтэй гэж сануулжээ. (Б.Чимид, 2008, х.125). Эвслийн гэрээ, түүний хариуцлагын асуудал сонгогчдын итгэлтэй шууд холбогдох тул яах аргагүй чухал асуудал. Энэ утгаараа 2005, 2011 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиудад “Эвслийн гэрээ нь тухайн сонгууль,

түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байна” гэсэн эвслийн гэрээний хугацааны тухай заалтууд байсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Улс төрийн намын тухай хуулийн 2023 оны шинэчилсэн найруулгатай холбоотойгоор эвслийн гэрээ урьд өмнөхөөсөө илүү хариуцлагатай, нарийвчилсан заалтуудтай байх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Үүнд хэрэв тухайн эвсэл төрийн санхүүжилт авах болзол хангасан тохиолдолд санхүүжилтийг хэрхэн хуваарилах, зарцуулах болон тайлагнах тухай асуудал, шууд бус дэмжлэгийн зарцуулалт, хуваарилалт гэх мэт зайлшгүй зохицуулах асуудлууд үүсэж байна.

2.Нэр дэвшүүлэх ажиллагаа. Зохиогч нам, эвслээс нэр дэвшигчийг тодруулах үйл явц нь үнэндээ нэг төрлийн сонгууль бөгөөд зарим оронд намын гишүүдийн дунд, эсвэл нээлттэй хэлбэрээр санал хураалтаар тодруулдаг. “УИХ-ын гишүүнд нэр дэвшүүлэх гэдэг чухамдаа урьдчилан сонгох хэлбэр бөгөөд сайн парламенттай болохын тулд уг тушаалд бүх талаараа тохирох зүтгэлтнүүдийг амьдралын гүнээс илрүүлэн олж, өрсөлдөөнд оруулан шалгаруулна гэсэн үг” тиймээс нам, эвсэл ч, иргэд ч сайн судалгаатай хандаарай гэжээ. Эндээс бид одоо ч намын тухай хуулиар намын дотоод ардчилал, нэр дэвшүүлэх үйл ажиллагааны ардчилсан, ил тод, нээлттэй зарчмыг шаардсаар байгаа нь аль 2008 оны хувьд ч асуудал болж байсныг харж байна. Улс төрийн намын тухай хуулийн 2023 оны шинэчилсэн найруулгаар дээрх асуудалтай холбоотойгоор дараах чухал заалтууд орсон тул бид бүгд (оролцогч талууд) хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр бүх талаас нь анхаарч ажилласнаар нөхцөл байдлыг сайжруулах боломжтой гэж харж байна. Улс төрийн намын тухай хуулиар Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглосон. Мөн Намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын

Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэхээр хуульчилсан. Түүнчлэн намын тухай хуулиар улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих дараах заалтууд хэрэгжиж эхэлсэн. Үүнд: 1. Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна. Мөн Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ гэж тус тус заажээ. Дээрх заалтуудын үндсэн зорилго нь Улс төрийн намын дотоод ардчиллыг дэмжих, намын нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой.

Бие даан нэр дэвшүүлэх тухайд: Бие даан нэр дэвших нь Үндсэн хуулиар олгогдсон иргэний сонгогдох эрх, гэтэл бид эхлээд 801-ээс доошгүй сонгогч-иргэний гарын үсэг, тэр гарын үсгийг нэр дэвших тойрогт хамрагдах бүх хорооны төлөөлөл байх, маш бага хугацаанд цуглуулах ёстой гэсэн нь гэсэн хэт хатуу шаардлага болсныг шүүмжилжээ. Энэ нь нам бусуудын нэр дэвшүүлэх эрхийг хуулиар хязгаарласан үйлдэл болсон гэжээ. Дэмжигчийн гарын үсэг цуглуулах асуудалд цуглуулах аргачлал, хугацаа мөн түүнийг хэрхэн шалгах баталгаажуулахтай холбоотой асуудал нь маргаан дагуулсан асуудал байсаар ирсэн. Улсын Их Хурлын 1992 он, 2005 оны хуулиудад дэмжигч “Нэр дэвшигчийг дэмжигчдийн гарын үсэг үнэн зөв эсэхийг сонгуулийн тойргийн буюу түүний салбар хороо сонгогчдын иргэний баримт бичиг, хаягийн бүртгэлтэй тулгах буюу шаардлагатай бол дэмжигчидтэй уулзаж нягтлан шалгана. Гарын үсгийг хуурамчаар үйлдвэл тухайн хүнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлснийг сонгуулийн тойргийн хороо хүчингүйд тооцно.” Гэсэн зохицуулалт дээрх хуулиудад байсан ч сүүлийн 2011, 2015, 2019 оны хуулиудад дэмжигчдийн гарын үсгийг хэрхэн шалгах талаар нарийн зохицуулалт байхгүй нь маргааны нэг шалтгаан болж байгаа нь цаашид эрх зүйн орчныг боловсронгуй

болгоход анхаарах асуудал болж байна. Энэхүү дэмжигчдийн гарын үсэг цуглуулах заалт “бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна” гэсэн заалт одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буюу Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд байсаар байгаа бөгөөд энэ хэсгийн “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн. Гэвч уг дүгнэлтийг “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн.

3. Сонгох, сонгуульд оролцох. Зохиогч сонгох эрхийн тухайд “..аль ч намыг дэмжихгүй бол бие даан нэр дэвшигчийг дэмжин оролцох, эсвэл саналын хуудсанд бичигдсэн хэнд ч саналаа өгөхгүй орхих нь мөн чөлөөтэй” (Б.Чимид, 2008, х.119) гэж тайлбарлажээ. Эндээс эсрэг санал өгөх эрхийн тухайд бид цаашид ч бодох хэрэгтэй. 2024 оны Улсын Их Хурлын сонгуулиар Монгол Улсын иргэд бид 126 гишүүнийг хосолмол тогтолцоогоор (78/48)-р сонгосон. 48 гишүүнийг улс нэг тойрог бүхий жагсаалтаар сонгосон бол 78 тойргийг томсгосон 13 тойргоос сонгосон. Сонгогчид 3-10 мандат бүхий саналын хуудас хүлээн авсан бөгөөд мандатын тоотой тэнцүү санал өгөх хүндхэн даалгавартай тулсан. Энэ нь нэг талаас маш том даалгавар төдийгүй, зохиогчийн хэлж буй эсрэг санал өгөх эрхийн асуудлыг хөндөж байгаа юм. Энэ асуудлаар 2025 онд Үндсэн хуулийн цэцийн дараах дүгнэлт гарсан.

“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт «Тойрогт ногдсон мандатын тооноос ... дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн ... саналын хуудсыг хүчингүйд тооцно.» гэж заасны «... дутуу ...» гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт «Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... чөлөөтэй ... сонгох эрхийн үндсэн дээр ... сонгоно.» гэснийг зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасан байна. Тиймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн «... дутуу ...» гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр 2025 оны 04 дүгээр дүгнэлтэд дурджээ.

Сонгуулийн боловсролын асуудал: Илтгэгч зохиогчийн “сонгуульд оролцоно гэдэг нь таамгаар тэмтэрч, бусдыг дагалдан дарвих, наалдаж хэдэн бор төгрөг, аар саар өглөг, аятайхан амлалтад хууртаж ээлж өнгөрөөхийн нэр биш” (Б.Чимид, 2008, х.119) гэдгийг тодотгон хэрэглэж буй нь уншигчдад нэгийг сануулж, хоёрыг тунгаахад хүргэж байна хэмээн Э.Гэрэлт-од судлаачийн тодотгосон санаа нь сонгогчдын боловсрол, улс төрийн боловсрол яагаад анхаарах шаардлагатайг харуулж байна. V-Dem буюу Varieties of Democracy¹ нь дэлхийн улс орнуудын ардчиллын индекс гаргадаг олон улсын судалгааны дүнгээр Монгол улс 2021 оноос тасралтгүй ухарч дэлхийн 190 гаруй орноос 61-ээс 81 дугаар байр хүртэл ухарсан байна. Цаашид Ардчилал, ардчилсан нийгмийг хамгаалах, бэхжүүлэхэд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар чиг үүрэг хүлээсэн Сонгуулийн ерөнхий хороо, Улс төрийн намын тухай хуулиар иргэд, намын гишүүдийн улс төрийн боловсролд анхаарах чиг үүрэгтэй Монгол Улсын дээд шүүхэд

¹ <https://www.v-dem.net/>

бүртгэлтэй 37 нам, иргэний нийгмийн байгууллагууд, улс төр, нийгмийн ухааны чиглэлийн сургууль гэх мэт оролцогч талууд хамтран хамтран зүтгэх хэрэгтэй байна.

Төгсгөлд нь: Э.Гэрэлт-Од доктор номын “Улс төрийн нам сонгуульд оролцох тухай” болон “Сонгуульд нэр дэвшүүлэх, түүнд тавигдах шаардлага, таны оролцоо” бүлгүүд бүхэлдээ улс төр судлалын судлагдахуун бөгөөд философийн тайлбар, эрх зүйн зохицуулалтын шинжилгээ, дэвшүүлж буй саналууд нь онол практикийн ач холбогдолтой тул цаашид олны хүртээл болгох хэрэгцээ байна. Тиймээс намын төлөвшил, намын дотоод ардчилал, иргэдийн улс төрийн боловсролыг нэмэгдүүлэхэд тус дөхөм болох юм.” гэж дүгнэсэнтэй санал нэгдэж буйгаа илэрхийлээд, зохиогчийн хэлсэн “Сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах амин хэрэгцээ мөн бөгөөд хамгийг эзэрхэгч хаант ёсыг халах, ганцаар дарангуйлагчийг хавчин зайлуулах тэмцлийн үр дүн мөн” гэсэн үгээр санал, дүгнэлтээ өндөрлөө

---ooOoo---

Ном зүй

1.Б.Чимид. (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.

IV

Сонгуулийн сурталчилгаа, санхүүжилт

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА, САНХҮҮЖИЛТ

Д.Энхцэцэг

*“Нээлттэй нийгэм форум”-ын Засаглалын хөтөлбөрийн
менеджер, улс төр судлаач*

Оршлын оронд товч түүх

2008 оны УИХ-ын ээлжит сонгууль дөхсөн үе байв. Нээлттэй Нийгэм Форумгаас сонгогчдын боловсролд зориулсан “брошюр” нийтлэхээр төлөвлөн, Б.Чимид (цаашид зохиогч гэх) багшид хандахад нааштай хүлээн авсан юм. Ийнхүү бид “брошюр” буюу сонгуулийн үйл явц, арга зүйг тайлбарласан авсаархан гарын авлага хүлээж байтал зохиогч “Сонгуульд суралцахуй” хэмээх номын эхийг гардуулснаар энэхүү бүтээл хэвлэгдсэн билээ.

Ардчилсан сонгуулийн түүхнээ мартаж үл болох гашуун сургамж үлдээсэн 2008 оны УИХ-ын тав дахь удаагийн ээлжит сонгуулийг угтан уншигчдын хүртээл болгосон номоо зохиогч “Сонгуульд суралцахуй” гэж нэрийдсэн нь утга учиртай мэт. Номд тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн үйл явц, арга зүйн талаар тайлбарлан хүүрнээд зогсохгүй ардчилсан сонгуулийн мөн чанарыг гуйвуулах гажуудал газар авч буй талаар сэрэмжлүүлэн учирлаж, зөв голдиролд хэрхэн залах талаар одоо ч үнэ цэнтэй хэвээр санал дэвшүүлжээ.

Ном хэвлэгдсэнээс хойш УИХ-ын ээлжит сонгууль дөрвөнтэй тохиож, сонгуулийн хууль тогтоомж тэр тоогоор шинэчлэгдэхэд зохиогчийн шүүмжлэн дурдсанаас өөрчлөгдөж сайжирсан зүйлс байх ч өнөөг хүртэл ужгирсан зарим асуудал хэвээр байгаа талаар энэхүү нийтлэлд тодруулахыг зорилоо. Дүн шинжилгээ нь номын найм болон есдүгээр бүлэг буюу Сонгуулийн сурталчилгаа, Сонгуулийн санхүүжилтийн асуудлыг хамрах болно.

Сонгуулийн сурталчилгаа


Сонгуулийн үйл явцын өрнөл гэж болох сонгуулийн сурталчилгааны талаар зохиогчийн өгүүлснээс үзэхэд агуулгын хувьд энэ нь сонгуульд оролцогч талуудын мөрийн хөтөлбөрт тулгуурласан бодлогын өрсөлдөөн байх ёстойг онцолжээ.

Зохиогч “Сонгуулийн сурталчилгаа гэж нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийн сонгуулийн байгууллага, ухуулагч, туслагч, дэмжигчдээс сонгогчдод зориулан өөрсдийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулж, нэр дэвшигчдийн дэмжин сурталчилж буйг хэлнэ” гэж тодорхойлоод сонгуулийн сурталчилгааны гол зорилго нь “сонгуулийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн давуу талыг зүйл бүрээр нотлон тайлбарлаж, сонгогчдыг түүний төлөө ‘өрсөлдүүлэн’ өөртөө татаж, аль болох олон санал авах, оюун санааны нөхцөл бий болгох явдал мөн” гэж тодотгон тайлбарлажээ. (Б.Чимид, 2008, х. 141)

Цаашилбал, “Сонгуулийн мөрийн хөтөлбөр бол сонгуулийн сурталчилгааны гол эх сурвалж мөн” гэж онцлоод “Сонгогчид чухамдаа сайн хүний төлөө тэмүүлэх нь зүйн хэрэг. Эцсийн дүнд хөтөлбөрийнх нь үр дүнгийн төлөө саналаа өгвөл илүү мэргэн шийд болно” гэсэн нь сонгууль хувь улс төрчдийн хоорондын уралдаан бус бодлогын өрсөлдөөн байх учиртайг сонгогчдод ухуулж ойлгуулахыг зорьжээ гэж дүгнэж байна.

2008 онд УИХ-ын тав дахь удаагийн ээлжит сонгууль болсноос хойш 2024 оныг хүртэл даруй дөрвөн удаагийн ээлжит сонгууль болж өнгөрсөн ч агуулгын хувьд сонгуулийн сурталчилгаа нь мөрийн хөтөлбөрт тулгуурласан бодлогын өрсөлдөөн байх мөн чанар нь биеллээ олоогүй хэвээр байгааг дараах тоо баримтаас харж болно.

Мэдээллийн агуулга



Глоб Интернэшнл (2024). УИХ-ын сонгуулийн үеэрх хэвлэл мэдээллийн мониторинг

2024 оны УИХ-ын сонгуулийн үеэр Глоб Интернэшнл ТББ-аас хийсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн дүнгээс харахад мөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл нийт сонгуультай холбоотой мэдээллийн зөвхөн 24 хувийг л эзэлж байжээ. Энэхүү мониторингид хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг, үзэгчдийн тоо, рейтинг өндөр, цаг үеийн мэдээний хөтөлбөр нэвтрүүлдэг MYONT, TV9, NTV, Ийгл Ньюс, Mongol HD гэсэн 5 телевизийг хамруулсан байдаг.

Зохиогчийн өгүүлснээр “Хэрэв сонгуульд ялбал олонхи болсон нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ноён нуруу болно.” Иймд мөрийн хөтөлбөр нь “ард түмэндээ андгайлсан амлалт, тэдэнтэй байгуулсан **нийгмийн гэрээ**” мөн гэсэн нь анхаарал татна. (Б.Чимид, 2008, х. 143) Ийм өндөр ач холбогдолтой баримт

бичиг болох тул тодорхой шаардлагыг хангасан байх ёстойг мөн онцолсон байна.

Зохиогч СМХ-д тавих нэн түрүүний шаардлага нь Үндсэн хуульд нийцсэн байх гээд цаашилбал “Ард түмний тусын тулд ялангуяа нийгмийн хамгаалал, халамжийн хувьд хийж гүйцэтгэх талаар дэвшүүлэх зорилтоо нам, эвсэл өөрийн бодит эрх мэдэлдээ тохирсон утгаар томъёолбоос зохино” гэжээ. Цаашлаад “Намууд сонгуульд ялбал ард олонд их мөнгө тараана, өгнө гэж дуудлага худалдаа шиг өрсөлдөн амалдаг” гаж хандлага байгааг мөн шүүмжилсэн байна. (Б.Чимид, 2008, х. 143-145) Өөрөөр хэлбэл, улс төрийн клиентелизмийн нөлөөнд ардчилсан сонгуулийн мөн чанар алдагдах вий гэсэн сэрэмжлэл энд хавчуулжээ.

Эдүгээ хэрэгжиж буй УИХ-ын сонгуулийн тухай хуулиар сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт сонгогчдын саналыг татах зорилгоор эдийн засгийн үндэслэлгүй, хэрэгжих боломж багатай халамжийн үйлчилгээ, эдийн засгийн амлалт тусгахыг хориглож байна. Тодруулбал, УИХ-ын сонгуулийн хуульд 38.5-д:

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан байна. (МУИХСтХ, 2019)

Хуулийн дээрх заалтын үр дүнд зохиогчийн хурц нүдээр шүүмжилж асан тооцоолол үндэслэлгүй “мөнгө тараах” амлалт нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт тусах нь хамжааргатай болжээ. Харин дээрх заалтыг мөрийн хөтөлбөрийг хэт “цензурдэх” хэрэгсэл болгож ач холбогдлыг нь алдагдуулах

вий гэсэн болгоомжлол судлаачдын зүгээс сүүлийн жилүүдэд сонсогдох болсон билээ.

2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах цагалбарын дагуу сонгуульд оролцох нам, эвсэл 3 дугаар сарын 25, бие даан нэр дэвшигчид 4 дүгээр сарын 25-наас өмнө төрийн аудитын дээд байгууллагад мөрийн хөтөлбөрүүддээ дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. Улмаар, аудитаас мөрийн хөтөлбөрүүдийг хянаж үзээд засуулахаар буцаасан шийдвэр гаргасан билээ. Энэ шийдвэрийн талаар Ерөнхий аудиторын орлогч хэвлэлд өгсөн ярилцлагадаа дурдсаныг сийрүүлбэл:

“27 нам, хоёр эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг буцаасан. Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжлийн зорилт, бодлогыг хангах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тооцооллуудыг үзэхэд засаж, залруулах зүйлс байгаа юм. Манай саналын дагуу нам, эвслүүд мөрийн хөтөлбөрөө эргэж харж, аудитын газарт 17-нд ирүүлнэ. Дөрөвдүгээр сарын 26-ныг хүртэл сонгуулийн мөрийн хөтөлбөрийг дахин хянаж, аудитын дүгнэлтээ гаргаад Сонгуулийн ерөнхий хороонд хүргэнэ” гэжээ. (Манлай, 2024)

Улс төрийн клиентелизмийн нөлөө сонгуульд тусахаас сэргийлж мөрийн хөтөлбөрт аудит хийх зохицуулалт нь мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ тусгагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах хүрээнд хэрэгжиж, улмаар энэ талаарх мэдээллийг сонгогчдод ил тод хүргэж, мэдээлэлтэйгээр санал өгөх нөхцөл бүрдүүлэхэд чиглэвэл ач холбогдолтой.

Харин одоо мөрдөж байгаа хуульд тусгасанчлан Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх асуудлыг хамрах нөхцөлд хяналтын хүрээ хэт өргөсөж улмаар чөлөөт

сонгуулийн шалгуур үзүүлэлт болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, олон ургалч байдлыг үгүйсгэх тал руу халтирах эрсдэлтэй. Сонгуулийн утга учир нь бодлогоор ялгаатай талууд чөлөөтэй мэтгэлцэн өрсөлдөх талбар болох учиртай. Парламентын үнэмлэхгүй олонхын баталсан хөгжлийн урт хугацааны бодлогод нийцэх мөрийн хөтөлбөртэй байх хуулийн шаардлага нь бодлогоор ялгарч өрсөлдөх боломжийг хязгаарласан шинжтэй байна. (Энэ номын 127-142 дахь тал)

Б.Чимид сонгуулийн сурталчилгаатай холбоотой үндсэн зарчмыг “Сонгуулийг шударга явуулахын хэмжүүр нь хуулийг дээдлэн сахих явдал мөн” бөгөөд “сонгуулийн өмнөх цогц ажлын үндсэн зарчим мөн” гэжээ. “Сурталчилгаанд хуулийг дээдлэх нь хүнийг үзэл бодлоор нь ялгаварлах, итгэл үнэмшилтэй байж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хааж боогдуулах ёсгүй.” (Б.Чимид, 2008, х. 148)

Сонгуулийн сурталчилгааны арга хэлбэрийн тухайд зохиогчийн зүгээс “Сонгуулийн цогц ажлын анхаарлын төвд нэр дэвшигч л байдаг: Тэрээр сонгогчдод өөрийгөө, нам, эвслээ, хөтөлбөрөө таниулж дэмжүүлэхийг хүсдэг. Сонгогчид ч түүнтэй нүүр учирч, үгийг нь сонсож, хувийн зан харилцаа, улс төрийн байр суурь, ажил хэргийн чанар чансааг тулж мэдэхийг хүсдэг. Хоёр талын хэрэгцээ сонирхлоос үүдэн энэхүү уулзалт сурталчилгааны хамгийн гол хэрэгсэл болдог гэж онцолсон нь анхаарал татна.

Өмнө дурдсанчлан зохиогчийн зүгээс мөрийн хөтөлбөр нь сонгуулийн сурталчилгааны гол эх сурвалж болохыг онцолж сонгууль нь чухамдаа бодлогоор өрсөлдөх уралдаан гэж үзсэн хэрнээ сурталчилгааны арга хэрэгслийн хувьд мэтгэлцээнийг төдийлөн онцлоогүй дурдаад өнгөрсөн байх аж.

Зохиогч бүтээлээ олны хүртээл болгосон 2008 онд улс төр, сонгуулийн мэдээлэл сурталчилгаанд цахим хэрэгслийг өнөөгийнх шиг өргөнөөр ашиглаж эхлээгүй байсан үе. Гэсэн хэдий ч Монголчуудын уламжлал, ахуйн соёлд нүүр тулсан уулзалт илүү

зохимжтой болохыг зохиогч өөрийн үзэж туулсан баялаг намтар, туршлагад үндэслэн өгүүлж байсан нь өнөөдөр ч ач холбогдол нь хэвээр чухал ажиглалт аж. “Нэр дэвшигч гэр орон, хот айлаар явах, ухуулах байраар хүлээн авах зэргээр сонгогчидтой ганцаарчлан уулзах хэлбэр нь Монголын хөдөөгийн нөхцөлд илүү үр нөлөөтэй.” (Б.Чимид, 2008, х. 167)

Түүнчлэн зохиогчийн зүгээс уулзалт хийх хугацаа нь “нэр дэвшигч бүртгүүлсэн өдрөөс эхлэн сонгуулийн сурталчилгааг дуусгавар болговол зохих өдөр хүртэл буюу ...17 өдөр” байгаа нь “тун давчуу” болохыг дурджээ. “Аймгууд 14-28 хүртэл сумтай. Сум 3-12 багтай. Тэр бүхэнд сонгуулийн хэсэг. Хэсэг бүрд төв бий. Сум бүрд хүрэлцэн очно гэвэл нэгд нь дунджаар нэг хоног, түүнээс бага хугацаа ноогдож байна.” (Б.Чимид, 2008, х. 164-165)

Бүтээл хэвлэгдсэн 2008 онд болсон УИХ-ын сонгуулийг мажоритар тогтолцоогоор буюу 2-4 мандаттай 26 томсгосон тойрогт зохион байгуулсан байдаг. Үүнд, Налайх, Багануурыг нэгтгэсэн нэг тойргоос бусад аймаг, дүүрэг тус тусдаа тойрог болж байв. Харин 2024 оны УИХ-ын сонгуулийг харьцуулж үзвэл холимог системийн мажоритар тойргууд нь 2-10 мандаттай 13 бүсчилсэн тойрог байлаа. Үүнд, хөдөөд 7 тойрог байгуулсан байх бөгөөд Баян-Өлгий аймгаас бусад аймгийг 3-4-өөр нь нэгтгэн нэг том тойрог болгосон байдаг. Сурталчилгааны хугацааны хувьд 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 26-ны өдрийг дуустал цөөн хоног явагдсан. Өөрөөр хэлбэл, 2008 онд зохиогчийн давчуу гэж үзэж байсан хугацаанд нэр дэвшигч 3-4 аймгийг хамарсан сурталчилгаа хийхээр хуульчилсан нь нөхцөл байдал улам дордсоныг илтгэнэ.

Сурталчилгааны хугацааг цөөн хоног байхаар зохицуулж ирсэн нь сонгуулийн зардал хэт өндөр болохоос сэргийлэх зорилготой гэдэг. Гэвч энэ нь сонгуулийн зардал буурахад төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгаа талаар дараагийн бүлэгт авч үзнэ.

Үүнээс гадна сонгуулийн тойргуудыг УИХ-аас ээлжит сонгууль бүрээр байгуулахаар хуульчилж зохицуулсаар өнөөг хүрсэн нь дээрх асуудлын цаадах бас нэг шалтгаан юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 12.1-т “Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойрог “цаашид “тойрог” гэх/-ийг байгуулна” гэж заасан. Дээрх заалт сонгуулийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болох сонгуулийн тойргууд тогтворгүй байхад нөлөөлж, сонгуульд өрсөлдөгчид талууд тодорхой тактик, төлөвлөгөөтэй сонгуулийн сурталчилгаагаа удирдан зохион байгуулах боломжийг хязгаарлах нөхцөл үүсгэж байгааг анхаарч цаашид хуульд зохих өөрчлөлтийг тусгах нь зүйтэй.

Сонгуулийн санхүүжилт


Сонгуулийн санхүүжилтийн асуудлыг танилцуулсан номын есдүгээр бүлгийг сөхвөл зохиогчийн хамгийн түрүүнд хөндсөн асуудал нь “Мөнгө тойрсон хардлага, сэрдлэг” байгаа нь сонгуульд мөнгөний ил, далд урсгал нэмэгдэхийн хэрээр зохисгүй нөлөө нь улс төр, эдийн засаг, нийгэмд хортой үр дагавар дагуулж буйд санаа зовнин, энэхүү гажуудлаас гэтэлгэх арга зам эрэлхийлэх нь юун түрүүнд чухал байгааг онцлохыг зорьсныг илтгэнэ.

Авлига сонгуулиас эхэлдэг гэсэн яриа ч оргүй биш бололтой. Төрөө цэгцэлж, хуулиа шулуутгаж, ёс суртахуунаа цэвэршүүлж амьдралаа өөд татъя гэвэл эхлээд сонгуулийн луйврыг арилгах хэрэгтэй. Тэр луйврыг арилгахын тулд уг өвчний голомтыг олж устгах хэрэгтэй. Тэр бол намын санхүүжилтийн гажиг, албан тушаалтны авлига, хяналтгүй мөнгөний урсгал, түүний завшигчдын сүлжээ гэхэд их зөрөхгүй мэт. Хэн сайн нь биш, хэн нь их мөнгө намд өгсөн нь нэр дэвшдэг, тэднээс хэн их мөнгө цацсан, тараасан нь “ялдаг” болсон гэлцэнэ. Мөнгөний цаана албан тушаал, түүний цаана авлига нуугдана. (Б. Чимид, 2008, х. 170-171)

Сонгуульд оролцогч талууд тэгш гараанаас тэнцвэртэй өрсөлдөх шударга сонгуулийн зарчмыг хангаж мөнгөний зохисгүй нөлөөнөөс сэргийлэх нэн түрүүний арга хэмжээ нь сонгуулийн зардалд тодорхой хориг, хязгаарууд тавих явдал болохыг мөн сургамжилжээ.

Сонгуулийн зардлыг нам, эвсэл нь гишүүний татвар, бусдын хандив цуглуулан санхүүжүүлээд өнгөрдөг төр, түмэнд “хоргүй” зүйл гэж ойлгож байна уу? Тэгэж яасан ч болохгүй. Хориг нь нэг талаар улсын аюулгүй байдал, төрийн албаны цэвэр ариун байдал, нөгөө талаар төрийн өмч, татвар төлөгчдийн мөнгө, ТББ-ын ашиг сонирхлыг хамгаалах, авлига үүсэхээс сэргийлэх зорилготой. (Б.Чимид, 2008, х.170-171)

Үүнд сонгуулийн зардлын хязгаарыг хэрхэн тогтоож мөрдүүлэх талаар хуульд нарийвчлан тусгаж мөрдөх нь чухал гэсэн санааг мөн дурдсан байна(Б.Чимид, 2008, х. 176). Сонгуулийн зардал нэмэгдэж буй талаар зохиогч ийнхүү санаа зовнин өгүүлж асан 2008 оноос хойш сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн зарцуулсан мөнгөний хэмжээ тасралтгүй нэмэгдэж ирснийг доорх хүснэгтээс харж болно.



Эх сурвалж: албан ёсны тоо баримтыг илтгэгч хураангуйлсныг
Тунгаахуй өгөгдлийн урлан дүрсжүүлсэн нь

Сонгуулийн зардал ийнхүү тогтмол олон тэрбумаар өсөх хандлага буурахгүй байгаа нь сонгогдох эрхийн хэрэгжилтэд таатай нөлөө үзүүлэхгүй нь тодорхой юм.

Өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн сонгуулийн сурталчилгааны хугацаа маш богино бөгөөд ялангуяа нэр дэвшигчдийн хувьд мөнгө босгож сурталчилгаатай холбоотой зардлаа санхүүжүүлэх нь нэн төвөгтэй нь ойлгомжтой. Энэ нь хуулиас гадуур аргаар кампанит ажлаа санхүүжүүлэх нэг сэдэл болохыг үгүйсгэх аргагүй. Зохиогчийн зүгээс энэ асуудлыг намын оролцоотой зохицуулах бололцоотой гэсэн санааг дэвшүүлсэн нь анхаарал татаж байна.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл тус тусын нэр дэвшигчдийг сонгуульд ялуулахын төлөө, сонгуулийн кампанид оролцох зардлыг өөрөө санхүүжүүлнэ. Нам, эвсэл сонгуулийн зардлаа эх үүсвэр, зориулалтаар нь нэгтгэн төсөвлөж Их, Бага (ҮЗХ) хурлаараа баталж, эвсэл бол гэрээндээ тусгаж гүйцэтгэх байгууллага нь эрхлэн хэрэгжүүлнэ. (Б.Чимид, 2008, х. 177)

Өөрөөр хэлбэл, нам санхүүжилтийг төвлөрсөн байдлаар бүрдүүлж, тодорхой төсөв, төлөвлөгөө батлан хуваарилах замаар зохион байгуулалт хийх ёстой гэж ойлгогдохоор байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигч сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш зардлын данс нээн ашиглах бололцоотой. Намын сонгуулийн зардлын данс тогтмол байхаар хуульчилсан бөгөөд үүнд орлого төвлөрүүлэх буюу хандив хүлээн авах боломжтой. Харин сонгуулийн сурталчилгаанд чиглэсэн зардал гаргахыг сонгуулийн жил тодорхой хугацаанд зөвшөөрөхөөр зохицуулсан. Зохиогчийн дэвшүүлж асан саналыг хэрэгжүүлэх нь намын институтчлэлийг дэмжих, сонгууль хөрөнгө нөөцийн хувьд давуу хувь хүмүүсийн уралдаан бус бодлогын өрсөлдөөн болох нөхцөл бүрдэх сайн талтай байж болох бөгөөд энэ талаар улс төрийн нам, судлаач болон бусад талууд зөвшилцөн хэлэлцэх нь үр дүнтэй.

Сонгуулийн санхүүжилтийн талаарх дээрх асуудлуудаас гадна мөнгөний зохисгүй нөлөөг хянаж сэргийлэхэд төр, иргэний нийгмийн зүгээс тавих хяналт нэн чухал болохыг зохиогч мөн онцлон дурджээ. “Намын санхүүжилт бүхэлдээ төрийн хяналтад байх ёстой.” (Б.Чимид, 2008, х. 171)

Ийнхүү хяналт тавихад сонгуулийн зардлын тайланг ямар хугацаанд ямар хэлбэрээр тавих нь чухал болохыг тэмдэглээд хууль тогтоомжид үүнийг оновчтой тусгаж зохицуулаагүй байгааг шүүмжилсэн байна. “Зардлын тайлан бол угтаа сонгуулийн хуулийн биелэлтийн мөнгөн илэрхийлэл, хяналтын гол хэлбэр гэж болно.” УИХ-ын сонгуулийн зардлын тайланг сонгууль аль хэдийн өнгөрсний дараа хянан дүгнэхээр СТХ-д заасныг шүүмжлээд “эцсийн тайлан бол угтаа ниргэсэн хойно нь хашгирав” гэгчийн үлгэр шахуу юм”, “ хэдий нь мөнгө төгрөгөө “баруун солгойгүй” зарж үрээд дууссан хойно шалгаад, тайланг сонсоод ч яах билээ” гэжээ. (Б.Чимид, 2008, х. 182)

Улмаар энэ асуудлыг шийдвэрлэх арга замыг зааж зөвлөснийг үзвэл: “Тайлан бол нилэнхүйд нь төдийгүй сэдэвчилсэн, сонгон, түүвэрлэсэн явцын, эцсийн гээд янз бүрийн хэлбэр хэмжээтэй байж болно.”, “Санхүүгийн үйл ажиллагаанд хийх шалгалт, тайланг: урьдчилсан, явцын, эцсийн гэхчлэн үечлэн зохиодог нь илүү үр нөлөөтэй” гэсэн байна. (Б.Чимид, 2008, х.180-181)

Зохиогчийн санал болгосон дээрх зохицуулалт сонгуулийн хууль тогтоомжид 2019 онд буюу бүтээл хэвлэгдсэнээс хойш арав гаран жилийн дараа сая тусан хэрэгжиж эхэлсэн. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 58.4-т “Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” Цаашид тайланд тусгах мэдээлэл, нийтэд мэдээлэх арга хэлбэр зэргийг боловсронгуй болгох замаар үр нөлөөг

нэмэгдүүлэх нь чухал юм. Түүнчлэн сонгуульд оролцогч талуудын зүгээс өмнө ач холбогдлыг нь ойлгон мэдээллийн ил тод байдлыг хангах нь ач холбогдолтой. Энэ талаар мөн зохиогч орхигдуулалгүй сануулсан байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчид бас **өөрийн** (дотоод) **хяналттай** байх ёстой. Ялангуяа хандивын хэмжээг зөвхөн тайланд яаж тусгахаа бодох бус. Харин сонгуулийн зохистой ажлын явцад хандивын хэд хичнээн мөнгийг, хэзээ, хаана, юу, юунд зарцуулж **яваагаа** цаг тухайд нь сонин, ханын хэвлэл, вэб хуудсанд баримтаар мэдэгдэж, уулзалтын хурал, цуглаанд амаар тайлагнах зэрэг боломжтой бүх хэлээр үнэн мөнөөр нийтэд мэдээлж байх нь ардчилсан ёс. **Энэ нь хандивлагчдын урмыг сэргээж сонгогчдын итгэлийг улам лавшруулна.** (Б.Чимид, 2008, х. 182)

Эцэст нь номын энэхүү бүлэгт онцгойлон тусдаа дэд сэдэв болгон авч үзсэн нэг зүйл нь сонгогчдын хөндлөнгийн хяналт юм. “Сонгууль бол сонгогчдын төлөө байдаг бөгөөд түүний зардал нь нэр дэвшигчийн биш татвар төлөгчдийн мөнгө, хандивлагчдын хөрөнгө мөн. Үүний учир иргэд түүний зарцуулалтыг хянах, мэдээлэл авч дүгнэлт хийх нь зүй ёсны хэрэг юм.” “Энэ бол иргэдээс төрийг удирдахад болон сонгуульд оролцох эрхийн чухал хэсэг, ил тод зарчмаас урган гарсан үйл хэрэг юм.” (Б.Чимид, 2008, х.183)

Хөндлөнгийн хяналтын ач холбогдлыг ийнхүү өгүүлэхдээ иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг онцлон үзэж ялангуяа төрийн эх үүсвэрийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах байдалд мониторинг хийх нь ач холбогдолтой болохыг дурджээ. “Сонгуулийн тойргийн болон улсын хэмжээний санхүүжилтэд ТББ хяналт шинжилгээ (мониторинг), хөндлөнгийн магадлан шинжилгээ (аудит) хийлгэх нь үнэнийг тогтоох, сонгогчдын итгэл, хандивлагчдын итгэлийг сэргээх ач холбогдолтой.” (Б.Чимид, 2008, х. 183). Үүнд ялангуяа, төрийн эх үүсвэрийг сонгуульд ашиглах зүй

бус үзэгдэлд иргэний нийгмийн зүгээс хийж буй хяналт үр дүнтэй болохыг дурджээ.

Засаг төрийн ажлын далбаан доор чухамдаа сонгогчдын эрхийг хангахын тулд биш, гагцхүү нам, эвсэл, нэр дэвшигчийн “ялалтын төлөөх” энэхүү үрлэг зарлагын дээр нам, эвслүүд сонгогчдын сонирхлыг ямар ч эх үүсвэрээр хамаагүй өөртөө татахын тулд хууль ёсны шийдвэргүйгээр төрийн өмнөөс асар их өглөг өрсөлдөн амладаг болсныг юу гэж үзвэл зохих? Эцсийн утгаараа сонгуулийн дам зардал, утгаа сонгогчдын саналыг худалдан авах далд хэлбэр мөн. (Б.Чимид, 2008, х.184-185)

Зохиогчийн сэрэмжлүүлэн шүүмжилсэн үзэгдэл өнөөг хүртэл сонгуульд ажиглагдсаар байгаа билээ. Тухайлбал, 2020 оны УИХ-ын сонгуулиар эрх баригч нам төрийн нөөц, эх үүсвэрийг захиран зарцуулах эрх мэдлээ халамж, тэтгэмжийн чанартай өргөн цар хүрээ бүхий үйл ажиллагаа хэрэгжүүлж давуу тал олж авахад ашигласныг иргэний нийгмийн зүгээс шүүмжилж байв. Энэ асуудал 2024 оны сонгуулиар ч давтагдсан.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах нь хууль бус сурталчилгаа болохыг зааж, хориглосон. Энэхүү заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл бүхий “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлж (Хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал) , мөн оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

Дээрх хуулийн хүрээнд “Шинэ хоршоо” санаачилгыг орон даяар сурталчилж, төрийн албан хаагчдыг дайчлан малчдад мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан. 2024 оны 10 дугаар сард энэхүү санаачилгад зарцуулсан хөрөнгийн талаар Засгийн

газрын албан тушаалтны хэвлэлд өгсөн мэдээллээс үзвэл 16,399 малчинд нийт 556 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосон гэжээ¹ (Монгол Улсын Засгийн газар).

Цаашид сонгуульд тэгш өрсөлдөх нөхцөлийг сайжруулахын тулд төсөв, төрийн албыг сонгуулийн үйл ажиллагаанаас зааглах зохицуулалтуудыг сонгуулийн хууль тогтоомжоос гадна Төрийн албаны тухай хууль, төсвийн холбогдолтой хууль тогтоомжид нарийвчлан зааж хариуцлагыг тодорхой болгох нь зүйтэй.

Зохиогчийн зэмлэн өгүүлснээр “Бэлэн мөнгө, бараа бүтээгдэхүүн тараах, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх, “өглөгийн зээл” дур мэдэн амлах нь эх үүсвэрийн (улс, хувь хүн, хандивын гэх) ялгаагүй “сонгогчдын санал худалдан авах хуулиар хориглосон гэмт явдал мөн.”; “Энэ гэмт үйлдэл нь цэвэр сонгуулийн шударга ёсыг хөсөрдүүлж улс төрийг бузарлан хэврэгшүүлж буйн зэрэгцээ сонгогчдын нэлээд хэсгийг санал өгөхдөө наанадаж “гар хардаг”, цаанадаж “саналаа үнэлдэг” үзэшгүй муу зуршилд хөтөлж, хүн ард, удам хойчоо сэтгэл зүйн хордлогод оруулж байгаа нэн аюултай үзэгдэл мөн” гэжээ. (Б.Чимид, 2008, х. 189)

Эцэст нь сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн бол зохих хариуцлага хүлээлгэх нь хууль дээдлэх ёсонд нийцэх талаар зохиогчийн сануулж өгүүлсэн нь өнөө хэр хэрэгжихгүй байгааг дурдах нь зүйтэй. “Хөрөнгө, мөнгө зориулалтаас гадуур үрэн таран хийсэн, завшсан, луйварт өгсөн, хориглосон эх үүсвэр, данснаас гадуур зарцуулсан, авлигадсан зэрэгт гэмтнийг гэсгээх, ийм замаар “гарсан” “сонгогдогч”-ийг эгүүлэн татахыг мэдүүлэх, зэм хариуцлага нэхэх нь шударга ёс.” (Б. Чимид, 2008, х. 184) Сонгуулийн санхүүжилт, сурталчилгаатай холбоотой гомдол, мэдээлэл хууль, хяналтын байгууллагуудад нэлээд очдог ч шүүхийн шатанд шийдэгдсэн нь тун цөөн байсаар өнөөг хүрчээ. Үүний цаадах учир

¹ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 95 дугаар тогтоолоор байгуулагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо”-ны анхдугаар хуралдаан боллоо. 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр. < <https://www.gov.mn/mn/news/all/1aa84e26-1a0e-438d-a7b0-ed194b3f20ef>> Сүүлд үзсэн огноо 2025 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр.

шалтгааныг нарийвчлан судалж зохиогчийн өгүүлсэн шударга ёсыг сахих арга замыг тодорхойлох нь сонгуулийн шинэчлэлийн нэг чухал асуудал мөн болно.

Дүгнэлт

Б.Чимид асан “Сонгуульд суралцахуй” бүтээлдээ 2008 онд сонгуультай холбоотой өрнөж байсан үйл явцыг олон талаас нь хурц нүдээр шүүмжлэхийн сацуу ардчилсан сонгуулийн мөн чанарын талаар ухуулан тайлбарлаж, энэхүү мөн чанарыг сэвтээхгүй хамгаалах нь “төрөө цэгцэлж, хуулиа шулуутгаж, ёс суртахуунаа цэвэршүүлж, амьдралаа өөд татах” ухаан болохыг учирласан нь өнөөдөр ч үнэ цэнтэй хэвээр. (Б.Чимид, 2008, х.170) Сонгууль нь өнгө, мөнгө, хувь хүмүүсийн хоорондын уралдаан бус, ул суурьтай бодож боловсруулсан мөрийн хөтөлбөрт тулгуурласан бодлогын өрсөлдөөн байх ёстой талаар өгүүлжээ. Мөрийн хөтөлбөр нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн үйл ажиллагааг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог бүхэлд нь хамарсан бөгөөд “улс орны эдийн засаг, улс төр, нийгэмшил, соёл, оюуны болон Монголын олон улсын үйл ажиллагаанд тулгарч буй зарчмын гол гол асуудлыг хэзээ яаж шийдвэрлэх” талаар “ажил хэрэг”, “авах арга хэмжээ” “биелэх хугацаа” “биелүүлэх эзэн” “хангах нөөц нөхцөлөө” заасан бодитой амлалт тусгасан байх ёстойг сануулсан нь одоо ч сонгуульд оролцогч талуудад чухал хэвээр зөвлөмж аж. (Б.Чимид, 2008, х.145)

Сонгуулийн хэт өндөр зардал, төрийн эх үүсвэрийг зүй бусаар зарцуулах зэрэг үзэгдэл нь улс төрийн клиентелизмийг угжиж, ардчилсан сонгуулийн мөн чанарыг гуйвуулах хортой нөлөө үзүүлж эхлээд байгаа талаар сэрэмжлүүлж байсан нь өнөөг хүртэл тулгамдсан асуудал хэвээр байна. Зохиогч мөнгөний зүй бус нөлөөг арилгахын тулд “намын санхүүжилт бүхэлдээ төрийн хяналтад байх ёстой” гэж өгүүлж байсан санаа нь бүтээл хэвлэгдсэнээс хойш 15 жилийн дараа 2023 онд шинэчлэн

баталсан Улс төрийн намд сая тусан хэрэгжиж эхлээд байна. Гэвч улс төрийн хүрээний авлигын асуудлын нэг гогцоо болсон улс төрд эргэлдэж буй мөнгөний асуудлыг шийдвэрлэхийн тулд цаашид эрх зүйн орчныг сайжруулах болоод хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, улс төрийн намуудын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх гэх мэт олон ажил хийгдэх ёстой. Үүнд төр, иргэний нийгэм, судлаачид хүчээ нэгтгэн зүтгэх нь чухал юм.

---ooOoo---

Ном зүй

- 1.Д.Энхцэцэг (2025). 2024 оны УИХ-ын сонгуулийн талаарх ерөнхий тойм: чөлөөт, шударга сонгуулийн зарчмуудтай холбоотой асуудлууд. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум.
- 2.Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.
- 3.Б.Манлай (2024, 04 10). Д.Загджав: 27 нам, хоёр эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр буцаагдсанд санаа зоволтгүй. www.ikon.mn: <https://ikon.mn/n/34bo>
- 4.Хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалыг үзэх: <https://lawforum.parliament.mn/project/566/>
- 5.Монгол Улсын Засгийн газар. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 95 дугаар тогтоолоор байгуулагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо”-ны анхдугаар хуралдаан боллоо. 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр. < <https://www.gov.mn/mn/news/all/1aa84e26-1a0e-438d-a7b0-ed194b3f20ef>> Сүүлд үзсэн огноо 2025 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

САНАЛ, ДҮГНЭЛТ

Б.Эрдэнэдалай

*МУИС-ийн Улс төр судлал, олон улсын
харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн
дэд профессор, улс төр судлалын доктор*

Оршлын оронд товч түүх

Д.Энхцэцэг судлаачаас ирсэн шүүмж эргэцүүллийг уншиж эхлэхэд Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй” хэмээх номыг хэдэн онд, хэрхэн бүтээлгэсэн тухай байсан нь миний хувьд энэ бүтээлтэй хэрхэн танилцаж байсныг минь бичмээр санагдуулав.

Миний бие 2008 онд МУИС-ийн Улс төр судлалын ангийн оюутан бакалаврын дипломын ажлаа “Сонгуулийн санхүүжилт” сэдвээр бичиж байсан юм. Тэр үед Нээлттэй нийгэм форумд оюутан, судлаачдад зориулсан гадаад, дотоодын их шинэлэг ном бүтээлтэй номын сан нэг давхарт нь ажилладаг байв. Яг миний судалгааны ажлын сэдэвтэй холбоотой асуудлыг хөндсөн ном бүтээл хэд хэд байснаас гадна олон улсын бодлогын судалгааны байгууллагуудын ардчилал, сонгууль, сонгуулийн санхүүжилт, иргэдийн оролцоо зэрэг сэдвээр хийгдсэн судалгааны ажлуудыг хэвлээд, үдээд тавьчихсан байсан нь судалгааны ажилд минь их хэрэг болсон. Нэг өдөр нөгөө бүтээлүүдээ унших гээд очтол Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй” гэдэг ном ирсэн байсан нь гадаад улсуудын сонгууль, сонгуулийн санхүүжилтийн талаар уншаад Монголынхоо хэсгийг Сонгуулийн тухай хуулийн заалтуудтай холбон дүгнэж байсан бүлэгт минь том нэмэр болж билээ. Гэхдээ уг номын агуулгыг бичсэн хэлбэр нь их сонин, би Б.Чимид багштай яриад сууж байгаа ч юм шиг, эсвэл эдгээр

сэдвээр Б.Чимид багшийн уншиж байгаа лекцэд сууж байгаа ч юм шиг тийм хялбар, дөнгөж бакалаврын оюутанд маш ойлгомжтой хэллэгээр бичигдсэн байсан нь их таалагдсан юм. Тэр өдрөө уншиж дуусгаад, маргаашаас нь аль хэсгийг өөрийнхөө дипломын ажилдаа эшилж оруулах вэ гэдэг ажилдаа шууд орсон. Мэдээж академик судалгааны ажил хийж байгаа болохоороо бараг энгийн ярианы юм шиг бичигдсэн хэсгээс нь биш, арай албан бичигдсэн хэсгүүдээс нь судалгааны ажилдаа эшилж оруулж байлаа.

Дээрх хэсгийг бичиж байхдаа энэ номын агуулга Монголын сонгууль, сонгуулийн системд тулгамдаад буй олон асуудлыг онолын үндэслэлтэй, гэхдээ маш практик байдлаар бичсэн, зөвхөн оюутан судлаачдад гэлтгүй, сонгуулийг зохион байгуулагч, сонгуульд бүх талаар оролцогч, нэр дэвшигч, сонгогч, сонгуулийн боловсролыг олгогч гээд бүх талуудад хялбар ойлгогдох бүтээл, гарын авлага байсан юм байна гэдгийг бодож суулаа. Гайхалтай.

Сонгуулийн сурталчилгаа

Сонгуульд нэр дэвшигчид зардлын тайлангаа аудитын байгууллагад тайлагнасны дараа олон нийтэд нээлттэй мэдээлэлдэг болсон. Эдгээр зардлын тайлангаас харахад, сонгуулийн сурталчилгааны зардал бусад зардалтай харьцуулахад 65-70 гаруй хувийг эзэлж байгаа нь хэн их хөрөнгө мөнгөтэй нам, нэр дэвшигчдэд илт давуу боломжийг олгосон, бүх нэр дэвшигчийн гарааны ижил, тэгш оролцоог хумьсаар байна. Гэтэл Б.Чимид багшийн (цаашид “зохиогч” гэх) “Сонгуульд суралцахуй” бүтээлд “Сонгуулийн сурталчилгаа гэж нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийн сонгуулийн байгууллага, ухуулагч, туслагч, дэмжигчдээс сонгогчдод зориулан өөрсдийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулж, нэр дэвшигчдийг дэмжин сурталчилж буйг хэлнэ” гэж тодорхойлоод сонгуулийн сурталчилгааны гол зорилго нь “сонгуулийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн давуу талыг зүйл бүрээр нотлон тайлбарлаж, сонгогчдыг түүний төлөө ‘өрсөлдүүлэн’ өөртөө татаж аль болох олон санал авах, оюун санааны нөхцөл бий

болгох явдал мөн” гэж тодотгон тайлбарлажээ. (Б.Чимид, 2008, х. 141)” гэж эшилсэн Д.Энхцэцэг судлаачийн саналд “сонгуульд оролцогч талуудын мөрийн хөтөлбөрт тулгуурласан бодлогын өрсөлдөөн байх ёстойг онцолжээ” гэсэн нь зохиогчийн бүтээлд сонгуулийн сурталчилгааны мөн чанарыг нарийн тодорхойлсныг харуулж байна.

Миний зүгээс дараах хэсэгт санал бичье. “...сонгуулийн байгууллага, **ухуулагч**, туслагч, дэмжигчдээс сонгогчдод зориулан өөрсдийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулж, нэр дэвшигчдийн дэмжин сурталчилж буйг хэлнэ” гэсэн хэсэгт байгаа “**ухуулагч**” сонгуулийн мөрийн хөтөлбөрийг нэр дэвшигчдийн бодлогын өрсөлдөөн болгон сонгогчдод сурталчлах ёстой. Энэ утгаараа, ухуулагч нь өөрийн улс төрийн үнэлэмж, үзэл баримтлалын хувьд тухайн нам, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр хэрхэн нийцэж буйд анализ хийн, тухайн нам, нэр дэвшигчдийн дэвшүүлж тавьсан бодлого буюу сонгуулийн мөрийн хөтөлбөрийг өөрсдөө бүрэн агуулгаар нь ойлгон ухаарч, ямар нэгэн цалин хөлсгүйгээр улс орны хөгжлийн төлөө тухайн нам, нэр дэвшигчтэй хамтран ажиллах ёстой юм. Гэтэл манайд аль ч түвшний сонгуулийн сурталчилгаанд ажиллахад цалин урамшуулалтай байдаг тул сонгуулиар далимдуулан мөнгөтэй болох, ажилтай болох гэсэн сэдлээр ухуулагч хийж байгаа нь их болжээ. Энэ талаар Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 37.3-т¹ хэдэн сонгогчид нэг ухуулагч байх талаар, 37.8-д² ухуулагчийн урамшууллын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байх талаар тус тус заасан. Цаашид энэ маш буруу тогтолцоог засах шаардлагатай байна.

Мөн “Зохиогчийн өгүүлснээр “Хэрэв сонгуульд ялбал

¹ 37.3.Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг менежер, аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороо, аймгийн төвийн баг тус бүрд нэг шадар туслагч, нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно. (МУИХСТХ, 2019)

² 37.8.Ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд урамшууллын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна. (МУИХСТХ, 2019)

олонхи болсон нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ноён нуруу болно.” Иймд мөрийн хөтөлбөр нь “ард түмэндээ андгайлсан амлалт, тэдэнтэй байгуулсан **нийгмийн гэрээ**” мөн гэсэн нь анхаарал татна. (Б.Чимид, 2008, х. 143) Ийм өндөр ач холбогдолтой баримт бичиг болох тул тодорхой шаардлагыг хангасан байх ёстойг мөн онцолсон байна.” гэж судлаач Д.Энхцэцэг дүгнэжээ. Энэ хэсэг их чухал санааг агуулсан байна. 2024 оныг хүртэл УИХ-ын сонгуульд намууд, нэр дэвшигчид сонгуулийн мөрийн хөтөлбөрийнхөө хүрээнд бодлогын мэтгэлцээн зохион байгуулаагүй. 2024 оны УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулахтай холбоотойгоор “намын жагсаалт”-ын нэр дэвшигчид дэвшсэн. Үүнээс гадна мэтгэлцээн хийгдэхгүй байна, сонгуульд дэвшүүлж буй мөрийн хөтөлбөрөөрөө мэтгэлцээнд оролцож чадахгүй нам, нэр дэвшигчийг сонгохгүй, бодлогын өрсөлдөөн байхгүй зэргээр судлаач, сонгогчдын шүүмж их гардаг байсан. 2023 онд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр буюу тус хуулийн “46.2.Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны болон **мэтгэлцээний** нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлнэ” гэж заасан нь зохиогчийн бүтээлдээ бичсэн санааг агуулж байна.

Сонгуулийн санхүүжилт

Миний хувьд эрдмийн зэрэг хамгаалсан дипломын ажлаа улс төрийн санхүүжилт сэдвээр бичсэн, түүнээс хойш энэ асуудлыг олон талаас нь судалж байгаагийн хувьд зохиогчийн болон судлаач Д.Энхцэцэгийн гаргасан бүх саналтай санал нийлж байна. Үүнээс ч олон асуудал байгаа, цаашид ч нэмж гарах байх. Товчхон дараах саналыг бичье.

Зохиогчийн бичсэн сонгуулийн сурталчилгаа, санхүүжилт гэсэн хоёр бүлэг нь нэг зоосны хоёр тал шиг бие биеэсээ шууд хамааралтай сэдэв гэдгийг бид мэднэ. Тэгвэл “зохиогчийн зүгээс

уулзалт хийх хугацаа нь “нэр дэвшигч бүртгүүлсэн өдрөөс эхлэн сонгуулийн сурталчилгааг дуусгавар болговол зохих өдөр хүртэл буюу...17 өдөр” байгаа нь “тун давчуу” болохыг дурджээ. “Аймгууд 14-28 хүртэл сумтай. Сум 3-12 багтай. Тэр бүхэнд сонгуулийн хэсэг. Хэсэг бүрд төв бий. Сум бүрд хүрэлцэн очно гэвэл нэгд нь дунджаар нэг хоног, түүнээс бага хугацаа ноогдож байна.” (Б.Чимид, 2008, х. 164-165). Бүтээл хэвлэгдсэн 2008 онд болсон УИХ-ын сонгуулийг мажоритар тогтолцоогоор буюу 2-4 мандаттай 26 томсгосон тойргуудад зохион байгуулсан байдаг. Үүнд Налайх, Багануурыг нэгтгэсэн нэг тойргоос бусад аймаг, дүүрэг тус тусдаа тойрог болж байв. Харин 2024 оны УИХ-ын сонгуулийг харьцуулж үзвэл холимог системийн мажоритар тойргууд нь 2-10 мандаттай 13 бүсчилсэн тойрог байлаа. Үүнд, хөдөөд 7 тойрог байгуулсан байх бөгөөд Баян-Өлгий аймгаас бусад аймгийг 3-4-өөр нь нэгтгэн нэг том тойрог болгосон байдаг. Сурталчилгааны хугацааны хувьд 2024 оны 6-р сарын 10-ны өдрөөс эхлэн 6-р сарын 26-ны өдрийг дуустал цөөн хоног явагдсан. Өөрөөр хэлбэл, 2008 онд зохиогчийн давчуу гэж үзэж байсан хугацаанд нэр дэвшигч 3-4 аймгийг хамарсан сурталчилгаа хийхээр хуульчилсан нь нөхцөл байдал улам дордсоныг илтгэнэ.” гэсэн судлаач Д.Энхцэцэгийн саналтай санал нийлж байна.

Уг нь сонгуулийн зардлыг бууруулах үүднээс сурталчилгааны хугацааг аль ч түвшний сонгуульд ийм цөөн хоногтой байлгаж байгаа. Гэтэл сүүлийн сонгуулиудад сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө хэн мөнгөтэй, нөлөө бүхий нэр дэвшигчид хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан боломжит бүх хувилбараар, урьдчилаад бүх сурталчилгаагаа хийгээд, албан ёсоор сонгуулийн кампанит ажил эхлэхэд бусад өрсөлдөгч нэр дэвшигчдээ хараад “шүдээ чигчлээд” инээгээд сууж байдаг болсон гэхэд хилсдэхгүй боллоо. Мөн сонгуулийн жил эхлэхээс өмнө санал худалдан авалтыг төгс төгөлдөр хийдэг болсоор байгаа нь зохиогчийн сануулж бичиж байсан зүйлтэй яг л нийцэж байна. Бидний төлсөн

татварын буюу төсвийн мөнгөөр бидний саналыг худалдаж авдаг арга техникийг улам боловсронгуй болгож байгаа эрх баригч намууд, улс төрчдөд “үйлийн үр” гэсэн ойлголт байдаггүй мэт. Энэ хашилт дахь үгийг бичихдээ улс төрийн санхүүжилт, санал худалдан авалттай холбоотой үүсдэг сөрөг асуудлуудад үнэхээр их бухимддаг болсон тул зохисгүй үг ашигласан байж магадгүй, хүлцэл өчье.

Тухайн сонгуулийн тойргийг хэрхэн “зурах”-аас хамаараад нэр дэвшигч хэдэн сонгогчид сурталчилгаагаа хүргэж ажиллах нь тодорхой болдог. Нэг тойрог дахь мандатын тоо ихсэх тусам сурталчилгаагаа хүргэх газар нутгийн хэмжээ, сонгогчдын тоо ихэснэ. Үүнийг дагаад ухуулагчдын тоо ч шууд нэмэгдэнэ. Ухуулагчдын тоогоо хангалттай байлгавал, амжилт гаргах боломж нэмэгдэх талтай. Гэхдээ үүнийг дагаад сонгуулийн зардал шууд нэмэгдэнэ. Энд бичиж байгаа асуудалтай мэт уншигдаж буй зүйлс нь мөнгөтэй, өмнөх жилүүдэд тухайн тойргоосоо олон сонгогдсон, эсвэл бүхний мэддэг улс төрч, угаас тойргоо тогтмол “усалсан” нэр дэвшигчдийн хувьд асуудал биш. Харин сонгогчдын үйл байдлыг тодруулах судалгаагаар тогтмол гарч ирдэг Монголчуудын “хүсэмжит” нэр дэвшигчид буюу боловсролтой, мэдлэгтэй, улс орныхоо төлөө гэсэн чин сэтгэлтэй, аль нэг улс төрийн намын увайгүй байдлыг дэмждэггүй, бодлогын төлөө тууштай, хувийн эрх ашгийг ард түмний эрх ашгаас дээгүүр тавьдаггүй, залуу зэргийг хангасан шинэ нэр дэвшигчдэд сонгуулийн тэгш, шударга байх зарчмыг хангаагүй нөхцөл байдлыг үүсгэдэг.

2024 оны УИХ-ын сонгуулийг бүсчилсэн том тойрогтой байхаар зохион байгуулсан нь олон жил улс төр, сонгуулийн асар их санхүүжилтийг хязгаарлах, бууруулах, залуучууд, эмэгтэйчүүдийг сонгуульд нэр дэвшүүлэх, ялалт байгуулах нь бодлогын хувьд ямар ач холбогдолтойг шийдвэр гаргагчид, олон нийтэд арай гэж ойлгуулж байсныг “нухчин дарсан”, бүхнийг эхнээс нь хэн хүчтэй, мөнгөтэй нь “бариа”-нд түрүүлж ордог байгалийн хуулийг дэмжсэн

юм. Нэгэнт барианд түрүүлж орох нь эхнээсээ маш тодорхой байсан нэр дэвшигчдийн хувьд сонгуулийн ямар тогтолцоог ашиглахаа эхнээсээ захиалдаг биз. Өмнөх парламентад суудалтай улс төрийн намууд буюу парламентын гишүүд ирэх сонгуулийн тухай хуулийг баталдаг тул өөрсдөдөө ашигтай сонгуулийн тогтолцоо, хувилбарыг санал болгож батлах нь ойлгомжтой. Ийм бохир, клиентелист улс төр, сонгуульд бидний “хүсэмжит” нэр дэвшигчид ялалт байгуулна гэдэг бол ойрын хоёр сонгуульд байхгүй л болов уу. Эсвэл гайхалтай сайн сонгуулийн кампанит ажлын шинэлэг технологи, сонгогчдын мэдлэг боловсрол илт сайжирч, санал худалдан авалтыг жигшдэг сонгогчидтой болсон цагт боломжтой байж болох юм.

Бид улс төрийн намууд, улс төрчдөөс ардчиллыг бэхжүүлэх,
улс орны хөгжил, иргэдийнхээ төлөө шийдвэр гаргадаг,
ажилладаг тийм “сэтгэл”-тэй
манлайллыг хүсэж, шаардаж байна.

Бид тэднийг ийм “сайн” байгаач гэж гуйж, олон талаас нь
шаардах, шүүмжлэх, нөлөөлөх гэж оролдох, жагсах биш тэд л
бидний төлөө “сэтгэл” гаргахад л болох юм ш дээ.

---ooOoo---

Ном зүй

1.Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

С.Бат-Орших

МУИС, Хууль зүйн сургуулийн багш

1992 оны ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид (цаашид зохиогч гэх) “Сонгуульд суралцахуй” номоороо тухайн үеийн буюу 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн үүднээс сонгуулийн тогтолцоо, бэлтгэл, үйл явцыг олон нийтэд тайлбарлан таниулжээ. Зохиогч тус номын VIII болон IX бүлэгт “Сонгуулийн сурталчилгаа”, “Сонгуулийн санхүүжилт”-ын талаар тус тус авч үзжээ.

Номын “VIII.Сонгуулийн сурталчилгаа” бүлгээр зохиогч сонгуулийн сурталчилгаа гэдгийг “нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийн сонгуулийн байгууллага, ухуулагч, туслагч, дэмжигчдээс сонгогчдод зориулан өөрсдийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулж, нэр дэвшигчдийн дэмжин сурталчилж буйг” хэлнэ хэмээн тодорхойлжээ. Мөн тэрээр сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сонгуулийн сурталчилгааны үндсэн эх сурвалж хэмээн онцолж, сурталчилгааны арга, хэрэгслүүдээс “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах” болон “Нэр дэвшигч олон түмэнтэй ажиллах”, түүнчлэн үүн дундаа “Сонгогчтой уулзах” явдлыг дэлгэрэнгүй авч үзсэн байна (Б.Чимид, 2008, х.140-69). Түүнчлэн тус бүлэгт зохиогч сонгогчдод хандан “ёс бус амлалтаас нь бус, юу сурсан, юу хийж чаддагийг [сонгуульд өрсөлдөгчийн] түүхэн замналаас нь, юу хийж яаж гийгүүлэхийг мөрийн хөтөлбөрөөс л шинжи[x] ... хэрэгтэй” хэмээн зөвлөсөн нь өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байна (Б.Чимид, 2008, х.142).

Номын “VIII.Сонгуулийн санхүүжилт” бүлгээр зохиогч сонгуулийн санхүүжилт гэдгийг “засаг төрөөс сонгуулийг бэлтгэн явуулах, нам, эвсэл, нэр дэвшигчдээс оролцон ажиллах зориулалтаар төсөвлөн хуримтлуулж, хуваарилан зарцуулдаг

мөнгөн хөрөнгийн хангалт” хэмээн тодорхойлжээ. Тэрээр сонгуулийн санхүүжилтийг эх үүсвэрээр нь “Улсын төсвийн санхүүжилт” болон “Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн санхүүжилт” гэж ангилан тус тусад нь дэлгэрэнгүй тайлбарласан байна (Б.Чимид, 2008, х. 170-89). Мөн зохиогч өнөөдөр ч үргэлжилсээр буй Улсын Их Хурлын сонгууль дагасан луйврыг хүчтэй шүүмжилж, энэхүү луйврын голомтыг сонгуулийн санхүүжилтийн гажиг хэмээн дүгнэж, тус гажуудлыг засварлахад сонгуулийн зардлын тайлан, хяналт чухал үүрэгтэйг онцолжээ (Б.Чимид, 2008, х.180-89).

Сонгуулийн асуудлыг хараахан гүнзгий судлаагүй залуу судлаачийн хувьд, зохиогчийн номын VIII болон IX бүлэгтэй танилцсанаар цахим хэрэглээ хурдацтай нэмэгдэж буй өнөө үеийн сонгуулийн сурталчилгаанд цахим орчныг ашиглах асуудлын талаар багахан хүрээнд хөндөхийг зорилоо. Зохиогчийн дурдсанчлан, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн зүгээс авч үзвэл “сонгуулийн сурталчилгаа” гэдгийг тухайн оролцогчдын сонгуульд ялалт байгуулах зорилгоор явуулж буй бүх төрлийн сурталчилгааны цогц үйл ажиллагаа гэж үзэж болох юм. Улмаар “сонгуулийн санхүүжилт” гэдгийг дээрх сурталчилгаанд ашиглагдах мөнгөн хөрөнгийг босгох, зарцуулах үйл ажиллагаа хэмээн ойлгож болно.

Өнөөдрийн буюу 2025 оны байдлаар, сонгуулийн сурталчилгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, нэр дэвшигч олон түмэнтэй ажиллах, сонгогчтой биечлэн уулзах зэрэг уламжлалт арга, хэрэгслүүдээр явагдсаар байгаа хэдий ч, цахим орчинд явуулах сурталчилгаа эрчимтэй нэмэгдэж байна. Энэ нь нэг талаас сонин, сэтгүүл, радио, зурагт зэрэг уламжлалт мэдээллийн хэрэгслүүдийг иргэд, ялангуяа 30 хүртэлх насныхан өргөн хэрэглэдэггүй болсонтой холбоотой. Жишээлбэл, миний хувьд өнгөрсөн 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеэр холбогдох мэдээллийг цахим орчноос авч байсан бөгөөд нам, эвсэл, нэр дэвшигчид ч цахим орчин, тэр дундаа олон нийтийн сүлжээний цахим хуудас (жишээ нь Facebook) болон бусад цахим хуудас (жишээ нь Youtube)-ыг өргөн хүрээнд ашиглан өөрсдийн сурталчилгааг явуулж байсан. Энэ үеэр анзаарагдсан нэг зүйл бол инфлүүнсер зэрэг “цахим орчны үйлчилгээ эрхлэгч”-ээр хийлгэсэн

сонгуулийн агуулгатай төлбөртэй сурталчилгаанд “сонгуулийн сурталчилгаа” гэсэн ил тэмдэглэл байхгүй байсан явдал юм.¹

Манай улсын хувьд өнөөдөр инфлүүнсер зэрэг цахим орчны үйлчилгээ эрхлэгчдийн хийж буй сонгуулийн агуулгатай төлбөртэй сурталчилгааг ерөнхийд нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 47 дугаар зүйл болон Сонгуулийн ерөнхий хорооны 14 дүгээр тогтоол (2024)-оор батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-аар зохицуулж байна. Гэвч дээрх зохицуулалтад инфлүүнсер зэрэг нийтэд нөлөө бүхий этгээдүүдийн хийсэн сонгуулийн буюу улс төрийн агуулга бүхий төлбөртэй контентод тухайн контентыг “улс төрийн эсхүл сонгуулийн сурталчилгаа” гэдгийг илтгэн харуулах тэмдэглэл оруулах, мөн ямар нам, хэн санхүүжүүлсэн талаарх мэдээллийг нийтэд ил тод байлгах талаарх шаардлага одоогоор байхгүй байна. Харин Европын холбоо, Их Британи, Австрали зэрэг орнуудад энэ талаарх зохицуулалтууд хэдийн хийгдэж эхэлсэн бөгөөд тэдгээрийн ерөнхий агуулгыг дараах байдлаар тоймлон харуулж болно:

Улс	Хууль/Дүрэм	Тавьсан шаардлага
Европын холбоо	Regulation of the European Parliament and of the Council on the Transparency and Targeting of Political Advertising (2024) (European Council)	Тус хуулиар улс төрийн агуулга бүхий сурталчилгаа нь ил тод тэмдэглэгээ (transparency label)-тэй байх ёстой бөгөөд ямар улс төрийн үйл ажиллагаатай холбоотой вэ, мөн тус зар сурталчилгаанд хэр их төлбөр төлсөн бэ, targeting буюу чиглүүлсэн үзэгчдийг ашигласан эсэх гэх мэт мэдээллийг олон нийтэд ил болгож байх шаардлагуудыг тавьсан.
Их Британи	UK Elections Act (2022) (The National Archives)	Тус хуулиар улс төрийн агуулга бүхий дижитал материалд мөнгө төлж хийлгүүлж байгаа этгээд нь өөрийн хэн болох, хэний нэрийн өмнөөс тухайн материалыг сурталчилж байгаагаа тодорхой харуулахыг шаарддаг болсон.

¹ Жишээлбэл рэппэр Б.Гантулгын Ерөнхий сайд асан Оюун-Эрдэнийн талаар хийсэн контентуудыг дурдаж болно. Өнөөдөр тухайн контентуудыг цахим орчноос утгасан байх тул олох боломжгүй байна.

Австрали	Australian Electoral Commission Statement: Authorisation statements for social media content (2025) (Australian Electoral Commission)	Тус зохицуулалтаар улс төрийн агуулга бүхий контентод хэнийг дэмжиж хийгдсэн, хэрэв төлбөртэй хийгдсэн бол төлбөр төлөгчийн талаарх мэдээллийг үнэн зөв оруулахыг шаарддаг болсон.
----------	---	--

Ийнхүү дүгнэж хэлэхэд, зохиогчийн бүтээлийн VIII, IX бүлэг болон “Сонгуульд суралцахуй” ном нь тухайн үеийн сонгуулийн тогтолцоо, түүнийг дагалдсан сорил, хүндрэлүүдийг гүнзгийрүүлэн ойлгоход үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй өнөөгийн сонгуулийн тогтолцоонд тулгамдаад буй бэрхшээлүүдийг даван туулах гарц, чиглэлийг эрэлхийлэхэд чухал онол-практикийн эх сурвалж болж байна.

---ooOoo---

Ном зүй

1. “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”, сүүлд үзсэн 2025.10.07, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089716019011>
2. European Council, “EU Introduces New Rules on Transparency and Targeting of Political Advertising”, last accessed on 2025.10.07, <https://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2024/03/11/eu-introduces-new-rules-on-transparency-and-targeting-of-political-advertising/>
3. The National Archives, “Elections Act 2022”, last accessed on 2025.10.07, <https://www.legislation.gov.uk/ukpga/2022/37/contents>
4. Australian Electoral Commission, “AEC statement: Authorisation statements for social media content”, last accessed on 2025.10.07, <https://www.aec.gov.au/media/2025/04-07b.htm>

САНАЛ, ДҮГНЭЛТ

М.Түвшинжаргал

*ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
хууль зүйн доктор*

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багшийн (цаашид зохиогч гэх) “Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй)” номынхоо наймдугаар дугаар бүлэг болон есдүгээр бүлгээр сонгуулийн сурталчилгаа болон санхүүжилтийн хүрээнд анхаарах асуудлыг тухайн цаг үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан сонгуулийн хууль тогтоомжид тулгуурлан хөндсөн байна.

Зохиогч уг бүтээлээ сонгуулийн төв байгууллага, улс төрийн нам, сонгогчдын боловсролд хувь нэмрээ оруулах зорилгоор сонгуульд суралцаж буй нийт сонгогч ард түмэндээ хаягласан зөвлөмж, анхааруулга, шүүмж байсан гэдэг нь тус бүтээлийн бүтэц агуулга, үг сонголт, найруулга зүй, сонгон авч тайлбарлан бичсэн жишээ баримтуудаас харагдана.

Номын сонгуулийн сурталчилгааны агуулгыг хөндсөн бүлэг нийт найман хэсэг, 11 дэд хэсэг, сонгуулийн санхүүжилт бүлэг нь долоон хэсэг, 5 дэд хэсгээс бүрдэж байгаа бөгөөд “Нээлттэй нийгэм форум”-ын Засаглалын хөтөлбөрийн менежер, улс төр судлаач Д.Энхцэцэг нь судлаачийн байр сууринаас дүн шинжилгээ хийж 2008 онд зохиогчийн бүтээлдээ хөндөж байсан сонгууль тойрсон асуудлууд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд шийдэгдэж чадсан эсэхийг харьцуулан хөндөж бичсэн нь чухал ач холбогдолтой болсон байна.

Сонгуулийн сурталчилгаа, санхүүжилт хэмээх VIII болон IX бүлгээр хөндсөн асуудал, агуулга өргөн тул зохиогчийн тухайн бүтээлдээ онцгойлон хөндсөн хэд хэдэн асуудлыг товч дүгнэхийг зорилоо.

Сонгуулийн сурталчилгаа

Нэг. Зохиогчийн зүгээс наймдугаар бүлэгт сонгуулийн мөрийн хөтөлбөр нь сурталчилгааны гол эх сурвалж мөн болохыг онцлон сонгогчдод хандан намуудын мөрийн хөтөлбөрүүдийг өрсөлдүүлэн үр дүнгийн төлөө л саналаа өгвөл илүү мэргэн сонголт болохыг тайлбарлажээ (Б.Чимид, 2025, х.122). Мөн тэрээр “мөрийн хөтөлбөрт туссан ёс бус амлалтаас нь бус, юу сурсан, юу хийж чаддагийг түүхэн замналаас нь, юу хийж яаж гийгүүлэхийг мөрийн хөтөлбөрөөс л шинжин” илүү зөвийг олж харах хэрэгтэйг сануулан тайлбарлажээ. Сонгуулийн хувь заяаг шийдэж төрийн эрх мэдлийг хэний гарт төвлөрүүлэхийг эцсийн дүнд сонгогчид л шийддэг. Иймд хэрсүү, ухаалаг, оюун санааны хувьд эрх чөлөөнд хүрсэн сонгогчид олон байх тусам сонголт мэргэн болно. Өөрөөр хэлбэл эцсийн дүнд мөрийн хөтөлбөрт туссан олон сайхан амлалтууд бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх нь сонгогчдын боловсрол мэдлэгээр шүүгдэх юм. Зохиогчийн зүгээс сонгогчийн боловсрол болон сонгуулийн үр дүн хоёр шууд харилцан хамааралтай гэдгийг илэрхийлэхийг зорьжээ.

Хоёр. Зохиогч сонгуулийн сурталчилгаа нь эерэг, сөрөг хоёр тал зэрэгцэн байдгийг сануулж өрсөлдөгч талаа ялахын тулд ямарч аргаар хамгаагүй муутган “харлуулах” башир, бохир арга хэрэглэх гэсэн үг огт биш гэдгийг сануулжээ (Б.Чимид, 2025, х.128). Цаашилбал, өрсөлдөгч нам, эвсэл, нэр дэвшигчийг доромжлох, гүтгэх, үзэл бодлыг нь гуйвуулах амин хувийн амьдралд нь ичгүүр сонжуургүй хутгалдан орох, хүнлэг бус, ёс зүй, зан суртахууны уналтад автсан хандлага гаргах зэрэг үйлдлийг нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж сонгуулийн манипуляц хийж буй үзэгдэл болохыг хурц шүүмжлэн хөндсөн байна. Манай улсад улс төрийн намууд сонгуулийн сурталчилгааны үеэр эсрэг тэсрэг талын хоёр дүрийг

бүтээлгэж улмаар хооронд нь сөргөлдүүлэн тавьж буруу зөвийг оньсого мэт орхин олон нийтээр таалган нийгмээр шүүлгүүлдэг сонгуулийн хар технологи хэдийнээ бий болсон. Сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуулийн хар технологи хэдий их ажиллана төдий чинээ сонгуулийн сурталчилгааны үндсэн эх сурвалж болох мөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэлд нийгэм анхаарал хандуулах нь багасах юм. Зохиогч дээрх эрсдэлийг онцолж сонгуулийн манипуляцийн аюулыг анхааруулжээ.

Гурав. Зохиогч сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Үндсэн хуульд нийцсэн буюу Үндсэн хуулийн хүрээнд бүрэн багтсан байхыг онцлон дурдсан. Улмаар сонгуулийн үр дүнд ялсан улс төрийн хүчин, нэр дэвшигчид Үндсэн хуульт байгуулалд үнэнч байх тангараг өргөн Үндсэн хуулийн үзэл санааг хамгаалах ёстойг ч онцгойлон сануулсан байна. Гэвч сонгуульд ялсан улс төрийн хүчин сонгуулийн дараа Үндсэн хууль болон сонгуулийн хууль тогтоомжид олон давтамжтай өөрчлөлт оруулах нь эргээд улс төрийн тогтворгүй байдалд шууд хүргэх аюултай болохыг ойлгуулахыг зорьжээ.

Сонгуулийн санхүүжилт

Нэг. Зохиогчийн сонгуулийн санхүүжилтийн асуудлыг танилцуулсан номын IX бүлгийн эхний хэсгийг мөнгө тойрсон хардлага, сэрдлэг гэж онцгойлон нэрлэсэн нь учиртай юм. Сонгуулийн луйврын гол эх үндэс нь намын санхүүжилт, албан тушаалын авлига, хяналтгүй мөнгөний урсгал болохыг анхааруулж уг өвчний үндсийг зөв тогтоож устгаж байж төрөө цэгцэлж, хуулиа шулуутгаж, амьдралаа өөд татах боломж нөхцөл бүрдэх боломжтой гэдгийг ойлгуулахыг зорьсон байна.

Хоёр. Сонгууль хийнэ гэдэг бол зайлшгүй төсөв мөнгө зарцуулагдах гэдэг нь тодорхой зүйл юм. Зохиогч сонгуулийн санхүүжилтийг:

1. улсын төсвийн (сонгуулийн зохион байгуулалтын);
2. нам, эвсэл, нэр дэвшигчдийн (улс төрийн намын санхүүжилт, хандив) эх үүсвэрээр гэсэн хоёр хэсэгт хувааж хуулиар зааг

ялгаатай байдлаар зохицуулах шаардлагатайг дурдсан байна. Сонгууль бол төрийн хэрэг учир улсын төсвийн хөрөнгө зарах нь тодорхой юм. Тэр хөрөнгө нь татвар төлөгчдийн мөнгө, ард түмний бүтээсэн сан хөмрөг тул үндэслэлтэй тооцоолж, ариг гамтай зарцуулж, зөв тайлагнаж, иргэдэд ил тод мэдээлж байх нь төрийн санхүүгийн сахилгыг бэхжүүлэх чухал үндэс болохыг зохиогч мөн бичжээ.

Гурав. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн санхүүжилт сонгуулийн зардлын хамгийн чухал хэсгүүдийн нэг юм. Нэр дэвшигчдэд өгч буй хандив бол албан тушаал, эрх мэдэл олж авах арга саам биш. Харин “засаг төрөө зөв төлөвшүүлэн бэхжүүлж улс орон, ард түмэнд үзүүлэх үр нөлөөг нь дээшлүүлэх чиг эрмэлзэлд хөтлөгдсөн сайн санаат хүмүүсийн өгөөмөр өргөл барьц” гэж зохиогч онцгойлон тайлбарласан байна. Гэвч “хандив хэрхэмжээнээсээ хэтэрч, ариун зорилгоосоо гажвал авлига болно” гэдгийг тодотгон сонгуулийн хандивт тавих хязгаарыг хэрхэн тогтоож мөрдүүлэх талаар хуульд нарийвчлан тусгаж мөрдөх нь чухал гэсэн санааг дурджээ. Мөн сонгууль бол сонгогчдын төлөө байдаг бөгөөд түүний зардал нь нэр дэвшигчийн биш татвар төлөгчдийн мөнгө, хандивлагчдын хөрөнгө тул сонгуулийн санхүүжилтэд ТББ-ын хяналт шинжилгээ, хөндлөнгийн магадлан шинжилгээ хийлгэх нь үнэнийг тогтоох, сонгогчдын болон хандивлагчдын итгэлийг сэргээх ач холбогдолтой гэжээ (Б.Чимид, 2025, х.165).

Эцэст нь Б.Чимид багшийн тэртээ арван долоон жилийн өмнө ээмлэж, шүүмжилж анхааруулж байсан сонгууль тойрсон асуудлуудын зарим нь одоог хүртэл тодорхой зохицуулагдаж чадаагүй ужиг болон оршсоор байгаа нь өнөөгийн бидний эрх зүйн хөгжлийн түвшний шууд үнэлгээ юм .

---ooOoo---

Ном зүй

1.Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.

V

**Сонгогчийн боловсрол
чухал болох нь**

СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ ЧУХАЛ БОЛОХ НЬ

С.Оюунтуяа

*“Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын
гүйцэтгэх захирал*

Нэг. Багшаа дурсахын учир

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид багшийгаа “бие нь үгүй ч билиг оюун нь, үзэл баримтлал нь, үнэт зүйл нь, итгэл үнэмшил нь, бүтээн туурвисан нь, хэлж захисан нь мөнх юм даа” хэмээн дурсаж байна.

“Сонгуульд суралцахуй” номын эхний нүүрэнд байх Хууль зүйн сургалт, судалгаа, төслийн “Х” төв гэдэг нь одоогийн “Чимид сан”-ийн суурь болов уу. Багшаас нэгэн удаа “Х” (“икс” буюу үл мэдэгдэх гэсэн агуулга болов уу) гэдэг чинь “юуг хэлж байгаа юм бэ” гэтэл багш “чамд ямар хамаатай юм” гэхэд хэрэгт дурласандаа ихэд ичиж билээ. Хожим хойно багш учрыг нь залруулж хэлсэн дээ.

Ийнхүү дурсахын учир нь миний бие тус төвийн ажилтнаар дөнгөж их сургуулийн босго алхаад ажиллах болсон их хувь заяатай минь холбоотой. 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг төгсөхдөө бакалаврын дипломын ажлаа эрхэм багшийнхаа удирдлага дор хамгаалах хувь тохиосон билээ. Бүтэн хаваржин их сургууль, одоогийн Удирдлагын академи, багшийнх 5 дугаар сургуулийн хойд талын орон сууцны байр, оюутны байрны дунд “улаан эрээн” болсон дипломын ажлаа тэврээд “улаа эргэтэл” гүйсэн дээ. Тэр цагаас хойш тэнгэрийн орноо зорих хүртэл нь бичиг цаасыг нь нааш цааш болгож, архивт сууж, мэдээлэл цуглуулахад нь дэм болж, судалгааны багт нь заримдаа багтаж, хөдөө гадаа томилолтоор хамт явж, үг сургаалыг нь сонсож, үйл

хэргийг нь хажуунаас нь харах ховор завшаан олдсон юм. Өдий зэрэгтэй яваа минь энэ ажлын буян юм.

2013 оны 3 дугаар сарын 14-ний өдөр багшийг бурхан болохоос хэдхэн хоногийн өмнө эмнэлэгт байхад нь эрхэм хүмүүсийн хамт зорин очиж уулзахад “алив Оюунтуяа суугаад бич” гээд хэлж бичүүлсэн 12 хуудас гар бичмэлийн нэг нүүрэнд **“Сонгууль бол ард түмний өөрсдийнх нь бүтээл байх ёстой”** гэсэн үг, өгүүлбэр тодхон байна.

Багшийн маань загнаж, зандрах нь ерөөл байсныг, хэлж захиж байсан болгоны зах зух, цаад учрыг одооноос бага ч атугай ухах ойлгож байна. Ийм агуу эрдэмтэн хүнээс суралцаж, ойр байж “загнуулах” ховорхон тавилан аль насны буяны үрээр ирсэн юм бүү мэд гэсэн бодол надад байдаг юм. Багшдаа мөргөнөм.

Хоёр. “Сонгуульд суралцахуй” номын тухайд

Би бээр 2001 оноос Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн гэдэг төрийн бус байгууллагад ажилд орж, тухайн үед хэрэгжиж байсан “Сонгогчдын боловсрол” хөтөлбөрийг хожмоо хариуцан ажиллаж байгаад 2008 оноос “Сонгогчдын боловсрол төв” нэртэй төрийн бус байгууллага болоход нь гүйцэтгэх захирлаар нь ажиллаж эхэлсэн. Энэ үеэс өнөөг хүртэл 25 дахь жилдээ сонгуулийн чиглэлээр ажиллаж байна.

Иймээс багшийн “Сонгуульд суралцахуй” гэдэг энэ номыг гарсан даруйгаас нь эхлээд эдүгээ хүртэл ширээний номоо болгож, өдөр бүр шахуу л эргүүлж, тойруулж нухаж ирсэн билээ. Гэсэн хэдий ч энэхүү “номын ойлголт, үзэл санаа, зарчмын ач холбогдлыг нээн илрүүлэх” уншлагад илтгэл бэлтгэж оролцох даалгавраас ихэд эмээсэн болно. Гэвч тус номын “Зохиогчийн үг” гэсэн хэсэгт байх **“...эш баримттай нотлон харуулахад нийгмийн практик, биеэр амссан амьдралын туршлага юугаар ч сольшгүй түшиг болдог”** гэснээс урам зориг авч, сонгуулийн чиглэлээр ажилласан өөрийн бага сагахан туршлагад дулдуйдан хүлээн авсан билээ. Алдаа байх аваас өршөөн хэлтрүүлэхийг юуны өмнө

хичээнгүйлэн хүсэж байна.

Энэ номыг бүтсэн түүхийг сайн санаж байна. Тухайн үед Нээлттэй нийгэм форумас сонгуулийн тогтолцооны талаар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тайлбарласан энгийн цомхон товхимол гаргахаар багштай гэрээлсэн боловч бүтээж, туурвих явцдаа агуулга, ач холбогдлыг нь өдрөөс өдөрт томруулснаар энэ ном бүтсэн түүхтэй. “Сонгогчдын боловсрол төв”-д ажилладаг тул багшийн даалгавраар энэ номд орсон тоо баримт, зарим жишээг нэгтгэж өгөх ажилд хувь нэмэр оруулсан минь нэр төрийн хэрэг байв.

Ширээний минь ном боловч унших бүр утга агуулга нь нарийсаж, шинэ ойлголт, мэдлэг өгдөг, дахин дахин ухаж ойлгож, учрыг нь олоход цаашаа улам бүр гүнзгий агуулгатайг таньж мэддэг, маш нарийн арга, аргачлалд суурилсан **шинжлэх ухааны бүтээл**, нөгөө талаас онол, практик хослуулсан **сурах бичиг**, түүнчлэн сонгуульд оролцдог бүх талуудад зориулсан сонгуулийн тогтолцоог бүхэлд нь багтаан тайлбарласан **гарын авлага**, сонгогчийн хувьд сонгуульд хэрхэн оролцох талаар **хөтөч** гэж боддог доо.

Сонгууль гэдэг өөрөө их нарийн төвөгтэй үйл явц, ойлголтоос бүрддэг тул түүнийг сонгогчдод ойлгуулж, тайлбарлан таниулах нь тун ярвигтай болохыг өнгөрсөнд өөрийн хийж хэрэгжүүлсэн олон ажлаас харсан билээ. Харин багшийн энэ ном нь эгэл жирийн сонгогч битгий хэл эрдэм номын хүн ч ойлгоход ярвигтай зүйлийг энгийн ахуйн үйл хэргээ тулгаа тойроод хэлэлцэн сууж буй адил хүүрнэн өгүүлэх байдлаар бичигдсэн байгаагаас өөрийн байгууллагын ажил хэргийн хүрээнд сэм хуулбарлан сонгогчдод хэсэгчлэн түгээж ирсэн болохоо энд илчилж байна.

Гурав. Нэрний учир

“Сонгуульд суралцахуй” ном нь “Өмнөх үеийн нэг намт сонгуульд хэний нэрийг дэвшүүлнэ, түүний төлөө саналаа өгч дадсан өвөг дээдсийн удамшилтай шинэ Монголчууд өдгөө

цагийн өрсөлдөөнт сонгуульд өөрийн бодолтой оролцож, бие даан шийддэг чадавхыг эзэмших нь төрийн хэрэгт нийтээр суралцахуйн гайхамшигт сургууль мөн болой” гэсэн зохиогчийн үгээр эхэлдэг. Энэ агуулгаас үндэслэн илтгэлийн сэдвээ **“Сонгогчдын боловсрол чухал болох нь”** гэж нэрлэсэн билээ.

“Сонгуульд суралцахуй” номыг уншигч 312 нүүр бүхий энэ номын зөвхөн нэг хуудас буюу 99 дэх нүүрнээс¹ л “сонгогчдын боловсрол” гэсэн холбоо үгийг олж харах бөгөөд өөр аль ч хуудсанд энэ үг байхгүй. Харин “сонгогчдыг мэдээллээр хангах”, “сонгогчдод мэдээлэл хүргэх” гэсэн үг, өгүүлбэр олонтоо таарна. Магадгүй “сонгогчдын боловсрол” гэж оноон нэршиж, хэрэглэх болсон нь нэлээд хожуу үеийнхтэй холбоотой байж болно. Мөн ихэнх тохиолдолд **сонгогчдыг мэдээллээр хангах**² (voter information), **сонгогчдын боловсрол** (voter education), **иргэний боловсрол** (civic education) гэсэн нэр томъёог нэг дор хэрэглэх хандлага бидэнд түгээмэл байдагтай холбоотой болов уу гэж бодож байна. Эдгээр нь сонгууль, ардчиллыг дэмжих боловсролын үйл ажиллагаа гэдэг утгаараа харилцан уялдаатай хэдий ч хооронд нь ялгаж салгаж ойлгох шаардлагатай болдог (The ACE Electoral Knowledge Network, “voter education”).

“Сонгогчдын боловсрол” гэдэг нь сонгогчдод сонгуульд санал өгөхийн ач холбогдлыг танин мэдүүлж, тэднийг сонгуульд бэлэн байлгахад чиглэсэн ойлголт бөгөөд сонгуулийн үйл явцаар дамжуулан сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлж, улс төрийн хүсэл зоригуу илэрхийлэх боломж олгодог. Иймд хэний төлөө санал өгөх вэ гэхээс илүүтэй хэрхэн санал өгөх вэ гэдэгт төвлөрдөг байна. Энэ талаас нь авч үзвэл тус ном бүхэлдээ сонгогч **сонгуулийн үйл явцаар дамжуулан сонгох эрхээ хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж,**

¹ “...сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах” гэж Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрх, чиг үүргийг тайлбарласан байна.

² Сүүлийн үед энэ ойлголтыг “сонгуулийн боловсрол” гэсэн нэр томъёогоор дүйцүүлж хэрэглэж байгаа тал бий.

улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэх вэ гэдэгт чиглэжээ. Мөн сонгогчдын боловсролд зориулсан “иж бүрэн хөтөлбөр” ч гэж хэлж болмоор санагдана.

Энэ талаар академич, Монгол Улсын гавъяат хуульч Ж.Амарсанаа номын өмнөх үгэнд “Зохиогч энэхүү номыг бүтээхдээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа “УИХ-ын сонгуулийн тухай хууль”-ийг олон түмэнд тайлбарлан таниулах хэлбэрийг бичлэгийн үндсэн аргаа болгожээ. Энэ талаас нь монгол улсын иргэд сонгох эрхээ эдэлж хэрэгжүүлэх боломж, арга замыг аргачлан сэнхрүүлсэн чухал гарын авлага болсон байна. Сонгогчдод сонгуульд хэрхэн оролцох талаар гүнзгийрүүлэн ойлгоход дэм болох зорилгоор ...тодорхой асуудлыг ухаж ойлгон, эргэцүүлэн бодож сонгуульд оролцох өөрийн байр сууриа тодорхойлоход тус дөхөм болжээ” (Б.Чимид, 2008, х.10) хэмээн тодорхойлжээ. Мөн зохиогч өмнөх үгэндээ “Түүнд сонгууль гэж ямар үүрэг, ач холбогдолтой, хэзээ юуны учир үүссэн хийгээд Монгол улсад үүсэж хөгжсөн түүхэн үе шат, өнөөгийн тогтолцооны уг чанар, Монголчууд биднээс ардчиллыг ёсоор нь хөгжүүлж, төвхнүүлж, улсаа жолоодоход сонгуулийн үр нөлөө юу болохыг нээн харуулахыг зорив” (Б.Чимид, 2008, х.13) гэснээс харж болно.

Дөрөв. Товч агуулга

“Сонгуульд суралцахуй” ном нийт 13 бүлэгтэй бөгөөд эдгээрээс Сонгогчдын нэрийн жагсаалт ба сонгогчийн үнэмлэх (5-р бүлэг), Сонгуулийн өдөрт бэлтгэх нь (10-р бүлэг), Санал хурааж, дүн гаргах (11-р бүлэг)-ийн товч агуулгыг авч үзье.

Эдгээр бүлгийн гол агуулга нь сонгуулийн үйл явцад оролцдог үндсэн, гол 2 оролцогч тал болох “сонгогч” болон сонгуулийг эрхлэн зохион байгуулдаг байгууллагын хоорондын харилцааг багтаасан байна. Нэг талаас сонгогч сонгуульд хэрхэн оролцох, нөгөө талаас сонгогчдын оролцоог хангах, тэдний оролцоо, саналыг сонгуулийн эцсийн үр дүн болгох ажлыг хэрхэн зохион байгуулах талаар дэлгэрэнгүй авч үзжээ. Тэгэхдээ

тухайн үед үйлчилж байсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд үндэслэн сонгуулийг эрхлэн явуулах болон сонгогчоос сонгох эрхээ хэрэгжүүлэх үйл явцыг алхам бүрээр нарийвчлан, өмнөх хэсэгт дурдсанчлан арга зүйн заавар, гарын авлага, хөтөч болохуйц байдлаар тодорхойлжээ.

Хэдийгээр сонгуулийн тогтолцоо, бэлтгэл, үйл явцыг зөвхөн эрх зүйн талаас нь хандаж гол төлөв одоо мөрдөж буй хуулийг тайлбарлах аргаар бичсэн тул хууль өөрчлөгдвөл ном “өөрчлөгдөхөд хүрэх” (Б.Чимид, 2008, х.16) талтай болохыг зохиогч урьдчилан хэлсэн ч дээрх бүлгүүдэд сонгуульд оролцохын мөн чанар, ач холбогдлыг тод томруунаар дүрсэлж, сонгуульд оролцох гэдэг нь зүгээр нэг саналын хуудас дугуйлах төдий хэрэг биш харин улс орноо жолоодон засгийн эрхээ хэрэгжүүлэх хариуцлагатай оролцоо болохыг, ийнхүү оролцох боломж нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлсэн байхаас эхлэхийг, мөн зохих мэдлэг, судалгаатай идэвхийлэн оролцохыг, нөгөө талаас сонгогчдод мэдээлэл хүргэж, тэднийг сонгуульд оролцох боломжийг төр засгаас хангах нь ардчиллын язгуур зарчим болох талаар сонгуульд оролцож буй бүхий л талуудад учирлан захиж, ухуулан ятгаж, ургуулан бодуулж, уг үндсийг нь нээн олж, таниулахад чиглүүлжээ.

Сонгуулийн тухай хууль тогтоомж олон удаа өөрчлөгдсөн ч энд дурдсан агуулгын амин сүнс “хуурамч бус жинхэнэ сонгууль” байгаа цагт хэзээ ч хуучрахгүй, ач холбогдлоо алдахгүй болохыг номын дараах хэсгүүдээс харж болно. Тухайлбал,

- “Цасан дээр гаргах мөртэй, Цаасан дээр бичих нэртэй, Төрдөө данстай, Түмэндээ алдартай” бүрэн эрхэт “Монгол Улсын иргэн хүн, би” гэж бахархах нь зүй билээ. Эрийн цээнд хүрч, эмийн шинжийг олж төрийн хэрэгт шийдвэрлэх эрхтэй оролцон явнаа гэдэг чинь нийгмийн идэвхтэй гишүүн болсны тод нотолгоо мөн шүү. Энэ нь сонгуулиас жинхэнэ утгаар эхэлдэг (Б.Чимид, 2008, х.108) гэдгийг;

- Харин сонгогчдыг сонгох, сонгогдох улс төрийн эрхээ гүйцэд эдлэхэд дөхөм үзүүлэх талаар засаг төр өөрөөс шалтгаалах бүхнээ бүрэн хийх нь илүү чухал, цар ихтэй ажил юм. Хэрэв та төрийг удирдахад иргэний оролцоог хангах нь ардчиллын язгуур зарчмын нэг гэж үнэхээр ойлгож байгаа бол сонгуульд оролцох нөхцөлийг баараггүй, гүйцэд сайн хангах ёстой (Б.Чимид, 2008, х.204) талаар;
- Сонгуульд гол нь зохих мэдлэг судалгаатай идэвхийлэн оролцож саналаа өгөх нь хууль зүйн албадлагын шинж, үүрэг биш ч гэсэн ардчилсан улсын иргэний зан суртахууны журамт үүрэг гэж болно. Улсдаа эзэн байя гэвэл саналаа өгөх нь зүй. Иймд өөрийгөө (биеэ) бэлтгэ! (Б.Чимид, 2008, х.206) гэжээ.

Түүнчлэн “санал авах өдөр”, “санал хураах өдөр”, “сонгох өдөр”, “сонгуулийн өдөр” гээд олон нэршил, агуулгаар хэрэглээд байдаг хууль зүйн ойлголтыг цэгцлэн дараах байдлаар тодорхойлсон байх бөгөөд үүнийг хууль зүйн нэр томъёо болгон тогтвол зүйтэй санагдана:

- ...сонгогчдын “санал авах” өдрийг “Сонгуулийн өдөр” гэж хэлж, бичиж заншсан билээ. Саналыг “сонгогч өгдөг”, хэсгийн хороо “авдаг”, тойрог улс даяар нэгтгэн дүгнэдэг болохоор аль нэгээр нь нэрлэх нь оновчгүй. Иймд бүгдийг нь багтаасан нэр хэрэгтэй. Тэр бол “Сонгуулийн өдөр” юм. Сонгуулийн өдрийг иргэн бүр сэтгэл догдлон хүлээнэ. ...Засгийн эрх бидний мэдэлд үнэхээр байна гэдгийг сонгогч бүр энэ л өдөр сэтгэлээрээ цэгнэн биеэр туршин мэдэрдэг. Сонгуулийн өдөр ард түмэн засаг төрийн эрх барих байгууллагаа өөрсдийн олонхын саналаар шинэчлэн бүрдүүлдэг. Үүнийг сонгууль гэж байгаа учир “санал авах өдөр” гэх нь дэндүү жижгэрүүлсэн хэрэг юм. ...Ард түмний сонголтоо хийдэг ганц өдрийг сонгуулийн өдөр гэх нь хоцорч хуучдахааргүй утга төгөлдөр нэр (Б.Чимид, 2008, х.109).

Сонгогчдын нэрийн жагсаалт ба сонгогчийн үнэмлэх гэсэн тавдугаар бүлэгт сонгогч сонгуульд оролцохын тулд хамгийн эхлээд нэрийн жагсаалтдаа бүртгүүлэхийн чухлыг учирлаж, зөвхөн бусдад найдах биш өөрөө ч гэсэн араас нь хариуцлагатай хөөцөлдөж байж, сонгуулийн эрхээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, нөгөө талаас танилцах эсэх нь сонгогчдын хүсэл мэдэх эрх боловч сонгох эрхийг хангахын тулд аль болохоор сонгуулийн байгууллага ч гэсэн хичээн чармайж ажиллах учиртайг дэлгэрүүлэн тайлбарлажээ.

“Сонгуулийн өдөрт бэлтгэх нь” гэсэн аравдугаар бүлэгт сонгогчдыг сонгуульд оролцох боломжийг хангах нь төр засгийн байгууллагын хийх ёстой чухал, цар хүрээ ихтэй ажил болохыг онцлон, үүний нэгийг “алгуурлаж болохгүй 14 хоног” гэж оноон нэрлэсэн нь анхаарал татна. Энэ хуулийн заалт одоогийн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд ч яг энэ үг, өгүүлбэрээр бий. Энэ талаар:

1. ...яг санал хураахын өмнөх 14 хоногийг ажлын ач холбогдлоор нь онцгойлон хуульчилсан байдаг. “Алгуурлаж болохгүй 14 хоног” гэж болох. Сонгуулийн хороодоос бэлтгэх ажлын цомог нь:
 - Сонгогчдыг мэдээллээр хангах;
 - Сонгуулийн саналын хуудас бэлтгэх;
 - Сонгуулийн санал авах байр бэлтгэх;
 - Сонгуулийн суурин ба зөөврийн хайрцаг бэлтгэх;
 - Сонгогчдыг хэсэгт хүрэлцэн ирэх нөхцөлөөр хангахад туслах;
 - Зөөврийн хайрцагаар санал авахад бэлтгэх зэрэг техник зохион байгуулалтын ажлаас бүрдэнэ. Ажил бүхэн өөрийн хууль зүйн болзол, технологитой (Б.Чимид, 2008, х.192-193) болохыг дурдаж.
2. Сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг хэсгийн хороо уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан

мэдээлнэ. Хуулийн эл заалт товчхон боловч амаргүй ажлыг агуулна. 14 хоногийн турш гэсэн нь тун чухал бөгөөд алгуурлаж болохгүйг сануулжээ. “Турш” гэснээс “дотор багтааж” гээгүй байна шүү дээ хэмээн учирлан өгүүлжээ.

“Санал хурааж, дүнг гаргах” гэсэн 11 дүгээр бүлэгт сонгууль зөвхөн сонгогчийн өгсөн саналыг тоолоод, түүний үр дүнгээр төлөөллийн байгууллагаа байгуулаад дуусах хэрэг биш “Сонгуулийн үйл явцад ултай судалгаа хийж, нэгтгэн дүгнэх асуудлыг сонгууль хүчинтэй эсэхээс үл хамааруулан Сонгуулийн ерөнхий хороо, УИХ-ын судалгааны алба, Байнгын зохих хороо, нам, эвсэл өөр өөрийн чиглэлээр эрхлэн явуулж, сонгуулийн тогтолцоо, хууль тогтоомжийг сайжруулах санал дүгнэлт гаргаж түүнийг харгалзан зохих шийдвэр гарган хэрэгжүүлж байх нь чухал. Түүнд төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний газруудыг түшиглэх нь үр нөлөөтэй юм” (Б.Чимид, 2008, х.240) гэж тухайн сонгуулийн үр дүнд үндэслэн сонгуулийн үйл явцыг сайжруулж байхын чухлыг сануулжээ.

Тав. Дүн шинжилгээ

Сонгууль гэдэг хууль зүйн ойлголтынхоо хувьд Монгол Улсад орчин цагийн сонгуулийн тухай үзэл санаа нэвтэрч байсан үе (Б.Чимид, 2008, х.26) буюу 1921 оны 3 дугаар сард гаргасан “Тунхаглан зарлах тогтоол бичиг”-т “Монгол Улс үүрд байх Засгийн газрыг олж, үндсэн цааз дүрмийг тогтоож **сонгуулийг эрхэлсэн гүрэн** байгуулна” гэснээс эхлэлтэй гэж багш номдоо тодорхойлсон байдаг.

Манай улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал

зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд “...сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” эрхийг аливаа алагчлалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр эдэлнэ гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан. Эндээс харахад аливаа засгийн эрх мэдэл нь ард түмний **“жинхэнэ хүсэл зоригийн илэрхийлэл”**, сонгогчдын өөрсдийн нь **“бүтээл”** байх бөгөөд засгийн эрх барих энэ эрхээ сонгуулиар дамжуулан хэрэгжүүлдэг болохыг ойлгоно.

Сонгогчид сонгуулийн үйл явцаар дамжуулан сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлж, улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэхэд сонгогчдын боловсрол хамгийн чухал. Сонгогч сонгуулийн үйл явцад оролцож, саналаа өгөхийн тулд зарим зүйлийг заавал мэдсэн байх шаардлагатай. Энэ нь санал өгөх байранд ирж, санал өгөхөд сонгогч бүрийн мэдвэл зохих сонгуультай холбоотой үндсэн мэдлэг, мэдээлэл юм. Уг мэдлэгийг олгох нь сонгогчдын боловсролын нэг үүрэг бөгөөд сонгуулийг шударга, чөлөөтэй явуулах зорилготой. Сонгогчдын боловсролын ачаар сонгогчид сонгуулийн үеэр аливаа хууль бус амлалт, ухуулга сурталчилгаанд амархан хууртагдахгүй, хэрсүү байж, аливааг олон талаас харах чадвартай болохоос гадна улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа, суртал ухуулгад “тэсвэртэй” болдог.

Иймээс зөвхөн сонгогчдын боловсролоор дамжуулан ардчиллыг бий болгож чадахгүй ч түүнийг хамгаалж чадна гэж зарим судлаачид үздэг. Ардчиллыг хамгаалахад сонгогчдын боловсрол ямар чухал болохыг багш “Сонгуульд суралцахуй” номдоо “Ардчилал хумигдвал сонгууль сульдана доройтож

дарангуйлагч бүлгийн гарын зэвсэг болдог. Ард түмэн үнэн зөв төсөөлөлтэй баймааж сонгуулийг өөрсдийн тусын тулд хүчтэй зэвсэг болгохын төлөө нэгдэн тэмцэх, наанадаж **сонгуульд саруулхан ойлголттой идэвхийлэн оролцох** болно. Энэ нь монголын сонгуулийн хувьд ч нэгэн адил учир холбогдолтой билээ (Б.Чимид, 2008, х.23)” хэмээн тэмдэглэн үлдээсэн байх юм. Өөрөөр хэлбэл, сонгогчдын боловсрол нь ардчиллыг идэвхжүүлж, бэхжүүлэх иргэдийн суурь хандлага, зан үйл, мэдлэгийг бий болгодог. Угтаа ард түмэн засгийн эрх барих эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, тэр боломжийг төрөөс яаж хангаж, хамгаалдаг, цаашлаад хамгаалах учиртайг ухуулан сэнхрүүлсэн тул “Сонгуульд суралцахуй” ном нь “сонгогчдын боловсрол”-ын хамгийн анхны иж бүрэн хөтөлбөр, удирдамж, ихээхэн явцуу хүрээнд тодорхойлох юм бол 2008 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцож буй “сонгогчдыг мэдээллээр хангах”-д чиглэсэн гарын авлага гэж дүйцүүлэн ойлгож болох нь. Ингэж хэлэх шалтгааныг дараах тодорхойлолтуудаас номын агуулга, сэдэвтэй уялдуулан харж болохоор байна.

Өмнөх хэсэгт авч үзсэний дагуу **сонгогчдыг мэдээллээр хангах**³ (voter information), **сонгогчдын боловсрол** (voter education) гэсэн ойлголтууд нь зааг ялгаатай нэр томьёо юм. “**Сонгогчдыг мэдээллээр хангах**” гэдэг нь санал өгөх огноо, саналаа өгөх цаг, газар, сонгуулийн төрөл, сонгогчдын бүртгэл зэрэг сонгогчдод саналаа өгөх боломжийг олгох үндсэн мэдээллийг хүргэх явдал. Сонгууль бүрд, түүнчлэн сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн систем, саналаа өгөх арга, хэлбэр өөрчлөгдөх бүрд сонгогчдод хүргэх мэдээлэл өөр, өөр байж болно. Энэ төрлийн мэдээллийг сонгуульд оролцож буй бүхий л талууд сонгогчдод хүргэх ёстой. Энэ хэсэгт сонгогчдод зайлшгүй өгөх үндсэн гол мэдээлэлд дараах агуулгыг улс орнууд онцолдог бөгөөд (The ACE Electoral Knowledge Network, “information/education common features”)

³ Сүүлийн үед энэ ойлголтыг “сонгуулийн боловсрол” гэсэн нэр томьёогоор дүйцүүлж хэрэглэж байгаа тал бий.

багшийн номд эдгээр агуулга бүрнээ багтсаныг харьцуулан харж болно. Үүнд:

1. Сонгуульд оролцохын тулд урьдчилан бүртгэл хийх шаардлагатай эсэх? Ихэнх улс орнуудад санал хураах өдрөөс өмнө бүртгүүлсэн байхыг шаарддаг.
2. Саналын хуудсыг хэрхэн зөв бөглөх вэ? Саналын хуудсыг буруу бөглөснөөр тухайн хүний санал хүчингүйд тооцогдох, буруу тоологдох эрсдэлтэй. Тиймээс саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар мэдээлэл чухал.
3. Сонгуулийг ямар системээр зохион байгуулах вэ? Саналаа өгөх нь сонгуулийн эцсийн үр дүнд хэрхэн нөлөөлөхийг сонгогч мэдэж байх нь чухал. Тухайн сонгууль ямар системээр явж байгаагаас хамаарч сонгогчдын санал хэрхэн тоологдох нь шалтгаалдаг.

Дээр дурдсан агуулгыг багш номдоо тусгахдаа хууль тайлбарлахын зэрэгцээ “түүнийг хэрэглэх, сахин биелүүлэхэд үүсдэг эгэл амьдралын элдэв учрал алийг тэр гэх вэ?, “үнэмлэхээ мартуузай”, “цагаасаа хожимдуузай”, “саналын хуудас аваад шалгаарай”, “хайрцагны лац, тэмдгээ зэх”, “цахилгаан гэрэл тасарвал хэрэглэх сэлбэг мотор, лаагаа бэлдээрэй” гээд дэндүү жижиг, хэт адгуу гэмээр “ялимгүй” зүйлийг ч сануулсан” (Б.Чимид, 2008, х.17) байх юм. Хэдийгээр хууль тогтоомж өөрчлөгдөж, сонгогч сонгуульд оролцох үйл явц илүү хялбар болж байгаа ч сануулан хэлэх, сайжруулах, анхааран болгоомжлуулах хэрэгцээ сонгууль бүрд байсаар л байна.

Харин **“сонгогчдын боловсрол”** гэдэг нь сонгогчдын сонгуульд бүрэн оролцох урам зориг болон бэлэн байдлыг шийдэхэд илүүтэй анхаардаг. Энэ нь сонгууль ба ардчиллын хамаарал, ардчилсан сонгуулийг явуулахад шаардлагатай нөхцөл, хүний үндсэн эрх болон сонгох эрхийн хоорондын уялдаа холбоо санал бүр яагаад чухал вэ, сонгогчийн эрх үүрэг, хариуцлага, санал өгөх, саналын хуудасны нууцлал, сонгогчийн саналыг

хэрхэн суудал болгон хуваарилах зэрэг сонгуулийн үйл явцын нарийн төвөгтэй мэдээллүүдийг багтаадаг. Энэ нь **“сонгогчдыг мэдээллээр хангах”** гэдэг ойлголтоос илүү өргөн хүрээтэй, илүү цаг хугацаа шаардсан, байнгын буюу тасралтгүй байхад чиглэдэг. Сонгогчдын боловсролын хөтөлбөрүүдээс харахад нийтлэг 4 ерөнхий агуулгыг тусгасан байдаг (The ACE Electoral Knowledge Network, “standard voter education message”) бөгөөд тус ном ч эдгээрийг бүхэлд нь багтаасан тул “сонгогчдын боловсролын иж бүрэн хөтөлбөр” гэж дүгнэхэд хүргэсэн билээ. Үүнд:

1. **Сонгууль ба ардчилал:** Чөлөөт, шударга сонгуульгүйгээр ардчилал бий болж, бэхжих боломжгүй гэсэн агуулгыг багтаадаг. Энэ нь нэг талаас сонгогчид бүх нийтээрээ, аливаа нэг айдас, дарамт шахалтгүйгээр чөлөөтэй сонголтоо хийх боломж, нөгөө талаас улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд сонгуулийн кампанит ажлаа явуулах эрх чөлөөтэй байх тухай юм.
2. **Сонгогчийн үүрэг, хариуцлага, эрх:** Энэ хэсэгт сонгогчдод сонгуульд оролцох ач холбогдлыг ойлгуулж, сонгуульд оролцох сэдэл, хүсэл зоригийг бий болгодог. Сонгууль нь нэг талаас засгийн эрх мэдлээ хэрэгжүүлэх, төлөөллөө бүрдүүлэх, нөгөө талаас сонгогдсон байгууллага, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох боломжтойг ойлгуулдаг.
3. **Таны санал маш чухал:** Сонгуулийн үр дүнг саналаа өгсөн сонгогчоос гадна саналаа өгөөгүй сонгогч хүртэл тодорхойлдог. Ялангуяа хэрэглэж буй сонгуулийн системийн нөлөө нь цөөн тооны саналаар ялж, ялагдах буюу сонгуулийн үр дүнг тодорхойлоход чухал нөлөөтэй. Тиймээс сонгуулийн эцсийн үр дүнг тооцоход санал бүр чухал, үнэ цэнтэй гэдгийг ойлгуулах ёстой.
4. **Таны санал нууц байна:** Сонгогч аливаа нэг айдас, дарамт шахалтаас ангид байх, аль нэг улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл дэмжээгүйн төлөө ямар

нэгэн ялгаварлан гадуурхалт, хавчлагад өртөх ёсгүй, таны саналыг танаас өөр хэн ч мэдэх боломжгүй гэдгийг хэлж өгдөг.

Эдгээр агуулга багшийн номд бүрэн тусгалаа олсон байх бөгөөд дараах цөөн хэсгээр энд эш татан дурдаж болно. Тухайлбал,

- ...ард түмэн засгаа гартаа авч, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээнээс шууд урган гарсанд оршино. Нөгөөтээгүүр сонгууль нь ганцаар дарангуйлах ёсноос ангид байх гэсэн ард түмний язгуур ашиг сонирхлыг бас илэрхийлдэг. Энэ хоёр зүйл нь **сонгууль байхын хийгээд орхиж болдоггүйн үндсэн шалтгаан** болно (Б.Чимид, 2008, х.22).
- Сонгуульд оролцохгүй болох энэ “өвчнийг” “абсентизм” гэж оношилдог. Тэр нь улс төрийн хямралын нэг шинж тэмдэг юм. Ийм нөхцөлд улс төрийн үнэхээрийн идэвхтэй хэсэг баахан өрсөлдөн бужигнаж, булхайцаж, луйвардаж өнгөрдөг. ...Бид эх орон, эрх чөлөө, эв нэгдэл, тусгаар тогтнол, хөгжил гэж ярьдаг шүү дээ. Маш зөв. Нэн чухал яриа. Харин энэ бүхний төлөө цохилох зүрхтэй хүн бүхэн улсын эзэн, иргэний хувьд өөрийнхөө болон бусдынхаа тусын тулд **сонгуулийн замаар төрөө түвшитгэхэд сэтгэлээ шулуутган, ухаан саруул чармайн оролцох нь эрхэм чухал билээ** (Б.Чимид, 2008, х.38).
- Улсын Их Хурал гэдэг “..онц чухал байгууллагыг сонгож бүрдүүлнэ гэдэг зүгээр нэг “таалагдсан хүнд” саналаа өгөх төдий хэрэг биш, **нийгмийн асар их үүрэг хариуцлага юм**” (Б.Чимид, 2008, х.63).
- Сонгууль гэдэг таамгаар тэмтэрч, бусдыг дагалдан дарвих, наанадаж хэдэн бор төгрөг, аар саар өглөг, аятайхан амлалтад хууртаж ээлж өнгөрөөхийн нэр биш гэдгийг ард олон мэднэ. ...нам, эвслийг, түүний өмнөөс нэр дэвшигчдийг үзэл бодол, өнгөрсөн үйл ажиллагааны

үр нөлөө, цаашдын хөтөлбөрийг үнэн магадтай, үнэ цэнтэй эсэхийг судалж, “өөрийн толгойгоор” хэнийг нь дэмжихээ шийдээрэй гэж зөвлөө. **Сонгууль бол эзэн хүний хариуцлагатай оролцоо, эцсийн шийдэл мөн шүү.**

Сонгогчдын боловсролыг ач холбогдол багатай, эсвэл сонголт гэж үзэж болохгүй, харин сонгуульд оролцох, засгийн эрх мэдлээ хэрэгжүүлэх суурь, хамгийн чухал хэсэг нь юм шүү гэдгийг энд дурдсан номын хэсгүүд батлан харуулж байна.

Зургаа. Дүгнэлт

Сонгогчдын боловсролын хөтөлбөр нь тухайн улсын түүх, ардчиллын түвшин, улс төр, эдийн засаг, нийгмийн орчин, иргэний болон ардчиллын боловсролын үндэсний хөтөлбөр, хэрэгжилт зэргээс хамаарч тухайн орны онцлогийг шингээсэн урт хугацаанд, тогтвортой, цогц байдлаар хэрэгждэг. Хэдийгээр бид одоог хүртэл албан ёсны үндэсний хөтөлбөргүй явж ирсэн ч бидэнд эрдэмт багшийн бүтээн туурвисан “Сонгуульд суралцахуй” гэдэг “үндэсний хөтөлбөрийн дайтай” томоохон бүтээл байгаа нь азтай хэрэг. Харин үүнийг цаашид улам гүнзгийрүүлэн, одоогийн хууль тогтоомж, сонгогчдын зан үйл, хэв маягт нийцүүлэн албан ёсны хөтөлбөр болгох ажлыг хаа хаанаа эхлүүлэх нь туйлын чухал байна.

Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй” номын уншлагыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хороо, “Чимид сан”, Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн хамтран ийнхүү зохион байгуулж буй нь энэ нөр их ажлын эхлэлийг тавьж буй хэрэг гэж талархан хүлээн авч байна.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн

хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, **сонгогчдын боловсролыг дээшлүүлэх**, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах” асуудлыг Хорооны бүрэн эрхэд хамааруулсан байдаг. Сонгуулийн ерөнхий хороо энэ чиг үүргийнхээ хүрээнд сонгуульд оролцогч бүх талыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, сонгогчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийг шударга, ил тод, нээлттэй, элдэв будилаангүй явуулахад анхаарч (Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй. Олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, х. 13) **ээлжит** сонгуулийн жил **“сонгогчдод мэдээлэл хүргэх”** төдийгөөр **“сонгогчдын боловсрол”-ыг ойлгож, орлуулж ирсэн** энэ нөхцөл байдлыг засаж, агуулгын хувьд өргөн, тасралтгүй үргэлжлэх, цогц үйл ажиллагаа талаас нь дахин шинээр авч үзэх цаг нь болсон гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Багш номын “Зохиогчийн үг” гэсэн хэсэгт “Алдаа оноог шүүлгэж, ахин сайжруулахыг хичээх болно. Хууль маань сайжрах болтугай” гэж тэмдэглэн үлдээжээ. Багшийнхаа энэ хүслийг гүйцээхэд өөрийн чадах зүйл байвал **“хувь нэмэр оруулахсан”** гэсэн чин сэтгэлээр энэхүү илтгэлээ өндөрлөж байна.

---ooOoo---

Ном зүй

- 1.Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй, Улаанбаатар.
- 2.Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй. Олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, 2022 он, Улаанбаатар.
- 3.The ACE Electoral Knowledge Network, “voter education” <https://aceproject.org/main/english/ve/vea02.htm>
- 4.The ACE Electoral Knowledge Network, “information/education common features” <https://aceproject.org/main/english/ve/vea03.htm>
- 5.The ACE Electoral Knowledge Network, “standard voter education messages”,<https://aceproject.org/main/english/ve/vea02b.htm>

САНАЛ, ДҮГНЭЛТ

Д.Сүмжид

*Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын дарга, хууль зүйн доктор*

Профессор Б.Чимидийн “Сонгуульд суралцахуй” (тогтолцоо, үйл явц, эрх зүй) хэмээх 2008 оны ном нь арван гурван бүлгээс бүрдэнэ. Сонгогчдын боловсролын талаар тухайлсан бүлэг болгон бичээгүй хэдий ч хоёрдугаар бүлэг “Сонгуулийн тогтолцоо ба эрх зүйн тухайд юу мэдвэл зохих вэ?”, тавдугаар бүлэг “Сонгогчдын нэрийн жагсаалт ба сонгогчийн үнэмлэх”, зургаадугаар бүлэг “Нэр дэвшүүлэх, түүнд тавих шаардлага, таны оролцоо”, есдүгээр бүлэг “Сонгуулийн санхүүжилт зардлын тухайд мэдүүштэй зүйл”, аравдугаар бүлэг “Сонгуулийн өдөрт бэлтгэх”, арваннэгдүгээр бүлэг “Санал хурааж, дүнг гаргах, нийтлэх”, арванхоёрдугаар бүлэг “Сонгуулийн эрхийг хамгаалах, хариуцлагын тогтолцоо” бүлэгт уг агуулгын талаар товч болон дэлгэрэнгүй байдлаар тусгажээ.

“Сонгогчдын боловсрол чухал болох нь” сэдвээр илтгэгч С.Оюунтуяагийн илтгэл 6 хэсгээс бүрджээ. Нэгдүгээр хэсэгт багшдаа зориулан шавийн дурсамжийг, хоёрдугаар хэсэгт уг ном бүтсэн түүхийг болон мэргэжлийнхэнд зориулсан биш хэн бүхэнд ойлгомжтой энгийн байдлаар бичсэн онцлогийг хуваалцжээ. Илтгэгч С.Оюунтуяа нь сонгуулийн боловсролын чиглэлээр 25 дахь жилдээ ажиллаж буй мэргэшсэн хуульч болохыг онцлон дурдаж, сонгогчдын боловсролын төлөө оруулж буй хувь нэмэрт нь талархал илэрхийлье.

Илтгэлийн гуравдугаар хэсэгт илтгэлийн сэдвийн учрыг тайлбарлахдаа “Өмнөх үеийн нэг намт сонгуульд хэний нэрийг дэвшүүлнэ, түүний төлөө саналаа өгч дадсан өвөг дээдсийн удамшилтай шинэ Монголчууд өдгөө цагийн өрсөлдөөнт сонгуульд өөрийн бодолтой оролцож, бие даан шийддэг чадавхыг эзэмших нь төрийн хэрэгт нийтээр суралцахуйн гайхамшигт сургууль мөн болой” гэсэн зохиогчийн үгээр эхэлжээ (Б.Чимид, С.Оюунтуяа). Уг номын зохиогч нэгдүгээр бүлэгт Монгол оронд сонгуулийн тогтолцоо үүсч, хөгжсөн үе шатыг тайлбарласан бөгөөд 1990 оноос ардчилсан дэглэм рүү шилжин орсон Монгол Улс ардчилсан Үндсэн хуулийн оршил хэсэгт “хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх”-ийг эрхэм зорилгоо болгон Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” хэмээн ард түмнээс, иргэнээс засгийн эрх мэдэл үүсч бий болох зарчмыг баталгаажуулсан билээ.

Тогтолцооны шилжилт амархан хийгдэхгүй, хууль тогтоомж, институт, механизмын төлөвшил төдийгүй иргэдээс энэхүү эрхийг ухамсарлах, улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд дадах, суралцах учиртай болохыг зохиогчоос номд тайлбарлаж, үүнд тулгуурлан илтгэгч “Сонгогчдын боловсрол чухал болох нь” гэж нэрлэсэн ажээ.

“Сонгогчдын боловсрол” гэдэг нь сонгогчдод сонгуульд санал өгөхийн ач холбогдлыг танин мэдүүлж, тэднийг сонгуульд бэлэн байлгахад чиглэсэн ойлголт бөгөөд сонгуулийн үйл явцаар дамжуулан сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлж, улс төрийн хүсэл зоригуу илэрхийлэх боломж олгодог. Иймд хэний төлөө санал өгөх вэ гэхээс илүүтэй хэрхэн санал өгөх вэ гэдэгт төвлөрдөг байна. Энэ талаас нь авч үзвэл тус ном бүхэлдээ сонгогч сонгуулийн үйл явцаар дамжуулан сонгох эрхээ хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж,

улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэх вэ гэдэгт чиглэжээ. Мөн сонгогчдын боловсролд зориулсан “иж бүрэн хөтөлбөр” ч гэж хэлж болмоор санагдана. Сонгогчдын боловсролын агуулгыг ийнхүү тодорхойлсон уг агуулгыг бүрэн илэрхийлэхүйц, ач холбогдолтой (Б.Чимид, 2008, х.3).

Сонгуулийн эрх зүйн амин сүнс нь иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрх юм. Хэдийгээр засаг төрийн байгууллагыг төлөвшүүлэн бүрдүүлэх арга болдог ч гэсэн ард түмэн засгаа барих эрх байхгүй бол сонгуулийн эрх байж үл чадна (Б.Чимид, 2008, х.26).

Сонгуульд яаж оролцох, хэнийг дэвшүүлж дэмжих, эцсийн саналаа аль хүчин, хэний төлөө өгөх зэрэг нь сонгогчдын эрх мэдлийн асуудал, иргэний журамт үүрэг мөн. Иймд сонгуульд бэлтгэж явуулах ажлыг сонгогчид өөрсдөө мэдэж, зохион байгуулах боломжийг аль болохоор хангах нь ардчилсан ёсны шаардлага юм (Б.Чимид, 2008, х.84).

Та нам, эвслийн үйл ажиллагаанд оролцох, эсхүл өөрөө бие даан нэр дэвшүүлэх замаар энэ чухал ажилд бие, сэтгэлээр оролцоно. Хэрэв “түүгээрээ болог цаашаа!” гэсэн шүү “хувиа бодон довоо шарлуулбал” та хамгийн зожиг идэвхгүй, улсын эзэн байх эрхээ эдэлдэггүй нэгэн болж үлдэнэ (Б.Чимид, 2008, х.110).

Сонгууль бол сонгогчдын төлөө байдаг бөгөөд түүний зардал нь нэр дэвшигчийн биш татвар төлөгчийн мөнгө, хандивлагчдын хөрөнгө мөн. Үүний учир иргэд түүний зарцуулалтыг хянах, мэдээлэл авч дүгнэлт хийх, тайлагнуулах нь зүй ёсны хэрэг юм (Б.Чимид, 2008, х.164).

Хүний эрх, тэр тусмаа иргэдийн улс төрийн эрхийг хамгаалах нь ойлгоход тийм амаргүй ч, хэрэгжүүлэх нь хэцүү асуудал юм. Улс төрийн эрх, эрх чөлөө бол эрх мэдлийг эзэлж, үүгээр дамжуулан бүхнийг ноёрхон давуу байдал тогтоож, эд баялгийг эзэмдэн захирахын төлөө улс төрийн нам, хүн амын элдэв давхрааны өрсөлдөөн ихтэй талбар мөн. Тэр дундаа сонгуулийн эрх, иргэдийн

сонгох, сонгогдох эрхийг хамгаална гэдэг улс төрийн энэхүү өрсөлдөөн тэмцлийн “гал” дунд “буцалж” байдаг олон талт үйл ажиллагаа мөн. Энэ бол эцсийн дүндээ засаг төрөөс иргэдийнхээ өмнө хүлээсэн Үндсэн хуулийн үүрэг хариуцлага мөн (Б.Чимид, 2008, х.227).

Илтгэлийн дөрөвдүгээрт хэсэгт номын 5, 10, 11 дүгээр бүлгийг онцолж, сонгуулийн харилцаанд оролцдог хоёр талын “сонгогч” болон сонгуулийг эрхлэн зохион байгуулдаг байгууллагын хоорондын харилцаа, сонгогч сонгуульд хэрхэн оролцох тогтолцоо, бэлтгэл, зохион байгуулалт, үйл явцын агуулгыг задалжээ. Сонгогчоос сонгох эрхээ хэрэгжүүлэх алхам бүрийг зохиогч тайлбарлаж, зураглаж, хөтөч болохуй байдлаар бичсэн амьдралд ойр, практик ач холбогдолтой болохыг илтгэгч онцолсон байна (Б.Чимид, 2008, х.4).

Сонгуулийн тухай хууль тогтоомж олон удаа өөрчлөгдсөн ч энд дурдсан агуулгын амин сүнс “хуурамч бус жинхэнэ сонгууль” байгаа цагт хэзээ ч хуучрахгүй, ач холбогдлоо алдахгүй болохыг номын дараах хэсгүүдээс харж болно (Энэ номын 166 дахь тал). Тухайлбал:

- Төрийн хэрэгт шийдвэрлэх эрхтэй оролцон явна гэдэг чинь нийгмийн идэвхтэй гишүүн болсны тод нотолгоо мөн шүү. Энэ нь сонгуулиас жинхэнэ утгаар эхэлдэг гэдгийг;
- Харин сонгогчдыг сонгох, сонгогдох улс төрийн эрхээ гүйцэд эдлэхэд дөхөм үзүүлэх талаар засаг төр өөрөөс шалтгаалах бүхнээ бүрэн хийх нь илүү чухал, цар ихтэй ажил юм. Хэрэв та төрийг удирдахад иргэний оролцоог хангах нь ардчиллын язгуур зарчмын нэг гэж үнэхээр ойлгож байгаа бол сонгуульд оролцох нөхцөлийг баараггүй, гүйцэд сайн хангах ёстой талаар;
- Сонгуульд гол нь зохих мэдлэг судалгаатай идэвхийлэн оролцож саналаа өгөх нь хууль зүйн албадлагын шинж, үүрэг биш ч гэсэн ардчилсан улсын иргэний зан суртахууны

журамт үүрэг гэж болно. Улсдаа эзэн байя гэвэл саналаа өгөх нь зүй. Иймд өөрийгөө (биеэ) бэлтгэ! гэжээ.

Зохиогчоос иргэд сонгуульд оролцохын тулд хамгийн эхлээд нэрийн жагсаалтдаа бүртгүүлэхийн чухлыг учирлаж, сонгох эрхийг хангахын тулд аль болохоор сонгуулийн байгууллага ч гэсэн хичээн чармайж ажиллах учиртайг дэлгэрүүлэн тайлбарлажээ.

Сонгогчдыг сонгуульд оролцох боломжийг хангах нь төр засгийн байгууллагын хийх ёстой чухал ажил бөгөөд үүний нэгийг “алгуурлаж болохгүй 14 хоног” хэмээн зохиогчоос онцгойлон нэрлээд сонгогчдыг мэдээллээр хангах, саналын хуудас бэлтгэх, санал авах байр бэлтгэх, суурин ба зөөврийн хайрцаг бэлтгэх, сонгогчдыг хүрэлцэн ирэх нөхцөлөөр хангахад туслах, зөөврийн хайрцагаар санал авах бэлтгэл зохион байгуулалтыг хангахад туслах зэрэг ажлаас бүрдэнэ. Ажил бүхэн өөрийн хууль зүйн болзол, технологитой болохыг дурдсан бөгөөд энэхүү хуулийн зүйл, заалт одоогийн УИХ-ын сонгуулийн хуульд ч байгааг илтгэгч тодотгожээ (Энэ номын 168 дахь тал).

Өнөөдөр ч сонгуулийн урьдчилсан зохион байгуулалт, иргэдийг мэдээллээр тэгш, хүртээмжтэй хангах асуудал чухал хэвээр байгаа бөгөөд 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр оролцох, бүх нийтийн байх зарчим бүрэн хангагдахгүй байна гэдгийг Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд дүгнэсэн. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй, гадаад улсад амьдарч буй иргэд, оюутан, суурин газраас алслагдмал нутаг дэвсгэрт амьдарч буй иргэд, малчид, уртын ээлжээр ажиллаж буй ажилтнууд, санал авах өдөр сонгуулийн хэсгийн хороонд буй төрийн албан хаагчид, эрүүл мэндийн шалтгааны улмаас өөр газар эмчлүүлж байгаа иргэд сонгох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна. Монгол Улсын Их Хурал, орон нутгийн Хурлын сонгуулийн сонгогчдын ирц улам бүр буурсаар байна. 2024 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль сонгогчдын ирц 70 хувьд хүрээгүй 2 дахь удаагийн

сонгууль болсон, орон нутгийн хурлын 2024 онд нийт сонгогчдын 53.1% санал өгснөөс, Улаанбаатар хот, Дархан Уул, Орхон аймагт ирц 50%-д хүрээгүй (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2025, х.39). Хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлээс нь хамааран ялгаатай хүндрэл бэрхшээл учирдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дундах судалгаагаар 69.5% нь нэр дэвшигчийн талаар хангалттай мэдээлэл авч чадаагүй хариулжээ. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харилцах арга зүй эзэмшээгүй, санал авах байрны орц, гарц, хүртээмж, зай талбай, гэрэлтүүлэг стандарт хангаагүй, мэдээллийн самбарыг ойлгомжтой, хүртээмжтэй байршуулаагүй зэрэг асуудлын талаар сонгуульд мониторинг хийж илтгэлдээ дүгнэжээ (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2025, х. 44-45).

Илтгэлийн тавдугаар хэсэгт илтгэгч Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактаар баталгаажуулсан сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэх, хүсэл зоригийг чөлөөтэй илэрхийлэхэд сонгогчийн боловсрол хамгийн чухал хэмээн тодотгож, чөлөөтэй сонголт хийх зарчмыг үүрэг, хариуцлага дагалддаг тул хэрсүү иргэн байх, хууль бус амлалт, ухуулга сурталчилгаанд хууртагдахгүй байх асуудлыг шүүн тунгааж, мэдээллийг боловсруулах чадвартай болохоос гадна улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн суртал ухуулгад “тэсвэртэй” болдог. “Сонгогчдын боловсролоор дамжуулж ардчиллыг бий болгож чадахгүй ч хамгаалж чадна” гэсэн илтгэгчийн үгийг онцолж байна (Энэ номын 170 дахь тал). Сонгуулийн урьдчилсан бүртгэл хийлгэх эсэх, саналын хуудас хэрхэн зөв бөглөх, сонгуулийн тогтолцоог тайлбарлах нь сонгогчдод зайлшгүй өгөх үндсэн, гол мэдээлэл болохыг улс орнууд онцолдог. Сонгогчдын боловсролын хөтөлбөрт 1.Сонгууль ба ардчилал, 2.Сонгогчийн үүрэг хариуцлага ба эрх, 3.Таны санал маш чухал, 4.Таны санал нууц байна гэсэн нийтлэг 4 агуулга тусгадаг болохыг илтгэгч дурдсан байна. (Энэ

номын 173-174 дэх тал)

Илтгэлийн зургаадугаар хэсэгт сонгогчдод мэдээлэл хүргэх төдийгөөр сонгогчдын боловсрол хязгаарлагдахгүй, цогцоор авч үзэх нь чухлыг онцолсонтой санал нийлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд санал өгөөгүй сонгогчдын тоог насны бүлгээр авч үзвэл 18-24 насны залуучууд байгаа бөгөөд яг энэ бүлгийн 70% нь сонгогчийн боловсролын талаар ямар ч мэдээллийг авч чадаагүй гэж судалгаанд хариулсан байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын 24 дэх илтгэлд сонгогчдын боловсролын талаар дүгнэхдээ сонгогчдын боловсролд зориулсан үндэсний хөтөлбөр хэрэгждэггүй, сонгуулийн төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулан хуульчилсан нь хангалтгүй гэсэн байна. Түүнчлэн сонгогчдод боловсрол олгох үйл ажиллагаа нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүний нөөц ихээр шаарддаг ажил учир үндэсний хэмжээнд төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран өргөн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн сонгогчдод бүх талаар ойлгомжтой дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь сонгуулийг зардал багатай, цаг хугацаа хэмнэн явуулахад тустай бөгөөд сонгогчдын боловсрол сайн байх тусам сонгуулийн ирц, оролцоо илүү байдаг болохыг илтгэгч олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлд дурдаж байжээ (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2025, х.23-24). Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг төсөвлөх саналыг Улсын Их Хуралд Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүргүүлсэн билээ.

Дүгнэлт

Ард түмний бүрэн эрхт байдал юуны өмнө сонгуулиар хамгийн ил тодоор хэрэгжинэ (Б.Чимид, 2008, х.21). Зохиогчийн бичсэнчлэн сонгогчийн өгсөн санал тоолоод дүн гаргаад сонгуулийн явц бус, сонгуулийн үр дүнд тулгуурлан сонгуулийн үйл явц, зохион байгуулалтыг сайжруулах нь чухал юм.

Монгол Улсад сонгох, сонгогдох эрхийг бодитоор эдлүүлэхэд чиглэсэн хууль, бодлого, журам бүхэлдээ ардчилсан сонгуулийн зарчимд үндэслэн, сонгуулийг зохион байгуулах суурь бүрэлдэн 1992 оноос хойш 3 түвшний 37 удаагийн сонгуулийг явуулж, ардчиллын соёл, оролцоог төлөвшүүлж байна. Гэвч өмнөх сонгуулийн үйл явц, үр дүнгээс сургамж авч залруулах, сайжруулах асуудлууд бий. Ялангуяа ээлжит сонгууль болгоны өмнө сонгуулийн тогтолцоог өөрчилдөг, Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын гишүүний тоог нэмэгдүүлж, олонхын ба хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулах болсон, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмчийн удирдлага, татварын хувь хэмжээг тогтоох эрхийг олгосон, орон нутгийн хурлын төсвийн харилцаа, чиг үүргийг ялгамжтай тодорхойлох өөрчлөлтүүдийг хийсэн учир сонгогчид хариуцлагатай байх, цахим платформ ашиглан хурдацтай түгэх мэдээлэлд шүүлтүүртэй хандах, сонгогчийн хувьд иргэний боловсролтой байх нь чухал юм.

Сонгогчдын боловсролын асуудал нь үндэсний хэмжээнд иргэн бүрд сонгуулийн боловсрол олгох нь эрх эдлэгчдийг эрх мэдээлэлжүүлэх, үүрэг хүлээгчдийг хариуцлагажуулахад үр нөлөөтэй билээ.

Сонгогчдын боловсрол нь сонгуулийн тогтолцоо, сонгуулийн зохион байгуулалтын талаар мэдээлэл өгөх болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэр дэвшигч, мөрийн хөтөлбөрийг танилцуулах асуудал төдий биш, Үндсэн хууль, сонгуулийн хууль тогтоомж, улс төрийн тогтолцоо, шийдвэр

гаргах механизм, иргэдэд үүсдэг үр дагавар зэрэг өргөн хүрээний агуулгыг цогц хамруулан ээлжит сонгуулийн жилийн завсар хооронд ч үргэлжлүүлэн өгч хэвшвэл зохих үйл ажиллагаа юм. Үүний тулд сонгогчдын боловсрол олгох бодлого, хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх нөөцийг оновчтой төлөвлөх тухайд шийдэл шаардлагатай хэвээр байна.

Ардчиллын үнэт зүйл нь мэдлэгтэй, чадвартай иргэдийн оролцоо байдаг билээ.

---ooOoo---

Ном зүй

- 1.Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.
- 2.С.Оюунтуяа (2025). Сонгогчдын боловсрол чухал болох нь илтгэл, Улаанбаатар.
- 3.Хүний эрхийн Үндэсний Комисс (2025). Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний талаарах 24 дэх илтгэл, Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Б.Хишигсайхан

Хүний эрхийн хуульч, магистр

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид багшаар бакалаврын дипломоо удирдуулж, хүний эрх, захиргааны эрх зүйн салбарт зарим сэдвээр хамтран ажиллаж, үг сургаалыг нь ойроос сонсож явснаа их хувь тохиол гэж боддог билээ. Дэлхийн банкны Захиргааны шийдвэрийг стандартчилах төслийг 2006 онд хариуцан ажиллах үедээ “Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг цэгцлэх ажлыг анх удаа хийж байна” гэж хэлээд хатуу шүүмж сонссон минь өмнөх түүхээ байнга судалж, асуудалд нухацтай хандах хандлагыг насан туршдаа баримтлах сэдлийг өгч билээ. Мөн багштай хамтран “Хүний эрхийг судлах аргачлал” хэмээх гарын авлага бичсэн минь багшийн цөөнгүй номд орсон бөгөөд тухай бүрд надтай хамтран бичсэнээ эшилснийг харахаар хүнийг их бага гэлгүй, хийсэн ажил, оюуны хөдөлмөрийг үнэлж чаддаг байсныг батлан харуулж, багшаараа улам бахархах, үг сургаалыг нь хэлбэрэлтгүй дагах урам зориг өгдөг юм.

Өнөөдөр бид Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй” номын талаар ярилцах завшаан тохиож, миний бие хэлэлцэгчээр оролцож байгаа нь нэр төрийн хэрэг билээ. Сонгуульд суралцахуй ном нь бүх насныхан, боловсролтой эсэхээс үл хамааран ухаж ойлгох гэж зоволгүй, баясан таашааж суусаар жаргаах ном болжээ. Чимид багшийн номын бичилт нь албаны хуурай үг хэллэг хэрэглэхээс илүүтэй энгийнээр хүүрнэн өгүүлсэн ч цаанаа сонгох, сонгогдох эрхийн үндсэн зарчим, агуулгыг тайлбарлан таниулсан

нь их бичгийн хүний саруул ухааныг илтгэнэ.

Миний бие судлаач С.Оюунтуяагийн “Сонгогчдын боловсрол чухал болох нь” хэмээх илтгэлд шүүмж бичихээр тохоон томилогдсон бөгөөд гарчгийн тухайд Б.Чимид багшийн ном тэр чигтээ сонгогч, сонгогдогч болон сонгууль зохион байгуулагчдад ардчилсан сонгуулийн талаарх суурь мэдлэг, боловсрол олгох сурах бичиг болсон тул илтгэлийн гарчиг агуулгатайгаа дүйжээ. Нөгөө талаас илтгэгчийн 25 жилийн хөдөлмөр шингэсэн сэдэв яахын аргагүй мөн тул сонгогчдын боловсролын агуулга, ач холбогдлыг өөрийн болон гадаад улсын туршлага, мэдээлэлд тулгуурлан дэлгэрүүлэн авч үзсэн нь өнөөг хүртэл сонгогчдын боловсролд цогц байдлаар хандалгүй явж ирсэн алдааг залруулахад чухал сэдэл болох санааг агуулжээ. Миний бие илтгэгчийн өгүүлэлд шүүмж бичихдээ багшийн номын агуулгыг, илтгэгчийн санаатай харьцуулан харж, хүний эрхийн хэм хэмжээ, зарчим талаас тайлбарлан бичихийг хичээсэн болно.

Сонгох, сонгогдох эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёр дугаар бүлгийн арванзургадугаар зүйлийн 16.9-д “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25-р зүйлийн “а) төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох; б) сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох,” хэмээн тус тус баталгаажуулсан. Чимид багш Үндсэн хуулийн эх баригчийн хувьд сонгох, сонгогдох эрхийн томъёоллыг хэлэлцэж байхад олон улсын хэм хэмжээг “... эрдэмтэд, хүний эрхийн хорооноос ирүүлсэн томъёоллууд байна. Тэрний эсрэг болоод байх юм” хэмээн сануулан хэлж байсан нь протоколд тэмдэглэгдэн үлджээ (БНМАУ-ын Бага хурлын чуулганы болон Ардын их хурлын

хуралдааны тэмдэглэл, 2023 он, х.280). Түүний энэ их мэдлэг, туршлага цаг хугацааны эргэлтэд ач холбогдол нь алдагдахгүй бүтээл туурвихын үндэс болсон буйзаа.

Б.Чимид багшийн номын 5, 10, 11 дүгээр бүлгийн гол агуулга нь иргэний сонгох эрхийг хангах ажиллагааг сонгуулийн байгууллага хэрхэн хэрэгжүүлэх, сонгогч хэрхэн сонгуульд оролцохыг чухалчлан авч үзжээ. Үүнийг ч илтгэгч олж харан “Эдгээр бүлгийн гол агуулга нь сонгуулийн үйл явцад оролцдог үндсэн, гол 2 оролцогч тал болох “сонгогч” болон сонгуулийг эрхлэн зохион байгуулдаг байгууллагын хоорондын харилцааг багтаасан байна.” хэмээн нэгтгэн дүгнэсэнтэй санал нэг байна (Энэ номын 165 дахь тал). Ингэхдээ хуулийн ярвигтай үг хэллэгээр биш энгийнээр хүүрнэн өгүүлж тайлбарласныг илтгэгч онцлон тэмдэглэжээ (Энэ номын 163-165 дахь тал).

5 дугаар бүлэг буюу “Сонгогчдын нэрсийн жагсаалт ба сонгогчийн үнэмлэх” гэсэн хэсэгт илтгэгч “нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ нягтлан шалгахын чухлыг сонгогчид учирлаж, сонгуулийн байгууллага ч энэ тал дээр санаачлагатай ажиллахын ач холбогдлыг дэлгэрүүлэн тайлбарласныг” онцлон авч үзсэн (Энэ номын 168 дахь тал) нь сонгуулийн бүх нийтийн байх зарчмын нэг чухал хэсэг, нөгөө талаас сонгогчийн боловсрол, сонгуулийн байгууллагын хараат бус ажиллагааны чухал баталгаа болохыг илтгэгч соргоогоор харжээ.

Сонгуулийн бүх нийтийн байх зарчмын үүднээс иргэний сонгох эрхийг бодитой, үндэслэл бүхий шалгуураар гагцхүү хуулиар хязгаарлах шаардлага Монгол Улсын Үндсэн хуулийн арван есдүгээр зүйлийн 2 (Цэцийн дүгнэлт, 2017, №07; 2020, №03; 2023, №03; 2024, №02, №03, №04; 2025, №01, №02, №03, №04, №05, №06; Цэцийн тогтоол, 2024, №02, №03), Иргэний олон улс төрийн эрхийн олон улсын Пактад (НҮБ-ын Хүний эрхийн хороо, CCPR/C/21/Rev.1/Add.7, догол 5) туссан билээ. Хэдийгээр хууль тогтоомжоор сонгох эрхийг баталгаажуулсан ч эрхийг хангах тухай ойлголт нь өргөн утгатай болохыг Чимид багшийн гарын авлага алхам тутамд онцгойлон сануулж байгааг бид анхаарахгүй

орхих учиргүй. Тухайлбал, **“хуулийн нөхцөл (гипотез) нэн явцуу мэт байгаа нь амьдралд тохиолддог зайлшгүй харгалзвал зохих зарим хүндрүүлэн үзэх шалтгааныг харгалзаж болохгүй, “хэл ам” гаргахад хүргэдэг. Жишээ нь, ганц гэрт өвчтэй хүн сахиж буй (өөр хүнгүй) эрүүл хүнийх нь саналыг авчихвал яасан юм бэ? Ер нь алс бөглүү нутагт ганц биеэр амьдрах малчид бий шүү дээ! Хуульд энэ мэтийг алсдаа бодолцох нь зүйтэй.”** хэмээн сануулжээ. Учир нь сонгох эрхээ эдлэх боломжгүй энэ мэт хүмүүсийг сонгуулийн зохион байгуулалтын явцад анхаарахгүй үлдээх нь сонгуулийн бүх нийтийн зарчим нэг мөр хэрэгжихгүй байх үр дагаварт хүргэнэ. Тухайлбал, сонгуулийн явцад цөөнгүй сонгогчдын (гадаад улсад ажиллаж, суралцаж буй, ростероор ажиллаж буй, урт богино хугацаагаар гадаад, дотоодод аялж, ажиллаж буй хүмүүс гэх мэт) сонгох эрхийг хөсөрдүүлсээр байгаагаа цаашид залруулах шаардлагатай.

Тэрээр “...Та төрийг удирдахад иргэний оролцоог хангах нь ардчиллын язгуур зарчмын нэг гэж үнэхээр ойлгож байгаа бол сонгуульд оролцох нөхцөлийг баараггүй, гүйцэд сайн хангах ёстой.” (Б.Чимид, 2008, х.185). гэсэн нь “бүх нийтийн сонгуулийн эрхийн зарчим нь сонгох, сонгогдох эрхийг эдлэх хүмүүсийн хүрээг хууль тогтоомжоор аль болох өргөн хүрээнд тогтоохын зэрэгцээ, тэдгээр хүмүүс сонгох эрхээ жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулах нь төрийн хүлээх үүрэг мөн билээ”(Манфред Новак, 2005, х. 580-581) гэх олон улсын хүний эрхийн хэм хэмжээг энгийнээр тайлбарласан хэрэг ажээ. Нөгөө талаас хүний эрхийг хангах төрийн үүргийг өргөн утгаар нь авч үзсэнээрээ багшийн номыг үнэлж баршгүй.

Сонгуулийн чөлөөт байдлын зарчмыг НҮБ-ын Хүний эрхийн хороо “...сонгогчид хүчирхийлэл болон хүч хэрэглэх заналхийлэл, сүрдүүлэг, албадлага, тулгалт болон аливаа төрлийн зүй бус нөлөөллөөс ангид, бие даасан үзэл бодолтой байх эрхтэй...” (НҮБ-ын Хүний эрхийн хороо, 1996, догол 19) гэж тайлбарласан бол Б.Чимид багш номондоо “...Харин хэн ч хэнийг ч саналаа заавал өг гэж ямар нэг байдлаар албадан шахаж болохгүй.

10, 11 дүгээр анги төгсөж буй цэвэр ариун зан суртахуунтай хөвгүүд, охидыг бөөнөөр нь намд элсүүлж, шан харамж өгдөг, авдаг багш ч байсан гэдэг. Хэний төлөө санал өгөхийг шавь нартаа тулган шаарддаг баримт ч бий..." (Б.Чимид, 2008, х.186). хэмээн энэ үйлийн хор хөнөөлийг практик нөхцөлтэй уялдуулан бичжээ.

Тухайлбал (Б.Чимид, 2008, х.179-180), "саналын байр нь сонгогчид саналаа нууцаар гаргах, хэсгийн хороо хэвийн ажиллах, ажиглагчид хууль ёсны бусад хүн байлцах багтаамж нөхцөлийг бүрэн хангахуйц тохижуулсан, сонгуулийн хууль тогтоомжид нийцсэн тавилга, тоног төхөөрөмжтэй байх ёстой.", "...аль болох олонхийн төвлөрсөн буюу сонгогчдод ойр дөт байх нь зүйтэй", "Харин хөдөөд онцлог бий. УИХ-ын сонгууль зуны дунд сард тохиодог тул малчин өрхийн олонхи зусланд нүүж багийн төвөөс алслан нутагладаг. Иймд олонхи айл өрх зусаж буй нутагт нь саналын байр байгуулдаг зөв зуршил бийг бодолцвол зохино.." хэмээн саналын байрны байршил, тавигдах шаардлагыг бүхий л асуудлыг багтаан, суурин, нүүдлийн онцлогоо харгалзан томьёолсон нь тухайн саналын байр сонгогчид сонгуульд бүх нийтээрээ идэвхтэй оролцох, нууцаар, чөлөөтэй саналаа өгөхөд хэр чухал болохыг энгийнээр хүүрнэжээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хороо саналын байрны стандарт баталсаар байтал сонгогчдод саналаа нууцаар өгөх боломжгүй өчүүхэн жижиг саналын байртай хэсгүүд багагүй байсаар байгаа нь сонгох эрхийн зөрчил болохыг сануулах нь илүүц биз ээ. Саналын байрны стандарт нь ард түмний төрийн үйл хэргийг шууд хэрэгжүүлж буй онцгой эрхийн баталгаа болдгийн хувьд нэг мөр хэрэгжих ёстой болохыг багш номдоо цөөнгүй газар онцлон дурдсаныг анхаарах шаардлагатай билээ.

Дүгнэх нь:

Илтгэгч "Сонгуульд суралцахуй" ном нь бүхэлдээ "...үндэсний хөтөлбөрийн дайтай" томоохон бүтээл байгаа нь азтай хэрэг. Харин үүнийг цаашид улам гүнзгийрүүлэн, одоогийн хууль тогтоомж, сонгогчдын зан үйл, хэв маягт нийцүүлэн албан ёсны хөтөлбөр болгох ажлыг хаа хаанаа эхлүүлэх нь туйлын чухал байна." хэмээн сонгогчдын боловсролын хөтөлбөртэй

болохын ач холбогдлыг онцлон дүгнэснийг цаашид ажил хэрэг болгох нь Үндсэн хуулиараа "...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно." хэмээн тунхагласныг хэрэгжүүлэх туйлын чухал алхам билээ. Учир нь Чимид багш номын багагүй хэсэгт сонгууль хэлбэрийн төдий болж, иргэд сонгуульд оролцохоос татгалзахын хор уршгийг учирлан тайлбарласан бөгөөд үүнээс сэргийлэх нэг гарц бол боловсролтой сонгогчдыг бэлтгэх бөгөөд илтгэгчийн илтгэл ч бүхэлдээ үүнийг сануулсан хэрэг юм.

Мөн тус ном нь сонгуулийн хууль тогтоомж өөрчлөгдсөн ч үнэ цэнээ алдахгүй болохыг илтгэгч доор дурдсанаар нотолсонтой (Энэ номын 166-167 дахь тал) миний бие санал нэг байна.

- "Цасан дээр гаргах мөртэй, Цаасан дээр бичих нэртэй, Төрдөө данстай, Түмэндээ алдартай" бүрэн эрхэт "Монгол Улсын иргэн хүн, би" гэж бахархах нь зүй билээ. Эрийн цээнд хүрч, эмийн шинжийг олж төрийн хэрэгт шийдвэрлэх эрхтэй оролцон явнаа гэдэг чинь нийгмийн идэвхтэй гишүүн болсны тод нотолгоо мөн шүү. Энэ нь сонгуулиас жинхэнэ утгаар эхэлдэг (Б.Чимид, 2008, х.108) гэдгийг
- Харин сонгогчдыг сонгох, сонгогдох улс төрийн эрхээ гүйцэд эдлэхэд дөхөм үзүүлэх талаар засаг төр өөрөөс шалтгаалах бүхнээ бүрэн хийх нь илүү чухал, цар ихтэй ажил юм. Хэрэв та төрийг удирдахад иргэний оролцоог хангах нь ардчиллын язгуур зарчмын нэг гэж үнэхээр ойлгож байгаа бол сонгуульд оролцох нөхцөлийг баараггүй, гүйцэд сайн хангах ёстой (Б.Чимид, 2008, х.204) талаар
- Сонгуульд гол нь зохих мэдлэг судалгаатай идэвхийлэн оролцож саналаа өгөх нь хууль зүйн албадлагын шинж, үүрэг биш ч гэсэн ардчилсан улсын иргэний зан суртахууны журамт үүрэг гэж болно. Улсдаа эзэн байя гэвэл саналаа өгөх нь зүй. Иймд өөрийгөө (биеэ) бэлтгэ! (Б.Чимид, 2008, х.206). гэжээ."

Учир нь Чимид багш уг номыг бичихдээ хуулийг даган тайлбарлах явцдаа зарим учир дутагдалтай зохицуулалтыг шүүмжилж, мөн сонгох, сонгогдох эрхийн хэм хэмжээ, зарчимд

нийцүүлэн бичсэн болохыг өмнөх хэсэгт сийрүүлэн тайлбарласан нь ийм учиртай.

Сонгууль хүчинтэй эсэхээс үл хамааруулан сонгуулийн мөрөөр ул суурьтай судалгаа хийж, сонгуулийн тогтолцоо, хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр санаачилгатай ажиллах, төрийн бус байгууллага, академик байгууллагатай хамтран ажиллах талаарх багшийн санааг илтгэгч онцлон дурдсан нь сонгуулийн мөчлөг хооронд хийх тун чухал ажил юм. Тиймээс шүүмжээ багшийн хэлсэн “Өнгөрснөө эргэн харж зөв дүгнэлт эс хийвээс ирээдүйг буруу замаар хөтлөхөд хүрч болно.” (Б.Чимид, 2008, х.223) хэмээх үгээр өндөрлөж байна.

---ooOoo---

Ном зүй

- 1.Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.
- 2.С.Оюунтуяа (2025). Сонгогчдын боловсрол чухал болох нь. Улаабаатар
- 3.Хүний эрхийн Үндэсний Комисс (2025). Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний талаарах 24 дэх илтгэл, Улаанбаатар.
- 4.НҮБ-ын Хүний эрхийн хороо (1996).
- 5.БНМАУ-ын Бага хурлын чуулганы болон Ардын их хурлын хуралдааны тэмдэглэл, (2023)
- 6.НҮБ-ын Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №25, (1996) CCPR/C/21/Rev.1/Add.7
7. Манфред Новак (2005), НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын тайлбар, (Manfred Nowak, U.N. Covenant on Civil and Political Rights CCPR Commentary, 2nd revision, N.P.Engel, Publisher)

VI

**Сонгуулийн маргаан
хянан шийдвэрлэх
хэргийн харьяалал**

СОНГУУЛИЙН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХЭРГИЙН ХАРЬАЛАЛ

Д.Бат-Эрдэнэ

Сонгуулийн ерөнхий хорооны

Тамгын газрын дарга

Оршил

Ардчиллыг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг бол чөлөөт, шударга сонгууль юм (Civic Academy South Africa. (n.d.)⁸ 2025,). Тийм ч учир үндсэн хуульт ардчиллыг чөлөөт, шударга сонгуульгүйгээр төсөөлөх боломжгүй. Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламентыг чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн үндсэн дээр ард түмэн өөрсдийн итгэл үнэмшил, хараат бус, чөлөөт сонголтоороо байгуулах нь Үндсэн хуульт ардчилал оршин байгаа эсэхийг тодорхойлох нэгэн гол хүчин зүйл юм.

Иймд улс орнууд өөрийн улс төр, нийгэм, соёлын хүчин зүйлээс хамааран ямар тогтолцоогоор сонгуулиа зохион байгуулахтай зэрэгцүүлэн сонгуулийг ил тод, шударга явуулах сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан, хараат бус байдал болон сонгууль зохион байгуулах процесс үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон хөгжүүлэх нь чухал юм.

Аливаа үйл явц, үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх шинжлэх ухаанч шүүмжлэлт сэтгэлгээнд тулгуурлан хөгжиж байдаг билээ. Сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн хөгжил ч мөн ялгаагүй ийм замаар хөгжих шаардлагатай.

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид (цаашид “зохиогч” гэх)-ийн “Сонгуульд суралцахуй” (УБ, 2008) бүтээл бол Монгол Улсын сонгуулийн эрх зүйн хөгжлийн онол, арга зүйн суурь эх

сурвалж бөгөөд сонгогчдын боловсрол, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх үлэмж үнэ цэнтэй бүтээл, судалгааны эх сурвалж юм.

Энэхүү бүтээлд сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн онол, арга зүйн үндсийг системтэй бөгөөд хэн бүхэнд нэн ойлгомжтой тайлбарласнаар ардчилал, сонгуулийн мөн чанар, үнэт зарчмыг иргэд, сонгогчдод ойлгуулах, өнөөгийн болон ирээдүйн сонгогчдын сонгуулийн боловсролын төлөвшилд жинтэй хувь нэмэр оруулах үүргийг олон жилийн турш хэрэгжүүлсээр ирсэн билээ.

Иймд уг бүтээлийг олон нийтэд хүргэхийн зэрэгцээ зохиогчийн уул санаа, агуулгыг эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах замаар сонгуулийн болон сонгуулийн процессын эрх зүйг хөгжүүлэх нь ардчилсан сонгуулийн бэхжүүлэх хөгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүлэлд “Сонгуульд суралцахуй” бүтээлийн “Сонгуулийн эрхийг хамгаалах арга, хариуцлагын тогтолцоо” арван хоёрдугаар бүлэг, “Сонгуулийн маргаан, түүнийг шийдвэрлэх нь” арван гуравдугаар бүлгийг агуулгын шинжилгээ хийх замаар судлахыг зорилоо.

Түлхүүр үг

Сонгуулийн маргаан, хэргийн харьяалал, сонгуулийн төв байгууллага, сонгуулийн менежмент, Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр, сонгуулийн дүн

I. Сонгуулийн эрхийг хамгаалах арга, хариуцлагын тогтолцоо

*Сонгогчдын эрхийг хамгаалах нь хэрэг дээрээ
Үндсэн хууль ба сонгуулийн хууль тогтоомж
зөрчсөн явдлыг таслан зогсоож, биелэлтийг
хангахтай агуулга, зорилго нэгтэй нь ойлгомжтой.*

Б.Чимид

Ард түмний сонгосон хүмүүс хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг учраас эдгээр эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрх ардчилсан сонгуулийн дүнгээр улс төрийн нам, эвслийн хооронд шилждэг (О.Мөнхсайхан, 2023, х. 198).

Нөгөө талаар хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчдэд шударгаар хариуцлага тооцох, хяналттай байлгах үндсэн аргын нэг бол чөлөөт, шударга сонгууль юм. Үүнийг улс төрийн хариуцлага тооцох үндсэн механизм ч гэж үзэх нь бий. Сонгууль бол хэнд төрийн эрх мэдлийг итгэмжлэн шилжүүлэхийг шийдэх ардчилсан арга бөгөөд сонгогдсон, томилогдсон албан тушаалтанд итгэл үзүүлэх эсхүл хариуцлага тооцох хяналтын тогтолцоо юм (ХБНГУ-ын Конрад Аденауэр сан, 2016, х. 31).

Иймд нэг талаас ардчилсан Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний үндсэн эрхтэй холбоотой асуудал боловч нөгөө талаар уг эрхийг түүнийг баталгаатай эдлүүлэх, тэрхүү эрхийг хамгаалах цогц тогтолцоо зайлшгүй шаардлагатай юм.

Энэхүү бүлэгт зохиогч Монгол Улсад сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоог онолын болон практик талаас нь тодорхойлж, улмаар зөрчлийг шийдвэрлэх болон хариуцлага тооцох механизмыг системтэй тайлбарлан авч үзсэн байдаг. Мөн сонгогчдын үндсэн эрхийг хамгаалах, түүнийг хэрэгжүүлэхэд шүүх болон захиргааны байгууллагын гүйцэтгэх үүргийг онцолжээ.

Зохиогч сонгуулийн эрх нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрх тул “идэвхтэй хамгаалалт” зайлшгүй

шаардлагатай гэж үзсэн бөгөөд энэ нь зөвхөн шүүхийн маргаан шийдвэрлэх хүрээнд бус захиргааны байгууллагаас урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэх зэрэг олон түвшинд байх хамгаалалтыг хамаарна гэж үзсэн байна.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа нь процессын шинжтэй, хэн хэзээ, ямар үйл ажиллагааг зохион байгуулах болон түүний хугацааг хуулиар нарийвчлан тодорхойлсон онцлогтой байдаг. Иймд энэхүү онцлогт нийцсэн маргаан хянан шийдвэрлэх эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай юм.

Жишээ нь, сонгуулийн сурталчилгааны явцад сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчид өрсөлдөгчөө гүтгэх, худал мэдээлэл тараах, нэр хүндийг нь гутаан доромжлох зэрэг хууль бус үйлдэл гарсан бол түүнийг эрх бүхий байгууллага холбогдох хуулийн дагуу шалгаж, тогтоох хүртэлх хугацаанд тухайн хууль зөрчсөн үйлдэл нь сонгуулийн сурталчилгааны богино хугацаанд аль хэдийнээ зорилгодоо хүрсэн байх эрсдэлтэй юм.

Иймд эрх зөрчсөн үйлдлийг эцэслэн тогтоох ажиллагаа явагдах хугацаанд захиргааны байгууллагын зүгээс шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах шаардлага үүсч байдаг. Мөн сонгууль зохион байгуулах зорилгоор байгуулагдсан байнгын бус ажиллагаатай анхан болон дунд шатны сонгуулийн байгууллага зохион байгуулалтын алдаа гаргасан, энэхүү үйлдэл нь сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн гэж үзвэл дээд шатны сонгуулийн байгууллага тухайн хууль зөрчсөн шийдвэрийг хянан хэлэлцэж хүчингүй болгох, эсхүл үр дагаврыг нэн даруй арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Захиргааны зүгээс авч хэрэгжүүлэх шаардлагатай энэхүү арга хэмжээг зохиогч онцолж энэ нь иргэний үндсэн эрхийг хамгаалах идэвхтэй бөгөөд урьдчилсан шатны хамгаалалт болохыг тодорхойлсон байдаг. Харин хууль зүйн хариуцлага гэх ойлголтыг сонгуулийн хууль тогтоомж зөрчигдсөн бүхий л тохиолдолд хүлээлгэх ёстой гэж үзсэн бөгөөд түүнийг иргэний,

захиргааны, эрүүгийн төрөл зүйлээр ялгаж үзэх шаардлагатай болохыг онцолжээ.

Тухайлбал, захиргааны журмаар болон шүүхийн журмаар хамгаалахыг давхар тогтолцооны нэг хэсэг болгон тайлбарласан нь Монголын сонгуулийн эрх зүй дэх эрх хамгаалах тогтолцоог шаталсан тогтолцоонд суурилан боловсронгуй болгох үзэл санааг илтгэдэг. Энэ нь иргэний сонгох, сонгогдох эрх нь зөвхөн тунхаглал төдий бус, бодит хамгаалалт, түүнийг хангах баталгаагаар хангагдах ёстой болохыг тодорхойлж байна.

Зохиогчийн дээрх гол үзэл санаа нь өдгөө хууль тогтоомжийн шинэчлэлийн явцад биеллээ олж, эрх зүйн орчин бүрдэж байгаа бөгөөд мэдээж хэрэг цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай. Тухайлбал сонгуулийн эрхийн хамгаалалтын давхар тогтолцоо дараах байдлаар бүрдэж байна. Үүнд:

1.Зохион байгуулалттай холбоотой гомдол: Бүх шатны сонгуулийн хороодын үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой гомдлыг шатлан захирагдах зарчмын дагуу дээд шатны сонгуулийн хороод хянан шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Сонгуулийн хороод энэ хуульд заасны дагуу шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана.”

2.Зөрчлийн хэрэг: Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн эсэх зөрчлийг есөн эрх бүхий албан тушаалтан, байгууллага хянан шийдвэрлэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Сонгуулийн хуулийг зөрчих 36 төрлийн зөрчлийг хуульчилсан. Уг зөрчлүүдийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Сонгуулийн хуулийг зөрчих дээрх зөрчлийг Тагнуулын

байгууллагын эрх бүхий ажилтан, Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Татварын улсын байцаагч, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч, Монголбанкны хянан шалгагч, Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Эрүүгийн хэргийн шүүх зэрэг нийт есөн эрх бүхий албан тушаалтан, байгууллага хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоосон байна.

3.Эрүүгийн хэрэг: Эрүүгийн хуулийн 14 дүгээр “Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг” бүлэгт нийт 5 төрлийн гэмт хэргийг хуульчилсан. 14.5 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх, 14.6 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх, 14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах, 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах, 14.9 дүгээр зүйл. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах зэрэг нийт 5 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна.

4.Захиргааны хэрэг: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.3-т зааснаар Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, мөн хуулийн 112.4.1-т зааснаар аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүх тус тус тусгай журмаар хянан шийдвэрлэхээр хуульчилсан.

Мөн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81.4-т “Энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.”, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн

тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-т “Сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4-т “Энэ хуулийн 80.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох захиргааны хэргийн хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тус тус тодорхойлон хуульчилсан байна.

5.Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан: Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргана.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81.3-т “Энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.3-т “Энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэж Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан сонгуулийн дүнд холбогдох маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх харьяаллыг тус тус тодорхойлон хуульчилсан байна.

Энэхүү бүлгийг бүхэлд нь дүгнэн үзвэл зохиогч Нэгдүгээрт, сонгуулийн эрхийг хамгаалах тогтолцоог шүүх болон захиргааны байгууллагын уялдаа холбоо бүхий цогц механизм хэлбэрээр тодорхойлсон, Хоёрдугаарт, сонгуулийн эрхийг хамгаалах арга,

хариуцлагын тогтолцоог системтэй тайлбарласан нь зөвхөн хууль эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй, харин ардчиллын үнэт зарчим, иргэний оролцоог баталгаажуулах зорилготой болохыг харуулдаг. Гуравдугаарт, сонгуулийн эрхийг хамгаалах тогтолцоо, хариуцлагын механизм нь зөвхөн эрх зүйн хөгжилд төдийгүй сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагаанд ч онцгой ач холбогдолтой эх сурвалж болох бөгөөд Монгол Улсад сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн суурийг шинжлэх ухааны түвшинд тайлбарласан анхны цогц оролдлого, өнөөгийн болон ирээдүйн сонгуулийн эрх зүйн хөгжлийн бодит туршлага, цаашдын судалгаа, бодлогын шинэчлэлийн гол эх сурвалж болж байна.

II. Сонгуулийн маргаан, түүнийг шийдвэрлэх нь

Сонгууль бэлтгэн явуулах, дүгнэхэд Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг эцсийн шатанд нь шийдвэрлэдгийн хувьд дагнасан шүүх мөн болоход Цэцийн онцлог оршино.
Б.Чимид

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэхээр тодорхойлсон. Гэвч нөгөө талаас сонгуулийн төв байгууллагын шийдвэр нь захиргааны акт учраас захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал болдог. Эндээс сонгуулийн төв байгууллагын гаргасан ямар шийдвэр Үндсэн хуулийн цэцийн харьяалалд байх, ямар шийдвэр нь захиргааны хэргийн шүүхийн харьяаллын байх асуудлаарх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүд, мөн судлаачдын байр суурь зөрүүтэй байна.¹

¹ Б.Чимид, 2008, Сонгуульд суралцахуй. (х. 282)-ийн тэмдэглэсэнээр “Сонгуулийн ерөнхий хорооноос тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсаны дагуу, эсвэл сонгуулийн тухай хуульд заасан асуудлаар өөрөө анх тутам хянан шийдвэрлэн гаргасан дүгнэлт, шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй гэж зохигчид

Иймд сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад сонгуулийн төв байгууллагаас гаргасан шийдвэр нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл, хэргийн харьяаллын зохист хувилбарын талаар зохиогчийн үндсэн санааг тодруулж, түүнд үндэслэн санал дэвшүүлэхийг зорилоо. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай, Сонгуулийн дүнг өргөн мэдүүлэх тухай сонгуулийн төв байгууллагын шийдвэр нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан болох талаар уг бүтээлийн арван гуравдугаар бүлэгт агуулгын шинжилгээ хийх, бусад улс орны эрх зүйн зохицуулалт, туршлагад харьцуулалт хийх замаар судална.

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэд бүх нийтээрээ, сайн дурын үндсэн дээр, яс үндэс, угсаа гарал, шашин шүтлэг, нас хүйс, үзэл бодол үл харгалзан, чөлөөтэй, шууд, нууц санал хураалтаар төрийн эрх барих дээд байгууллагаа сонгох, түүнд сонгогдох эрхийг баталгаажуулсан. Үндсэн хууль батлагдсанаас хойших хугацаанд парламентын сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяаллын талаарх тогтсон нэг ойлголт, шийдэлд хүрэлгүй олон сонгуулийг ардаа орхижээ.

Тухайлбал, 2020 он хүртэл Монгол Улс парламентын ардчилсан сонгуулийг 8 удаа зохион байгуулсан бөгөөд хууль

заргалдсан маргаан байж таарна. Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн ямар асуудлаар гаргасан ямар шийдвэр жишээ нь нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгээгүй, бүртгэлээс хассан зэрэг Цэц авч үзэх.” Харин Эрдэнэцогт, А. (2014). Монгол Улсын захиргааны процессын эрх зүй (Нэмж засварласан 2 дахь хэвл.). Улаанбаатар. (х. 103)-ийн тэмдэглэснээр “Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэнтэй холбогдсон гомдлын талаарх сонгуулийн тойргийн хороо, түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэртэй холбогдсон маргаан, Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай сонгуулийн тойргийн хороо, түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэртэй холбогдсон маргаан. Эдгээр нь үндсэн хуулийн маргаан бус, харин захиргааны маргаан болно. Уг маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх онол, эрх зүйн бүрэн үндэслэлтэй төдийгүй захиргааны хэргийн шүүх байгуулагдсан цаг мөчөөс эхлэн энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх талаар зохих туршлагыг хуримтлуулж ирсэн юм. Иймд Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны акт нь Үндсэн хуулийг бус, харин ердийн хуулийг зөрчсөн тухай маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодотгон сэргээн тогтоох нь иргэний үндсэн эрхийн хууль зүйн баталгааг хангахад чиглэгдсэн дорвитой алхам болох бөгөөд эрх зүйт төрийг төлөвшүүлэх, иргэний нийгмийг цогцлуулах үйлсэд бүрнээ нийцнэ.” гэж дүгнэсэн байдаг.

эрх зүйн орчны хувьд 5 удаагийн шинэчилсэн найруулга, нийт 22 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, 2019). Эрх зүйн орчин тогтворгүй байгаагийн шалтгаан нь нэг талаар парламентын сонгууль бүрийн өмнө сонгуулийн тогтолцоо тодорхой хэмжээнд өөрчлөгдөж байсан, нөгөө талаар сонгуульд оролцож буй нам, эвсэл нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны арга хэлбэр, төрөл нэмэгдэх болсонтой холбоотой юм.

Тухайлбал, сонгуулийн сурталчилгааны арга хэлбэр 1992 онд хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулах, ухуулах байр ажиллуулах, ухуулга хуудас тараах зэрэг цөөн хэлбэртэй байсан бол 2020 оны сонгуулиар хуулиар зөвшөөрсөн үндсэн 8 төрлийн арга хэлбэрээр явагдах болсон. Сонгуулийн сурталчилгааны арга хэлбэр нэмэгдэхийн хэрээр иргэний сонгох, сонгогдох эрхэд халдсан хууль бус үйлдэл, үйл ажиллагаа буюу зөрчлийн хэлбэр түүнийг даган нэмэгдэх болсон.

Сонгуулийн ямар тогтолцоог сонгож байгаагаас үл хамааран сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг ардчилсан сонгуулийн зарчимд нийцүүлэн зохион байгуулах тухай асуудал нэн чухал юм. Монгол Улс сонгуулийн ямар тогтолцоогоор парламентын сонгуулиа явуулах нь зохистой талаар дүгнэлт, санал, шүүмжлэлээ дэвшүүлсэн судлаачдын бүтээл, эрдмийн зэрэг горилох бүтээл, нийтлэл олон боловч сонгуулийн менежментийн зохист хувилбар тэр дундаа сонгуулийн эрх, түүнийг хөндөж буй зөрчил, маргааныг харьяалан шийдвэрлэх хэргийн харьяаллын талаарх судалгаа ховор байна.²

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдан, 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Захиргааны

² Б.Чимид, 2008, Сонгуульд суралцахуй. (х. 229)-ийн тэмдэглэснээр “Шүүх хянан шийдвэрлэвэл зохих сонгуулийн болон сонгуультай холбоотой бусад маргаан амьдрал баян гэдэг шиг олон янз. Түүнийг олж гаргах бараг боломжгүй. Учир юун гэвэл сонгуулийн эрх зөрчлийг ангилсан, зөрчлийн шинж байдал бүрэлдэхүүнийг тодорхойлсон, шүүхийн харьяаллыг нарийвчлан тогтоосон хууль ба судалгааны бүтээл манай улсад харахан байхгүй”.

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар Захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх маргааны төрлүүдийг жагсаалтын зарчмаар тодорхойлсон. Ингэхдээ Монгол Улсын Засгийн газар болон Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт гарч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.6-д заасан Монгол Улсын Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр нь захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан байх гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэж байв.

Энэхүү дүгнэлттэй холбоотойгоор хууль зүйн доктор О.Мөнхсайхан “Захиргааны шүүхийн хяналтаас гарч, дураараа авирлах гэсэн Засгийн газрын хүслийг Улсын Их Хурал зогсоож чадна” эрдэм шинжилгээний нийтлэл өгүүлэлдээ Засгийн газрын шийдвэр болон Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх эсхүл Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх хэргийн харьяаллын асуудлыг хөндөж авч үзсэн.

Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэртэй холбоотойгоор зохиогч “Сонгуульд суралцахуй” бүтээлдээ “Үндсэн хуулийн цэц Сонгуулийн ерөнхий хорооны аливаа шийдвэрийг хянах ёстой гэсэн хөнгөн хийсвэр, омголон дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал түүнийг нь хүлээн зөвшөөрч, улмаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас “Сонгуулийн ерөнхий хороо” гэсэн заалтыг хассантай холбоотой. Ингэснээр захиргааны олон зүйл маргааныг захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас гаргаснаар хууль зүйд томоохон гажиг суужээ. Томоохон гэдэг нь сүржин үг бус, гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны олон мянган байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тавих дагнасан шүүхийн хяналтыг дөнгөж төлөвшиж байхад нь үл ойлгон нураасан хэрэг

юм.” (Б.Чимид, 2008, х. 230) гэж дүгнэсэн байдаг.

Мөн онолын хувьд Үндсэн хуулийн цэц нь сонгогчид болон нэр дэвшигч нам, эвсэл түүний байгууллага, ажилтнаас сонгуулийн эрхийн талаарх Үндсэн хуулийн заалт зөрчигдөв хэмээн хандсан үндэслэл бүхий хуульд нэрлээгүй бусад маргааныг хянан шийдвэрлэхээс зайлсхийх аргагүй (Жишээлбэл, Сонгуулийн ерөнхий хороо нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгээгүй, бүртгэлээс хассан зэрэг)-г Цэц авч үзэх шаардлагатай (Б.Чимид, 2008, х. 282) гэж дүгнэж байв.

Сонгуулийн эрхийн хэрэгжилтийн баталгааны нэг гол механизм нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо болдог. Энэ ч утгаараа сонгуулийн эрх болон улс төрийн бусад эрхийг өөр, өөр арга замаар хамгаалдгаас шалтгаалж дэлхийн бусад улс орнууд Үндсэн хуулийн шүүх, Захиргааны хэргийн шүүх, Сонгуулийн байгууллагын хянан шийдвэрлэх харьяаллуудыг тогтоож өгсөн байна. Энэ талаар Ардчилал, сонгуульд дэмжлэг олон улсын хүрээлэн (International IDEA)-ээс 2011 онд гаргасан “Зүй ёсны сонгууль” гарын авлагад дурдсанаар сонгуулийн эрхийг хамгаалах буюу маргааныг хянан шийдвэрлэх субъектуудыг сонгуулийн байгууллага, шүүх байгууллага, олон улсын байгууллага (IDEA International. (2011). Зүй ёсны сонгууль (орчуулга) х. 38) гэж ангилан үзжээ.

Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэрийг хянан шийдвэрлэх харьяаллын талаар Үндсэн хуулийн цэцээс 2005 оны 02, 2006 оны 05, 2010 оны 07 дугаар дүгнэлт гарсан бөгөөд эдгээр дүгнэлтүүд сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн цэц дангаар хянан шийдвэрлэх, Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх, Сонгуулийн байгууллага өөрөө хянан шийдвэрлэх зэрэг 3 өөр байдлаар дүгнэсэн нь цаашид энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хэргийн харьяаллын хувьд тодорхойгүй байдалд оруулж байв.

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх харьяаллыг

оновчтой тогтоохын тулд бусад улс орны туршлага, эрх зүйн орчныг харьцуулан дүгнэх, Монгол Улсын хувьд өнгөрсөн хугацаанд үүссэн практик кэйсүүдийг сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг тогтоосон эрх зүйн орчны өөрчлөлтүүдтэй уялдуулан судалснаар маргаан хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг оновчтой тодорхойлох боломж бүрдэх юм.

Сонгуулийн маргаан гэдэг нь санал авах, тоолох, нэр дэвшүүлэх, бүртгэх, дүн гаргах зэрэг сонгуулийн бүхий л үе шатанд иргэд, нэр дэвшигчид, улс төрийн намууд болон бусад этгээдүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан гэж үзэхээс үүсдэг эрх зүйн зөрчил юм. Зохиогч уг бүлэгт сонгуулийн үйл ажиллагааг хамгаалах чухал хяналтын механизм гэж үзэж, тухайн үеийн хуулиар заасан эрх бүхий байгууллагуудаар шийдвэрлүүлэх зарчмыг онцолсон байдаг.

А. Бусад улс орны туршлага, эрх зүйн орчин:

Зохиогчийн тайлбараас үзвэл энэ бүлэгт Монголын тогтолцоог гадаадын жишээтэй харьцуулан тайлбарлах хандлага ажиглагддаг. Иймд бусад улс орны туршлага, эрх зүйн зохицуулалтын талаар тодорхой хэмжээнд авч үзэхийг зорилоо.

Сонгуулийн эрх зүйн гол ухагдахуун нь иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрх бөгөөд төрийн эрх барих дээд байгууллагаа сонгох эрх нь идэвхтэй эрх төдийгүй объектив эрх юм. Иргэний эрх зүйн чадамжаас хамааран түүнийг эдлэх тухайд субъектив эрх болдог. Харин сонгогдох эрхийг идэвхгүй гэх бөгөөд сонгуульт албан тушаалд нэрээ дэвшүүлэх боломжийг илэрхийлнэ (Б.Чимид, 2008, х. 46). Ардчилсан улс орнууд сонгуулийн эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулахаас гадна сонгуулийн эрхийг тунхагласан хүний эрхийн холбогдолтой олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орсон байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20, 21 дүгээр зүйл, Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенцын 1, 2, 3 болон 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2,

19, 21, 22 болон 25 дугаар зүйл, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 7 дугаар заалт зэрэгт тусгалаа олжээ. Мөн бүс нутгийн хэмжээнд хэрэгждэг хүний эрхийн баримт бичгүүдэд сонгуулийн эрх тусгалаа олсон байдаг.

Хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд сонгуулийг зүй ёсоор бүрдүүлдэг сонгуулийн эрхүүд, түүнийг тодорхойлох олон зарчмыг дэлгэрүүлэн тодорхойлсон бөгөөд сонгуулийн эрхийн хэрэгжилтийн баталгааны нэг гол механизм нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо болдог. Мөн сонгуулийн эрх болон улс төрийн бусад эрхийг өөр өөр арга замаар хамгаалдгаас шалтгаалж ялгаатай байдаг. Жишээ нь, Өмнөд Африкт сонгуулийн эрхийг хамгаалдаг байгууллага нь Сонгуулийн шүүх байдаг бол улс төрийн бусад эрхийг зөрчсөн асуудлаарх гомдлыг Дээд шүүх нь харьяалан шийдвэрлэдэг байна.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-ээс 2011 онд гаргасан “Зүй ёсны сонгууль” гарын авлагад дурдсанаар сонгуулийн эрхийг хамгаалах буюу маргааныг хянан шийдвэрлэх субъектуудыг сонгуулийн байгууллага, шүүх байгууллага, олон улсын байгууллага (International IDEA (2011). х.38) гэж ангилан үзжээ.

ХБНГУ-ын Үндсэн хууль (Grundgesetz für die Bundesrepublik Deutschland)-ийн 93 дугаар зүйлийн 1.4-д “Бундестагийн сонгуульд улс төрийн нам бүртгэсэн эсэх талаар” (German Federal Ministry of Justice (n.d.), 2025) мөн Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль (Bundesverfassungsgerichtsgesetz, BVerfGG)-ийн 13 дугаар зүйлд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааныг тодорхойлон хуульчилсан. Энэхүү зүйлийн 3-д “Бундестагийн сонгууль хүчинтэй эсэх, Бундестагт суудал авах, алдахтай холбоотой шийдвэрийн эсрэг гаргасан гомдол”, 3а-д “Бундестагийн сонгуульд улс төрийн намыг бүртгэсэн эсэх асуудлаарх гомдол” (German Law Archive (n.d.), 2025) гэж тус тус Үндсэн хуулийн шүүхийн харьяаллын шийдвэрлэх маргааныг

тодорхойлон хуульчилжээ.

ХБНГУ-ын хувьд Үндсэн хуулийн буюу сонгуулийн объектив эрх зөрчигдсөн маргааныг Үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэхээр хэргийн харьяаллыг хуульчилсан. Харин субъектив эрх зөрчигдсөн сонгуулийн маргаан буюу сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, буруу бүртгэгдсэн, нэр дэвшүүлэх ажиллагаа түүнд холбогдох баримт бичгийг сонгуулийн байгууллагад ирүүлэх, тэдгээрийг шалгах, тойргийн сонгуулийн хороо, сонгуулийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг шийдвэрлэх зэрэг сонгуулийн менежментийн бусад асуудлаар гомдол хянан шийдвэрлэх харьяалал журмыг Холбооны сонгуулийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1-т зааснаар Холбооны дотоод хэргийн яам батлан мөрдүүлэхээр хуульчилсан байна (German Law Archive (n.d.), 2025).

“Австрийн загвар” гэж нэрлэгддэг энэ загвар нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн цэцэд олгодог. Дэлхийн I дайны дараа боловсруулсан Европын орнуудын Үндсэн хуулиуд нь Веймарын Үндсэн хууль (1919 он) болон Австрийн Үндсэн хууль (1920 он)-ийн загварыг жишиг болгон сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн шүүхүүдэд олгосон. Тухайлбал, 1958 онд Франц, 1978 онд Испани улс парламентын сонгуулийн үр дүнд үүссэн бүх маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн зөвлөл болон Үндсэн хуулийн шүүхэд олгосон. Мөн Франц улс ерөнхийлөгчийн сонгуулиас үүссэн гомдлыг захиргааны шүүх урьдчилсан байдлаар шийдвэрлэх боловч тухайн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх эцэслэн шийдвэрлэхээр хуульчилжээ.

ХБНГУ-д Үндсэн хуулийн шүүх парламентын сонгуулийн санал хураалтын дүнд холбогдуулан гаргасан маргааныг хянан шийдвэрлэж байна. Мөн Румын зэрэг төв болон зүүн Европын зарим орнууд сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг Үндсэн

хуулийн шүүхүүдэд олгосон гэдгийг дурдах нь зүйтэй (Electoral Knowledge Network (n.d.), 2025). ХБНГУ-ын хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачдын олонхын үзэл баримтлалаар бол нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хувийн эрх зүйн хуулийн этгээдээс зааглах хамгийн гол шалгуур нь түүний үүсгэн байгуулагдах онцлог байдаг. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь төрийн хүсэл зоригоор түүний эрх зүйн байдал болон нийтийн эрх зүйн чиг үүргийг тодорхойлсон хууль болон төрийн захиргааны байгууллагын захирамжилсан шийдвэрийн үндсэн дээр байгуулагддаг. Харин хувийн эрх зүйн хуулийн этгээдийг хувийн эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүд өөрийн хүсэл зоригт үндэслэн байгуулдаг (Б.Эрхэмбаяр, 2013.). Энэ утгаараа улс төрийн нам нь төрийн эрхийг барих парламентын сонгуульд оролцож, нэг талаас сонгогдох эрхийг, нөгөө талаар сонгох эрхээ хэрэгжүүлэх сонголтыг бүрдүүлэн сонгуульд оролцдог тул улс төрийн намыг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн болон бүртгээгүй асуудлаар гаргасан сонгуулийн байгууллагын шийдвэрийг Үндсэн хуулийн шүүх байгууллага нь харьяалан хянан шийдвэрлэдэг байна.

Шинээр ардчиллыг бий болгож буй улс орнуудад сонгуулийн маргааныг шийдвэрлэх үр дүнтэй механизм, сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх хамгийн оновчтой арга замыг олж, сонгуулийн хариуцлагын журмыг бий болгож чадсан ч сонгуулийн маргаан тасрахгүй гарсаар байна. Харин өндөр хөгжилтэй, ардчилал өндөр түвшинд хүрсэн гэж тооцогддог улс орнуудын хувьд сонгуулийн маргаанаас урьдчилан шийдвэрлэх механизмыг хангалттай хэмжээнд тогтоогоогүй, сонгуулийн маргаан болон хариуцлага ногдуулах журам нь энгийн байдаг бөгөөд нөгөө талаар сонгуулийн холбогдолтой маргаан цөөн гардаг байна. Энэ нь тухайн улсад улс төрийн соёл, бусад нөхцөл байдал хэрхэн төлөвшсөнтэй холбоотой гэж үздэг. Жишээ нь, Скандинавын орнуудад сонгуулийн маргааныг сонгуулийн хуулийн хатуу зүйл, заалт, журам, заавраас илүүтэй улс төрийн

соёл нь зохицуулдаг онцлогтой байна.

Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны ялгаатай байдлаас хамааран сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагаа нь харилцан адилгүй байдаг. Жишээлбэл, Ром-Германы эрх зүйн тогтолцоотой /Испани, Итали, Уругвай гэх мэт/ улс орнууд эрх зүйн уламжлалтай байдаг бол Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудад философи, шашин, шударга ёсны уламжлалтай (НҮБ Хөгжлийн хөтөлбөр, 2013, х. 33–34). Америк болон Итали, Этиоп, Англи, Пакистан, Тайван, Испани, Индонези, Нигер, Палестин, Уругвай зэрэг улс нь хэдийгээр өөр өөр эрх зүйн тогтолцоотой ч сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны бүтэц болон ажиллагаа нь ижил байдаг.

Сонгуулийн маргааныг урьдчилан шийдвэрлэх хүний эрхийн олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцод зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хараат бус шүүхээс өмнө үр дүнтэйгээр хамгаалах хамгаалалттай байх шаардлагатайг тогтоож өгчээ. Олон улсын Парламентын Хорооноос 1994 онд баталсан Чөлөөт, шударга сонгуулийн шалгуурын тухай тунхаглалын 4.9-д “Тунхаглалд нэгдэн орсон талууд нь хүний эрхийн зөрчил, сонгуулийн ажиллагаатай холбоотой гомдлыг нэн даруй шүүх, сонгуулийн хороо зэрэг хараат бус, төвийг сахисан эрх бүхий байгууллага үр дүнтэйгээр шийдвэрлэнэ.” гэж тодорхойлсон бөгөөд зарим улс орны хувьд сонгуулийн эрх бүхий байгууллага нь тухайн зөрчил маргааныг хэлэлцэн шийдвэрлэж, санал хураалтын үр дүнг хүчингүй болгох, өөрчлөх тухай урьдчилсан шийдвэрийг гаргадаг байна.

БНСУ-ын хувьд Үндэсний сонгуулийн комисс нь сонгуультай холбоотой зөрчил, маргааныг харьяалан шийдвэрлэхээс гадна мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй. Энэ чиглэлээр Үндэсний сонгуулийн комиссын бүтцийн байгууллага ажилладаг. Зарим орны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгууль зохион байгуулдаг байгууллага, албан тушаалтан нь сонгуулийн маргааныг авч хэлэлцэх, байцаалт явуулах зэрэг

процедурыг явуулсны дараа тухайн улс төрийн нам эсхүл, нэр дэвшигч нь захиргааны зөрчил (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх) гаргасан тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэж болох бөгөөд уг шийдвэрийг голдуу шүүхийн өмнөх шатанд гаргаж байна.

Сонгуулийн маргааныг харьяалан шийдвэрлэх байгууллага болон маргааныг хянан шийдвэрлэх процесс зохицуулалтын хувьд олон төрөлтэй ч зарчмын хувьд нэгдмэл шинжтэй юм. Тухайлбал, сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан хуулиудад “Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч улс төрийн нам, хамтарсан намууд болон бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо хууль дээдлэх; ил тод байдлыг хангах; шударга ёсыг сахих; маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шударга шийдвэрлэх; сонгогчдын эрх, сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх; зарчмыг баримтална.” гэж заажээ. Энэ нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдээс баримтлах тусгайлсан зарчим юм. Ингэж нарийвчлан тусгаж өгснөөрөө зарим тохиолдолд хуулиар бүрэн гүйцэд тусгагдаагүй харилцаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд энэхүү зарчмыг удирдлага болгон шийдвэрлэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Харин Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад маргааны талаарх шийдвэр нь үндэслэлтэй байх, хууль ёсны байх, хянан шийдвэрлэх ажиллагаа хараат бус байх зэрэг зарчмууд нь сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн цэц болон шүүхээр хянан шийдвэрлэхэд хамааралтай юм. Сонгуулийн маргааны төрлөөс шалтгаалан түүнийг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал нь

харилцан адилгүй байгааг дээрх улс орны жишээнээс харж болохоор байна.

Эрх зүйн тогтолцооны онцлог шинжээрээ манай улстай ойролцоо, нэг бүлд багтдаг улс орнуудын хувьд сонгуулийн объектив эрх зөрчигдсөн маргааныг Үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэхээр хэргийн харьяаллыг хуульчилсан. Харин субъектив эрх зөрчигдсөн сонгуулийн маргаан буюу сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, буруу бүртгэгдсэн, нэр дэвшүүлэх ажиллагаа түүнд холбогдох баримт бичгийг сонгуулийн байгууллагад ирүүлэх, тэдгээрийг шалгах, тойргийн сонгуулийн хороо, сонгуулийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг шийдвэрлэх зэрэг сонгуулийн менежментийн бусад асуудлаарх гомдол хянан шийдвэрлэх харьяаллыг сонгуулийн байгууллага болон захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх нийтлэг хандлагатай байна.

Б. Монгол Улсын туршлага, эрх зүйн орчны өөрчлөлт

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдан, 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг харьяалуулан хуульчилсантай холбоотойгоор иргэн Б.Энхбаяр, С.Магнайсүрэн нараас Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргажээ. Тэд “Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг захиргааны актад тооцож, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна. Сонгуулийг зохион явуулах үүргийг сонгуулийн байгууллагууд хариуцах ба сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг улс даяар зохион байгуулж, хангах үүрэгтэй сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн үнэн зөв,

эргэлзээгүй байдлаас хамаарч, нийт сонгогчдын хүсэл зориг шударгаар илэрхийлэгдэж чадах эсэх нь тодорхойлогдох, сонгуульд оролцогч бусад этгээдийн эрх зүйн байдал (статус)-д өөрчлөлт ороход хүргэдэг. Мөн сонгуулийн баталгаажсан үр дүнгээр засаг төрийн тогтвортой, залгамж чанар хадгалагдах, үндэсний эв нэгдэл хангагдах, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг хууль ёсоор эмхлэн байгуулах зэрэг төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх үндэс болж байдаг. Ийм ч учраас Үндсэн хуулийн үзэл баримтлалд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна. Гэтэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтаар Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хамааруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн харилцаанд оролцогч сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцохоо тус Хороонд албан ёсоор илэрхийлж, бүртгүүлсэн нам, эвсэл зэрэг этгээдийн хооронд үүсч болох нийтийн эрх зүйн аливаа маргааныг Захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэж байх давуу боломжийг олгосон байна” гэсэн агуулгатай мэдээлэл гаргажээ.

Энэхүү мэдээлэлтэй холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар дүгнэлт гарч “Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд, энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй бол Дээд шүүх

нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтжээ. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2-т сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна.” гэж дүгнэжээ.

Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэрийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас гарсантай холбоотойгоор зохиогч “Онолын хувьд бол Үндсэн хуулийн цэц нь сонгогчид болон нэр дэвшигч нам, эсвэл түүний байгууллага, ажилтнаас сонгуулийн эрхийн талаарх Үндсэн хуулийн заалт зөрчигдөв хэмээн хандсан үндэслэл бүхий өргөдөл хуульд нэрлээгүй бусад маргааныг хянан шийдвэрлэхээс зайлсхийх аргагүй /жишээлбэл, нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгээгүй, бүртгэлээс хассан зэрэг/-ийг Цэц авч үзэх...” гэж (Б.Чимид, 2008, х. 229) байр сууриа илэрхийлж байжээ.

Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлттэй холбоотойгоор 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т “Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана.”, 57.5-д “Энэ хуулийн 26.3-т заасны дагуу нам, эвслийг, 30.10-т заасны дагуу нэр дэвшигчийг тус тус бүртгэхээс татгалзсан, 30.17, 30.18, 37.18, 40.7, 41.9-д заасны дагуу нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, түүнчлэн санал хураалтын дүнгийн талаар энэ хуулийн 50 дугаар зүйл, санал хураалт болон сонгуулийг хүчингүйд тооцох, дахин санал хураах, дахин сонгууль явуулах асуудлаар Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан

шийдвэрийн талаар маргаан гарвал Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэж сонгуулийн ямар төрлийн маргааныг Үндсэн хуулийн цэц харьяалан хянан шийдвэрлэхийг Үндсэн хуулийн үзэл баримтлал болон Цэцийн дээрх дүгнэлтэд нийцүүлэн зааглаж хуульчилсан.

Хуулийн энэхүү өөрчлөлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа “Сонгуулийн ерөнхий хорооны талаар заасан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцээс 2005 онд гаргасныг анхаарч үзсэн. Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалтыг хийсэн болно. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.1, 57.5 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна” (Цэцийн дүгнэлт, 2006, №05) гэж тайлбарласан байдаг.

Сонгуулийн маргааныг тухайн маргааны төрөл болон зөрчигдсөн эрхийн объектив болон субъектив шинжээс хамаарч, Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх заалтаар хуульчлан боловч тус хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийг 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар “57.5.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 26.3-т заасны дагуу нам, эвслийг бүртгэхээс татгалзсан асуудлаар гарсан маргааныг 14 хоногийн дотор, тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, 30.10-т заасны дагуу нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, тойргийн хороо 30.17, 30.18, 37.18, 40.7, 41.9-д заасны дагуу нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, түүнчлэн санал хураалтыг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тус тус эцэслэн

шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулсан байдаг. Уг нэмэлт, өөрчлөлт орсноор сонгуулийн маргааныг зөвхөн сонгуулийн байгууллага эцэслэн шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн маргааны эцэслэн шийдвэрлэхээр өөрчилсөн энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандаж “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаарх маргаан буюу санал дахин тоолуулахтай холбогдсон хэрэг маргааныг шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх энэхүү шатанд эцэслэн шийдвэрлэгдэхээр заасан нь Монгол Улсын иргэний зүгээс улс төрийн эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж, улмаар шүүхийн “шүүх” эрх мэдлийг хязгаарласан байна.” (Цэцийн дүгнэлт, 2010, №07) гэх агуулгаар мэдээлэл гаргасан.

Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 07 дугаар дүгнэлтээр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо “эцэслэн” шийдвэрлэж байхаар заасан нь тухайн асуудлаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх сонгогч, сонгогдогчийн эрхийг зөрчихөд хүргэж байна” гэж үзсэн (Цэцийн дүгнэлт, 2010, №07).

Зохиогч “Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн ямар төрлийн асуудлаар гаргасан шийдвэрийг Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэх, тухайлбал нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан, хассантай холбоотой. Онолын хувьд бол Үндсэн хуулийн цэц нь сонгогчид болон нэр дэвшигч нам, эсвэл түүний байгууллага, ажилтнаас сонгуулийн эрхийн талаарх Үндсэн хуулийн заалт зөрчигдөв хэмээн хандсан үндэслэл бүхий бөгөөд хуульд нэрлээгүй бусад маргааныг хянан шийдвэрлэхээс зайлсхийх аргагүй. Энэ нь түүний Үндсэн хуулийн

эрх зүйн байдлаас шууд урган гарч байгаа юм.” (Б.Чимид, 2008, х. 280) гэж дүгнэсэн байдаг.

Харин уг асуудлаар доктор А.Эрдэнэцогт “Монгол Улсын захиргааны процессын эрх зүй” бүтээлдээ “Үндсэн хуулийн маргаан нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих явцад үүссэн маргаан байна. Дээд хяналт тавих гэдэг нь Үндсэн хуулийн цэцээс зөвхөн Үндсэн хуулийн эрх зүйн шинжтэй хяналт тавих агуулгыг илэрхийлж буй ойлголт билээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн амьдралд биечлэн оролцдог төрийн дээд байгууллага, албан тушаалтны болон эрх мэдэл хоорондын харилцаанд тавих хяналт юм. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих нь Үндсэн хуулийн цэцээс ердийн болон дагнасан шүүхийн хяналтыг “зэрэгцүүлэн” буюу “давхардуулан” тавихгүй гэсэн үг юм. ...Мөн иргэний сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэх талаар органик хуулиар тогтоосон захиргааны журмыг Сонгуулийн ерөнхий хороо зөрчсөн тухай маргааныг цэц нь ердийн шүүхтэй зэрэгцэн хянах нь Үндсэн хуулийн утга, агуулгад нийцэхгүй бөгөөд дээд хяналтын ач холбогдлыг бууруулж байна. ...Улсын Их Хурлын сонгуулийн тухай тойргийн санал хураалт болон сонгуулийг хүчингүйд тооцох, дахин санал хураах, дахин сонгууль явуулах тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдсон маргаан, Улсын Их Хурлын сонгуулийн дүнгийн талаар Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэрт холбогдуулан гаргасан маргаан, эдгээр маргаан нь хуулиар тогтоосон захиргааны журамтай шууд холбогдолгүй, харин Үндсэн хуулийн эрх зүйн шинжийг өөртөө агуулсан буюу тухайн нэр дэвшигчээс үл хамаарах шинжтэй байх тул Үндсэн хуулийн маргаан гэж үзэх үндэстэй юм гэж” (А.Эрдэнэцогт, 2014, х. 101-104) дүгнэсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн дээрх 3 төрлийн дүгнэлтэд үндэслэн 2015 батлагдаж, 2016 хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ЗХШХШТХ-д анхлан сонгуулийн маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх харьяаллыг хуульчилсан. Мөн 2015 онд батлагдсан

Сонгуулийн тухай хуулийн 114, 115 дугаар зүйлээр захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан, Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргааныг зааглан хуульчилж байсан. Энэхүү хууль нь Улсын Их Хурлын, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн харилцааг нэгтгэн зохицуулсан онцлогтой хууль байсан юм.

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хууль тогтоогчийн зүгээс Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Сонгуулийн төв байгууллагыг хуульчилсан үзэл баримтлалд нийцүүлэн Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан, шүүхийн харьяаллын маргааныг зааглаж хуульчилсан. Гэвч 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулан тухайн маргааныг Сонгуулийн ерөнхий хороо эцэслэн шийдвэрлэх тухай өөрчлөлтийг оруулж улам бүр ойлгомжгүй, хүндрэлтэй нөхцөл байдлыг бүрдүүлэхэд хүргэсэн байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг оруулах болсон үндэслэл нь Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 05 дугаар дүгнэлт боловч цэц Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нарийвчлан тогтоосон маргааны харьяалал Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэж байжээ. Гэтэл энэхүү зөрчилгүй зохицуулалтад өөрчлөлт оруулан Сонгуулийн ерөнхий хороо эцэслэн шийдвэрлэх тухай ойлгомжгүй зохицуулалтыг хуульчилсан байна.

Сонгуулийн ерөнхий хороо эцэслэн шийдвэрлэх тухай энэхүү нэмэлт өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц 2010 оны 07 дугаар дүгнэлтээр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо “эцэслэн” шийдвэрлэж байхаар заасан нь тухайн асуудлаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх сонгогч, сонгогдогчийн эрхийг зөрчихөд хүргэж байна” гэж үзсэн. Дээрх кэйсүүд болон хууль тогтоомжийн ойлгомжгүй бөгөөд зарим тохиолдолд Үндсэн

хуулийн цэцийн дүгнэлтээс өөр нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсаар 2012 оны ээлжит сонгуультай залгасан.

2011 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар дээрх ойлгомжгүй нөхцөл байдал улам бүр даамжирч сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх тодорхой субъект байхгүйд хүргэсэн байна. Өөрөөр хэлбэл, сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн шүүх ч, Үндсэн хуулийн цэц ч харьяалан шийдвэрлэхгүй, тэр ч байтугай сонгуулийн хороод ч шийдвэрлэх эрхгүй, тодорхой бус, зохицуулалтгүй нөхцөл байдалд хүргэж байсан. Хамгийн тод илрэл нь Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн үеэр гарсан. Тухайлбал, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч, сонгогчид сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой гомдлоо бүх шатны сонгуулийн байгууллага, цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, иргэний хэргийн болон захиргааны хэргийн шүүх, мөн Үндсэн хуулийн цэцэд гэх мэтчилэн олон байгууллагад давхардуулан гаргаж, хүндрэлтэй нөхцөл байдалд хүргэж байжээ.

Үүний дараа 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн 114, 115 дугаар зүйлээр захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан, Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргааныг зааглан хуульчилсан. Гэвч энэхүү хууль нь 3 өөр төрлийн, 3 өөр харилцан адилгүй онцлогтой сонгуулийг нэг хуулиар зохион байгуулах зохицуулалттай тул эдгээр сонгуулийг зохион байгуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх тухайд буюу хууль хэрэглээний олон төрлийн хүндрэл үүсч байсныг бүх шатны сонгуулийн байгууллага, сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцсон нам, эвслээс илэрхийлж, үүний илрэл нь батлагдсан өдрөөс хойш 8 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулснаар харагдаж байна.

Үүнээс хойш буюу 2019 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай 2020 оны хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээ, зохицуулалтад сонгуулийн маргааны харьяаллыг зааглан тусгасан байдаг.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-д ...“энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.”, 81.4-т ...“энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж сонгуулийн хороодын үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн, сонгуулийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрөх буюу сонгуулийн хорооны эс үйлдэхүй зэрэг өргөдөл, гомдлыг тухайн сонгуулийн хороонд гаргаж, гаргасан шийдвэрт нь дээд шатны хороонд давж заалдах боломжтой байхаар зохицуулж өгсөн байна.

Мөн хуулийн 81.2-т “сонгуулийн хороод энэ хуульд заасны дагуу шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана.”, “81.5.Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй.” хэмээн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор гомдол гаргах хугацааны талаарх тусгайлсан зохицуулалтыг хуульчилжээ.

Дүгнэлт:

Монгол Улсын хувьд 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Жарган зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт сонгуулийн төв байгууллагаас ард нийтийн санал асуулга, Улсын

Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар гаргасан шийдвэр нь Үндсэн хуулийн цэцийн хяналтын объект байхаар тогтоож өгсөн. Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн төв байгууллагаас гаргаж буй бүхий л шийдвэр Үндсэн хуулийн цэцийн хяналтын объект байх тухай 2005 оны 02 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэц гаргасан. Гэтэл үзэл баримтлалын хувьд сонгогдсонд тооцох тухай, сонгуулийн дүн гаргах, дүнг өргөн мэдүүлэх зэрэг объектив эрхтэй холбоотой сонгуулийн төв байгууллагын шийдвэрүүд нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан байх талаар бусад улс орны туршлага болон зохиогчийн бүтээлээс дүгнэж болохоор байна.

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдаж, 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 04 дүгээр зүйлд Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг харьяалуулан анх удаа хуульчилсан. Гэвч ингэж хуульчлахдаа мөн л сонгуулийн төв байгууллагын бүхий л шийдвэр Захиргааны хэргийн шүүхийн харьяалал байхаар хуульчилсан байна. Энэхүү зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээр хүчингүй болгож шийдвэрлэхдээ дээр дурдсанаар ялгаж зааглаагүй бүхэлд нь авч үзсэн нь дараа дараагийн ойлгомжгүй нөхцөл байдалд хүргэх үндэслэл болсон байдаг.

Дээрх ойлгомжгүй, тодорхой бус нөхцөл байдалд хууль тогтоогчийн зүгээс дүгнэлт өгч, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-т “Энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэж объектив эрх хөндөгдөж буй сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг тогтоож, сонгуулийн дотоод зохион байгуулалттай

холбоотой гомдлыг бүх шатны сонгуулийн хороод шатлан захирагдах зарчмаар шийдвэрлэх, харин сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий 9 байгууллага, албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу харьяалан хянан шийдвэрлэхээр хуульчилсан. Дээрх зохицуулалтуудаас үзвэл сонгуулийн маргааныг тухайн маргааны төрлөөс хамааран хянан шийдвэрлэх харьяалал журмыг холбогдох бусад хууль тогтоомжоор зааглан тогтоож өгсөн нь чухал ач холбогдолтой болсон.

Хэдийгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-т зааснаар Үндсэн хуулийн цэц зөвхөн санал хураалтын дүнг гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбоотой маргааныг Үндсэн хуулийн эрх зүйн маргаан гэж зохиогчийн дэвшүүлсэн үзэл санааг зөв дүгнэж Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан боловч мөн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т “Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.” 74.3-т “Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу тойрогт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.” 74.4-т “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.” гэж санал хураалтын дүн гаргах харилцааг зохицуулжээ.

Гэтэл 81 дүгээр зүйлийн 81.3-т “санал хураалтын дүнг гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр” гэж 74 дүгээр зүйлд заасан дүн гаргах 2 төрлийн шийдвэр болон дүнг өргөн барих шийдвэр нийт 3 төрлийн шийдвэрийг нэг томьёоллоор

тодорхойлон хуульчилснаас үүдэн Үндсэн хуулийн цэц болон Захиргааны хэргийн шүүхэд хэргийн харьяаллын хувьд дахин маргаан дагуулах нөхцөлд хүргэж байсан. Уг нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж зохиогчийн анх дэвшүүлж, шүүмжлэлтэй хандаж байсан дээрх дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлаас 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулан “Энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэж өөрчлөлт оруулснаар маргааны харьяаллын асуудлыг нэг мөр шийдвэрлэх эрх зүйн орчин бүрджээ.

Үндсэндээ 2004 оноос хойш сонгуулийн маргааны харьяаллын асуудлыг шийдвэрлэх, нэг мөр болгож эрх зүйн орчныг бүрдүүлэхэд 2023 оныг хүртэл нийт 19 жилийн хугацаанд гагцхүү зохиогчийн тухайн үед дэвшүүлж, шүүмжлэлтэй хандаж байсан зарчмын хандлага нь голлох үүргийг гүйцэтгэж байжээ. Энэхүү үзэл баримтлалд үндэслэн цаашид маргааны харьяаллын асуудлыг илүү нарийвчлан судалж, эрх зүйн орчныг цогцоор нь харж сайжруулах нь зүйн хэрэг болж байна.

---ooOoo---

Ном зүй

1. Civic Academy South Africa. (n.d.). What are free and fair elections? Retrieved September 28, 2025, from <https://civicsacademy.co.za/what-are-free-and-fair-elections/>
2. О.Мөнхсайхан (2023). Үндсэн хуульт ардчиллын төлөө 2013–2023: ярилцлага, нийтлэл. Улаанбаатар.
3. ХБНГУ-ын Конрад Аденауэр сан. (2016). Иргэн таны оролцоо ардчиллын баталгаа. Улаанбаатар.
4. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.
5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, (2019 он).
6. О.Мөнхсайхан (2018). Захиргааны шүүхийн хяналтаас гарч дураараа авирлах гэсэн Засгийн газрын хүслийг Улсын Их Хурал зогсоож чадна. Эрдэм шинжилгээний нийтлэл өгүүлэл, <https://legalddata.mn/buteel/pdf?id=727>.
7. German Federal Ministry of Justice. (n.d.). Basic Law for the Federal Republic of Germany (Art. 93(1)(4c)). Retrieved September 28, 2025, from https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html#p0199.
8. Electoral Knowledge Network. (n.d.). Electoral dispute resolution: Constitutional court model. Retrieved September 24, 2025, from <https://aceproject.org/ace-en/topics/lf/lfb12/lfb12a/lfb12a04>.
9. Б.Эрхэмбаяр (2013). Улс төрийн намын бүртгэл, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх асуудал. Retrieved September 24, 2025, from <https://legalddata.mn/b/58>.
10. НҮБ Хөгжлийн хөтөлбөр. (2013). Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь. Улаанбаатар.
11. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 2010.11.17, №07.
12. А.Эрдэнэцогт (2014). Монгол Улсын захиргааны процессийн эрх зүй. Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Т.Сүхболд

*Цагдаагийн ерөнхий газрын дарга,
хууль зүйн доктор*

Монгол Улсын сонгуулийн эрх зүйн тогтолцоо нь ардчилсан нийгмийн тулгуур багана болох иргэдийн сонгох, сонгогдох үндсэн эрхийг бодитойгоор баталгаажуулж, эрх зүйн хамгаалалтаар хангах цогц механизмыг бүрдүүлдэг. Энэхүү тогтолцоо нь зөвхөн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт туссан “төрийн эрх мэдлийг ард түмэн өөрийн төлөөлөгчдийн байгууллагаар болон шууд хэрэгжүүлнэ” гэсэн заалтад тулгуурлаад зогсохгүй, Сонгуулийн тухай хууль болон түүнд нийцсэн бусад хуулийн зохицуулалтаар улам боловсронгуй болж ирсэн онцлогтой.

Ардчилсан сонгуулийн эрх зүйн суурь үзэл нь эрх тэгш байдал, чөлөөт өрсөлдөөн, ил тод, хариуцлагатай хэрэгжилт гэсэн олон улсын нийтлэг зарчмуудад (Олон улсын иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 25 дугаар зүйл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” зэргээр баталгаажсан) нийцэж, Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийн хөгжилд онол-практикийн үндэслэл болж ирсэн.

Үндсэн хуулийн эхийг баригч, хөдөлмөрийн баатар, доктор, профессор Б.Чимид багшийн 2008 онд хэвлэгдсэн “Сонгуульд суралцахуй” нэртэй судалгааны бүтээлийн 12, 13 дугаар бүлгүүд нь сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн аргачлал, хяналт-шинжилгээ, хариуцлагын тогтолцоог нарийвчлан шинжилсэн байдаг. Энэхүү бүтээл нь сонгуулийн маргаан шийдвэрлэх,

зөрчлийг таслан зогсоох, хууль зүйн хариуцлага тооцох механизмын онолын үндэс, түүхэн хөгжлийг харуулснаараа зөвхөн Монгол Улсад төдийгүй бүс нутгийн түвшинд ардчилсан сонгуулийн тогтолцоог хөгжүүлэхэд чухал судалгааны эх сурвалж болон үнэлэгддэг.

Ийнхүү Монгол Улсын сонгуулийн эрх зүйн орчин нь иргэний улс төрийн оролцоог хамгаалах, төрийн эрх мэдлийг ард түмнээс шууд болон төлөөллийн хэлбэрээр хэрэгжүүлэх баталгааг хангах, мөн сонгуулийн үйл явцын шударга ёс, хариуцлагын тогтолцоог эрх зүйн шинжлэх ухааны үндэстэйгээр бэхжүүлэхэд чиглэсэн цогц систем болон хөгжиж ирсэн нь энэхүү бүтээлийн гол ач холбогдол юм.

I. Сонгуулийн эрхийг хамгаалах тогтолцоо

Монгол Улсад сонгуулийн эрхийг хамгаалах эхний түвшний баталгаа нь засаг захиргааны буюу сонгуулийн захиргааны хяналтын тогтолцоонд тулгуурладаг. Сонгуулийн төв байгууллага болох Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) болон түүний аймаг, нийслэл, сум, дүүргийн шатлалтай салбар хороод нь сонгуулийн үйл явцын зохион байгуулалт, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх замаар иргэдийн сонгох, сонгогдох эрхийн биелэлтийг хангах үндсэн чиг үүрэгтэй. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг бодитойгоор хамгаалах засаг захиргааны анхдагч баталгаа болдог.

Олон улсын эрх зүйн туршлагаас үзвэл (жишээлбэл, Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага–ЕАБХАБ-ын Ардчилсан институт ба хүний эрхийн албаны зөвлөмж), сонгуулийн захиргааны байгууллагын хяналт нь сонгуулийн шударга байдлыг хангах эхний шүүлтүүр бөгөөд иргэд шүүхэд хандахаас өмнөх үр нөлөөтэй хамгаалалт гэж үздэг. Иймээс сонгуулийн хороодын бие даасан байдал, мэргэжлийн чадавх, санхүү, хүний нөөцийн тогтвортой хангалт нь хамгаалалтын үр нөлөөг тодорхойлох гол

хүчин зүйл юм.

Монголын нөхцөлд сүүлийн үеийн судалгаанууд (жишээлбэл, “Сонгуулийн шударга байдлын үнэлгээ”, 2022) хороодын мэргэжлийн бэлтгэл, шийдвэрийн ил тод байдал, улс төрийн нөлөөллөөс ангид байх асуудалд анхаарах шаардлагатайг онцолдог. Энэ нь иргэдийн сонгуулийн байгууллагад итгэх итгэл, улмаар сонгуулийн үйл явцын хууль ёсны байдлыг бэхжүүлэх чухал урьдчилсан нөхцөл юм.

Иймд сонгуулийн эрхийг засаг захиргааны түвшинд хамгаалах механизмыг улам боловсронгуй болгохын тулд нэгдүгээрт, сонгуулийн хороодын гишүүдийн мэргэжлийн сургалт, тогтвортой бүрэлдэхүүнийг хуульчлан баталгаажуулах, хоёрдугаарт, шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг дижитал шийдлээр хангах, гуравдугаарт, гомдол, маргааныг нэг мөр шийдвэрлэх процедурын уялдаа холбоог сайжруулах нь шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогын зөвлөмж болж байна.

Монгол Улсад сонгуулийн эрхийн эцсийн баталгаа нь шүүхийн хяналтын тогтолцоо бөгөөд иргэдийн сонгох, сонгогдох эрхийн маргаан болон сонгуулийн үйл явцтай холбоотой аливаа зөрчил, гомдлыг шийдвэрлэх гол механизм болдог. Олон улсын эрх зүйн зарчмаар (International Covenant on Civil and Political Rights. Art.25, 1966) иргэн сонгуулийн эрхийн зөрчлийг бие даасан, хараат бус шүүхээр хянуулах эрхтэй. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он) ч мөн 16 дугаар зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1-д иргэдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулж, түүнийг хамгаалах шүүхийн тогтолцоог бий болгосон.

Шүүхийн хамгаалалт нь гурван түвшний институцийн зохицуулалтаар хэрэгжинэ.

Үндсэн хуулийн цэц – Сонгуулийн тухай хууль болон сонгуулийн үйл явц Үндсэн хуульд нийцэж буй эсэх, сонгуулийн үндсэн зарчим (ерөнхий, тэгш, шууд сонгуулийн эрх, нууц санал хураалт) зөрчигдсөн эсэх маргааныг шийдвэрлэнэ. Жишээлбэл,

Цэц 2020 онд Сонгуулийн тухай хуулийн зарим заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн нь шүүхийн дээд хяналтын чухал жишээ болсон (Үндсэн хуулийн цэцийн 2020 оны дүгнэлт шийдвэр №05, 2020).

Захиргааны хэргийн шүүх – Сонгуулийн захиргааны байгууллагын (жишээлбэл, Сонгуулийн ерөнхий хороо болон түүний салбар хороод) шийдвэр, үйл ажиллагааг хуульд нийцэж буй эсэх талаас нь хянадаг. Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлэх, нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох зэрэг маргаан ихэвчлэн энэ шатанд шийдэгддэг (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны шийдвэр №128., 2021).

Иргэний болон эрүүгийн шүүх – Сонгуулийн үеийн эдийн засгийн болон өмчийн маргаан (сонгуулийн санхүүжилттэй холбоотой өр төлбөр, гэрээний маргаан гэх мэт) болон сонгуулийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.

Эдгээр шатлал нь шүүхийн хамгаалалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийн сонгуулийн эрхийг хангах олон улсын стандартад нийцдэг (OSCE/ODIHR. Guidelines on Resolving Election Disputes, 2019).

Сонгуулийн эрхийг хамгаалах шүүхийн системийн үр нөлөө нь шүүгчдийн бие даасан байдал, мэргэжлийн ур чадвар, иргэдийн шүүхэд итгэх итгэл зэргээс шууд хамаарна. Судлаач Б.Энхжаргал (Б.Энхжаргал, 2021) Монголын шүүхийн тогтолцоонд сонгуулийн маргаан шийдвэрлэх хугацаа, шийдвэрийн ил тод байдал нь иргэдийн итгэлд нөлөөлдөг болохыг тэмдэглэсэн. Түүнчлэн шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах институцийн уялдаа сул бол иргэдийн эрх хамгаалагдахгүйд хүрэх эрсдэлтэй.

II. Сонгуулийн хариуцлагын олон талт тогтолцоо

Сонгуулийн үйл ажиллагааны ил тод, шударга, эрх зүйн баталгааг хангах үндсэн нөхцөл нь хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Олон улсын судлаачид (Venice Commission. Report on Electoral Disputes and Sanctions, 2020)

хариуцлагын тогтолцоог сонгуулийн шударга ёсны баталгаа, иргэдийн улс төрийн итгэлийг хадгалах үндсэн механизм гэж тодорхойлдог. Монгол Улсын Сонгуулийн тухай хууль (Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, 2020), Эрүүгийн хууль (Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлттэй, 2015), Захиргааны зөрчлийн тухай хууль (Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлттэй, 2017) зэрэг нь сонгуулийн зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргасан этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Судлаач Г.Алтанцэцэг (Г.Алтанцэцэг, 2022) "...хариуцлагын хэрэгжилтийн үр дүн нь хууль сахиулагч байгууллагын чадавх, шүүхийн шуурхай ажиллагаа, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах тогтолцооны нэгдмэл байдалд тулгуурладаг" хэмээн тэмдэглэсэн.

Иймээс сонгуулийн хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгохын тулд нэгд сонгуулийн зөрчилтэй холбоотой мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хүргэх цахим платформ хөгжүүлэх, хоёрд сонгуулийн маргаанд мэргэшсэн шүүгч, прокурорын сургалтыг тогтмолжуулах, гуравт санхүүгийн хяналтын бие даасан байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь зүйтэй. Эдгээр арга хэмжээ нь сонгуулийн шударга ёсыг хамгаалах, иргэдийн улс төрийн оролцоонд итгэх итгэлийг бэхжүүлэх ач холбогдолтой.

III. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны шинжилгээ

Сонгуулийн маргаан нь ардчилсан сонгуулийн шударга, ил тод байдлыг хамгаалах үндсэн баталгаа бөгөөд иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэх чадавхтай шууд холбоотой (Venice Commission. Report on Electoral Disputes and Complaints, 2010). Монгол Улсын Үндсэн хууль болон Сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуулийн маргааныг зохих байгууллага, шүүхийн шат дараалсан тогтолцоогоор шийдвэрлэдэг бөгөөд энэ нь иргэдийн

улс төрийн оролцоог хамгаалах, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох ач холбогдолтой.

Сонгуулийн маргааныг шинжлэх ухааны үндэслэлээр дараах үндсэн ангиллаар судалж болно (International IDEA, 2021).

Үндсэн хуулийн маргаан – Сонгох, сонгогдох эрх, санал тэнцүүлэх зарчим, сонгуулийн үйл явц Үндсэн хуульд нийцсэн эсэхтэй холбоотой зөрчил. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь ийм төрлийн маргааныг эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхтэй (Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 2010).

Захиргааны маргаан – Сонгуулийн журам, зохион байгуулалт, захиргааны байгууллагын шийдвэртэй холбоотой зөрчил. Жишээ нь, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах, санал тоолох үйл ажиллагаанд гарсан зөрчил зэрэг нь захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэгдэнэ (Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015).

Иргэний маргаан – Сонгуулийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нэр хүндийн болон эд хөрөнгийн маргаан багтана. Жишээлбэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараах, сурталчилгааны зардлын маргаан зэрэг нь иргэний шүүхийн харьяалалд хамаарна (Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2021).

Эрүүгийн маргаан – Санал худалдах, сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал тоолох үйл ажиллагаанд хүч хэрэглэн саад хийх зэрэг эрүүгийн шинжтэй гэмт хэрэг (Монгол Улсын Эрүүгийн хуулийн 14.1–14.9 дүгээр зүйл, 2015).

Энэхүү ангилал нь сонгуулийн маргааны шалтгаан, шинж чанарыг тодорхойлох, зохих институцийн хяналтыг зөв чиглүүлэх ач холбогдолтой бөгөөд шүүх нь сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх эрх бүхий байгууллага юм. Үүнд Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн зөрчилтэй маргааныг; Захиргааны хэргийн шүүх нь СЕХ болон бусад захиргааны байгууллагын шийдвэрийн

хууль ёсны байдлыг; Иргэний болон эрүүгийн шүүх нь нэр хүнд, эд хөрөнгө, эрүүгийн шинжтэй зөрчлийг тус тус шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелэгдэх хүчтэй (Commission Venice, 2010).

Дүгнэлт

Монгол Улсын сонгуулийн эрх зүйн тогтолцоо нь ардчилсан засаглалын үндэс суурь бөгөөд иргэдийн улс төрийн оролцоо, төрийн эрх мэдлийг хууль ёсны үндсэн дээр хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлдэг (Venice Commission, 2010). Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын сонгуулийн хууль эрх зүйн орчин нь олон улсын нийтлэг жишигт ойролцоо бүтэцтэй хэдий ч хэрэгжилтийн түвшинд институцийн чадавх, шүүхийн хүртээмж зэрэг олон асуудал тулгарч байна.

Энэ тогтолцоо нь Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмаар хангагдсан цогц бүтэцтэй боловч хэрэгжилтийн шатанд хяналт, хариуцлагын механизм жигд биш байна. Сонгуулийн хороод нь анхан шатны хяналт, зохион байгуулалтын гол институт боловч бие даасан байдал, мэргэжлийн ур чадварыг хангах төсвийн болон хүний нөөцийн тогтвортой дэмжлэг дутмаг байна.

Сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүхийн хамгаалалт иргэдэд хүртээмжтэй байх нь чухал бөгөөд энэ нь шүүхийн бие даасан байдал, мэргэшсэн шүүгчдийн тоо, гомдол гаргах цахим сувгийн хүртээмжээс шууд хамаарна. Сонгуулийн хариуцлагын тогтолцоо нь зөвхөн зөрчилд хариу арга хэмжээ авах бус, урьдчилан сэргийлэх, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх чиглэлд илүү анхаарах шаардлагатай.

Сонгуулийн эрх зүйн тогтолцоо нь ардчилсан нийгмийн улс төр, эдийн засгийн тогтвортой байдлын баталгаа бөгөөд зөвхөн хууль тогтоомжийн шинэчлэлд бус иргэдийн сонгуулийн соёл, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх тасралтгүй үйл явцад тулгуурлах ёстой. Монгол Улс сонгуулийн хамгаалалт, хариуцлагын тогтолцоогоо

олон улсын сайн туршлагатай уялдуулан шинэчилснээр иргэний улс төрийн оролцоог өргөжүүлэх, ардчиллын институцийн суурийг бэхжүүлэх чухал нөхцөл бүрдэх боломжтой.

---ooOoo---

Ном зүй

1. Commission Venice. (2010). Venice Commission.
2. International Covenant on Civil and Political Rights. Art.25. (1966). International Covenant on Civil and Political Rights. Art. 25. Швейцар улсын Женев хот: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газар.
3. International IDEA. (2021). International IDEA.
4. OSCE/ODIHR. Guidelines on Resolving Election Disputes. (2019). OSCE/ODIHR. Guidelines on Resolving Election Disputes,.
5. Venice Commission. Report on Electoral Disputes and Complaints, C. o. (2010). Venice Commission. Report on Electoral Disputes and Complaints, Council of Europe.
6. Venice Commission. Report on Electoral Disputes and Sanctions, C. o. (2020). Venice Commission. Report on Electoral Disputes and Sanctions, Council of Europe, 2020.
7. Б.Энхжаргал (2021). “Монгол Улсад сонгуулийн маргааны шүүхийн хамгаалалт”, Хууль зүйн шинжлэх ухааны сэтгүүл, №3,. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
8. Г.Алтанцэцэг (2022). “Сонгуулийн хариуцлагын эрх зүйн зохицуулалтын шинжилгээ,” Хууль зүйн шинжлэх ухааны сэтгүүл, №2,. Улаанбаатар: Соёмбо.
9. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны шийдвэр №128. (2021). Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн сонгуулийн маргааны жишээ. Улаанбаатар.

- 10.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
2016.02.04.
- 11.Зөрчлийн тухай хууль. 2017.05.11.
- 12.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
2002.01.10.
- 13.Монгол Улсын Сонгуулийн тухай хууль. (2020). Монгол
Улсын Сонгуулийн тухай хууль. Улаанбаатар: Төрийн
эмхэтгэл.
- 14.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль.
1992.05.08
- 15.Эрүүгийн хууль. 2015.12.03
- 16.Үндсэн хуулийн цэцийн 2020 оны дүгнэлт шийдвэр
№05. (2020). Үндсэн хуулийн цэцийн 2020 оны дүгнэлт,
шийдвэр №05. Улаанбаатар.

САНАЛ, ДҮГНЭЛТ

П.Баттулга

*“Легал дата” ХХК-ийн
гүйцэтгэх захирал*

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ “Б.Чимид багшийн номын уншлагыг манай байгууллага энэ жил “Сонгуульд суралцахуй” номоор нь зохион байгуулах гэж байгаа. Миний бие тус номын XII, XIII бүлэгт холбогдуулан “сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал” сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүлнэ, энэ сэдэвтэй холбоотойгоор санал, дүгнэлт бичиж өгнө үү” гэхэд нь би бээр түрүү жилийн Б.Чимид багшийн “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын уншлагын дагуу хэвлэгдсэн “Бяраагийн Чимидийн уншлага: Үндсэн хуулийг дээдлэх шүтэн ёс” номыг уншиж байснаа санаж, тус уншлагад санал, дүгнэлт бичсэн хүмүүсийн эрдэм мэдлэг, зэрэг цолыг, өөрийн эрдэм мэдлэгийн өчүүхэнтэй харьцуулан бодож эрс татгалзсан боловч энэ бол санал, гүйлт биш өөрөөр тань санал, дүгнэлт бичүүлэхээр ярилцаад тогтчихсон байгаа гэсэн тул арга буюу зөвшөөрч чадан, ядан бичихийг оролдлоо.

Б.Чимид багш (цашид “Зохиогч” гэх)-ийн “Сонгууль суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй” номын “Сонгуулийн эрхийг хамгаалах арга, хариуцлагын тогтолцоо” XII бүлэгт 1/Иргэдийн сонгуулийн эрхийг хамгаалах арга (учир шалтгаан, засаг захиргааны болон шүүхийн журмаар хамгаалах), 2/Сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчигдсөний хууль зүйн хариуцлага (хууль зүйн хариуцлагын ойлголт, төрөл зүйл, сонгуулийн хууль

зөрчсөний хариуцлага)-ын талаар, “Сонгуулийн маргаан, түүнийг шийдвэрлэх нь” XIII бүлэгт 1/Сонгуулийн маргаан, 2/Маргааны (хэргийн) харьяалал, 3/Сонгуулийн хороодоос захиргааны журмаар шийдвэрлэх маргаан (орон нутгийн сонгуулийн хороод, Сонгуулийн ерөнхий хорооноос шийдвэрлэх маргаан), 4/Шүүхийн шийдвэрлэх маргаан, түүний харьяалал (Үндсэн хуулийн цэц, иргэний, эрүүгийн болон захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх хэрэг, маргаан)-ны талаар авч үзжээ.

Зохиогч номынхоо дээрх хоёр бүлгийн талаар “Зөвхөн УИХ-ын сонгуулийн хуулийн сүүлчийн хоёрхон зүйлийг тайлбарлах гэж сүүлчийн 2 бүлгийг зориулах жишээтэйгээр өгүүлэх зүйл мундахгүй” (Б.Чимид, 2008, х. 291) гэсэн нь иргэдийн сонгуулийн эрхийг хамгаалах арга, сонгуулийн маргаан, түүнийг шийдвэрлэх журмын талаар номд оруулаагүй, бичих зүйл их үлдсэнийг илтгэх агаад энэ нь тус номыг зөвхөн мэргэжлийн хүмүүст бус, сонгогч, сонгуулийн болон түүнд оролцогч байгууллагын ажилтан нарт зориулж, гарын авлага хэлбэртэйгээр бичсэнтэй¹ холбоотой байсных бизээ.

Зохиогчийн номын дээрх бүлгийг илтгэгч “...Нэгдүгээрт, сонгуулийн эрхийг хамгаалах тогтолцоог шүүх болон захиргааны байгууллагын уялдаа холбоо бүхий цогц механизм хэлбэрээр тодорхойлсон, Хоёрдугаарт, сонгуулийн эрхийг хамгаалах арга, хариуцлагын тогтолцоог системтэй тайлбарласан нь зөвхөн хууль, эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй, харин ардчиллын үнэт зарчим, иргэний оролцоог баталгаажуулах зорилготой болохыг харуулдаг. Гуравдугаарт, сонгуулийн эрхийг хамгаалах тогтолцоо, хариуцлагын механизм нь зөвхөн эрх зүйн хөгжилд төдийгүй сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагаанд ч онцгой ач холбогдолтой эх сурвалж болох бөгөөд Монгол Улсад сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн суурийг шинжлэх ухааны

¹ Энэ бол нам, эвслийн сонгуулийн өмнөх сурталчилгаа огт бишээ. Харин түмэн олон сонгогч, сонгуулийн болон сонгуулийн цогц ажилд оролцогч засаг захиргаа, нам, эвслийн байгууллагын ажилтан нарт зориулсан нэгэн зүйл гарын авлага болно. (Б.Чимид, 2008, х. 12-13).

түвшинд тайлбарласан анхны цогц оролдлого, өнөөгийн болон ирээдүйн сонгуулийн эрх зүйн хөгжлийн бодит туршлага, цаашдын судалгаа, бодлогын шинэчлэлийн гол эх сурвалж болж байна” гэж оновчтой, тодорхой дүгнэсэн байна.

Номын “Сонгуулийн эрхийг хамгаалах арга, хариуцлагын тогтолцоо” XII бүлэгт зорхиогч **“иргэний сонгох, сонгогдох эрхийг хамгаална** гэдэг улс төрийн энэхүү өрсөлдөөн, тэмцлийн «гал» дунд «буцалж» байдаг олон талт үйл ажиллагаа юм. Энэ бол эцсийн дүнд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж зааснаар төрөөс иргэдийнхээ өмнө хүлээсэн Үндсэн хуулийн үүрэг, хариуцлага мөн” (Б.Чимид, 2008, х. 245) хэмээн иргэдийн сонгуулийн эрхийг хамгаалахын учир шалтгааныг тодорхойлжээ.

Улмаар зохиогч сонгуулийн эрхийг засаг захиргааны журмаар хамгаалах буюу хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтийг хангах, зохион байгуулах, хянан шалгах болон шүүхийн журмаар буюу хэрэг, маргаан шийдвэрлэх тогтолцоогоор иргэдийн сонгох, сонгогдох үндсэн эрх, сонгогчийн субъектив (“олсон”) эрхийг хэн нэг этгээд, засаг төрийн байгууллага, түүний албан тушаалтан зөрчвөл 1) уул зөрчлийг таслан зогсоох; 2) зөрчил бүхий хэрэг маргааныг шийдвэрлэх; 3) зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоож, хууль ёсны байдалд нь оруулах², нөгөөтэйгүүр сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргаа, сахилгын, эрүүгийн болон эдийн хариуцлага хүлээлгэх аргаар хамгаалах”-ыг системчлэн бичсэн.

Зохиогч сонгуулийн эрхийг хамгаалах арга, сонгуулийн

² Жишээлбэл, нэрийн жагсаалтад буруу бичсэнийг зөвтгүүлэх, санал луйвардсан бол санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураах хүртэл тэр зөрчлийг үйлдсэн, гаргасан байгууллага, албан тушаалтны хүсэл зоригоос хамаарахгүйгээр уг зөрчлийг арилгаж, хохирогчийн эрхийг сэргээнэ. (Б.Чимид, 2008, х. 248).

маргаан шийдвэрлэх хэргийн харьяаллын талаар авч үзэхдээ захиргааны шүүхээс хянан шийдвэрлэх сонгуулийн маргааны талаар онцгойлон авч үзсэн байна. Үүний учир нь Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар дүгнэлттэй³ холбоотой. Зохиогч энэ талаар бүр өмнө нь (2005 онд) Монгол Улсад Хансс Зайделийн сангийн үйл ажиллагаа явуулж эхэлсний 10 жилийн ой зориулж тавьсан “Захиргааны хэргийн шүүх бол эрх зүйн шинэтгэийн цоо шинэ үзэгдэл (ЗХШ-ийг бүрэн эрхийг тоносны хариуцлагыг хэн хүлээх вэ?) сэдэвт илтгэл (Б.Чимид, 2008Б, х. 79-96)-дээ тодорхой бичсэн байдаг. Улмаар энэ үндэслэл, тайлбараа давахгүйгээр “Сонгуульд суралцахуй” номдоо захиргааны хэргийн шүүх сонгуулийн маргааныг харьяалан шийдвэрлэх нь бултах аргагүй, жам ёсны эрх зүй болохыг дараах байдлаар илэрхийлжээ (Б.Чимид, 2008А, х. 289-290).

- Сонгууль бэлтгэн явуулах талаар сонгуулийн болон захиргааны бусад байгууллагаас явуулж буй үйл ажиллагаанд **захиргааны хэргийн шүүхийн хяналт** хүссэн ч, хүсээгүй ч байж таарахнээ.
- УИХ-ын сонгуулийн тухай хуульд Захиргааны шинжтэй хэрэг маргааныг, шийдвэрлэх тухай, түүнийг эрхэлсэн шүүх байдаг тухай юу ч заагаагүй хийдэл гарчээ. Манайхан “цоорхой” гэгцгээдэг.
- Сонгуулийн маргааны дотор “Захиргааны хэрэг” болох зөрчил, зөрчилдөөн болон бий. ... Цэцээс таамгаар буруушааж, Их хурлаас эрхийг хасахаас өмнөхөн хэсэгхэн хугацаанд ЗХШ сонгуулийн хууль зөрчсөн захиргааны шинжтэй зөрчил бүхий цөөнгүй маргаан хүлээн авч шийдвэрлэж байсныг бид тухайн үед нь судалж байв.
- ... Үүссэн маргаан нь захиргааных бол шийдвэрлэх шүүх нь захиргааны хэргийнх л байж таарна. Энэ бол жам ёсны

³ Үндсэн хуулийн цэцийн тус дүгнэлтээр “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар”, 4.1.6-д “Сонгуулийн ерөнхий хороо” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн” гэж шийдвэрлэсэнийг та бүхэн мэдэж байгаа билээ.

эрх зүйн мөн. Түүнийг дур зоргоор хааж хавчих нь хууль ёс, шударга ёс, бас зүй ёсонд харш билээ” гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлттэй холбоотойгоор Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн хороодын сонгуулийн хууль зөрчсөн захиргааны шинжтэй маргааныг ердийн шүүх эсхүл захиргааны хэргийн шүүхийн аль нь харьяалан шийдвэрлэх нь тодорхойгүй болж, улмаар Улсын дээд шүүх 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн (2011.12.15) тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 16 дугаар тогтоол гаргаж “Үндсэн хуулийн цэцийн 2005 оны ... 02 дугаар дүгнэлт Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан **“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах”** Монгол Улсын иргэний үндсэн эрхийг хязгаарлахгүй тул Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулиас бусад хуулийг, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон сонгох, сонгогдох эрхээс бусад эрхийг зөрчсөн талаарх гомдлыг ... дүүргийн шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гаргана. Хуулийн 21 дүгээр зүйлд заасан тойргийн хорооны шийдвэрт тухайн тойргийн хороог харьяалах сум буюу сум дунд, дүүргийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гомдол гаргана” гэж тайлбарыг гаргаж байсан.

Хэдий Улсын дээд шүүхээс ийм тайлбарыг гаргаж байсан боловч тойргийн сонгуулийн хороонд холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж байсан (Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2013.03.04, №40; 2013.04.01, №61.) нь зохиогчийн сонгуулийн маргаанд захиргааны хэргийн шүүхийн хяналт хяналт зайлшгүй гэсэн үзэл санааг баталж байна. Улмаар 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “Сонгуулийн тухай хууль”,

2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-аар Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль зөрчсөн захиргааны шинжтэй маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрч, хуульчилсан билээ.

Дагаж мөрдөж буй 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81.3-т “Энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ”, 81.4-т “Энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус заажээ.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-аас хайж үзэхэд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуультай холбоотойгоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсантай холбоотой 4 маргааныг хянан шийдвэрлэснээс 2-т нь нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, 2-т нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2024.06.06, №221/ШШ2024/0015; 2024.06.07, №221/ШШ2024/0016; 2024.06.14, №221/ШШ2024/0020; 2024.06.19, №221/ШШ2024/0024). 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхны шийдвэр гарсан бол, 2024 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хамгийн сүүлийн шийдвэр нь гарсан байна. Эдгээр тохиолдолд хэргийн оролцогчид давж заалдах гомдол гаргалгүйгээр шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон⁴ тул практик дээр асуудал гараагүй.

⁴ Шүүхийн шийдвэрийн цахим санд эдгээр шүүхийн шийдвэрийг хянаж гаргасан Улсын дээд шүүхийн тогтоол байхгүй байна.

Хэрэв Сонгуулийн ерөнхий хорооны нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсантай холбоотой маргаан захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж дуусаагүй байхад сонгуулийн санал хураалт болоод дуусчихвал яах вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарч байна. Ийм асуудал үүсэх боломжтой. Учир нь МУИХСтХ-ийн 29.1-д “Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана”, 32.11-т “Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана”, 32.12-т “Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлнэ” тус гэж заасан. Харин Улсын Их Хурлын сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэж дуусах хуулиар тогтоосон нийт хугацаа 78 хоног⁵ болж байна.

Нэгэнт санал хураалт болоод дуусчихвал захиргааны хэргийн шүүх тухай хүнийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэр хууль бус байсан ч, түүнийг нэр дэвшигчээр бүртгэхийг Сонгуулийн ерөнхий хороонд даалгаж шийдвэрлэх боломжгүй болж, харин нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэр хууль бус байсан болохыг⁶

⁵ Нэхэмжлэлийг шүүх хүлээж аваад 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Захиргааны хэрэг үүсгэсэн тохиолдолд хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 10 хүртэл хоногоор сунгаж болно. Шүүхийн шийдвэрийг 5 хоногийн дотор бичгээр үйлдэнэ. Хэргийн оролцогч шүүхийн шийдвэрийг хүлээж авснаас хойш 5 хоногийн дотор гомдол гаргана. Улсын дээд шүүх 21 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэнэ. $(7+30+10+5+5+21=78)$.

⁶ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2016.02.04

106.3. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараахь шийдвэрийг гаргана:

106.3.3. захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох;

тогтоогоод орхих боломжтой.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 75.2-т “Нэр дэвшигч энэ хуулийн 35.3, 38.2, 48.1, 48.5.1, 48.5.2, 56.2-т заасныг зөрчсөн болох нь санал хураалтын дүн гаргахаас өмнө тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ” гэж заасан. Үүнтэй холбоотой үүссэн маргааныг мөн л захиргааны хэргийн шүүх шийдвэрлэнэ. Гэтэл нэгэнт санал хураалт болоод дуусчихвал Сонгуулийн ерөнхий хорооны нэр дэвшигчийг хассан шийдвэр нь хууль бус байсан ч бодит байдал дээр хэрэгжээд дууссан байхаар байна.

Энэчилэн 2012 онд гарсан УИХ-ын сонгуулийн нэгэн маргаанд Улсын дээд шүүхээс “... хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн дагуу шаталсан тогтолцоотой захиргааны байгууллагын эцсийн шат болох Сонгуулийн төв байгууллагын шийдвэр эцэслэн гарч, ... Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн талаар шийдвэр гаргах эрхийг Захиргааны хэргийн шүүхэд хуулиар олгоогүй байна” (Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2013.04.01, №61.) гэсэн дүгнэлт хийсэн байдаг ба энэ шийдвэрээс харахад сонгуулийн маргааны хүрээнд захиргааны хэргийн шүүхийн хяналт хэр хэмжээнд байх, хаа хүрээд дуусах нь сонирхол татаж байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос бүртгэх ёсгүй нэр дэвшигчийг бүртгэсэн, бүртгэх ёстой нэр дэвшигчийг бүртгээгүй, хасах ёсгүй нэр дэвшигчийг хассан асуудал нь аль ч тохиолдолд сонгуулийн дүнд нөлөөлөхүйц шийдвэр юм. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц сонгуулийн төв байгууллагын зөвхөн санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан гаргасан маргааныг хянан шийдвэрлэхээр хязгаарлах нь учир дутагдалтай мэт.

Зохиогч мөн энэ асуудлын талаар номдоо “Харин

сонгуулийн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны илтгэлийг сонсон хэлэлцэх явцад аль нэг тойрогт сонгуулийн хууль ноцтой зөрчигдөж, **сонгогчдын олонхын хүсэл** зориг үнэ мөнөөр илэрхийлэгдэж чадаагүй өөрөө хэлбэл, сонгогчид саналаа өөрийнхөөрөө гаргаж чадаагүй бол хэрхэх вэ? Энэ тухай хуульд шууд нэрлэж заагаагүй, Монгол төрийн амьдралд тохиолдоогүй, урьдын ёс төдий арга хэлбэр үргэлжилж байгаа учир урьдчилан шийдвэрлэвэл зохих асуудлын нэгж болж байна. **Хууль бол сүүл барих бус, угтан харсан байх учиртай.** Олонхийн хувьд хэрэв тойрогт сонгууль хүчинтэй эсэх тухай үндэслэлтэй маргаан үүсвэл “хүчинтэй” гэж оруулж ирсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг тогтоолгохоор мөн Улсын Их Хурлаас Цэцэд хандах нь зөв гарц болно” (Б.Чимид, 2008, х. 240) гэсэн санааг дэвшүүлжээ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд: “... сонгуулийг бэлтгэх, явуулах, дүнг гаргах явцад сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөн нь Улсын Их Хурлын суудал хуваарилалт, Ерөнхийлөгчийн сонгуулийн, ... дүнд нөлөөлсөн тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний суудал хуваарилалтыг зөвтгөх, эсхүл тухайн тойргийн сонгуулийг хүчингүй болгох”, “нэр дэвшигчийг, эсхүл намын нэрийн жагсаалтыг бүртгэхтэй холбогдсон сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд сонгуулийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох” шийдвэр гаргахаар тусгасан (Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/хуулийн төсөл, 2024) хувилбар нь дээрх асуудлыг шийдвэрлэх гарц байж болох юм.

Дээрхээс дүгнэхэд иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд сонгуулийн төв байгууллагаас

гаргасан шийдвэр нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл, хэргийн харьяалал, маргааныг шийдвэрлэх хугацаа, журам, шийдвэрийг оновчтой тодорхойлох асуудлыг зөвхөн сонгуулийн хуулийн хүрээнд бус Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд цогцоор нь тусгаж шийдвэрлэх шаардлагатай байна.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008А). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.
2. Б.Чимид (2008Б). “Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр”, Улаанбаатар.
3. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол. “Э-н нэхэмжлэлтэй тойргийн сонгуулийн хороонд холбогдох захиргааны хэрэг” 2013.03.04, №40. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол. “М, Н нарын нэхэмжлэлтэй тойргийн сонгуулийн хороонд холбогдох захиргааны хэрэг” 2013.04.01, №61.
4. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр. “Н.Н-ийн нэхэмжлэлтэй Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох захиргааны хэрэг” 2024.06.06, №221/ШШ2024/0015.
5. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: “Б.Х-ийн нэхэмжлэлтэй Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох захиргааны хэрэг” 2024.06.07, №221/ШШ2024/0016.
6. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: “Д.Т, ИХ намын нэхэмжлэлтэй Сонгуулийн

ерөнхий хороонд холбогдох захиргааны хэрэг”
2024.06.14, №221/ШШ2024/0020.

7. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: “Н.Х-ийн нэхэмжлэлтэй Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох захиргааны хэрэг” 2024.06.19, №221/ШШ2024/0024
8. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол. “М, Н нарын нэхэмжлэлтэй тойргийн сонгуулийн хороонд холбогдох захиргааны хэрэг” 2013.04.01, №61.
9. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/хуулийн төсөл, 2024.03.05, <https://lawforum.parliament.mn/project/537/>

САНАЛ, ДҮГНЭЛТ

Э.Лхагвасүрэн

*Захиргааны хэргийн давж заалдах
шатны шүүхийн шүүгч*

Б.Чимид Сонгуульд суралцахуй хэмээх (2025) бүтээлийн төгсгөлд зохиогч “Хуулийг уншаад ойлгочих юм шиг санах нь бий. Гэтэл хуулийн зүйл заалтын цаана олон янз харилцаа, түүнийг хэрхэн зохицуулах тухай онол сургаал үй олон бий. Зөвхөн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн сүүлчийн хоёрхон зүйлийг тайлбарлах гэж сүүлчийн 2 бүлгийг зориулах жишээтэйгээр өгүүлэх зүйл мундахгүй” (Б.Чимид, 2025, х. 273) гэж бичсэнээс үзвэл тус бүтээлийнхээ 12, 13 дугаар бүлгүүдэд ач холбогдол өгсөн болохыг илтгэж байна. Иймд эдгээр бүлгүүдийн агуулга, ач холбогдлын талаар товчхон эргэцүүлэе.

I.Зохиогч бүтээлийн 12 дугаар бүлгээр хүний эрх, тэр тусмаа иргэдийн улс төрийн эрхийг хамгаалах тухай нь ойлгоход тийм ч амаргүй, хэрэгжүүлэх нь бүр ч хэцүү асуудал (Б.Чимид, 2025, х.227) гээд сонгууль, түүний мөн чанартай холбон “эцсийн үр дүнд засаг төрөөс иргэдийнхээ өмнө хүлээсэн Үндсэн хуулийн үүрэг хариуцлага мөн” (Б.Чимид, 2025, х. 227) гэж авч үзсэн нь онцлог байна. Үүнтэй зэрэгцэн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналт бол хүний бас сонгогчдын эрхийг хамгаалах чухал хэрэглүүр бөгөөд сонгуулийн хууль сонгогчдын эрх зөрчигдөх явдал янз бүрээр илэрдэг (Б.Чимид, 2025, х. 233). Нөгөөтэйгүүр сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудал явдал чухал гэж үзсэн. Учир нь зохиогчийн үзэж байгаагаар “хууль зүйн хариуцлага нь хатуу ширүүндээ биш, зайлшгүйдээ байдаг. Алив нэгэн алдаа зөрчлийг адилхан шанагаар тугнаж (хэмжиж) болохгүй. Харин

түүнийг үйлдсэн нөхцөл шалтгаан зөрчил гаргагчийн гэм буруу буюу санаа зорилго, учруулсан хохирлын их багыг харгалзан хөнгөтгөх, хүндрүүлэн үзэх учир бий” (Б.Чимид, 2025, х. 236) гээд сонгуулийн хууль зөрчсөний хариуцлага (Б.Чимид, 2025, х. 237) хүлээлгэж болох талаар тухайлан тус тус бичсэн байна.

Илтгэгч илтгэлийнхээ эхний хэсгээр зохиогчийн гаргасан үзэл санаа, агуулгыг нэгтгэн дүгнэхийн зэрэгцээ утга агуулгыг нь улам тодруулан баяжуулан бичсэн нь олзуурхууштай болсон байна.

II. Зохиогч бүтээлийн 13 дугаар бүлэгт сонгуулийн маргаан гэж юу вэ, түүнийг ямар агуулгаар тодорхойлох вэ, шүүх хянан шийдвэрлэвэл зохих сонгуулийн болон сонгуультай холбоотой бусад маргаан гэдгийг хэрхэн ойлгох вэ гэх зэрэг агуулгын хүрээнд авч үзсэн байна. Товчхондоо бол **сонгуулийн маргаан** гэдгийг “сонгогчийн эрх, сонгуулийн харилцааны талаарх Үндсэн хууль, сонгуулийн болон бусад хууль, тэдгээрт нийцсэн хэм хэмжээний актыг зөрчсөн тухай иргэн, нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийн төлөөлөгчдөөс гаргасан хүсэлт, гомдол, нэхэмжлэлийн үндсэн дээр үүссэн маргааныг” (Б.Чимид, 2025, х.253) гэж өргөн тодорхойлсон байна. Үүн дээр үндэслэн сонгуулийн болон сонгуулийн холбогдолтой маргаан гэх хоёр зүйлийн нэр хэрэглэсний учир юу гэвэл сонгох, сонгогдох эрхэд суурилсан **сонгуулийн эрх зүй**, түүнийг хамгаалж хэрэгжүүлэх зарчим, журмыг тогтоосон **сонгуулийн хууль тогтоомж** нь хамтатган үзэх боломжгүй хоёр өөр зүйл юм (Б.Чимид, 2025, х. 260-261) гэж бичсэн байна. Өөр үгээр хэлбэл, эрх зүй болон хууль тогтоомж нь нэр томъёоны төдийгүй утга агуулгын хувьд ялгаатай гэх эрх зүйн онолын үндсэн ойлголтыг нэн ойлгомжтойгоор **“сонгуулийн”** жишээн дээр зохиогч бүтээлээрээ авч үзсэн нь онцлог. Үүнээс гадна Захиргааны хэргийн шүүхийн хяналтад Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны шинжтэй шийдвэр, үйл ажиллагааны практик үндэслэлийг хөндсөн байна. Тухайлбал, “Үндсэн хуулийн цэц Сонгуулийн ерөнхий хорооны аливаа шийдвэрийг хянах ёстой гэсэн “хөнгөн хийсвэр омголон”

дүгнэлт гаргаж, ... захиргааны олон зүйл маргааныг Захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас гаргаснаар хууль зүйд томоохон гажиг суужээ” (Б.Чимид, 2025, х. 262), эсвэл “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэвэл зохих сонгуулийн маргаан байдаг уу? Байдгаар барах уу хамгийн их хэл ам таталдаг юм чинь чухам энэ” (Б.Чимид, 2025, х. 268) гээд “сонгуулийн маргааны дотор “Захиргааны хэрэг” болох зөрчил, зөрчилдөөн олон бий” (Б.Чимид, 2025, х. 270) гэх зэргээр дурдсан.

Илтгэгч илтгэлийнхээ удаах хэсэгт сонгуулийн маргаан, түүнийг хянан шийдвэрлэх асуудлыг авч үзэхдээ үндэсний болон бусад улсуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан онолын үндэслэлийг гаргасан нь саашаалтай байна. Үүний зэрэгцээ үндэсний эрх зүйн тогтолцоон дахь зарим (Сонгуулийн ерөнхий хорооны алив шийдвэр, үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуурх байх) Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт зохиогч болон илтгэгч нар мөн адил шүүмжлэлтэй хандаж байна. Өнөөгийн үндэсний эрх зүйн тогтолцоонд **“захиргааны, сонгуулийн”** хууль тогтоомжийн хүрээнд захиргааны байгууллагыг жагсаалтын зарчмаар бус харин шинжээр тодорхойлж, Захиргааны хэргийн шүүх Сонгуулийн ерөнхий хорооны захиргааны шинжтэй шийдвэр, үйл ажиллагааг хянах боломжтой боломжтой болсон нь зохиогчдын хэлснээр “хууль зүйн гажиг согог” нь засагдсан байна.

Эцэст нь тэмдэглэхэд, зохиогчийн тухайн үед дэвшүүлж, шүүмжлэлтэй хандаж байсан сонгуулийн маргааны харьяаллын асуудлыг нэг мөр болгож эрх зүйн орчныг бүрдүүлэхэд багагүй хугацаа (2023 он хүртэл) өнгөрснийг илтгэгч илтгэлээрээ бүрэн харуулж чадсан байна.

---ooOoo---

Ном зүй

1. Б.Чимид (2008). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.

Сонгууль бол зайлшгүй, тогтмол, цаг үеэ олсон, чөлөөтэй өрсөлдөөн бөгөөд ард түмэн засгийн эрхэнд шууд оролцож, төлөөлүүлэн хэрэгжүүлэх хууль ёсны гол арга мөн.

Монгол Улсын Үндсэн хуульд нийт, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа чөлөөтэй нууцаар гаргах журмыг тодорхойлжээ.

Нам, эвслээс нэр дэвшүүлнэ гэдэг бол зөвхөн их, бага хурал, түүний гишүүдийн эрх мэдлийн асуудал, эцсийн дүнд намын даргын ажил мэт ойлгож болохгүй. Цаад утгаараа нэр дэвшүүлэх гол эзэн нь сонгогчид мөн.

Засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналт бол хүний ба сонгогчдын эрхийг хамгаалах хүчит хэрэглүүр мөн.

Сонгуулийн луйвар гэдэг бол шударга сонгууль, түүний эрх зүй, ёс суртахууны үндсийг санаатайгаар эвдэн бусниулах замаар засгийн эрх мэдлийг авахын төлөө зохион байгуулалттай гэмт үйлдэл мөн.

A handwritten signature in black ink, appearing to be a stylized name, possibly "Т. Түвшин", written over a horizontal line.